



**“МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСТОЙ
ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРЭГТ ОНОГДУУЛЖ БУЙ ЯЛЫН
БОДЛОГО (2022-2024)” судалгааны тайлан**

“Хууль дээдлэх ёс эрх зүйн хөгжлийн төв” ТББ
Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 12-р хороо

2025 он

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГ	3
УДИРТГАЛ	4
НЭГ. ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ҮНДСЭН АСУУДАЛ	7
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ШАЛТГААН НӨХЦӨЛ, ЯЛЫН ҮР НӨЛӨӨ	16
2.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, анхаарах асуудал	
2.2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал	
2.3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, нөлөөлж буй хүчин зүйл	
2.4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгт оногдуулсан ял, түүний үр нөлөө	
ГУРАВ. МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР ГАДААДЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА	
3.1. Дэлхийн орнуудын хар тамхитай холбоотой өнөөгийн нөхцөл байдал	34
3.2. Гадаад орны эрх зүйн зохицуулалт, туршлагаас	
3.2.1. Нидерланд улс	40
3.2.2. ХБНГУ	47
3.2.3. Тайвань	55
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ	69
ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ	72
ЭХ СУРВАЛЖ	73
ХАВСРАЛТ	75

ТОВЧИЛСОН ҮГ

АНУ- Америкийн Нэгдсэн Улс

ГХУСАЗЗАА- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба

ДЭМБ- Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

НҮБ- Нэгдсэн үндэстний байгууллага

НҮБХХ-Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр

СЭМҮТ- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв

ТББ- Төрийн бус байгууллага

ХБНГУ- Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХЗДХЯ- Хууль зүй, дотоод хэргийн яам

ХЗҮХ- Хууль зүйн үндэсний хүрээлэн

УЕПГ-Улсын ерөнхий прокурорын газар

ЦЕГ- Цагдаагийн ерөнхий газар

ШЕЗ- Шүүхийн ерөнхий зөвлөл

ШШГБ- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага

ШШГЕГ-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

ЭХ- Эрүүгийн хууль

ЭХХШтХ- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

ЭБША- Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа

ЭХХША- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

UNODC - НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар

UNAIDS- ХДХВ/ДОХ-тай тэмцэх НҮБ-ын хамтарсан хөтөлбөр

УДИРТГАЛ

НҮБ-ын Хар тамхитай тэмцэх газрын (UNODC) гол баримт бичиг болох “Дэлхийн мансууруулах бодисын тайлан (2024 он)”-д хар тамхи үйлдвэрлэл, хууль бус тээвэрлэлтийн чиглэлээр гол асуудлуудыг авч үзэж, хар тамхины хэрэглээ, түүнтэй холбоотой хор уршиг, хохирлын хандлагыг судалж, дэлхийн хар тамхины хурдацтай өөрчлөгдөж буй сорилтуудыг ил тод харуулж, хар тамхины хууль бус эргэлттэй холбоотой үхэл, зовлон зүдгүүр, хүчирхийллийн нөхцөл байдлын улам дордож буйг хүн төрөлхтөнд анхааруулж байна.¹

Монгол Улсад мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хэрэглээ улам бүр нэмэгдэж, дамжуулагч орноос хэрэглэгч орон руу шилжиж, зөвхөн хүн амын эрүүл мэндэд бус, улс орны эрх ашиг, сонирхолд сөргөөр нөлөөлж, үндэсний аюулгүй байдалд заналхийлэх түвшинд хүрснийг өнөөгийн нөхцөл байдал харуулж байна.

Эрүүгийн хуулийн 1-р зүйлийн 1.1 дэх хэсэгт зааснаар үндэсний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалахад Эрүүгийн хуулийн зорилго оршдог.² Эрүүгийн хуулийн энэ зорилгын хүрээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийг тодорхойлж, эдгээр төрлийн гэмт хэрэгт ял оногдуулж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж, урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллагууд ажиллаж байна.

Гэсэн хэдий ч энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдал улам дордож, гэмт хэргийн тоо өссөөр байгааг Гэмт хэргийн цагаан ном (2023) болон бусад судалгаанд дурдсаар байна. Иймд ГХУСАЗЗАА-ны захиалгаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн ялын үр нөлөө, бодлогын талаар энэхүү судалгааг хийж, Монгол Улсад хэрэгжүүлэх зохистой ялын бодлогыг тодорхойлох, санал зөвлөмж боловсруулахаар зорилоо.

Судалгааны зорилго, зорилт

Судалгааг Монгол Улс дахь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн ялын бодлогыг тодорхойлох, түүний үр нөлөөг сайжруулах зөвлөмж боловсруулахаар гүйцэтгэсэн бөгөөд энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан. Үүнд:

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, түүний хууль бус эргэлттэй холбогдох олон улсын эрх зүйн зохицуулалтыг судалж, конвенциудын үндсэн асуудлыг гаргах замаар Монгол Улсын хүлээсэн үүргийг тодорхойлох;
- Монгол Улс дахь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, анхаарах асуудал, гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, гэмт хэргийн шалтгаан, хүчин зүйлийг тогтоох;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, ялын бодлогын талаар 3 гадаад орны эрх зүйн зохицуулалт, туршлагыг харьцуулан судалж, сайн туршлагыг илрүүлэх;

¹ Key findings and conclusions https://www.unodc.org/documents/data-and-analysis/WDR_2024/WDR24_Key_findings_and_conclusions.pdf

² Эрүүгийн хуулийн 1.1-д “Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино.” гэжээ. <https://legalinfo.mn/mn/detail/11634>

- Эцэст нь олон улсын болон гадаад орны сайн туршлага, өнөөгийн практикт тулгамдаж буй асуудлын дүн шинжилгээнд үндэслэн, Монгол Улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбогдох гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг үнэлэн, сайжруулах талаар санал зөвлөмжийг боловсруулах.

Судалгааны ажлын үндэслэл, ач холбогдол

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Засгийн газрын 2024-2028 оны мөрийн хөтөлбөр зэрэг цөөнгүй бодлогын баримт бичгүүдэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар эрх зүйн орчин бүрдүүлсээр байна.

Гэсэн хэдий ч Монгол Улсад 2014-2024 он хүртэл 10 жилийн хугацаанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ болон түүнтэй холбоотой гэмт хэрэг тогтмол өссөн дүн мэдээ байна. Тухайлбал, 2014 онд 62, 2015 онд 79, 2016 онд 98, 2018 онд 128, 2019 онд 170, 2020 онд 181, 2021 онд 187, 2022 онд 230, 2023 онд 238 болж жил ирэх бүр өссөн дүнтэй гарчээ.³

Түүнчлэн дээр дурдсан UNODC-ын “Дэлхийн мансууруулах бодисын тайлан (2023 он)”-д Зүүн Азийн орнууд метамфетамин төрлийн мансууруулах бодисын хэрэглээ, үйлдвэрлэл ихээр нэмэгдэж, зах зээл өргөжиж, тэр дундаа Монгол Улс хэрэглэгч орон болсон талаар дурджээ.⁴

Монгол Улсад төдийгүй хар тамхины гэмт хэрэгт гадаад улсад манай улсын иргэд ял шийтгэгдэх явдал нэмэгдэж, гадаадын иргэд манай улсад энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж эрүүгийн хариуцлага хүлээх тохиолдол ч нэмэгдэж байна. Тухайлбал, БНХАУ-д 34, БНТУ-д 3, ХБНГУ-д 2, БНСУ д 1, Японд 1 тус тус 41 иргэн ял шийтгүүлсэн байгаагаас бүх насаар хорих ялаар шийтгүүлсэн 1, 25 жил хорих ялаар шийтгүүлсэн 4, 20 жил хорих ялаар шийтгүүлсэн 3, 19 жил хорих ялаар шийтгүүлсэн 1, 12 жил хорих ялаар шийтгүүлсэн 1, 11 жил хорих ялаар шийтгүүлсэн 2, 10 жил хорих ялаар шийтгүүлсэн 4, 9 жил хорих ялаар шийтгүүлсэн 2, 8 жил хорих ялаар шийтгүүлсэн 4, 7 жил хорих ялаар шийтгүүлсэн 2, 5 жил хорих ялаар шийтгүүлсэн 11, 4 жил хорих ялаар шийтгүүлсэн 5 байна. Түүнчлэн сүүлийн 7 жилд гадаад улсын 12 иргэн хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт шалгагдсанаас Нигер Улсын 1, БНХАУ-ын 1 иргэн 2 4 жилийн хорих ялаар шийтгүүлжээ.⁵

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг 10 жилийн турш тогтмол нэмэгдэж, үндэстэн дамнасан шинжтэй болж, дамжуулагч улсаас хэрэглэгч улс руу шилжиж, гэмт хэргийн нөхцөл байдал улам доройтон байгаа энэ цаг үед тус гэмт хэргийн нөхцөл байдал, хүчин зүйл, ялын үр нөлөөнд дүн шинжилгээ хийх, цаашид анхаарах асуудлыг тодруулах, санал зөвлөмж боловсруулах судалгааг гүйцэтгэх нь нэн ач холбогдолтой гэж үзлээ.

³ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар товч танилцуулга, <https://www.mojha.gov.mn/content/663c3d4d9fea4ca6d5e6d21f>

⁴ А.Манлай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн нөхцөл байдал, нөлөөлж буй хүчин зүйл, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэхэд байгууллагуудын хамтын ажиллагаа эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, Уб., 2025 он, 107 дахь тал.

⁵ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар товч танилцуулга, <https://www.mojha.gov.mn/content/663c3d4d9fea4ca6d5e6d21f>

Судалгааны арга зүй

Дээрх судалгааны ажлаар хууль зүйн шинжлэх ухааны үндсэн аргууд болох норматив аргаар хэм хэмжээнүүдийг логик зарчмын үүднээс авч үзэж, тухайн асуудлыг илүү оновчтой авч үзэх үүднээс харьцуулалтын арга, нийгмийн асуудлыг тодорхой болгох үүднээс анализ, синтезийн арга, мөн тухайн харилцааг зохицуулж байгаа эрх зүйн зохицуулалт тэдгээрийн ойлголтыг системтэйгээр судлах үүднээс системчлэх аргыг хэрэглэсэн болно.

Түүнчлэн практикт ажиллаж буй мөрдөгч, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчид, тус гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээдээс ганцаарчилсан ярилцлагын судалгаа авч, гэмт хэргийн шалтгаан нөхцөл, анхаарах зүйл, ялын үр нөлөөнд дүн шинжилгээ хийхээр зорилоо.

Судалгааны хүрээ

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн ялын бодлогыг тодорхойлох үүднээс түүнтэй холбоотой Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн зохицуулалт, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц, Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц зэрэг олон улсын баримт бичиг болон 3 улсын эрх зүйн зохицуулалт, сайн туршлагыг сонгон авч, харьцуулан судаллаа.

Ганцаарчилсан ярилцлагын судалгаанд ШШГЕГ-ын 407, 409, 421, 441, СХТБ-ын нийт 43 хүмүүжигч, эдгээр хорих ангийн 20-аад алба хаагч, ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газрын ахлах мөрдөгч, мөрдөгч нарыг хамруулахын зэрэгцээ 2025 онд шүүхээр шийдвэрлэсэн 20 гаруй шүүхийн шийтгэх тогтоолд дүн шинжилгээ хийсэн болно.

Судлагдсан байдлын тойм

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн талаарх асуудал нь хүний эрхийг хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах чухал асуудлын төвд оршдог нэн чухал сэдэв болохын хувьд судлаачдын анхаарлыг татсаар байгаа асуудал тул энэ гэмт хэргийн талаар зарим судалгаа Монгол Улсад байна. Ялангуяа 2025 онд зохион байгуулагдсан Хар тамхитай тэмцэх газрын 25 жилийн ойн хүрээнд энэ сэдвийн хүрээнд 30-аад эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл хэвлэгдсэн нь тун сайшаалтай байна.

2013 онд гүйцэтгэсэн “Монгол Улс дахь мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэрэгт ногдуулж буй ял шийтгэл, тулгамдаж буй асуудал”, 2016 онд гүйцэтгэсэн “Хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал” сэдэвт судалгааны ажлын тайлангууд байгаагийн зэрэгцээ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд ХЗҮХ-ээс хийсэн “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” сэдэвт судалгаа, Гэмт хэргийн цагаан ном 2023 -д оруулсан “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг” гэсэн тусгайлсан бүлэг зэргийг дурдаж болох юм.

Эдгээр судалгаанууд нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн тухайд олон талаас нь судалсан нь сайшаалтай бөгөөд эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр хийгджээ. Бидний энэхүү судалгаа нь ялын бодлогыг тодорхойлох чиглэлээр нарийвчлан судалж буй гэдгээрээ шинэлэг байна.

НЭГ. ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ҮНДСЭН АСУУДАЛ

Монгол Улс нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх олон улсын хамтын нийгэмлэгийн гишүүн улсын хувьд НҮБ-аас баталсан гол гэрээ, конвенцод нэгдэн орсон. Эдгээр гэрээ, конвенцын хүрээнд гишүүн улсууд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын жагсаалтыг баталж гаргах, хууль бус үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлтийг эрүүгийн гэмт хэрэгт тооцох, хилийн хяналт, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, мэдээлэл солилцох, тайлагнах, хяналтын байгууллагатай хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд хуулийн шинэчлэл хийх, дотоодын хууль тогтоомжийг олон улсын гэрээтэй нийцүүлэх эрх зүйн үүрэг хариуцлага хүлээдэг. Нэгдэн орсон гэрээнүүдийн тухайд дэлгэрэнгүй авч үзвэл дараах байдалтай байна.

1. 1961 оны 3 дугаар сарын 25-ны өдөр батлагдаж, 1961 оны 12 дугаар сарын 13-ны өдөр хүчин төгөлдөр болсон “Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц”⁶, “Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц”-оор 2 үндсэн асуудлыг авч үзсэн нь хуулийн дагуу хэрхэн хэрэглэх, хууль бусаар хэрэглэхгүй байх талаар авах арга хэмжээний тухайд юм. Конвенц нь мансууруулах эмд донтох нь хувь хүнд ноцтой хор хөнөөл, хүн төрөлхтөнд нийгэм, эдийн засгийн аюул учруулж байгаа учраас түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, мансууруулах эмийг урвуулан хэрэглэхийн эсрэг эрх зүйн зохицуулалт баталж олон улсын хамтын ажиллагааг сайжруулахыг зорилго болгосон байдаг.

Уг конвенцоор мансууруулах бодисын жагсаалтыг баталсан ба хуулийн дагуу хэрэглэх хар тамхины хэмжээг хэрхэн тооцоолох, түүнд хэрхэн хяналт тавих, улс бүр дотоодын хяналтын тогтолцоог бүрдүүлэх, хар тамхитай холбоотой үйл ажиллагаанд ашиглагдсан техник, тоног төхөөрөмжийг хураах зэрэг асуудлыг тусгасан байдаг. Түүнчлэн шинээр гарч буй мансууруулах эмийг хяналтад авах олон улсын механизмыг тодорхой заасан бөгөөд энэ нь шинэ бодисыг олон улсын жагсаалтад нэмж оруулах үндсэн журам болдог. Өөрөөр хэлбэл, гэрээний оролцогч улс эсвэл ДЭМБ ямар нэгэн шинэ бодис нь мансууруулах эмийн шинжтэй гэж үзвэл НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэл өгч холбогдох нотлох мэдээллийг хүргүүлэх ба холбогдох процессын ажиллагаа явагдаж, тухайн бодисыг I-IV жагсаалтын аль нэгэнд хамруулсан эсэх эцсийн үр дүнг зохих бүх талуудад мэдэгддэг байна. 1961 оны конвенцод нэгдэн орсон улс мансууруулах үйлчилгээтэй байж болзошгүй гэж үзсэн бодис, эм бэлдмэлийн талаарх мэдээллийг холбогдох олон улсын байгууллагад нэн даруй хүргэх үүрэгтэй.

Энэ конвенцын 1 дүгээр зүйлд мансууруулах бодис болон түүний эргэлтийг хууль ёсны бус гэж ангилах үндэслэлийг бүрдүүлж өгчээ. Конвенцын 2 дугаар зүйлд хяналтанд хамаарах бодисыг тодорхойлохдоо "бүх төрлийн мансууруулах бодис нь хяналтанд байна" гэж заажээ. Мөн зүйлийн 5 дахь хэсэгт “гэрээнд нэгдэн орсон талууд нь тухайн орны хүн амын эрүүл мэнд, ахуй амьдралыг хамгаалах зайлшгүй шаардлагатай тохиолдолд эмнэлгийн болон эрдэм шинжилгээ, судалгаанд ашиглахаас бусад зорилгоор мансууруулах бодисыг худалдаалахыг хориглохоор” заасан байна. Уг конвенцоор үйлдвэрлэх, бэлтгэх, худалдаалах, импортлох, экспортлох, хуваарилах болон ашиглах явдлыг хязгаарлаж, хууль бус эргэлтийн аливаа хэлбэрийг хориглосон юм. Энэхүү конвенцод заасан журмын дагуу

⁶ Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенцод Монгол Улс 1990 оны 12 дугаар сарын 6-нд нэгдэн орсон.

мансууруулах бодисын олон улсын худалдаа нь Мансууруулах бодист хяналт тавих олон улсын хорооны хяналтанд байхаар заасан байна.

Конвенцын нэг чухал өөрчлөлт бол 1972 оны конвенцод өөрчлөлт оруулах тухай протокол бөгөөд гол агуулга нь шийтгүүлж байгаа хүнд хорих, эсхүл албадан эмчилгээ хийх, өөрөөр хэлбэл, хорихоос гадна эмчилгээ хийх шийтгэл оногдуулах боломжтой болсон юм.

2. 1971 оны 2 дугаар сарын 21-ний өдөр батлагдаж, 1976 оны 8 дугаар сарын 16-ны өдөр хүчин төгөлдөр болсон “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц”⁷, 1960-аад оны дунд үеэс баруун Европын орнуудад шинэ төрлийн мансууруулах бодис өргөнөөр дэлгэрсэн бөгөөд тэдгээрийг 1961 оны конвенцын дагуу олон улсын хэмжээнд зохицуулаагүй тул Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенцоор уг шинэ төрлийн мансууруулах бодисыг олон улсын хэмжээнд зохицуулах шаардлага гарчээ.⁸ Иймээс 1971 онд тус конвенцыг баталж, 1961 оны конвенцод багтааншй мансууруулах бодисуудыг нэгтгэн нийт 4 жагсаалт гарган 1 дүгээр жагсаалтад орсон бодисыг хатуу хяналтад авч, хэрэглэхийг хориглох талаас нь оролцогч орнууд арга хэмжээ авах, мөн 2,3,4 дүгээр жагсаалтад орсон бодисыг хяналтад авч зөвхөн эмчийн жороор олгож байхаар зохицуулжээ. Энэхүү конвенц батлагдсанаар сэтгэцэд нөлөөлөх бодисын буруу хэрэглээ, хууль бус үйлдвэрлэл, эргэлтэд хяналт тавих, хязгаарлах, хүн амыг хорт зуршлаас хамгаалахад чиглэгдсэн олон улсын эрх зүйн орчин бүрдсэн юм.⁹ Түүнчлэн тус конвенцын 2 дугаар зүйлд зааснаар шинэ төрлийн сэтгэцэд нөлөөт бодисыг олон улсын хяналтад хамруулах тухай Комиссын шийдвэр нь Ерөнхий нарийн бичгийн даргаас оролцогч талуудад албан ёсоор мэдэгдсэний 180 хоногийн дараа хүчин төгөлдөр болох зохицуулалттай нь 1961 оны конвенцоос онцлог нарийвчилсан заалт болсон байна.

Тус конвенцоор I-IV жагсаалтад орсон бодистой холбоотой гэмт хэрэгт тооцогдох өөр хоорондоо холбоотой үйлдлийг хэд хэдэн оронд үйлдсэн бол үйлдэл бүрийг тусдаа гэмт хэрэгт тооцох тухай, эдгээр гэмт хэргийн аль нэгийг үйлдэхэд санаатайгаар хамтран оролцох, үйлдэхээр үгсэн тохиролцох, завдах түүнчлэн бэлтгэх үйлдэл болон санхүүгийн үйл ажиллагаа явуулах нь шийтгэвэл зохих гэмт хэрэг болох талаар заасан төдийгүй гадаад улсад оногдуулсан ял шийтгэлийг тухайн этгээдийн рецидив байдлыг тогтооход харгалзан үзэх тухай заасан байдаг.

3. 1988 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлагдаж, 1990 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр хүчин төгөлдөр болсон “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц”¹⁰.

1988 оны дээрх конвенц нь 1961 болон 1971 оны конвенцуудын нөхөх нэмэлт баримт бичиг болсон юм. Уг конвенцын зорилго нь хар тамхи болон түүнтэй холбоотой хууль бус үйл ажиллагааг таслан зогсооход олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэгджээ. Энэхүү конвенцын 1 дүгээр зүйлд мансууруулах бодис болон түүний хууль бус эргэлтийн тухай ойлголт тусгагдсан нь мансууруулах бодисын борлуулалтыг хууль ёсны ба хууль бус гэдгийг зааглах нөхцөлийг мөн бүрдүүлсэн байна.

⁷ Монгол Улс тус конвенцод 1999 онд нэгдэн оржээ.

⁸ Монгол Улс дахь мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэрэгт ногдуулж буй ял шийтгэл, тулгамдаж буй асуудал, сэдэвт судалгааны тайлан, Уб., 2013 он, 21 дэх тал.

⁹ Монгол Улс дахь мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэрэгт ногдуулж буй ял шийтгэл, тулгамдаж буй асуудал, сэдэвт судалгааны тайлан, Уб., 2013 он, 21 дэх тал.

¹⁰ Монгол Улс 2001 онд тус конвенцод нэгдэн орсон.

Конвенц нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын хяналтын тогтолцоо, хууль бус эргэлтийн эсрэг авах арга хэмжээний талаар, түүнтэй холбоотой мөнгө угаах үйл ажиллагааг зогсоох, эрүүгийн эрх зүйн асуудлаар олон улсын хамтын ажиллагааг сайжруулах зэрэг зорилтуудыг тавьсан бөгөөд өмнөх конвенцуудыг үр дүнд хүргэхэд арга барил, механизм, тогтолцооны үүднээс туслахад чиглэсэн байна.

Конвенцын 2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Оролцогч тал нь тухайн орны хүн амын эрүүл мэнд, ахуй амьдралыг хамгаалах илүү тохиромжтой арга гэж үзвэл эмнэлгийн болон эрдэм шинжилгээ, судалгааны ажилд шаардлагатайгаас бусад тохиолдолд түүнийг худалдаалахыг хориглох” тухай тусгаснаас гадна хяналтанд хамаарах бодисыг тодорхойлохдоо бүх төрлийн мансууруулах бодис нь хяналт дор байна” гэжээ.¹¹ Уг конвенцоор мансууруулах бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх, худалдаалах, импортлох, экспортлох, хуваарилах болон ашиглах явдлыг хязгаарлан, мансууруулах бодисын хууль бус эргэлтийн аливаа хэлбэрт хориг тавьсан юм. Энэ нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар борлуулах явдалд тавих эрүүгийн эрх зүйн хоригийн үндэс болсон юм. Түүнчлэн конвенцын агуулга нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг үйлдвэрлэхэд байнга хэрэглэгддэг утгвар бодис, түүхий эд, урвалуудын жагсаалтыг гаргаж тэдгээрийг хяналтанд авах асуудлын олон улсын эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд оршжээ.

Конвенц нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлт, түүнээс олох ашиг орлогыг олон улсын хяналтанд авах, хууль бус эрэлттэй тэмцэх, хууль бус эргэлтээс олсон ашиг орлого, эд хөрөнгийг хураан авах, энэ төрлийн үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтыг бүрдүүлэх, гэмт хэргийг шалгах явцад талууд эрх бүхий байгууллагуудаараа дамжуулан бие биедээ эрх зүйн өргөн туслалцаа үзүүлэх зэрэг боломжийг бүрдүүлж өгчээ. Тухайлбал Конвенцын 7 дугаар зүйлд мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг шалгах явцад талууд бие биедээ эрх зүйн өргөн туслалцаа үзүүлэх бөгөөд уг туслалцаа нь нотлох баримт цуглуулах байцаах нэгжих болон баривчлах ажиллагаа явуулах, тодорхой эд зүйл, газарт үзлэг хийх, мэдээлэл олж авах зэрэгтэй холбоотой байхаар заажээ. Үүнээс гадна, дээрх конвенцын “Эрх зүйн зөрчил ба үр дагавар” гэсэн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “талууд нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг худалдах, нийлүүлэх энэ талаар санал тавих, дурын нөхцөлтэйгөөр нийлүүлэх зэрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцох талаар арга хэмжээ авна” гэж заан хууль бус эргэлт байж болох бүх хэлбэрийг тодорхойлжээ.

Олон улсын хамтын ажиллагааны хэлэлцээр, протокол, санамж бичиг: Мансууруулах бодистой тэмцэх нь дан ганц тухайн орны асуудал биш олон улсын эрх зүйн хамтын ажиллагаа, харилцан туслалцааны үндсэн дээр улс, тив дамнан мөрдөн шалгах бүхий л ажиллагааг явуулах нь үр дүнтэй талаар НҮБ-аас гаргасан зөвлөмжид онцолсон байна.¹²

2003 оны 07 сарын 04-ний өдөр Вена хотноо Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хар тамхи, мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн алба (UNODC)-ын хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт холбогдох албаны хүмүүс гарын үсэг зурсан байна.¹³ Уг санамж бичигт Монгол Улсын мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн нөхцөл байдалд шуурхай үнэлгээ хийх, мансууруулах бодисын эргэлтэд хяналт тогтооход болон “хар тамхи, мансууралтай тэмцэх

¹¹ Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1292>

¹² Legal Framework for Drug Trafficking <https://www.unodc.org/unodc/en/drug-trafficking/legal-framework.html>

¹³ President of Mongolia Visits UNOV, Signs Cooperation Agreement on Drugs and Crime <https://unis.unvienna.org/unis/en/pressrels/2003/vic101.html>

үндэсний хөтөлбөр"-ийг хянаж шинэчлэх, Засгийн газрын холбогдох байгууллага, агентлагуудын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр сургалт явуулах, техник хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэргээр Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхлэх албанаас Монгол Улсын Засгийн газарт туслалцаа дэмжлэг үзүүлэхээр болсон байна.

Олон улсын гэрээгээр зохицуулсан үндсэн асуудал:

Олон улсын дээрх конвенцуудад дараах үндсэн асуудлуудыг тусгасан байдаг.

1. Ямар үйлдлийг гэмт хэрэгт тооцох талаар дэлгэрэнгүй дараах байдлаар заажээ. Үүнд: Мансууруулах эм **тарималжуулах, үйлдвэрлэх, бэлтгэх, гаргаж авах, бэлдэх, эзэмших, санал болгох, худалдахаар санал болгох, түгээх, худалдан авах, худалдах, аливаа нөхцөлөөр хүргүүлэх, зуучлах, илгээх, дамжин өнгөрүүлэн илгээх, тээвэрлэх, импортлох болон экспортлох, түүнчлэн конвенцид харш байж болох аливаа бусад үйлдлийг санаатайгаар үйлдсэн бол шийтгэвэл зохих гэмт хэрэг гэж үзэхээр заасан байдаг.**¹⁴
2. Олон улсын дээрх конвенциудад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын төрлийг ангилан жагсаасан төдийгүй тэдгээрийг ялгаатай болохыг, хатуу хяналт тавих талаар дэлгэрэнгүй тусгасан байна.
3. Дээрх гэмт хэргүүдэд ямар ял оногдуулах талаар заасан. Өөрөөр хэлбэл, тохирох ял шийтгэл, ялангуяа **хорих ял оногдуулах** талаар заасан. Тус зүйлд зааснаар дээрх гэмт хэргийг ноцтой гэмт хэрэгт тооцож, тохирох шийтгэл, тухайлбал хорих буюу эрх чөлөөг нь хасах бусад шийтгэл хүлээлгэх явдлыг хангах арга хэмжээг өөрийн үндсэн хуулийн хязгаарлалтыг харгалзан авна гэсэн байдаг.¹⁵
4. Ял шийтгэлийн оронд эсвэл нэмэлтээр **эмчилгээний арга хэмжээ авах** талаар заасан. Үүнд, мансууруулах эм урвуулан хэрэглэгчдийг **эмчлэх, хүмүүжүүлэх, эмнэлгийн дараахь эмчилгээ хийх, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргүүлэн оруулах** арга хэмжээнд хамааруулах тухай заасан. Улс орнуудад дээрх арга хэмжээг онцгой анхаарч, боломжтой бүх арга хэмжээг авна гэж заасан.¹⁶
5. Гэмт хэрэг үйлдэхэд ашигласан буюу зориулсан аливаа мансууруулах эм, бодис болон тоног төхөөрөмжийг түр хураах болон бүрмөсөн хураах талаар заасан.
6. Гэмт хэрэгтнийг ямар нөхцөлд **шилжүүлэн өгөх боломж болон эрх зүйн туслалцааны** талаар заасан. Түүнчлэн гэмт хэрэгтнийг шилжүүлэн өгөхгүй байх нөхцөлийг тусгасан.
7. Талууд мансууруулах эм урвуулан хэрэглэгчдийг эмчлэх, эмнэлгийн дараахь эмчилгээ хийх, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргүүлэн оруулах боловсон хүчний **сургалтыг** дэмжинэ.¹⁷

Дэлгэрэнгүй авч үзэхэд **нэгдүгээр асуудлын тухайд** Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенцын 3 дугаар зүйлд аливаа улс санаатайгаар үйлдэгдсэн дараахь үйлдлийг дотоодынхоо хуулийн дагуу эрүүгийн гэмт хэрэг гэж тогтоох арга хэмжээ авна гээд а) 1961 оны конвенц, нэмэлт өөрчлөлт оруулсан уг конвенц болон 1971 оны конвенцийн заалтыг зөрчиж аливаа мансууруулах эм, сэтгэцэд

¹⁴ Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц, 36 дугаар зүйл, 1а, <https://legalinfo.mn/mn/detail/1206>

¹⁵ Мөн тэнд.

¹⁶ Мөн тэнд, 38 дугаар зүйл.

¹⁷ Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц, 38 дугаар зүйл, <https://legalinfo.mn/mn/detail/1206>

нөлөөлөх бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх, гаргаж авах, бэлдэх, санал болгох, худалдахаар санал болгох, түгээх, худалдах, ямар ч нөхцөлөөр хамаагүй хүргэх, зуучлах, илгээх, дамжуулан өнгөрүүлж илгээх, тээвэрлэх, экспортлох, импортлох б) 1961 оны конвенц, нэмэлт, өөрчлөлт оруулсан уг конвенцийн заалтыг зөрчиж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг үйлдвэрлэх зорилгоор опиумын намуу, кока бут, каннабис ургамлыг тарималжуулах в) а-д заасан үйл ажиллагааг явуулах зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хадгалах, худалдан авах г) мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг тарималжуулах, үйлдвэрлэх эсхүл бэлтгэхэд зориулагдсаныг мэдсээр байж I хүснэгт, II хүснэгтэд заасан тоног төхөөрөмж, эд зүйлс, бодисыг бэлтгэх, тээвэрлэх, түгээх, д) дээрх бүх хэсгүүдэд заасан гэмт хэргийг удирдах, санхүүжүүлэх, зохион байгуулах гэсэн 5 зүйлийг гэмт хэрэгт тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заажээ.¹⁸

Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенцоор мансууруулах бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх, худалдаалах, импортлох, экспортлох, хуваарилах болон ашиглах явдлыг хязгаарлан, мансууруулах бодисын хууль бус эргэлтийн аливаа хэлбэрт хориглосон. Түүнчлэн конвенцод гэмт хэрэгт тооцохоор нэрлэж тоочсон нийт үйлдлийг Эрүүгийн хуульд тусгасан эсэхийг харьцуулан авч үзвэл, үйлдвэрлэх, санал болгох, худалдахаар санал болгох, түгээх, зуучлах, импортлох болон экспортлох үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор хуульчлаагүй байна. Үйлдвэрлэх үйлдлийн тухайд Зөрчлийн тухай хуульд тусгасан ба доктор Б.Болдбаатар “Эрүүгийн хуульд хууль бус “үйлдвэрлэл”-ийн талаар огт тусгагдаагүй, 2002 оны ЭХ-ийн 193 дугаар зүйлд заасан “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх журам зөрчих” зүйл, ангийг хассан нь хүндрэл учруулж байна. Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэх нь гэмт этгээдүүд ял завших боломжийг олгосон байна”¹⁹ гэж үзжээ.

Хоёрдугаар үндсэн асуудлын хүрээнд, НҮБ-ын 1971 оны Сэтгэцэд нөлөөт бодисын тухай конвенцод мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисыг 1-4 жагсаалтад ангилан хуваасан байх ба 1р жагсаалтад орсон бодисын хувьд засгийн газрын эсвэл түүнээс тусгайлан зөвшөөрсөн анагаах ухааны болон эрдэм шинжилгээний байгууллагуудад зохих ёсоор зөвшөөрөл авсан этгээд эрдэм шинжилгээ, анагаах ухааны маш хязгаарлагдмал зорилгоор хэрэглэхээс бусад тохиолдолд бүх хэрэглээг хориглоно гэсэн нь энэ жагсаалтад багтсан бодис хатуу хяналттайг харуулжээ.²⁰

Түүнчлэн НҮБ-ын 1961 оны Мансууруулах эмийн тухай конвенцын тухайд 1. Тодорхой мансууруулах эмээр хязгаарласан хяналтын арга хэмжээнээс бусад тохиолдолд I жагсаалтад орсон мансууруулах эм нь энэхүү конвенцийн дагуу мансууруулах эмийн хувьд хэрэглэх хяналтын бүх арга хэмжээ, ялангуяа 4 дэх хэсгийн (с) дэд хэсэг, 19, 20, 21, 29, 30, 31, 32, 33, 34, 37 дугаар зүйлд заасан арга хэмжээнд хамрагдана.

2. II жагсаалтад заасан мансууруулах эм нь жижиглэн худалдаалах талаар 30 дугаар зүйлийн 2 болон 5 дахь хэсэгт заасан арга хэмжээнээс бусад I жагсаалтад орсон мансууруулах эмийн адил хяналтын арга хэмжээнд хамрагдана.

3. III жагсаалтад орсноос бусад бэлдмэл нь тэдгээрт орсон мансууруулах эмийн адил хяналтын арга хэмжээнд хамрагдах боловч эдгээр мансууруулах эмийн тооцоо, дүн

¹⁸ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенцын 3 дугаар зүйл. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1239>

¹⁹ Б.Болдбаатар, “Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлтэй тэмцэж буй хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал”, *Хар тамхины гэмт явдал: шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам*” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2018, 15 дахь тал.

²⁰ НҮБ-ын 1971 оны “Сэтгэцэд нөлөөт бодисын тухай” конвенц, 7,8 дугаар зүйл.

бүртгэлээс ялгаатай тооцоо (19 дүгээр зүйл), дүн бүртгэл (20 дугаар зүйл)-ийн ийм бэлдмэлийн хувьд шаардахгүй бөгөөд 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн (с) дэд хэсэг, 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (b) (ii) дэд хэсгийг хэрэглэхгүй.

4. III жагсаалтад заасан бэлдмэлүүд нь II жагсаалтад орсон мансууруулах эм агуулсан бэлдмэлийн адил хяналтын арга хэмжээнд хамрагдана. Харин үүнд 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн (b) дэд хэсэг болон 3-15 дахь хэсэг, түүнчлэн тэдгээрийг олж авах болон жижиглэн худалдаалахын хувьд 34 дүгээр зүйлийн (b) хэсгийг хэрэглэх хэрэггүй бөгөөд шаардлагатай мэдээллийг ийм бэлдмэл бэлтгэхэд хэрэглэсэн мансууруулах эмийн хэмжээгээр тооцоо (19 дүгээр зүйл) болон дүн бүртгэл (20 дугаар зүйл)-ийн зорилгоор хязгаарлана.

5. IV жагсаалтад орсон мансууруулах эмийг I жагсаалтад мөн оруулж тэдгээрт I жагсаалтад орсон мансууруулах эмийн хувьд хэрэглэдгийн адил хяналтын бүх арга хэмжээнд хамруулна.²¹

Дээрх жагсаалт нь өөр өөр заалттайгаас гадна хэрхэн хяналт тавихыг ялгаатай заасан байдаг нь байгалийн болон нийлэгжүүлсэн аргаар гаргаж буй байдал, хүний биед үзүүлэх үйлчлэл, сөрөг нөлөөллийг харуулж буй юм. Гэтэл манай Эрүүгийн хуульд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис гэсэн нэр томъёог ерөнхийлөн хэрэглэхийн зэрэгцээ тухайн бодисын төрөл, шинж чанар, нийгэм, хүний бие махбодид үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүний хэмжээ зэргийг анхааран үзээгүй учир дутагдалтай. Тухайлбал, шүүхийн шийдвэрүүдэд хууль бусаар хадгалсан бодисын нийгэмд үзүүлэх хор хөнөөл, нийгмийн хор уршиг хоорондоо эрс ялгаатай байхад шүүгдэгч нарт ижилхэн 1 жилийн хорих ял оногдуулсан байна. Гэтэл хууль бусаар хадгалсан бодис нь НҮБ-ын 1971 оны “Сэтгэцэд нөлөөт бодисын тухай конвенц”-ын II жагсаалад багтсан метамфетаминийн агууламжтай “мөс” гэх нийлэгжүүлсэн аргаар гаргаж авдаг, хэрэглэсэн хүнд хор хөнөөл ихтэй гэж үзэх бодис байхад хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн байна.²²

Ял оногдуулах, эрүүгийн хариуцлага хүлээлгэх **гуравдугаар асуудлын тухайд** Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенцод аливаа улс нь дээрх буюу 1 дэх хэсгийн дагуу тогтоосон гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тухайн хэргийн ноцтой шинж байдлыг харгалзан хорих, эсхүл бусад хэлбэрээр эрх чөлөөг нь хасах, торгох болон хөрөнгө хураах ял ногдуулахаар зааж болно²³ гэжээ. Түүнчлэн Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенцын 36 дугаар зүйлд шийтгэлийн тухай заахдаа “... энэхүү конвенцийн заалтуудыг зөрчиж мансууруулах эм тарималжуулах, үйлдвэрлэх, бэлтгэх, гаргаж авах, бэлдэх, эзэмших, санал болгох, худалдаагаар санал болгох, түгээх, худалдан авах, худалдах, аливаа нөхцлөөр хүргүүлэх, зуучлах, илгээх, дамжин өнгөрүүлэн илгээх, тээвэрлэх, импортлох болон экспортлох, түүнчлэн тухайн талын үзэж байгаагаар энэхүү конвенцид харш байж болох аливаа бусад үйлдлийг санаатайгаар үйлдсэн бол шийтгэвэл зохих гэмт хэрэг гэж үзэх, мөн ноцтой гэмт хэрэгт тохирох шийтгэл, тухайлбал хорих буюу эрх чөлөөг нь хасах бусад шийтгэл хүлээлгэх явдлыг хангах арга хэмжээг өөрийн үндсэн хуулийн хязгаарлалтыг харгалзан авна.”²⁴ гэсэн

²¹ <https://legalinfo.mn/mn/detail/1206>

²² Г.Янжиндулам, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэхэд хууль тогтоомжийг боловронгуй болгох асуудал, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэхэд байгууллагуудын хамтын ажиллагаа эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, Уб., 2025 он, 133 дахь тал.

²³ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенцын 3 дугаар зүйлийн 4. а хэсэг. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1239>

²⁴ Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенцын 36 дугаар зүйл 1 а хэсэг.

байна. Үүнтэй нэгэн утга бүхий заалтыг Сэтгэцэд нөлөөт бодисын тухай конвенцын 22 дугаар зүйлийн 1а хэсэгт заасан байдаг.²⁵ Эндээс үзэхэд дээрх конвенциудаар хорих буюу эрх чөлөөг нь хасах ялыг оногдуулахыг тохиромжтой байж болох ч тухайн улсын Үндсэн хуульд заасны дагуу ял оногдуулах боломжийг тодорхойлсон.

Түүнчлэн дээрх ялд нэмэлт болгож эмчлэх, хүмүүжүүлэх, эмнэлгийн дараахь эмчилгээ хийх, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргүүлэн оруулах арга хэмжээг хэрэгжүүлэх нь тэднийг шийтгэхийн зэрэгцээ засан хүмүүжүүлэх нь чухал болохыг заасан байна. Учир нь мансууруулах эм урвуулан хэрэглэгч нь нэг талаас өвчтөн байх магадлалтайг онцолж тухайн хүнийг эмчлэх, хүмүүжүүлэх, эмнэлгийн дараахь эмчилгээ хийх, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргүүлэн оруулах талаар онцгой анхаарч, боломжтой бүх арга хэмжээг авах үүргийг улс орнуудад хүлээлгэжээ.²⁶ Энэ нь **дөрөвдүгээр асуудалд** хамаарах ба мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын гэмт хэрэгт холбогдсон этгээдэд зохих ял оногдуулахын зэрэгцээ албадан эмчилгээ хийлгэх арга хэмжээ авахыг заасан заалт юм. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенцын 3 дугаар зүйлийн 4.b хэсэгт гэмт хэрэг үйлдсэн этгээдийн шийтгэл болон ялд нэмэлт болгож түүнийг эмчлэх, хүмүүжүүлэх, эмнэлгийн дараахь эмчилгээ хийх, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргүүлэн оруулах арга хэмжээг хэрэгжүүлэхээр зааж болно гэсэн бол Сэтгэцэд нөлөөт бодисын тухай конвенцод сэтгэцэд нөлөөлөх бодис урвуулан хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, тухайн хүнийг эрт таньж тогтоох, эмчлэх, хүмүүжүүлэх, эмнэлгийн дараахь эмчилгээ хийх, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргүүлэн оруулах талаар боломжтой бүх арга хэмжээг авч, энэ зорилгод хүрэх хүчин чармайлтаа уялдуулан зохицуулна.²⁷ гэж тус тус заасан.

Хар тамхины эмчилгээний талаар дээрх конвенцуудын заалтаас гадна хүний эрхийн үүднээс **“Хүний эрх ба хар тамхины бодлогын олон улсын удирдамж”**-ийн 2-р бүлэгт хүний эрхийн стандартаас үүдэлтэй дэлхийн улсууд хүлээх үүргийг заасан байдаг. Үүнд хар тамхины донтолтын эмчилгээ²⁸-г онцгойлон тусгасан байдаг. Өөрөөр хэлбэл, аливаа улс хар тамхины бодлого явуулахдаа эрүүл мэндийн эрхийг хангах үүднээс сайн дурын үндсэн дээр нотлох баримтад суурилсан хар тамхины донтолтын эмчилгээг багтаана гэжээ.

Үүнд:

1. Хүлээн зөвшөөрөгдсөн хар тамхины эмчилгээ үйлчилгээний боломж, хүртээмжийг хангах, шинжлэх ухааны үндэслэлтэй, эрүүл мэндийн хувьд тохирсон, сайн чанарын (нотлох баримттай, хараат бус хяналттай) эмчилгээг хүргэх, ийм үйлчилгээг төрөөс хангалттай санхүүжүүлэх ёстой бөгөөд тодорхой эмзэг бүлгийн буюу гадуурхагдсан бүлгүүдэд тохиромжтой байхын зэрэгцээ үндсэн эрхүүд болох хувийн нууц, бие махбодийн бүрэн бүтэн байдал, зохих журмын дагуу үйл ажиллагаа явуулах, дур зоргоор баривчлахгүй байх зэрэгт нийцэж, хүний нэр төрийг хүндэтгэх ёстой.

²⁵ Сэтгэцэд нөлөөт бодисын тухай конвенц, 22 дугаар 1 а хэсэг.

²⁶ Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц, 36.1.b дэх хэсэг.

²⁷ Сэтгэцэд нөлөөт бодисын тухай конвенц, 20 дугаар зүйл, Сэтгэцэд нөлөөлөх бодис урвуулан хэрэглэхийн эсрэг арга хэмжээ 22 дугаар зүйлийн 1 b хэсэг.

²⁸ Хүний эрх болон хар тамхины бодлого дахь олон улсын удирдамж, НҮБХХ, ДЭМБ, Хүний эрх ба хар тамхины бодлогын олон улсын төв зэрэг байгууллагуудаас гаргасан. 2019 он

<https://www.undp.org/publications/international-guidelines-human-rights-and-drug-policy>

2. Сайн дурын, мэдээлэлтэй зөвшөөрөл нь аливаа эмчилгээ, урьдчилан сэргийлэх, оношлох арга хэмжээний урьдчилсан нөхцөл бөгөөд зөвхөн хар тамхины хэрэглээ, донтолт нь хэн нэгнийг зөвшөөрөл авахаас татгалзах үндэслэл болохгүй гэдгийг баталгаажуулах.
3. Мансууруулах бодисын туршилт эмчилгээ амжилтгүй болсон зэрэг хөтөлбөрийн дүрмийг дагаж мөрдөхгүй байх нь сахилгын шийтгэл болгон автоматаар албадан халах эсвэл түр хугацаагаар хөөхөд хүргэхгүй байхыг баталгаажуулах.
4. Мансууруулах бодистой холбоотой эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хувь хүний оролцоотой холбоотой бүх мэдээллийн нууцыг хамгаалах. зөвхөн тухайн хүний эрүүл мэндийг сайжруулах зорилгоор ашиглахыг баталгаажуулах.²⁹

Үүний зэрэгцээ ДЭМБ /WHO/ болон UNODC-оос 2020 онд "Мансууруулах бодисын хэрэглээний донтох эмгэгийг эмчлэх олон улсын стандарт 5-ыг³⁰ гаргасан. Уг стандарт нь үндсэн 7 зарчимтай. Үүнд:

1. Эмчилгээ, үйлчилгээ нь нээлттэй, хүртээмжтэй, сонирхол татам, зөв зүйтэй байх;
2. Эмчилгээ үйлчилгээ нь тусламж үйлчилгээний ёс зүйн стандартыг хангах;
3. Эрүүгийн эрх зүйн тогтолцоо, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний хооронд үр дүнтэй зохицуулалт хийсэн эмчилгээ, үйлчилгээ байх;
4. Эмчилгээ нь өвчтөн тус бүрийн үзүүлж буй хариу нөлөө болон шинжлэх ухаанд суурилсан байх;
5. Нийгмийн бүлгүүдийн тусгай эмчилгээ, асрамжийн хэрэгцээг хангах;
6. Мансууруулах бодисын хэрэглээний донтох эмгэгийг эмчлэх эмчилгээ, үйлчилгээ нь эмнэлзүйн сайн засаглалыг хангах
7. Эмчилгээ, үйлчилгээний бодлого, журам нь эмчилгээний нэгдсэн аргыг дэмжих ёстой ба нэмэлт үйлчилгээ нь мониторинг, үнэлгээ хийх. Эмчилгээ, үйлчилгээ нь богино хугацааны, амбулаторийн, урт хугацааны болон хэвтэн эмчлүүлэх гэсэн төрөлтэй. Мөн жирэмсэн эмэгтэйчүүд, төрөх хүүхэд, хүүхэд өсвөр үеийнхэнд чиглэсэн тусгай хөтөлбөртэй байх.

Олон улсын гэрээнүүдэд заасан **тавдугаар асуудал** бол хураан авахтай холбоотой эрх зүйн зохицуулалт юм. Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенцын 37 дугаар зүйлд түр болон бүрмөсөн хураах гэсэн зүйлд 36 дугаар зүйлд дурдсан гэмт хэргүүдийн аль нэгийг үйлдэхэд ашигласан буюу зориулсан аливаа мансууруулах эм, бодис болон тоног төхөөрөмжийг түр хураах болон бүрмөсөн хураана гэж заасан. Харин Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенцын 3 дугаар зүйлд хураах гэсэн тусгай бүлэг байх ба үүнд заахдаа аливаа улс нь хөрөнгийг хураахад шаардлагатай байж болох арга хэмжээ авна гэжээ. Хураах хөрөнгөд гэмт хэргээс олсон орлого, тийм орлоготой тэнцэх үнэтэй хөрөнгө, гэмт хэргийг үйлдэхэд ашигласан эсхүл ямар нэг байдлаар ашиглахад зориулсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис, материал, тоног төхөөрөмж, бусад хэрэгсэл хамаарна гэж заасан байдаг. Түүнчлэн орлого, хөрөнгө, хэрэгсэл болон бусад зүйлийг хураах зорилгоор тодорхойлох, эрэн сурвалжлах, битүүмжлэх, түр хураах эрхийг өөрийн эрх бүхий байгууллагад олгоход шаардлагатай

²⁹ Хүний эрх болон хар тамхины бодлого дахь олон улсын удирдамж, НҮБХХ, ДЭМБ, Хүний эрх ба хар тамхины бодлогын олон улсын төв зэрэг байгууллагуудаас гаргасан. 2019 он, 2р бүлэг, 1-2 дахь хэсэг. <https://www.undp.org/publications/international-guidelines-human-rights-and-drug-policy>

³⁰International standards for the treatment of drug use disorders: revised edition incorporating results of field-testing <https://iris.who.int/handle/10665/331635>

байж болох арга хэмжээг тухайн улс авахыг тодорхойлжээ.³¹ Тус конвенцод хураасан орлого эд хөрөнгө, мөнгөн хуримтлалыг, эсхүл тэдгээрийн томоохон хэсгийг нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг урвуулан хэрэглэх явдал болон тэдгээрийн хууль бус эргэлтийн эсрэг тэмцэх тусгайлсан чиг үүрэг бүхий засгийн газар хоорондын байгууллагуудад шилжүүлэн өгөх болон тухайн улстай байгуулсан хоёр болон олон талт гэрээнд нийцүүлэн бусад талд нэг удаа эсхүл тогтмол шилжүүлэн өгөх тухай заасан байна. Түүнчлэн Сэтгэцэд нөлөөт бодисын тухай конвенцод гэмт хэргийг үйлдэхэд ашигласан, эсхүл зориулагдсан сэтгэцэд нөлөөлөх аливаа бодис, эсхүл өөр бодис, түүнчлэн аливаа тоног төхөөрөмжийг түр хураах буюу бүрмөсөн хураана³² гэсэн эрх зүйн зохицуулалттай байдаг.

Тус конвенцын 6 дугаар зүйлд гэмт этгээдийг шилжүүлэн өгөх талаар заасан олон улсын гэрээнгээр зохицуулагдаж буй **зургаадугаар үндсэн асуудал** юм. Конвенцод заасан гэмт хэрэг бүрийг талуудын хооронд байгуулсан шилжүүлэн өгөх тухай аливаа гэрээнд шилжүүлэн өгвөл зохих хэрэг гэж тусгах гэмт хэрэг гэж үзнэ гэсэн. Хэрэв гэрээний үндсэн дээр шилжүүлэн өгөх нөхцөл шаарддаг тал түүнтэй шилжүүлэн өгөх тухай гэрээ байгуулаагүй нөгөө талаас шилжүүлэн өгөх тухай хүсэлт хүлээж авсан бол энэ зүйлд хамаарах аль ч хэргийн хувьд энэхүү конвенцийг эрх зүйн үндэс хэмээн тооцож болох эрх зүйн зохицуулалтыг тодорхойлжээ. Түүнчлэн тус конвенцийг шилжүүлэн өгөхөд эрх зүйн үндэс болгож хэрэглэхийн тулд үндэсний дотоодын хууль тогтоомжийг батлан гаргах нь зүйтэй болохыг заасан.³³ Шилжүүлэн өгөх ажиллагааг хүсэлт хүлээн авагч талын хууль тогтоомжид заасан нөхцөлийн дагуу, эсхүл шилжүүлэн өгөх тухай гэрээнд заасны дагуу хэрэгжүүлэх бөгөөд үүнд хүсэлт шилжүүлэн өгөхөөс татгалзах хүлээн авагч талын үндэслэлүүд ч мөн хамаарна гэсэн нь шилжүүлэн өгөхийг татгалзах эрх зүйн үндэслэлийг мөн тогтоож өгсөн байна. Гэмт этгээдийг үндэс угсаа, шашин шүтлэг, иргэншил, эсхүл улс төрийн итгэл үнэмшлийг нь харгалзан яллах болон шийтгэхийг хөнгөвчилж эсхүл хүсэлтэд хамаарах аливаа этгээдэд тэдгээр шалтгааны алинаар нь ч хор хохирол учруулж болзошгүй гэж үзэх бодитой үндэслэл байвал уг хүсэлтийг биелүүлэхээс татгалзаж болохыг тухайн конвенцод тусгажээ. Конвенцын тал болсон аливаа улс нь гэмт этгээдийг шилжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, түүний үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор хоёр болон олон талт хэлэлцээр байгуулахыг эрмэлзэх ёстойг чухалчилсан заалт энэ зүйлд мөн тусгажээ. Эцэст нь тус конвенцод мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт хорих болон эрх чөлөөг нь хасах өөр төрлийн ялаар шийтгүүлсэн этгээдийн шийтгэлийн нь үлдсэн хугацааг эх оронд нь эдлүүлэх зорилгоор түүнийг тухайн улсад шилжүүлж өгөх асуудлаар хоёр болон олон талт ерөнхий болон ad hoc хэлэлцээр байгуулах боломжийг хэлэлцэн шийдвэрлэж болох талаар тусгасан байна.³⁴

Сэтгэцэд нөлөөт бодисын тухай конвенцод шилжүүлэн өгөх төлөөр заахдаа 1 дэх хэсэг болон 2 дахь хэсгийн (a)(ii) дэд хэсэгт дурдсан гэмт хэргүүдийг аливаа талуудын хооронд байгуулсан болон үүнээс хойш байгуулах шилжүүлэн өгөх тухай аливаа гэрээнд шилжүүлэн өгвөл зохих гэмт хэрэг гэж тусгаж, гэрээ буюу харилцан адил байх зарчмын үндсэн дээр шилжүүлэн өгөх нөхцөл тавьдаггүй аливаа талуудын хооронд шилжүүлэн

³¹ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ -ын конвенцын 3 дугаар зүйл

³² Сэтгэцэд нөлөөт бодисын тухай НҮБ-ын конвенц, 22 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.

³³ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенцын 6 дугаар зүйлийн 1-3 дахь хэсэг.

³⁴ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенцын 6 дугаар зүйлийн 12 дахь хэсэг.

өгвөл зохих гэмт хэрэг гэж хүлээн зөвшөөрөх нь зүйтэй ч ингэхдээ өргөдөл гаргуулсан талын хуульд нийцүүлэн шилжүүлэн өгөх бөгөөд эрх бүхий байгууллагууд нь уг гэмт хэргийг хангалттай ноцтой бус гэж үзсэн тохиолдолд тухайн тал гэмт этгээдийг баривчлах буюу шилжүүлэн өгөхөөс татгалзах эрхтэй гэсэн байна.³⁵

Эрх зүйн туслалцаа үзүүлэх талаар тус конвенцод заахдаа гэмт хэргийг мөрдөн байцаах, эрүүгийн журмаар мөрдөх, шүүх ажиллагааны явцад эрх зүйн туслалцааг хамгийн өргөн хүрээгээр харилцан үзүүлнэ гэжээ. Эрх зүйн туслалцааг тодорхой этгээдээс нотлох баримт, мэдүүлэг авах, шүүн таслах ажиллагааны материалтай танилцах, нэгжих, хураах ажиллагаа явуулах, эд зүйл болон газар оронд үзлэг хийх, мэдээлэл болон нотолгооны зүйлээр хангах, банк, санхүү, корпораци, бизнесийн баримт бичиг, тэмдэглэл зэрэг холбогдох баримт бичгийн эх хувь болон хуулбарыг авах, нотлох зорилгоор орлого, хөрөнгө, хэрэгсэл, эсхүл бусад эд зүйлийг тодорхойлох, олж илрүүлэх болон бусад төрлөөр үзүүлж болох тухай заасан байна.³⁶

Долоодугаар асуудлын тухайд буюу сургалт, мэдээлэл өгөх асуудлаар Сэтгэцэд нөлөөт бодисын тухай конвенцод сэтгэцэд нөлөөлөх бодис урвуулан хэрэглэгчдийг эмчлэх, эмнэлгийн дараахь эмчилгээ хийх, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргүүлэн оруулах боловсон хүчний сургалтыг бололцооны хэрээр дэмжинэ гэсэн бол Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенцод аливаа улс нь мансууруулах эм урвуулан хэрэглэгчдийг эмчлэх, эмнэлгийн дараахь эмчилгээ хийх, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргүүлэн оруулах боловсон хүчний сургалтыг бололцооны хэрээр дэмжих болон сэтгэцэд нөлөөлөх бодис урвуулан хэрэглэхийн бэрхшээлтэй асуудал, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлыг ойлгохыг ажил нь шаарддаг этгээдүүдэд туслах талаар боломжтой бүх арга хэмжээ авч, мөн мансууруулах эм урвуулан хэрэглэх явдал өргөн дэлгэрэх эрсдэл байгаа бол ийм ойлголтыг олон нийтэд түгээхийг дэмжинэ гэжээ. Энэ нь мансууруулах эм, бодис хэрэглэгчдийг эмчлэх, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргэн оруулах боловсон хүчний сургалт болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ явуулдаг төрийн, ТББ-ын ажилтнуудыг дэмжих, хор хөнөөлийг олон нийтэд түгээхийг дэмжихийг улс орнуудад уриалсан заалт юм.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ОНЦЛОГ

Монгол Улс хар тамхи, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, яллах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг дараах байдлаар бүрдүүлэн ажиллаж байна. Тухайлбал, 2002 онд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль, 2017 онд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж ирсэн. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн зорилт нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршдог.³⁷ Тус хуулийн 2 дугаар бүлэгт

³⁵ Сэтгэцэд нөлөөт бодисын тухай НҮБ-ын конвенц, 22 дугаар зүйл b хэсгийн 1 дэх заалт.

³⁶ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенцын 7 дугаар зүйлийн 1,2,3 дахь хэсэг.

³⁷ Эрүүгийн хууль, 1 дүгээр зүйл, 1.1, 2002 он, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=315>

мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг үйлдвэрлэх, ашиглах, хэрэглэх, Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, хадгалах, устгах мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх түүнчлэн тэдгээрийг үйлдвэрлэх, худалдах тусгай зөвшөөрөл олгох зэрэг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хяналтыг голчлон зохицуулсан бол 3 дугаар бүлэгт урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар болон донтолын эмчилгээний талаар зохицуулжээ.

“Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус хэрэглээтэй тэмцэх үндэсний чадавхийг бэхжүүлнэ³⁸ гэж, түүнчлэн нийгэмд эдгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаархи сургалт, сурталчилгааг эрчимжүүлж, олон улсын хамтын ажиллагааг идэвхжүүлнэ³⁹ гэж тус тус заасан.

Засгийн газрын мөрийн хөтөлбөр (2020-2024)-т мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ⁴⁰ гэсэн заасан бол Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлт, хэрэглээтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хууль бус эргэлттэй тэмцэхэд төрөөс баримтлах бодлого, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, нэгдмэл байдлыг хангах, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой бүхий л үйл ажиллагааг төрийн хяналтад авч, уг үйл ажиллагааг зөвхөн тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлүүлэх, мансуурах донтой хүнд олон улсын стандартад нийцсэн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын тусламж, үйлчилгээ үзүүлэх, мансуурах донг эрт илрүүлэх, эмчлэх, хяналтад авах, нийгэмшүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгоно”⁴¹ гэсэн нь өмнөх мөрийн хөтөлбөрт заасан тэмцэх урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх ерөнхий зорилтын зэрэгцээ төрийн хяналтыг сайжруулах, ТББ, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, олон улсын стандартад нийцсэн эмчилгээ, нийгэмшүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох зэрэг онцлог зохицуулалтуудыг тусгасан нь сайшаалтай байна.

Эрүүгийн хуульд 4 төрлийн гэмт хэргийг, Зөрчлийн тухай хуульд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль зөрчсөн зөрчлийг шийтгэхээр хуульчилсан. Дэлгэрэнгүй авч үзвэл дараах байдалтай байна.

2.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, анхаарах асуудал

Монгол Улсад Эрүүгийн хуулийн 20.7-20.10 дугаар зүйл хүртэл 4 төрлийн гэмт хэрэгт дараах байдлаар ял оногдуулж байна.

1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийг ЭХ-ийн 20.7 дугаар зүйлд хуульчилсан.

³⁸ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010 он, 3.4.4.3 дугаар зүйл.

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=208070&showType=1>

³⁹ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 3.4.4.4

⁴⁰ Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөр, 4.3.4.

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=211219&showType=1>

⁴¹ Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 4.4.1.9, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт,

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141368388631&showType=1>

Энэ төрлийн гэмт хэргийг худалдаалах зорилготой болон зорилгогүйгээр нь хөнгөн ба хүнд гэмт хэргийн ангилалд хамааруулсан ба зорчих эрхийг 1-5 жил хязгаарлах, хорих, 2-8 жил зөвхөн хорих ял шийтгэхээр ялгамжтайгаар хуульчилжээ. Үйлдлийн хувьд хууль бусаар бэлтгэсэн, хадгалсан, бусдад өгсөн, олж авсан, боловсруулсан, тээвэрлэсэн, илгээсэн, худалдсан үйлдлүүдийг хамруулжээ.

Дээрх гэмт хэргийг байнга тогтвортой, улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол 5-12 жил, зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол 12-20 жил, хуулийн этгээд үйлдсэн бол эрх хасаж, торгох ял оногдуулахаар заажээ.

2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангах үйлдлийг тусгайлан Эрүүгийн хуулийн 20.8 дугаар зүйлд гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэх орон байраар хангасан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Хуулийн этгээд үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ гэжээ.

3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 20.9 дүгээр зүйлд хуульчилжээ.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж завшсан бол мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг 2-5 жил хасаж торгох, эсхүл 1-5 жил зорчих эрхийг хязгаарлах, хорих ял шийтгэнэ гэжээ.

4. Мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 20.10 дугаар зүйлд ял шийтгэхээр заасан.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын түүхий эдийг хууль бусаар тариалсан, ургуулсан бол 1-5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, хорих ял шийтгэнэ. Зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол 5-12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Хуулийн этгээд үйлдсэн бол эрх хасаж торгох ял шийтгэнэ.

Монгол Улсын дээрх эрх зүйн зохицуулалтаас үзвэл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний түүхий эдийг худалдаалах болон худалдах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэх, хадгалах, бусдад өгөх, олж авах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангах, хууль бусаар тариалах, ургуулах үйлдлийг гэмт хэрэг тооцдог бөгөөд түүнчлэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж завшсан албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилжээ.

Гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг болон хуулийн этгээд үйлдсэн болон байнга тогтвортой, улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон авч үзэж, оногдуулах ялын хэмжээ нэмэгдэхээр заасан.

Түүнчлэн Зөрчлийн тухай хуулийн Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль зөрчих (6.4 дүгээр зүйл) гэсэн зүйлд хуульд заасан журам зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж заажээ.

Гэмт хэргийн зүйлчлэл

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийг зүйлчлэхэд дараах анхаарах асуудлууд байна.

Гэмт хэргийн үйлдлүүд

Хэрэглэх: Эрүүгийн хуулийн дээрх заалтуудаас харахад мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисыг “хэрэглэх” нь гэмт хэрэгт тооцогдохоор заалт Эрүүгийн хуульд байхгүй байна.

Олж авах: Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг олж авсан гэдэгт түүнийг худалдан авсан, эсхүл ямар нэг үүргийн гүйцэтгэл, үйлчилгээ үзүүлсний төлбөрт, эсхүл өрөндөө тооцож авсан, ямар нэг эд зүйлээр сольж авсан үйлдлийг хамааруулан ойлгохоос гадна гээгдсэн мансууруулах бодисыг олж аван өөрийн болгосон, мөн мансууруулах бодис агуулсан зэрлэг ургамлыг түүж авсан зэрэг үйлдлүүдийг ойлгох бөгөөд түүнийг эзэмшилдээ авч, захиран зарцуулах бодит боломж үүссэн үеэс гэмт хэрэг төгссөнд тооцно.⁴² Харин мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис олж авахаар бусдад мөнгө өгсөн боловч түүнээс үл хамаарах нөхцөл байдлын улмаас авч чадаагүй бол гэмт хэрэг үйлдэхээр завдсан гэж үзнэ.⁴³ Гэмт этгээд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг олж авахын тулд заавал идэвхтэй үйлдэл хийсэн байхыг шаардах ба бусад хүн дэргэд нь хэрэглэж байхад түүнээс авч хэрэглэснийг олж авсан гэж үзэхгүй.⁴⁴

Хадгалах: Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг орон байр, агуулах сав, тээврийн хэрэгсэл, бусад газарт нууц байдалд байлгасныг хэлнэ.⁴⁵ Гэмт этгээд тухайн эм, бодисыг биедээ хууль бусаар авч явсныг хадгалсан бус хууль бусаар олж авсан гэж үзнэ. “Хадгалсан” үйлдэл нь үргэлжилсэн үйлдэлд хамаарах ба гэмт хэрэг илэрснээр төгссөнд тооцно. Ямар хугацаанд хадгалсан нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй.

Бэлтгэх: Мансууруулах үйлчилгээтэй ургамал, эмийн, химийн бодис болон бусад түүхий эдээс нэг буюу хэд хэдэн ширхэг мансууруулах бодис, бэлдмэлийг гар болон үйлдвэрийн аргаар бэлтгэсэн, мөн мансууруулах бодисын агууламжийг нэмэгдүүлэх, мансууруулах үйлчилгээтэй бодисыг ялгаж авах, хэрэглэхэд хялбар болгох зорилгоор түүхий эдийг дахин боловсруулсан санаатай үйлдлийг “бэлтгэсэн” гэдэгт хамааруулан ойлгох бөгөөд мансууруулах үйлчилгээтэй бэлдмэл, бодис бэлтгэх үйлдлийг хийж эхэлснээр уг хэргийг төгссөнд тооцно.⁴⁶

Тээвэрлэх: Эрүүгийн хуулийн 192.2-т заасан мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг “тээвэрлэсэн” гэдэгт бүх төрлийн тээврийн хэрэгсэл ашиглан Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг нэг газраас нөгөө газарт хууль бусаар тээвэрлэсэн санаатай үйлдэл хамаарах боловч дээрх эд зүйлийг явганаар зөөвөрлөсөн үйлдлийг “тээвэрлэсэн” гэх хүндрүүлсэн нөхцөлд хамааруулахгүй.

Бусдад өгөх гэж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг худалдах зорилгогүйгээр бусдад дамжуулсан, бэлэглэсэн, шуудан, илгээмжээр илгээсэн, бусдад хүргүүлсэн, хэрэглүүлсэн байхыг ойлгоно.⁴⁷

⁴² Хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал судалгааны ажлын тайлан, 2016 он

⁴³ Мөн тэнд.

⁴⁴ Б.Энхболд, С.Гантулга, Эрүүгийн эрх зүй тусгай анги, Уб., 2024 он, 286 дахь тал.

⁴⁵ Мөн тэнд, 286 дахь тал.

⁴⁶ Хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал судалгааны ажлын тайлан, 2016 он

⁴⁷ Б.Энхболд, С.Гантулга, Эрүүгийн эрх зүй тусгай анги, Уб., 2024 он, 286 дахь тал.

Эрүүгийн хуулийн дээрх 4 зүйлд заасан гэмт хэргийн объектив талын үйлдлүүдийг олон улсын гэрээнд заасан харьцуулан үзэхэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг үйлдвэрлэх, гаргаж авах, санал болгох, түгээх, хүргэх, зуучлах, дамжуулан өнгөрүүлж илгээх, эспортлох, импортлох үйлдлүүдийг Эрүүгийн хуульд тусгаагүй бөгөөд Зөрчлийн тухай хуулийн 6.4 дүгээр зүйлд үйлдвэрлэх, бэлтгэх, боловсруулах, тээвэрлэх, улсын хилээр нэвтрүүлэх зэргээр заасан зарим үйлдлийг зөрчилд тооцож, ял хөнгөдүүлж байгаагийн зэрэгцээ зарим үйлдлүүд огт тусгагдаагүй нь гэмт этгээд ял завших боломжийг бий болгожээ. Мөн конвенцод заасан худалдаж авах үйлдлийг Эрүүгийн хуульд тусгаагүй нь учир дутагдалтайн зэрэгцээ санхүүгийн үйл ажиллагаа явуулах, үйлдэхээр үгсэн тохиролцох зэрэг үйлдлийг тухайлан дурдсаныг Эрүүгийн хуульд нарийвчлан тусгаагүй ч тухайн гэмт хэрэгт бэлтгэх, худалдах гэсэн гэдэгт хамааруулан ойлгож болох юм гэж үзжээ.⁴⁸

Бодисын хэмжээ, төрөл

Эрүүгийн хуульд зааснаар дээрх төрлийн гэмт хэргийг зүйлчлэхэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэмжээ болон төрөл хамаардаггүй.

2006-2010 онд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэй холбоотой гэмт хэргийн ихэнх хувийг манай оронд ургадаг мансууруулах үйлчилгээтэй олсны ургамлын төрлийн бодистой холбоотой гэмт хэрэг эзэлж байсан бол 2011 оноос химийн аргаар боловсруулсан буюу мансууруулах, сэтгэцэд нөлөөт синтетик бодис, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис агуулаагүй хэдий ч санаатайгаар урвуулан ашиглаж мансуурах боломжтой эмийн хэрэглээ жил бүр өссөн байдаг. 2022 онд эд мөрийн баримтаар хурааж авсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэмжээг өмнөх онтой харьцуулахад каннабис 30 хувиар, гашиш 4,5 дахин, морфин 61,4 хувиар, ДХМ 2,7 дахин тус тус өсчээ. Хураан авсан каннабис ойл 371,7 граммаар, дроп 300 миллилитрээр, тебантин 56 ширхэгээр, ДХМ 25 ширхэгээр нэмэгджээ. Харин мөс 1,299.1 граммаар буюу 7 дахин буурсан байна.⁴⁹

Сүүлийн жилүүдэд лабораторийн аргаар боловсруулсан, олон улсын гэрээнд тусгагдаагүй, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй шинэ төрлийн бодисууд гарсан бөгөөд эдгээрийн нэр, төрөл улам олширч байна. Мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээ ихсэж, бэлтгэгч, худалдан борлуулагч, тээвэрлэгч, зуучлагч, хэрэглэгчийн сүлжээ үүсээд байна. Манай улсын хууль, эрх зүйн орчин бүрхэг, зохицуулалт дутмаг байгаагаас шинэ төрлийн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис олон улсын гэрээнд заасан жагсаалтад байхгүй гэдэг үндэслэлээр гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх боломжгүй нөхцөл байдалтай байна.

Тухайлбал, Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн 2024/ШЦТ/813 дугаар шийтгэх тогтоолоор нэр бүхий 3 шүүгдэгчийг ADB-BUTINACA бодисыг худалдаалах зорилгоор улсын хилээр нэвтрүүлсэн гэж гэм буруутайд тооцон хорих ял оноосон байдаг. Гэтэл уг шийтгэх тогтоолыг Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 2025/ДШМ/132 дугаар магадлалаар хүчингүй болгож, шүүгдэгч нарыг гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр цагаатгасан байна. Энэхүү цагаатгасан үндэслэл нь ADB-BUTINACA бодисыг олон улсын хэмжээнд хяналтад авах тухай шийдвэрийг 2023 оны 3 дугаар сард гаргасан ч тус бодисыг “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц”-ын

⁴⁸ Судалгааны тайлангийн эмхэтгэл XII боть, ХЗҮХ, Уб., 2025, 15 дахь тал.

⁴⁹ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар товч танилцуулга, <https://www.mojha.gov.mn/content/663c3d4d9fea4ca6d5e6d21f>

жагсаалтад албан ёсоор нэмэгдсэн өдрөөс хойш 180 хоногийн дараа хүчин төгөлдөр болно гэсэн заалтын дагуу шүүгдэгч нар уг бодисыг 180 хоногийн хугацаа дуусахаас өмнө улсын хилээр нэвтрүүлсэн тул “хууль бус” гэж үзэх боломжгүй гэж дүгнэсэн байна.⁵⁰

Гэтэл үүнтэй адилхан тохиолдолд буюу 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 2023/ШЦТ/627 дугаар шийтгэх тогтоолоор нэр бүхий 2 шүүгдэгчийг ADB-BUTINACA бодисыг худалдаалах зорилгогүйгээр хууль бусаар хадгалсан гэх үндэслэлээр гэм буруутайд тооцсон байна. Энэ шийтгэх тогтоолыг Давж заалдах шатны шүүх 2023/ДШМ/1133 дугаар магадлалаар хүчингүй болголгүй хэвээр үлдээж шийдвэрлэсэн⁵¹ нь ижил төрлийн бодистой холбоотой хэрэгт олон улсын гэрээний заалтыг өөрөөр хэрэглэсэн, зөрүүтэй байдлыг бий болгосон учир дутагдалтай байна.

Энэ төрлийн хэргийг зүйлчлэхэд шинжээчийн дүгнэлтийг үндэслэхээс гадна мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл бодисын хэмжээг анхаарвал зүйтэй боловч одоогийн хуулиар ийм заалт байхгүй байна. 2002 оны Эрүүгийн хуулийн 192.1 дэх хэсэгт “хэмжээ”-г зааж өгөөгүй тул хүний биед мансууруулах үйлчилгээ үзүүлж чадах тухайн бодисын доод хэмжээнээс “онц их хэмжээ” хүртэлх хэмжээг хамааруулан ойлгох ба “онц их хэмжээтэй” бол хэргийг Эрүүгийн хуулийн 192.3.1-д зааснаар хүндрүүлэн зүйлчилдэг байсан. Эрүүгийн хуулийн 192.3.1-д заасан “Онц их хэмжээ”-г ямар шалгуураар тогтоох, энэ тохиолдолд Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйлд заасан хохирлын хэмжээг шалгуур болгон хэрэглэх боломжтой эсэх нь хуульд тодорхой биш байсан.⁵² НҮБ-ын Хар тамхинд хяналт тавих хорооноос гаргасан зөвлөмжөд тухайн хэрэг, тохиолдол бүрт мансууруулах бодисын хэмжээ, хүнд үзүүлэх үйлчилгээний шинж чанарыг харгалзан хэмжээг тогтоох шаардлагатай гэж үздэг.⁵³ Тухайлбал, гэмт этгээдээс 0.10.3 гр хэмжээтэй гашиш хураан авсан тохиолдолд НҮБ-ын Хар тамхинд хяналт тавих хорооноос гаргасан хүснэгтийг үндэслэн хэргийг шийдэх боломжтой байдаг.⁵⁴

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад хэмжээгээр нь хүндрүүлэн зүйлчлэх эрх зүйн зохицуулалт байхгүй. Тухайлбал, ганцаарчилсан ярилцлагын судалгаагаар ямар төрлийн бодис хэрэглэж байсан бэ гэх асуултад ихэнх нь өвс, мөс, бусад гэсэн хариулт өгсөн ба аль ч төрлийг хэрэглэсэн адилхан ялын санкцтай байдаг гэж хариулжээ. Түүнчлэн эдгээр хэрэглэгчдээс хэрэглээд ямар мэдрэмж төрдөг талаар тодруулахад өвс хэрэглэсэн этгээд тайвшрах мэдрэмж төрдөг бол мөс болон бусад синтетик бодис хэрэглэгч нар цовоо сэргэг болдог, унтах, идэхгүй болох, хэрэглэхгүй бол уур уцаартай, сэтгэл гутранги болдог гэсэн хариултыг өгсөн нь бодисын төрөл нь мансууруулах болон бусад хор хөнөөлийн хувьд ихээхэн ялгаатай нь харагдаж байна.

Гэсэн хэдий ч эдгээр бодисын төрөл, хэмжээг ялгахгүйгээр зүйлчилж байгаа нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.3 дугаар зүйлд заасан “Эрүүгийн хариуцлага нь

⁵⁰ Б.Ариунтөр, Нэгдэн орсон олон улсын гэрээнүүдийн хэрэгжилтийн асуудал: Монгол Улс дахь мансууруулах бодистой холбогдох эрх зүйн зохицуулалтын мэдээллийн хоцрогдол, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэхэд байгууллагуудын хамтын ажиллагаа эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, Уб., 2025 он, 16 дахь тал.

⁵¹ Б.Ариунтөр, Нэгдэн орсон олон улсын гэрээнүүдийн хэрэгжилтийн асуудал: Монгол Улс дахь мансууруулах бодистой холбогдох эрх зүйн зохицуулалтын мэдээллийн хоцрогдол, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэхэд байгууллагуудын хамтын ажиллагаа эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, Уб., 2025 он, 16 дахь тал.

⁵² Хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал судалгааны ажлын тайлан, 2016 он

⁵³ Legal Framework for Drug Trafficking <https://www.unodc.org/unodc/en/drug-trafficking/legal-framework.html>

⁵⁴ Хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал судалгааны ажлын тайлан, 2016 он

тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна” гэсэн шударга ёсны зарчмын үзэл санаатай нийцэхгүй байгааг хуульчид шүүмжилж⁵⁵ байгаатай бид санал нэгтэй байна.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцод мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисуудыг хооронд нь ангилан, жагсааж байгаа шалтгаан нь байгалийн болон нийлэгжүүлсэн аргаар гаргаж буй байдал, хүний биед үзүүлэх үйлчлэл, сөрөг нөлөөлөл зэргээс хамааралтайг илэрхийлж буй хэрэг болохыг дээр дурдсан билээ.

Гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенцын 3.5-д заасан тодорхой нөхцөлүүдийг гэмт хэргийг үйлдэхэд нөлөөлсөн хүндрүүлэх нөхцөл байдал гэж үзнэ. Өөрөөр хэлбэл шүүхээс ял оноохдоо өөрийн харьяалагддаг болон олон улсын зохион байгуулалттай гэмт бүлгийн үйлдсэн гэмт хэрэгт оролцсон, тухайн гэмт хэрэг үйлдсэний улмаас хууль бус бусад үйл ажиллагаанд оролцсон, гэмт этгээд хүч, эсхүл галт зэвсэг хэрэглэсэн, гэмт этгээд албан тушаалтан бөгөөд гэмт хэрэг нь албан тушаалтай нь холбоотой, гэмт хэргийг үйлдэхэд насанд хүрээгүй хүнийг татан оруулсан, ашигласан, гэмт хэргийг хорих ял эдлүүлэх газар, сургууль, олон нийтийн үйлчилгээний газар, эсхүл сурагч, оюутны сургалт, олон нийтийн үйл ажиллагаа явуулдаг газарт үйлдсэн, дотоодын хуулиар хуульчилсан хэмжээнд гадаад улсад болон эх орондоо урьд нь ял шийтгэгдсэн, ялангуяа ижил төрлийн гэмт хэрэгт шийтгэгдсэн нөхцөл байдал байвал ял хүндрүүлнэ гэсэн байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлд хүндрүүлэх бүрэлдэхүүнийг хуульчлахдаа 1. худалдаалах зорилгоор 2. байнга, тогтвортой, улсын хилээр нэвтрүүлж, 3. гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн, 4. гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хүндрүүлэхээр заасан.

Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлагын талаар Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлд заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах, 20.10 дугаар зүйлд заасан мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол тодорхой төхлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж, торгох ял шийтгэн хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх зохицуулалт Эрүүгийн хуульд тусгажээ.

- Эрүүгийн хуулийн дээрх 4 зүйлд заасан гэмт хэргүүдэд байнга тогтвортой, улсын хилээр нэвтрүүлж, зохион байгуулалттайгаар үйлдсэн бол хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр зүйлчлэхээр заасан байна.

Гэмт этгээд өөрийн харьяалагддаг зохион байгуулалттай гэмт бүлгийн үйлдсэн гэмт хэрэгт оролцсон гэснийг Эрүүгийн хуулийн 3.8 дугаар зүйлийн 3.8.3-т “Зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүнийг зохион байгуулалттай гэмт бүлэгт элссэн үйлдэлд ба өөрийнх нь үйлдсэн гэмт хэрэгт ял оногдуулна.” гэж, Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн 20.7.4-т хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон мөн тусгасан байна. Харин тус конвенцын b, d, f, g, h-д гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдлыг дэлгэрэнгүй тусгасан боловч Эрүүгийн хуульд эдгээр зохицуулалтыг орхигдуулсан байна. Мөн конвенцын e) хэсэгт гэмт этгээд албан тушаалтан бөгөөд тухайн гэмт хэрэг нь түүний албан тушаалтай

⁵⁵ Г.Янжиндулам, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэй тэмцэхэд хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудал, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэй тэмцэхэд байгууллагуудын хамтын ажиллагаа эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, Уб., 2025 он, 130 дахь тал.

холбоотой байхаар заасан. Энэхүү холбоо нь ихэвчлэн албан тушаалын эрх мэдлийг урвуулан ашиглах, эсвэл нөлөөллийн хэлбэрээр явагдах боловч конвенцын бичвэрт уг холбооны тодорхой хэлбэрийг заагаагүй болно.²⁵ Өөрөөр хэлбэл, энэ нь гэмт этгээд албан тушаалтан бөгөөд тухайн гэмт хэрэгт түүний албан тушаалын чиг үүрэг ямар нэгэн байдлаар холбоотой байхаар өргөн хүрээнд хамруулж ойлгохоор тусгасан. Харин Эрүүгийн хуулийн 20.9 дүгээр зүйлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж завшсан үйлдлээр хуульчилснаар тухайн гэмт хэргийн зөвхөн нэг шинжийг хуульчилсан гэж үзэхэд хүргэж байна. Эрүүгийн хуулийн тус заалт нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгт тусгай субъектийг эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан зохицуулалт хэдий ч хүрээг нь хязгаарласан зохицуулалт болжээ.

2.2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн нөхцөл байдлыг тодруулахдаа цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тоон мэдээг харьцуулан дүн шинжилгээ хийх замаар гүйцэтгэлээ. Ингэснээр тус гэмт хэргийн процессын үйл ажиллагаанд дүгнэлт хийх, гэмт хэргийн ялын бодлогыг тодорхойлоход үр нөлөөтэй гэж үзсэн юм.

2.2.1. Цагдаагийн байгууллагын тоон мэдээ

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн гаралт (2020-2024)⁵⁶

Хүснэгт 1

Нутаг дэвсгэр	2020	2021	2022	2023	2024
Нийслэл	178	145	204	204	206
Орон нутаг	24	42	25	34	48
Улсын хэмжээнд	202	187	229	238	254

Хүйсийн байдлыг авч үзвэл 2022 онд 238 хүний 25 нь, 2023 онд 220 хүний 28 нь 2024 онд 221 хүн яллагдагчаар татагдсаны 27 буюу 12.2 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь дунджаар үзэхэд 10 гаруй хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Насны байдлыг авч үзэхэд 18-24 насны хүн 32.2 хувь, 25-29 насны хүн 27.7 хувийг буюу 18-29 насныхан нийт гэмт хэргийн 60 орчим хувийг буюу дийлэнх хувийг эзэлж байгаа⁵⁷ нь энэ төрлийн гэмт хэргийг залуучууд үйлдэж байгааг харуулж байна.

Эрүүгийн хуулийн 20.8 дугаар зүйлд заасан гэмт хэрэг 2022, 2023 онд байхгүй, 2024 онд 2 хэрэг, 20.9 дугаар зүйлд заасан Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших гэмт хэрэг 2022 онд 1, 2023, 2024 онд цагдаагийн байгууллагад бүртгэгдээгүй байна.⁵⁸

Түүнчлэн Зөрчлийн тухай хуулиар 2024 онд 244 зөрчил бүртгэгдэн 212 нь шийдвэрлэгдсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй шийтгэлийг нь харьцуулахад захиргааны

⁵⁶ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2023, Уб., 2024 он, 244 дэх тал.

⁵⁷ Мөн тэнд. 246 дахь тал.

⁵⁸ ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газрын тоон мэдээ. 2025.7.05

журмаар баривчилсан хүний тоо 9 нэгжээр, сургалтад хамруулсан /насанд хүрээгүй хүн/ 2 нэгжээр тус тус өссөн байна. Шийтгэврээр торгосон хүн 28 нэгжээр торгуулийн хэмжээ 4,290,000 төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 1



Шийдвэрлэлт	2024 он эхний хагас жил	2025 он эхний хагас жил	Нийт
Захиргааны журмаар баривчилсан	63	72	135
Шийтгэврээр торгосон	8	36	44
Сургалтад хамруулсан /насанд хүрээгүй хүн/	7	9	16
Нийт	78	117	195

2.2.2. Прокурорын байгууллагын тоон мэдээ

Эрүүгийн хуулийн 20.7-20.10 дугаар зүйлд заасан гэмт хэргийн тоон мэдээг УЕПГ-аас дараах байдлаар гаргажээ.⁵⁹

Хүснэгт 2

№	Эрүүгийн хуулийн зүйл	Он	ЭХҮЯТатсан хэрэг	Хэрэгсэхгүй болгосон	Нэгтгэсэн	Шүүхэд шилжүүлсэн	Түдгэл з
1	ЭХ-20.7	2022	196	1	16	189	2
		2023	225	-	20	199	8
		2024	279	1	50	186	7
2	ЭХ-20.8	2022	2			2	
		2023	1		1		
		2024	1	1			
3	ЭХ-20.9	2022	1	1			
		2023	-	-	-	-	

⁵⁹ УЕПГ-ын Бодлого төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар, 2025.07.20

		2024	1		1		
4	ЭХ-20.10	2022	-	-	-	-	
		2023	-	-	-	-	
		2024	-	-	-	-	
	Нийт						

Прокурорын байгууллагын тоон мэдээг дүгнэж үзэхэд 2022-2024 онд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тоо жил бүр өссөн бөгөөд хэрэгсэхгүй болгох тохиолдол маш цөөн бөгөөд шүүхэд шилжүүлсэн хувь 2022 онд 96%, 2023 онд 88%, 2024 онд 66% болж буурсан үзүүлэлттэй байна.

2.2.3. Шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоон мэдээ (ШЕЗ)⁶⁰

Хүснэгт 3

Он	ЭХ-ийн зүйл	Шийдвэрлэсэн хэргийн тоо	Ял шийтгүүлсэн хүн	Ялын төрлөөр			
				Торгох	Нийтэд тустай ажил	Зорчих эрхийг хязгаарлах	Хорих ял
2022	20.7	177	241	-	-	70	171
	20.8	1	1	-	-	1	-
	20.9	1		1	-	-	-
	20.10	-	-	-	-	-	-
2023	20.7	176	195	-	-	68	127
	20.8	-	-	-	-	-	-
	20.9	-	-	-	-	-	-
	20.10	-	-	-	-	-	-
2024	20.7	177	237	-	5	76	156
	20.8	-	-	-	-	-	-
	20.9	-	-	-	-	-	-
	20.10	-	-	-	-	-	-
	Нийт	532	675	1	5	215	454

Эрүүгийн хуулийн 20.7-20.10 дугаар зүйлд заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн тоон мэдээнд дүн шинжилгээ хийхэд Эрүүгийн хуулийн 20.7 буюу Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг нийт шийдвэрлэсэн хэргийн 99.6 хувийг эзэлж байна. Үлдсэн 3 зүйл нь 2022-2024 оны байдлаар 2 гэмт хэрэг шийдвэрлэсэн байна.


Ял оногдуулж буй байдлыг авч үзвэл торгох ялаар 1, нийтэд тустай ажил хийлгэх ял 5, зорчих эрхийг хязгаарлах ял 215 байгаа бол хорих ялыг хамгийн түгээмэл буюу 454 байгаа нь нийт оногдуулсан ялын 67 хувийг хорих ял эзэлж байна.

Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн 1-4 дэх хэсэгт заахдаа "...нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл

⁶⁰ Эрүүгийн хуулийн 20.7, 20.8, 20.9, 20.10 дугаар зүйл ангид холбогдох гэмт хэргийг эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн тоон мэдээлэл (2022-2024), ШЕЗ-ийн 2025 оны 6 дугаар сарын 28-ны 03/1108 дугаар албан бичгийн хавсралт.

хугацаагаар хорих ял шийтгэнэ.”, “...хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”, “...таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”, “...арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.” гэсэн нь хорихоос өөр төрлийн альтернатив ялын төрөл хомс зөвхөн хорих ял оногдуулахаар эрх зүйн зохицуулалттай байна. Түүнчлэн 20.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ гэсэн заалттай хэдий ч 2022-2024 онд дээрх гэмт хэргийг хуулийн этгээд үйлдэж шийтгэгдсэн тохиолдол байхгүй байна.

Гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдийн насны байдлыг авч үзэхэд дийлэнх хувийг буюу 47 хувийг (317 хүн) 22-29 насныхан эзэлж байгаа бол 30-34 насныхан 152 хүн буюу 23 хувийг эзэлж байна. Энэ нь **22-34 насныхан** нийт гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн хүний 70 хувийг эзэлж байгаа нь ⁶¹ мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийг үйлдэж байгаа этгээд залуучууд байгааг харуулж байна. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг боловсролын байдлаар ангилж үзэхэд бүрэн дунд боловсролтой 372, дээд буюу бакалавр 174 гэсэн нь хамгийн өндөр хувийг эзэлж байгаа бол суурь боловсролтой 74, тусгай мэргэжлийн 32 байна.⁶² Нийт ял шийтгүүлсэн 286 хүнийг эрхэлсэн ажлаар нь авч үзэхэд ажилгүй 252 хүн, оюутан 60, аж ахуйн нэгжийн албан тушаалтан 58, төрийн албан хаагч 9, сурагч 5 гэсэн тоон мэдээ байна.



2.2.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тоон мэдээ

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэгт

⁶¹ Эрүүгийн хуулийн 20.7, 20.8, 20.9, 20.10 дугаар зүйл ангид холбогдох гэмт хэргийг эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн тоон мэдээлэл (2022-2024), ШЕЗ-ийн 2025 оны 6 дугаар сарын 28-ны 03/1108 дугаар албан бичгийн хавсралт.

⁶² Мөн тэнд.

шийтгүүлсэн хоригдлын тоо 2025 оны 6 дугаар сарын 25-ны байдлаар 151 байгаа⁶³ бөгөөд нийт 22 ангид хорих ял эдэлж байна. Эдгээр 151 хоригдлын 107 нь давтан, 44 нь анх удаа ял эдэлж байгаа хоригдол байна.

2022-2024 онд Эрүүгийн хуулийн 20.7-20.10 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт ШШГБ-д ял эдэлж буй байдалд дүн шинжилгээ хийвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 4

№	он	Нийт хоригдол	Анх удаа	Давтан	Хорихоос өөр төрөл
1	2022 ⁶⁴	79
2	2023	130	45	85	90
3	2024	151	44	107	76

20.7 дугаар зүйлд заасан гэмт хэргийг ангилж үзвэл 20.7-1 дэх хэсэгт заасан хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг худалдаалах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, хадгалсан, бусдад өгсөн, олж авсан зүйлээр 123 хоригдол, 20.7-2 дахь хэсэг буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг худалдаалах зорилгоор хууль бусаар олж авсан, бэлтгэсэн, боловсруулсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, худалдсан гэмт хэрэгт 48 хоригдол, 20.7-3 дахь хэсэг буюу байнга тогтвортой, улсын хилээр нэвтрүүлсэн 11 хоригдол ял эдэлж байна.

Дээрх тоон мэдээнээс үзэхэд 2023 онд хорих ял эдэлж буй этгээдийн 65.3%, 2024 онд 71% нь давтан гэмт хэрэг үйлдэж хорих ял эдэлсэн байгаа нь хорих ял үр нөлөө муутайг харуулж байна.

2.3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, нөлөөлж буй хүчин зүйл

Монгол Улс дахь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн гаралт 2016-2024 онд өмнөх жилүүдээс 2-3 дахин өсөж, 2019-2024 онд 58 насанд хүрээгүй хүн энэ төрлийн гэмт хэрэгт холбогдсон байна.⁶⁵

Зөрчлийн тухай хуулийн 5.1.3-т заасан мансуурсан гэх үндэслэлээр 2024 онд нийт 306 зөрчлийн хэрэгт 284 хүнд хэрэг үүсгэж, 225 хүнийг баривчилж, 44 хүн торгосон 15 насанд хүрээгүй хүнийг сургалтад хамруулсан нь өмнөх оныхтой харьцуулахад зөрчлийн хэрэг 7.7, холбогдсон хүний тоо 24.5 хувиар өссөн байна.⁶⁶ Эдгээр тоон мэдээ нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлийн тоо Монгол Улсын хэмжээ жил бүр өсөн нэмэгдэж, түүнд холбогдогчдын нас залуужиж, насанд хүрээгүй хүний холбогдох байдал нэмэгдсээр буйг харуулж байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хэрэглээ манай улсад өсөн нэмэгдэж байгаа нь хүний эрүүл мэнд болон улс орны үндэсний аюулгүй байдал,

⁶³ ШШГЕГ-ын Хорих ял эдлүүлэх албаны Нэгдсэн тоо бүртгэлийн хэлтсийн дүн мэдээ, 2025.06.25-ны 02-01/1960 тоот албан бичгийн хавсралт

⁶⁴ ШШГЕГ-ын тоон мэдээнээс гаргах боломжгүй гэсэн хариу өгсөн.

⁶⁵ П.Сандагсүрэн, Б.Зоригтбаатар, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал, тулгамдсан асуудал, илтгэлээс, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэхэд байгууллагуудын хамтын ажиллагаа сэдэвт ЭШХ-ын эмхэтгэл, Уб., 2025 он.

⁶⁶ Мөн тэнд.

нийгэм, эдийн засаг, соёлын үндэс, тогтвортой байдалд ноцтой аюул занал учруулж, үр дагавар нь тооцоолохын аргагүй нөхцөл байдалд хүргэж болзошгүйг анхаарах шаардлагатай байна.⁶⁷

1990-ээд оны үед Монгол Улс нь дамжин өнгөрүүлэгч орноор нэрлэгдэж, тухайн үед гэмт хэргийн гаралт маш бага байсан бол одоо хэрэглэгч орноор тооцогдож, хэрэглэгч, донтогчдын тоо нэмэгдэж, эрэлт нийлүүлэлт нэмэгдсэн. Түүнчлэн 2020 оноос хойш хэрэглэгч орны зэрэгцээ үйлдвэрлэгч орон болох эрсдэл рүү шилжиж байна гэж зарим мэргэжилтнүүд үзэж байна. Тухайлбал, ахуйн хүрээнд өвсний ургамлыг газтай хольж, шавар, гашиш бодисыг гар аргаар гарган авч ашигласан хэргүүд бүртгэгдэж эхэлсэн нь цаашид манай улс нь олон улсад үйлдвэрлэгч орон руу шилжих эрсдэл бий болгожээ.⁶⁸

Нийлүүлэлт нэмэгдэж байгаа шалтгаан нөхцөлийг дараах хүчин зүйлстэй холбоотой гэж үзэж байна.

- Мансууруулах үйлчилгээтэй олсны ургамлын тархац-хяналт,
- Энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулж байгаа ялын бодлого сул,
- Гэмт этгээдүүд давтан гэмт хэрэг үйлдэх,
- Мөрдөн шалгах ажиллагаанаас оргон зайлах,
- Шинэ төрлийн мансууруулах бодисын эргэлт нэмэгдэх,
- Гэмт этгээдүүдийн хялбар аргаар мөнгө олох шунахай сэдэл,
- Хил гаалийн хяналт сул зэрэгтэй холбоотой гэжээ.⁶⁹

Судалгаанд дурдсанаас үзвэл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг анх хэрэглэх, донтох болсон шалтгааныг гэмт хэрэг үйлдсэн этгээдээс тодруулахад “бусдад уруу татагдаж, сонирхсон, хөгжим гоё сонсогддог, тайвширдаг, онгод ордог, эсхүл өвчнөө намдаах зорилгоор олж авч хэрэглэсэн” гэх тайлбарыг өгсөн⁷⁰ бол өөр судалгаанд ихэнх хувь нь сониуч зан бусдыг даган дуурайх, чөлөөт цаг ихтэйгээс, хор уршиг, ойлголт мэдлэггүйгээс, түүнчлэн буруу эх сурвалжаас мэдээлэл авсан, найз нөхөд танилын хүрээллээс нөлөөлж гэх зэргээр хариулсан байна.⁷¹

Энэхүү судалгааны ажлын хүрээнд хийгдсэн чанарын судалгаа нь ганцаарчилсан ярилцлагын аргаар хийгдсэн ба нийслэлийн хэмжээний 5 хорих анги (407, 409, 421, 441, СХТБ)-д судалгааг явуулсан. Хорих ангид ял эдэлж байгаа 43 хоригдлоос авсан ганцаарчилсан ярилцлагын асуулт нь ерөнхий мэдээлэл, гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан нөхцлийг тодруулах, хэр удаан хэрэглэсэн, донтогч эсэх, үзүүлсэн сөрөг нөлөө, ханган нийлүүлэлт, зохион байгуулалт, ялын үр нөлөө, нийгэмшүүлэх үйл явц, ухамсарын түвшин, цаашдын хандлага, сэтгэл зүйн болон нийгмийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд анхаарах зүйлс зэргийг тодруулахаар зорьсон юм.

17-44 насны 43 хоригдлын 7 эм, 36 эрэгтэй, 17 дээд боловсролтой, 17 бүрэн дунд,

⁶⁷ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар товч танилцуулга, <https://www.mojha.gov.mn/content/663c3d4d9fea4ca6d5e6d21f>

⁶⁸ П.Сандагсүрэн, Б.Зоригтбаатар, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал, тулгамдсан асуудал, илтгэлээс, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэхэд байгууллагуудын хамтын ажиллагаа сэдэвт ЭШХ-ын эмхэтгэл, Уб., 2025 он.

⁶⁹ Мөн тэнд.

⁷⁰ Хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал судалгааны ажлын тайлан, уб., 2016 он.

⁷¹ П.Сандагсүрэн, Б.Зоригтбаатар, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал, тулгамдсан асуудал, илтгэлээс, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэхэд байгууллагуудын хамтын ажиллагаа сэдэвт ЭШХ-ын эмхэтгэл, Уб., 2025 он.

бүрэн бус дунд 5, тусгай дунд 3, суурь 1 гэсэн боловсролын түвшинтэй байсан юм. Анх хар тамхи хэрэглэсэн нас нь 15-18 нас, 18-25 насны хооронд байх нь түгээмэл бөгөөд хэрэглэх болсон шалтгаан, хүчин зүйл гэсэн асуултад сонирхол гэж -17, найз, нөхдийн хүрээллээс болж-12, сэтгэл гутрал-2, цахим тоглоом тоглох гэж-3, хип хоп хөгжмийн нөлөөлөл-2, турах гэж-2 гэсэн түгээмэл шалтгааныг нэрлэсэн бол худалдан борлуулсан болон хил давуулсан гэмт этгээдийн тухайд амар аргаар мөнгө олох гэсэн шалтгааныг ихэнхдээ хариулжээ.

Ганцаарчилсан ярилцлагын судалгааны нэг зорилго нь анх юунаас болж энэ гэмт хэрэгт холбогдсоныг тодруулах явдал юм. Нийт судалгаанд оролцсон 35 хоригдлын 15 хувь нь мөн найз нөхдийн амнаас сонсоод сонирхож үзэх өөрийн хүслээр гэж хариулсан байна.

Ямар төрлийн мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн, хамааралтай болсон тухай асуултад мөс гэж 16, өвс 9, аль алиныг 7, бусад төрөл (drop, TG9, morphine) 5, бүх төрөл 4 хүн хариулсан бөгөөд аль алиныг хэрэглэдэг этгээдийн тухайд эхэндээ өвс, сүүлдээ мөс гэж хариулсан бол бүх төрлийг хэрэглэдэг этгээдийн хувьд 10-аас дээш жил хэрэглэж байгаа хүмүүсийн хувьд байна.

Анх мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэхэд нөлөөлсөн хүн хэн болох талаар асуултад найз нөхөд гэж 85 хувь нь хариулсан ба мөн хэрэглэх үедээ найз нөхдийн хамт гэж хариулсан нь түгээмэл байна. Судалгаанд оролцсон хүмүүсийн хариултаас харахад эхний шатанд байгаа буюу хэт донтолтонд ороогүй хэрэглэгчдийн хувьд найз нөхдийн хамт хэрэглэх нь түгээмэл бол олон жил хэрэглэсэн, гүн донтолттой этгээдийн хувьд ганцаараа хэрэглэдэг гэж хариулах байдал ажиглагдаж байна.

Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай болж, байнгын хэрэглэх нь эдийн засагт нь хэрхэн нөлөөлж буйг тодруулахад 68 хувь нь сөргөөр нөлөөлдөг байсан гэж хариулжээ. Судалгаанд оролцогч *“Маш сөрөг нөлөөтэй мөнгө олоо тэрийгээ зарцуулчихна, гэр бүлээ алдсан, хэн донтогчтой амьдрах вэ, хүнийг хайрлахаа мартдаг юм билээ.”* гэж хариулсан байна.

2.4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгт оногдуулсан эрүүгийн хариуцлага, түүний үр нөлөө

Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд заахдаа эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна гэжээ. Монгол Улсад гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсэн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино гэж заасан.

Тэгвэл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэхийн зэрэгцээ тэдгээр хүмүүсийг нийгэмшүүлэх нь нэн чухал зорилго юм.

Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлд заасан гэмт хэргүүдэд нэгдүгээрт хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг худалдаалах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, хадгалсан, бусдад өгсөн, олж авсан гэмт хэрэг үйлдсэн бол 1-5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсвэл 1-5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэдэг эрх зүйн зохицуулалттай. Хоёрдугаарт худалдах зорилгоор дээрх гэмт хэргийг үйлдсэн бол өөр ялын төрөлгүй зөвхөн 2-8 жилийн

хугацаагаар хорих ял шийтгэнэ гэсэн бол гуравдугаарт байнга тогтвортой эсвэл улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол 5-12 жилийн хугацаагаар хорих ял шийтгэнэ гэсэн заалттай.

2022-2024 онд шүүхээс 20.7.1-т заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан ялын байдлыг авч үзэхэд 2022 онд 179 хэргийн 241 хүний 171-т, 2023 онд 176 хэргийн 195 хүний 127, 2024 онд 177 хэргийн 237 хүний 156-д хорих ял шийтгэж үлдсэн хувь нь зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэгджээ. Хувиар авч үзэхэд 2022 онд 70 хувь, 2023 онд 65 хувь, 2024 онд 66 хувьд хорих ял оногдуулж сүүлийн 3 жилийн байдлаар 67.5 хувьд хорих ял 32.5 хувьд зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулжээ. Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн дөрөв дэх хэсэгт заасан дээрх гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн шүүхээр шийдвэрлэсэн тохиолдол сүүлийн 3 жилд байхгүй байна.

Дээрх байдлаас дүгнэвэл Монгол Улсын эрүүгийн эрх зүйн зохицуулалт нь ялын бодлогын тухайд хорих ялд төвлөрсөн бөгөөд оногдуулах санкцыг хорих ял, зорчих эрхийг хязгаарлах ялын хүрээнд хуульчлагджээ. Эрх зүйн зохицуулалтын хүрээнд шүүхээс хорих ялыг 67 хувьтайгаар оногдуулж байгаагаас энэ нь нотлогдож байна.

Хорих ялын хугацаа 6 сараас 12 жилийн хооронд байгаа бөгөөд Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 1-5 жилийн ял оногдуулж байна. Гэтэл эдгээр ял эдэлж байгаа этгээдийг хорих ялын үр нөлөөг тооцохоор давтан гэмт хэргийн хувийг гаргаж үзэхэд 2024 онд 70 хувь буюу 151 хоригдлын 107 нь давтан, 2023 онд 130 хоригдлын 80 нь буюу 61 хувь давтан тус гэмт хэрэгт холбогдож ял эдэлж байна.⁷²

Давтан ял эдэлж буй хоригдлын тоо ийм өндөр хувьтай байгаа нь хорих ялын үр нөлөө маш муу байгааг нотолж буй хэрэг бөгөөд донтолттой хоригдолд ямар ч эмчилгээ хийхгүйгээр хорих нь олон удаа шоронд хоригдох нөхцөлийг үүсгэж хорих ангийн ачаалал, хоригдлын тоог нэмэгдүүлж байна. Хорих ял оногдуулах хувь ихээхэн өндөр, эмчилгээний арга хэмжээ авдаггүй Монгол Улсын ялын бодлогын тогтолцоо нь өвчтөн бус-гэмт хэрэгтэн гэж үзэх хандлага зонхилсон, эмчлэх бус цээрлүүлэх ёстой гэсэн зарчмын хүрээнд хэрэгжиж байгааг харуулж байна. Энэ бодлого нь ялыг үр нөлөөгүй болгохын зэрэгцээ донтох өвчтэй эдгээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарал бүхий этгээдүүдийг нийгэмших боломжгүйд хүргэж байгаа муу талтай байна.

Гэтэл Япон улсад цээрлүүлэх бус эмчлэн эдгээх бодлогыг амжилттай хэрэгжүүлж, хорих ялаас аль болох татгалзах өөрөөр хэлбэл, хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах замаар хорих ялын зэрэгцээгээр эмчилгээнд хамруулах, эсвэл хорих ялыг хэсэгчлэн түдгэлзүүлэх, зан үйлийн эмчилгээ болон хар тамхины шалгалт хийх, өөртөө туслах бүлгүүдтэй холбох зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна. Хуулийн тус шинэчлэлтийн хүрээнд өмнө нь бүх цагийг хорих ангид өнгөрүүлдэг байсан хоригдлын хорих ялын зарим хэсгийг тэнсэж, тэнссэн хугацаанд туршилтаар танин мэдэхүйн зан үйлийн эмчилгээ, хар тамхины шалгалт хийх, өөртөө туслах бүлгүүдтэй холбох зэрэг нийгэмшүүлэх төрөл бүрийн арга хэмжээнд хамруулдаг болсон нь өндөр үр дүнгээ өгсөн гэж үзэж байна.

Ялын үр нөлөөг тодруулах ганцаарчилсан ярилцлагын үр дүн

Бидний хийсэн ганцаарчилсан судалгааны нэг зорилго нь ялын үр нөлөөг тодруулах явдал юм. Эдгээр 43 хоригдолд оногдуулсан ялын хувьд 20.7.1-т зааснаар 1-2 жил хорих ял авсан нь хамгийн бага бол 20.7.3-т зааснаар хил дамнуулан оруулж ирсэн гэмт хэрэгт 12 жилийн хорих ялтай гэсэн ялын байдалтай байна. Нийт хоригдлын 44 хувь нь тухайн гэмт хэргийг давтан үйлдсэн төлөвтэй байна. ШШГБ-ын тоон мэдээнээс үзэхэд 2023 онд хорих ял эдэлж буй этгээдийн 65.3%, 2024 онд 71% нь давтан гэмт хэрэг үйлдэж хорих ял эдэлж

⁷² ШШГЕГ-ын Нэгдсэн тоо бүртгэлийн хэлтсийн "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэгт шийтгүүлсэн хоригдлын тоо" дүн мэдээ, 2025 он

байгааг дээр өгүүлсэн.

Хорих ялын үр нөлөөг тодруулах зорилгоор асуусан хорих ял эдлээд ямар үр нөлөө үзүүлж байгааг тодруулахад үр нөлөөтэй гэж 30 хүн, үр нөлөөгүй 8 хүн, эерэг сөрөг 2 талаар нөлөөлж байна гэж 5 хүн хариулжээ. Үр нөлөөгүй гэж хариулсан нь энд ороод засраагүй харин ч хүрээллээ нэмэгдүүлсэн, эмчилгээ байхгүй болохоор хэрэглэхгүй байгаа ч тархинаас гарахгүй байгаа, хорихоос өөр төрлийн ял авахыг хүсч байсан зэргээр хариулсан бол “донтолтоос гарч байна”, “эергээр нөлөөлж байна, бие эрхтэн маань цэвэршсэн, бүх муу зүйлийг ардаа үлдээж урагшилж байна”, “галзуурах дөхсөн дотор хүн орчихсон юм шиг 2 туйлт эмгэгтэй болсон байсан, хорихын эмнэлэгт хэвтээд эдгэрсэн”, “гэр бүлээ хайрлахгүй худлаа ярьдаг байсан одоо сэтгэхүй өөр болсон”, “больчих юм сан гэж их боддог байсан, чадахгүй хэрэглээд дараа нь их харамсдаг, эмчлүүлээд хэрэглэхгүй болохыг хүсч байна”, “үр нөлөөтэй хорих ял аваагүй бол бүүр дордох байсан” зэргээр дийлэнх нь эерэг үр нөлөөтэй байгааг дурдсан бөгөөд гэхдээ эмчилгээ ялангуяа сэтгэл зүйн эмчилгээ хэрэгтэй байгааг судалгаанд оролцогчдын 90 хувь нь хариулсан.

Хамгийн олон жил хэрэглэсэн хүн нь 12 жилийн турш өдөр бүр хэрэглэж байсан бөгөөд хорих ангид ирээд хэрэглэхгүй 6 сар болох хугацаанд 56 кг жинтэй байснаас 75 кг болж, эмчилгээнд 2 удаа орж хий юм харахаа болисон гэж ярилцлаганд дурджээ. Судалгаанд оролцогчдын өгсөн саналд хорих ялаас илүүтэй сэтгэл зүйн болон бие махбодийн эмчилгээг үр дүнтэй талаар маш их дурдагджээ. Тухайлбал, судалгаанд оролцогч “Зорчих эрхээ хязгаарлуулсан байхдаа хэрэглэсээр байсан, энд хэрэглэж болохгүй нь сайн боловч нэг нэгнээсээ туршилага судлах гараад уруу татагдах магадлал өндөр. Гол нь эмчилгээтэй болоосой гэж боддог учир нь хэрэглэж байсан тэр мэдрэмж тархинаас гардаггүй.” гэж хариулжээ.

Албадлагын арга хэмжээ оногдуулах болон эмчилгээ

Манай улсын Эрүүгийн хуулийн 7.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 (үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ), 7.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2 (зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах), мөн зүйлийн 3 дахь хэсгийн 3.3 (согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох)-г зааснаар зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэх, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох хязгаарлалт тогтоох албадлагын арга хэмжээг авах талаар заасан. Түүнчлэн ЭХ-ийн 6.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт согтуурсан, мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн хүн согтуурах, мансуурах донтох эмгэгтэй болох нь тогтоогдвол түүнд оногдуулсан ял дээр нэмж энэ хуулийн 7.4 дүгээр зүйлд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэж болно гэжээ. Үүнд: Эрүүгийн хуулийн 6.4 дүгээр зүйлийн 9 дэх хэсэгт “шүүх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл, согтуурах, мансуурах донтой байдлыг харгалзан сэтгэл заслын, донтох зуршлын эсрэг эмчилгээ хийлгэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулж болно”⁷³ гэсэн нь 20.7 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд донтох зуршлын эсрэг эмчилгээ хийлгэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авч болох суурь эрх зүйн зохицуулалт юм.

Гэсэн хэдий ч шүүхээс ял оногдуулж буй байдлыг үзэхэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэхгүй байна. 2025 онд (1-6 дугаар сар) ЭХ-ийн 20.7.1 дэх

⁷³ Эрүүгийн хууль, 7.4 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг.

хэсэгт зааснаар ял оногдуулсан шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж үзэхэд ЭХ-ийн 7.4 дүгээр зүйлийн 9 дэх хэсэгт зааснаар эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авсан тохиолдол байхгүй байна. Учир нь шүүхээс эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан, гэмт хэрэг үйлдсэний дараа хэрэг хариуцах чадваргүй болсон нөхцөлд шүүхээс эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргана гэсэн заалтын дагуу эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэг хариуцах чадваргүй, сэтгэцийн өвчтэй хүнд оногдуулах явцуу утгаар хэрэглэж байна.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ буюу Эрүүгийн хуулийн 6.4 дүгээр зүйлийн 9 дэх хэсэгт зааснаар мансуурах донтой байдлыг харгалзан сэтгэл заслын, донтох зуршлын эсрэг эмчилгээ хийлгэх эрх зүйн зохицуулалтыг манай улсад огт оногдуулж, энэ төрлийн эмчилгээ хийхгүй байгаа явдал нь дээр дурдсан олон улсын гэрээний заалтыг хэрэгжүүлэхгүй байгааг харуулж байна. Энэ нь мансууруулах донтой этгээдийг эмчлэх бус цээрлүүлэх зарчмын хүрээнд ялын бодлого Монгол Улсад хэрэгжиж буйг илтгэж байгаагийн зэрэгцээ донтох өвчтэй гэмт хэрэгтнүүдийг дахин гэмт хэрэг үйлдэхэд хүргэж, нийгэмших боломжийг олгохгүй байна. Түүнчлэн Эрүүгийн хуулиас гадна Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 12 дугаар зүйлд мансууруулах донтой нь эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон боловч эмчлүүлэхээс зайлсхийсэн этгээдийг шүүхийн шийдвэрээр албадан эмчилнэ мөн мансуурах донтой этгээд сайн дураараа эмчлүүлэх хүсэлт гаргавал ердийн журмаар эмчилнэ гэсэн заалт байдаг.

Тус хуулийн зэрэгцээ “Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль”-ийг 2018 онд шинэчлэн найруулж, согтуурах, мансуурах донтой болох нь эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон этгээдийг сайн дураар эмчлүүлэхээс татгалзсан бол шүүхийн шийдвэрээр албадан эмчлэхээр заасан.⁷⁴ Хуульд заахдаа албадан эмчлэх төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг байх ба тус эмнэлэг нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяанд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээр заасан. Гэтэл Монгол Улсад мансуурах донтой этгээдийг албадан эмчилдэг эмнэлэг тус хуульд зааснаар байгуулагдаагүй нь өнөөг хүртэл тус хуулийн заалт хэрэгжихгүй байгааг харуулж байна. Одоогийн байдлаар СЭМҮТ албадан эмчилгээг биш, сайн дураар ирсэн мансуурах донтой хүнд эмчилгээ хийж байгаа бөгөөд сайн дураараа эмчилгээнд хамрагдах нь бага байдгийг тус төвийн мэргэжилтнүүд үздэг. Учир нь мансууруулах бодис хэрэглэдэг хүн СЭМҮТ-д хандахад мэргэжилтнүүд төрийн албан хаагчийн хувьд цагдаагийн байгууллагатай хамтарч ажиллаж, ямар хүн мансууруулах бодис борлуулж байгаа, ямар хүмүүстэй нийлдэг хүрээллийн талаарх мэдээллийг судлаад цагдаад мэдээлдэг, ингэснээр хар тамхины сүлжээг илрүүлэхэд хамтран ажилладаг байна.⁷⁵ Энэ нь тэднийг сайн дураар эмчлүүлэхээс татгалзах гол шалтгаан болдог талаар манай ганцаарчилсан ярилцлагын судалгаанд оролцсон хоригдлын ярилцлагаас мөн илэрсэн юм. Иймд Эрүүгийн хуулиар хорих ял оногдуулахын зэрэгцээ эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ буюу мансууруулах донтой хүнийг албадан эмчлэх арга хэмжээг давхар оногдуулах, түүнчлэн Зөрчлийн тухай хуулиар шийтгэл оногдуулахдаа шүүхээс мансуурах

⁷⁴ Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль, 2018, 3.1 дүгээр зүйл.

⁷⁵ Судалгааны тайлангийн эмхэтгэл XXII боть, ХЗҮХ, УБ., 2025 он, 51 дэх тал.

донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх гаргах эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх шаардлагатай гэж дүгнэлээ.

Бусад улс оронд яллахад суурилсан ялын бодлогоос татгалзаж, эмчилгээнд төвлөрсөн төрийн бодлого баримтлах болсныг Япон улсын туршлагаас харж болох юм. Тус улсад 1951 онд Сэргээх төрлийн бодистой эм, бэлдмэлүүдийг хянах тухай хуулиар худалдан борлуулах, хууль бусаар хэрэглэхийг бүрэн хориглосон ч хууль батлагдсаны дараа мансууруулах бодис хэрэглэж баривчлагдсан хүний тоо эрс нэмэгдэж 55000-д хүрчээ. Энэ нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэж, хорих ялаар шийтгэх болсонтой хамаатай гэж үздэг бөгөөд эдгээр хүмүүст хүний эрхийг хязгаарлах бодлого үр дүнгээ үзүүлээгүй нь нотлогдож, эмчилгээ үйлчилгээнд хамруулж эдгэрүүлэх арга замыг хайхад хүргэсэн юм.⁷⁶ Учир нь мансууруулах бодисын хамааралтай хүмүүсийн хорих зардалд 1 жилд 30000 доллар зарцуулж байгаа ч үр дүнгүй байсан нь тогтоогдсон тул төрөөс нийгмийн халамжид суурилсан донтох эмгэгийн сэргээх үйл ажиллагааг илүүтэй дэмжиж эхэлсэн. Тус улсын Засгийн газраас 2019 онд донтох эмгэгийн нөхөн сэргээх төвөөр үйлчлүүлсэн хүмүүсийн эмчилгээний үр дүнг тодорхойлох судалгааг 2 жилийн хугацаанд явуулахад 2 жилийн нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдсан хүмүүсийн 80 хувь нь эдгэрэлтийн түвшинд орсон дүн гарсан байна.⁷⁷

Донтох эмгэгийн нөхөн сэргээх төвийн үйлчилгээ нь орон байраар хангах, сэтгэц заслын эмчилгээ үйлчилгээнд хамруулах, амьдрах ухааны зөв дадалд сургах, хөдөлмөр эрхлэлтэд дэмжлэг үзүүлэх зэргээс бүрдэнэ. Эдгээр нөхөн сэргээх төвүүд нь улсын төсвөөс санхүүжүүлэх хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Харин Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 01 /нэг/ жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан тусгай ангийн 27.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2 дахь заалтад зааснаар тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг 03 жилийн хугацаагаар хасаж, 01 /нэг/ жилийн хугацаагаар хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох хязгаарлалт тогтоох арга хэмжээ, сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэх арга хэмжээг авахаар заасан нь бусдаас онцлог шийдвэр бүхий шүүхийн шийдвэр байна.⁷⁸

Нийгэмшүүлэх үйлчилгээний талаарх ганцаарчилсан ярилцлагын үр дүн

Нийгэмшүүлэх зорилгын тухайд дараах байдлаар ганцаарчилсан ярилцлагын судалгааны үр дүн гарсан байна. Хорих ангид нийгэмшүүлэх үйл ажиллагааны үр нөлөөний талаар асуултад хорих ангид ажил хийдэг, сургалтад хамрагддаг гэсэн ерөнхий байдлаар хариулсан хэдий ч мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын донтогч, хэрэглэгчийн хувьд зориулсан тусгайлсан нийгэмшүүлэх үйл ажиллагаа огт байдаггүй гэж хариулсан. Үүнээс үзэхэд хорих ангид энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хүнд зориулсан эмчилгээ, нийгэмшүүлэх буюу нийгэмд эргэн нэгтгэхэд чиглэсэн тусгай хөтөлбөр Монгол

⁷⁶ Мөн тэнд.

⁷⁷ Такехито Ичикава, Ёокояма Жуничи, "Мансууруулах бодисын хэрэглээтэй тэмцэж ирсэн Япон улсын түүх, төрөөс баримталж ирсэн болдлого, гээд ХЗҮХ-ийн судалгааны боть, 54 дэх тал.

⁷⁸ Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн Шийтгэх тогтоол, Дугаар 2025/ШЦТ/1269, 2025 оны 05 сарын 09 өдөр,

https://shuukh.mn/single_case/119916?daterange=2025-01-01%20-%202025-07-01&id=1&court_cat=2&bb=1

Улсад хэрэгжихгүй байгааг харуулж байна. Энэ нь тухайн хорих ял эдэлсэн этгээд дахин гэмт хэрэг үйлдэж давтан хоригдож байгаа тоон мэдээгээр мөн батлагдаж байгаа юм. Монгол Улсад хорих ангид төдийгүй нийгэмд эргэн гараад хамрагдах сэтгэл зүйн тусгай эмчилгээ бүхий төв, эмнэлэг ховор байгаа эдгээр төрлийн гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн засрал хүмүүжилд сөргөөр нөлөөлж байгаа талаар судалгаанд оролцогчид дурдсан юм. Судалгаанд оролцогчид хэлэхдээ “Өмнө нь гадна байхдаа төлбөртэйгээр сэтгэл зүйн үйлчилгээ авч үзсэн, тэр сэтгэл зүйч нэмэр болоогүй, мэргэжлийн хүн хэрэгтэй. Надад тийм хүн олдоогүй.”, “Хорих ангиас сэтгэл зүйн үйлчилгээ авч үзээгүй, гадна байхдаа Мондем эмнэлгийн эмчилгээнд хамрагдаад үр дүнтэй байсан. Бүлгийн уулзалтанд эдгэрсэн хүмүүс ирж туршилагаа ярилцдаг нь их чухал байсан. Би нэг жил гаран хэрэглэхгүй гарсан байсан. Гэхдээ хүрээлэлтэйгээ тааралдаад дахиад орчихсондоо маш их харамсдаг.”, “Хор тайлах эмнэлгийн үйлчилгээнд 2 удаа хамрагдсан, гэхдээ сэтгэл зүйн үйлчилгээ бол аваагүй. Хорих ангид сэтгэл зүйчтэй ярилцах боломжтой гэхдээ энэ надад нөлөөлөхгүй байгаа.” зэргээр судалгааны “Сэтгэл зүйн үйлчилгээ авч байсан уу” гэсэн асуултад хариулжээ.

Суллагдаад дахин хэрэглэх эсэх талаар асуултад 98 хувь дахин хэрэглэхгүй гэсэн бол 2 хувь нь эргэлзээтэй байгаагаа илэрхийлжээ. Хэдийгээр тэд суллагдаад дахин хэрэглэхгүй чин хүсэлтэй байгаа ч давтан энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж ял эдэлж байгаа этгээдийн тоо өндөр хувьтай байгаа нь тэдний хүсэл эрмэлзлээс гадна өөр олон хүчин зүйлүүд дахин хэрэглэхэд нөлөөж байгааг харуулж байна. Судалгаанд оролцогчдын өөр нэг хариулсан зүйл нь суллагдсаны дараа хүрээлэлтэйгээ дахин уулзахгүй, бусдын нөлөөнд автахгүй байхыг чухалчилсан төдийгүй хорих ангид танилцсан хар тамхины хэрэгт холбоотой хүмүүстэй хүрээллээ нэмэгдүүлээд суллагддаг гэсэн сөрөг үр нөлөөтэй нь судалгаагаар илэрч байна.

ГУРАВ. МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР ГАДААДЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

3.1. Дэлхийн орнуудын хар тамхины өнөөгийн нөхцөл байдал

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, хяналт тавих системийг бүрдүүлэх талаар анх 1909 онд Шанхай хотноо Опиумын Комисс хуралдсан нь олон улсын гэрээ байгуулах эхлэл тавигдсан. Олон улсын хүрээнд мансууруулах бодист хяналт тавих стратегийн бодлого нь эртний түүхтэй. 1909 онд дэлхийн түүхэнд анх удаа 13 орон оролцсон, хар тамхины олон улсын комиссын зөвлөгөөн болсон бөгөөд 1912 онд Гааг хотноо зохиогдсон хар тамхины талаарх олон улсын бага хурлаас эмийн зүйлд хяналт тавих тухай олон улсын гэрээ байгуулагдсан болно.⁷⁹

НҮБ-ын ивээл дор 81 улс оролцон “Мансууруулах эмийн тухай Нэгдсэн конвенц”⁸⁰-ийг 1961 оны 3 дугаар сарын 25-ны өдөр баталж, 1964 оны 12 дугаар сарын 13-ны өдөр хүчин төгөлдөр болсон, 1972 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн протоколоор нэмэлт өөрчлөлт оруулж уг протокол нь 1975 оны 8 дугаар сарын 8-ны өдөр хүчин төгөлдөр

⁷⁹This day in history: The Shanghai Opium Commission, 1909 <https://www.unodc.org/unodc/en/frontpage/this-day-in-history-the-shanghai-opium-commission-1909.html>

⁸⁰Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц <https://legalinfo.mn/mn/detail/1206>

болсон. Уг конвенц нь мансуурал үүсгэх чадвартай бодисууд ба опиуд, каннабиноид ба кокаиньг хууль бусаар үйлдвэрлэх, дамлах худалдаалах, хууль бусаар ашиглах зэрэг 51 заалт бүхий олон улсын эрх зүйн тулгуур баримт бичиг болж, мансууруулах бодис агуулсан ургамлыг тарималжуулахыг хязгаарлаж, хяналт тавих системийг бий болгожээ.

Энэ цаг үеэс хойш олон улсын хэмжээнд мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тогтолцоо бүрэлдэн бий болох нөхцөл бүрэлдсэн бөгөөд өнөөдрийн байдлаар дараах олон улсын байгууллагууд хяналт тавих, тэмцэх арга хэмжээг зохион байгуулж байна. Үүнд:

А. Хар тамхитай тэмцэх НҮБ-ын комисс;

Б. Хар тамхины асуудал хариуцсан НҮБ-ын хэлтэс;

В. Хар тамхийг хортойгоор хэрэглэх явдалтай хийх тэмцлийг санхүүжүүлэх НҮБ-ын фон;

Г. Хар тамхинд хяналт тавих олон улсын хороо;

Д. Дэлхийн эрүүл мэндийн хороо;

Е. Интерпол;

Е. Дэлхийн гаалийн байгууллага;

Ж. Засгийн газрын бус байгууллага

Гадаадын улсуудад мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөт бодисын асуудалд хандах хоёр эсрэг тэсрэг байр суурь байна.⁸¹ Үүнд:

1) Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын эргэлттэй үл эвлэрч, эрс шийдэмгий тэмцэх;

2) Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын нөлөөлөл, үйлчлэлээр нь хөнгөн ба хүнд чанараар нь ангилж, хөнгөнийг нь зөвшөөрч ил болгох, хатууг нь эрс хориглож байгаа юм.

2013 оноос Уругвай улсад мариуханыг хэрэглэх хадгалахыг бүрэн зөвшөөрч, харин Нидерланд, Канад, Чех, Португал, АНУ, Испани, Израйл улсуудад зарим эргэлтийг зөвшөөрчээ. Жишээ нь: Амстердам хотод "хөнгөн" гэгдэх мансууруулах бодисыг цагдаагийн байгууллагаас хүлээн зөвшөөрч, "хүнд" гэж тооцогдох мансууруулах бодисыг тараасан тохиолдолд хариуцлага ногдуулж байна.⁸² Мөн бага хэмжээний мансууруулах бодис тараах нүүдлийн станц ажиллуулах замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байна. Нидерланд улсад мөн энэ чиглэлийн арга хэмжээ авч "кофейн" гэж нэрлэгдэх сүлжээгээр "хөнгөн" гэгдэх мансууруулах бодисыг тараах арга хэмжээ авч байна.⁸³ АНУ-д мариуханыг хувь хүн тусгай дэлгүүрээс худалдан авч, гэрийн нөхцөлд хэрэглэхийг зөвшөөрчээ. Коноплийг хуульчилсан явдал нь нэг талаас тухайн "өвс"-нд дурлагчдыг 28 хувь дэвэргэж байгаа боловч, нөгөө талаас чанаргүй бодисоос хордож үхэх явдлыг хоёр дахин буурсан үзүүлэлт гарчээ. Мөн наркобизнесетэй (контрабанд, хууль бус худалдаа) холбоотой гэмт явдлын түвшин 30 хувь буурчээ.⁸⁴

БНХАУ-ын Эрүүгийн хуульд Хар тамхи, мансууруулах бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх, тээвэрлэх, боловсруулах, худалдаалах гэмт хэргийн санкци нь хар тамхи, мансууруулах бодисын нэр төрөл, хэмжээнээс шалтгаалдаг.⁸⁵ Тухайлбал: 1000

⁸¹ Theories on drug abuse <https://archives.drugabuse.gov/sites/default/files/monograph30pdf>

⁸² Additional investments in fight against international drug trafficking <https://www.government.nl/topics/drugs>

⁸³ Additional investments in fight against international drug trafficking <https://www.xn--government-bna10g.nl/topics/drugs/news/2022/03/15/additional-investments-in-fight-against-international-drug-trafficking>

⁸⁴ Preventing Drug Abuse: What do we know? <https://www.ncbi.nlm.nih.gov/books/NBK234579/>

⁸⁵ Anti-Drug Law of the People's States Republic of China <http://www.npc.gov.cn/npc/index.html>

гр-аас багагүй хэмжээний опиум, 50 гр—аас багагүй героин, металинин, болон бусад төрлийн мансууруулах бодис их хэмжээгээр худалдаалсан, тээвэрлэсэн, улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн, бэлтгэсэн, энэхүү гэмт хэргийг өмнө нь ял эдэлж саатуулагдсан хүн үйлдсэн, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт бүлэглэл бол 15 жил, бүх насаар нь хорих, эсхүл цаазаар авч, эд хөрөнгө хураах Харин 200-1000 гр опиум, 10-50 гр героин, метиланилин болон бусад төрлийн хар тамхи, мансууруулах бодисын хууль бусаар тээвэрлэсэн, худалдаалсан, бэлтгэсэн, улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бол 7 жилээс доошгүй хугацаагаар, дээрх дурдсан хэмжээнээс бага хэмжээгээр тээвэрлэсэн, орон нутаг, муж, холбооны засгийн газрууд санхүүжүүлдэг.

АНУ-д 14500 гаруй төрөлжсөн байгууллагууд мансууруулах бодисын хамааралтай хүмүүст зөвлөгөө, зан үйлийн эмчилгээ, эм тариа зэрэг бусад төрлийн үйлчилгээ үзүүлдэг. Үйлчилгээ үзүүлэгчдийн гуравны хоёр орчим нь ашгийн бус байгууллагууд байдаг ба засгийн газрын буцалтгүй тусламж, хандивлагчдын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаа явуулдаг байна. Донтолтын нөхөн сэргээх төв нь зөвлөгч, эмч, сэтгэцийн эмч, сэтгэл зүйч, сувилагч, нийгмийн ажилтан зэрэг олон төрлийн мэргэжилтэн багаар ажилладаг байна.

Дэлхийн ихэнх улс орнуудад мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэй хатуу тэмцэх бодлого баримталж байна. Мансууруулах бодистой холбоотой гэмт хэргүүдэд оноох цаазын ялыг халах дэлхийн хөдөлгөөнийг олон улс орон дэмжиж буй хэдий ч сүүлийн жилүүдэд хар тамхитай холбоотой гэмт хэрэгт цаазын ял гүйцэтгэсэн хүний тоо нэмэгдсэн байна. Хар тамхитай холбоотой гэмт хэрэгт оноосон цаазын ялын тоо нь дэлхий дахинд гүйцэтгэсэн нийт цаазын ялын 40 гаруй хувийг эзэлж байгаа бөгөөд эдгээр цаазын ялын ихэнх нь Ази тивд явагддаг. Одоогийн байдлаар дэлхий даяар 58 улс цаазын ялтай байгаа ба тэдгээрээс 35 улс (БНХАУ, Индонез, Иран, Малайз, БНАСУ, Арабын нэгдсэн Эмират улс, Сингапур, Витнам, Бахрейны хаант улс, Бангладеш, Египт, Ирак, Кувейт, Лао, Пакистан, Бүгд Найрамдах Ардчилсан нийгэм журамт Шри-Ланка Улс, Тайланд, Саудын Араб, Йемен, Брунае Даруссалам, Оманы Султант улс, Куба, Энэтхэг, Жордан, Мавритани, Мьянмар, Катар, Өмнөд Солонгос, Өмнөд Судан, Судан, Тайвань, АНУ, Ливи, Палестин улс (Газ), Сири улс) хар тамхины гэмт хэрэгт цаазын ял оногдуулах зохицуулалттай⁸⁶ бөгөөд үүнээс “цаазын ялыг өндөр хэмжээнд хэрэглэдэг” гэж тодорхойлсон 9 улс (БНХАУ, Индонези, Иран, Кувейт, Малайз, БНАСУ, Саудын Араб, Сингапур, Вьетнам) нь бүгд **Ази тивд** байрладаг.⁸⁷

НҮБ-ын мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас гаргасан мэдээлэлд дэлхий дээр 2023 онд 316 сая хүн хар тамхи хэрэглэж байгаа нь 2022 он (292 сая)-той харьцуулахад 24 саяаар өссөн байна. Эдгээр нь каннабис хэрэглэдэг 244 сая хүн, Амфетаминь төрлийн сэргээх үйлчилгээтэй бодис хэрэглэгч 30.7 сая хүн, Экстази хэрэглэж байгаа 21 сая хүн, Опиум хэрэглэж байгаа 61 сая хүн, Кокайн 25 сая хүн хэрэглэж байгаа тухай тус тус бүртгэгдсэн байна.⁸⁸ Каннабис хамгийн өргөн хэрэглэгддэг хэвээр

⁸⁶ The death penalty for drug offences: Global overview 2024 <https://hri.global/flagship-research/death-penalty/the-death-penalty-for-drug-offences-global-overview-2024/>

⁸⁷ Death Penalty for Drug Offenders in Southeast Asia: Weakening of Resistance to Change? <https://www.crimejusticejournal.com/article/view/3681>

⁸⁸ UNODC World Drug Report 2024: Harms of world drug problem continue to mount amid expansions in drug use and markets <https://www.unodc.org/lpo-brazil/en/frontpage/2024/06/unodc-world-drug-report-2024-harms-of-world-drug-problem-continue-to-mount-amid-expansions-in-drug-use-and-markets.html>

байгаа бол опиоид, амфетамин, кокаин, экстази зэрэг бодисуудын хэрэглээ бүгд өсчээ. Монгол улсад дээр дурдагдсан мансууруулах төрлийн бодисуудаас геройноос бусад төрлийн бодис хэрэглэгдэж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд мансууруулах бодис хэрэглэгчдийн тоо өссөөр байгааг Хар тамхи, мансуурлаас иргэдийг хамгаалах нийгэмлэгээс болон бусад төрийн, төрийн бус байгууллагууд анхааруулсаар байгаа билээ.⁸⁹

Кокаины үйлдвэрлэл Латин Америкт тэсрэлттэйгээр өсөж, хэрэглээ болон зах зээл нь Европ, Африк, Ази тивд хурдацтай тэлж байна. Мөн синтетик мансууруулах бодисууд олон хүний амь нас, эрүүл мэнд, орон нутгийн нийгэмд ноцтой хор уршиг үзүүлж байна. Тухайлбал, метамфетамины тэвэрлэлт Өмнөд-Баруун Ази, Ойрх Дорнод, Дундад Дорнод болон Зүүн Өмнөд Европт өсөж байгаа бол Хойд Америкт фентанилын хэтрүүлэн хэрэглээ нас баралтыг нэмэгдүүлж байна. Үүний зэрэгцээ, Афганистаны де-факто эрх баригчдын гаргасан хар тамхи (опиум)-ны хориг нь тариаланчдын амьжиргаа, орлогод ноцтой нөлөөлж байгаа тул тогтвортой хүмүүнлэгийн хариу арга хэмжээ шаардлагатай байна.

НҮБ-ын Хар тамхитай тэмцэх газрын “Дэлхийн мансууруулах бодисын тайлан”-д дараах тусгай бүлгүүд багтсан болно:⁹⁰

- Афганистаны хар тамхины хоригийн нөлөөлөл,
- Эмэгтэйчүүдийн дунд синтетик мансууруулах бодисын хэрэглээ өндөр байгаа асуудал ба тэдний эмчилгээ, тусламж үйлчилгээ авах боломжийн хязгаарлагдмал байдал,
- “Алтан гурвалжин” дахь хар тамхины тэвэрлэлт ба зохион байгуулалттай гэмт хэргийн шалтгаан нөхцөл,
- Каннабис болон психоделик бодисуудтай холбоотой эрх зүйн зохицуулалт, нөлөөлөл.

Түүнчлэн тус тайланд “Эрүүл мэндийн эрх ба хар тамхины хэрэглээ” гэсэн бүлэг багтсан бөгөөд энэ нь уг эрхийг хэрхэн хангах талаар хэлэлцүүлэг өрнүүлэх суурь болохоос гадна цаашдын ахиц дэвшлийг үнэлэх суурь мэдээлэл болж чадна гэж үзсэн байна. Дэлхийн хар тамхины асуудлын улмаас хэт олон хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хар тамхи хэрэглэсэн гэх үндэслэлээр гадуурхагдаж, ялгаварлан гадуурхалтад өртөж, эрүүл мэндийн үндсэн эрхээ эдэлж чадахгүй байгаа нь ноцтой асуудал юм. Эрүүл мэндийн эрх нь бүх хүнд адил тэгш хамаатай бөгөөд хар тамхи хэрэглэдэг хүмүүс ч энэ эрхийг эдлэх ёстой. Үүнд чанартай, сайн дурын, үр дүнтэй, ялгаварлалгүйгээр хүртээмжтэй эмчилгээ, асаргаа, үйлчилгээ үзүүлэх ёстой бөгөөд хүний нэр төрийг хамгаалсан байх шаардлагатай гэж үзэж байна.

Олон улсад хар тамхитай тэмцэх арга хэмжээнд эрүүл мэндийн арга хэмжээг нэн тэргүүнд тавихын зэрэгцээ хар тамхины хууль бус зах зээлд илүү зорилтот, стратегийн, шүүхийн арга хэмжээнүүд шаардлагатай гэж үзэж байна. Хамгийн сүүлийн үеийн мэдээллээр 7 сая хүн хар тамхитай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн улмаас хууль хяналтын байгууллагатай холбоотой болсон ч тэдгээрийн гуравны хоёр нь зөвхөн хэрэглээ болон хэрэглээнд зориулагдсан хадгалалттай холбоотой байсан байна. Түүнчлэн хар тамхины эдийн засгийг таслан зогсоох урт хугацааны хүчин чармайлт нь ядуурал, хөгжил дутмаг байдал, аюулгүй байдлын хомсдол зэрэг үндсэн шалтгаануудыг шийдвэрлэхэд чиглэх

⁸⁹ Хар тамхи мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт хийх биечилсэн судалгаа түүнийг хэрэглэсэн этгээдийг тогтооход анхаарах асуудал <https://legaldata.mn/buteel/pdf?id=782>

⁹⁰ World Drug Report 2024 https://www.unodc.org/documents/data-and-analysis/WDR_2024/WDR24_Key_findings_and_conclusions.pdf

ёстой. Синтетик хар тамхины хэрэглээнд өртөх өндөр эрсдэлтэй залуучуудыг хар тамхины сүлжээнд татан оруулж буй хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ хэрэгтэй гэж олон улсад үзэж байна.

Зарим улсын хил залгаа бүс нутагт олон улсын зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлүүд хяналтаа тогтоож, төрийн хяналт сул байгааг далимдуулан үйл ажиллагаагаа өргөжүүлж байна. Үүний тод жишээ нь “Алтан гурвалжин” бүс нутаг бөгөөд тус бүсэд эдгээр бүлэглэлүүд хар тамхины хууль бус тээвэрлэлтийн хажуугаар зэрлэг амьтдын хууль бус худалдаа, байгалийн нөөцийн хууль бус олборлолт, санхүүгийн залилан зэрэг улам бүр тэлж буй хууль бус үйл ажиллагаанд хөрөнгө оруулж, үйл ажиллагааныхаа цар хүрээг төрөлжүүлж байна. Гэмт хэргийн үйл ажиллагаа болон хууль бус тээвэрлэлт нь олон улсын хил дамнасан, төрийн хяналт султай, алслагдсан бүс нутгуудад өргөн тархсан байдаг. Эдгээр бүс нутгууд хар тамхины хууль бус тээвэрлэлтийн төв гэдгээрээ алдартай бөгөөд янз бүрийн гэмт бүлэглэлүүд улс төр, санхүүгийн стратегийн ашиг сонирхлын үүднээс зэвсэгт бүлэглэлүүдтэй хамтран ажилладаг. Аргентин, Бразил, Парагвай улсын хилийн заагт орших Гурван улсын хилийн бүс нь сул хяналттай хилээр дамжуулан хар тамхи, хуурамч бараа бүтээгдэхүүн зөөвөрлөх, мөнгө угаах зэрэг хууль бус үйл ажиллагаанд хар тамхины бүлэглэлүүдийг татан оролцуулж байна.⁹¹ Түүнчлэн Лаос, Мьянмар, Тайланд улсын хил хязгаарыг хамарсан Алтан гурвалжин бүс нь опиум болон синтетик мансууруулах бодисын үйлдвэрлэл, мөн сүүлийн жилүүдэд зэрлэг амьтдын хууль бус худалдаа болон нөөцийн хууль бус олборлолтын гол төв болжээ. Энэ бүс нутагт хууль бус опиумын үйлдвэрлэл нь газар зүйн байршил, уур амьсгалын хувьд тохиромжтой байдлаасаа шалтгаалан удаан хугацаанд цэцэглэн хөгжсөн боловч, сүүлийн 30 жилийн дотор дотоодын зэвсэгт мөргөлдөөн, синтетик мансууруулах бодисын чиглэлд шилжсэн хандлага зэргээс шалтгаалан хар тамхины гол орлогын эх үүсвэр байхаа больсон.⁹²

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн талаарх орчин үеийн чиг хандлага (World Drug Report 2025) дараах байдалтай байна. Дэлхий даяар 2023 онд мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт сэжиглэгдсэн, баривчлагдсан эсвэл сануулга авсан байдлаар цагдаагийн байгууллагатай албан ёсоор холбоотой болсон хүмүүсийн тоо 6.1 саяд хүрсэн гэж тооцоолж байна.⁹³ Үүнээс гуравны хоёр нь буюу 4 сая хүн нь мансууруулах бодис эзэмшсэн болон хэрэглэсэнтэй холбоотой, харин 29 хувь буюу 1.75 сая хүн нь хар тамхины хууль бус наймаатай холбоотой, үлдсэн 5 хувь буюу 308,000 хүн нь бусад төрлийн мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдсон байна.

Сүүлийн жилүүдэд хар тамхины гэмт хэрэгт эрүүл мэндийн арга хэмжээг нэн тэргүүнд тавих шаардлага болгож байна. UNODC-ын стратеги дор урт хугацааны хязгаарлагдмал эмчилгээ, эрүүл мэндэд суурилсан арга нь хэрэглэгчдийг гэмт хэрэгтэн биш харин эмчилгээ шаардлагатай хүн гэж үздэг. Энэ нь хүчээр шийтгэх бус, эрүүл мэндийн хамгаалалтыг тэргүүлэх зарчмын дагуу хийгддэг, тухайлбал **prevention, harm reduction**, эмчилгээ, сэтгэл зүйн дэмжлэг, эрүүл мэндийн хөтөлбөрүүд орж байна.⁹⁴

⁹¹World Drug Report 2024 https://www.unodc.org/documents/data-and-analysis/WDR_2024/WDR24_Key_findings_and_conclusions.pdf

⁹² Мөн тэнд

⁹³ The Global State of Drug Criminalization <https://www.statista.com/chart/34701/people-in-criminal-justice-process-for-drug-related-offenses>

⁹⁴ CND Intersessional Session 2 Synthetic Opioids and Non-medical Use of Prescription Drugs <https://cnblog.org/2024/11/cnd-intersessional-12-november-202-synthetic-opioids-and-non-medical-use-of->

Залуучууд болон өндөр эрсдэл бүхий бүлэгт зориулсан сүүлийн үеийн эрүүл мэндийн, сошиал, аков хамгааллын хөтөлбөрүүдийг дэлхийн улсууд батлах болжээ.

- UNODC болон WHO нь гэр бүлийн ур чадвар нэмэгдүүлэх **Strong Families, CHAMPS** зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, залуу үеийн бие сэтгэлийн болон нийгмийн стресс, эрсдэлээс урьдчилан сэргийлдэг, хөгжлийн суурь хүмүүжилд суурилсан системүүдийг бататгаж байна.⁹⁵
- Түүнээс гадна, залуучууд хар тамхины сүлжээнд татагдахад аюулгүй байдал, ядуурал, боловсролын түвшин, гэр оронгүй байдал, сэтгэл зүйн дэмжлэгийн дутагдал зэрэг шалтгаан ихээр нөлөөлж байгааг олон улсад онцолж байна.⁹⁶

НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх газрын мэдээллийн нэгдсэн дүн мэдээлэлд үндэслэн харахад, Европын орнуудад мансууруулах бодис эзэмших болон хэрэглэдэг хүмүүсийн тоо өндөр байгаа ч, хар тамхи худалдах хэрэгт холбогдсон хүмүүс шүүхээр шийтгүүлэх, ял авах магадлал илүү өндөр байна. Түүнчлэн UNODC нь төрийн байгууллага, институциудад хандан дараах чиглэлүүдэд уриалга гаргасан байна:

- мансууруулах бодисын хэрэглээг бууруулах,
- хар тамхинд донтсон хүмүүсийг эмчлэн эдгэрэхэд дэмжлэг үзүүлэх,
- мөн санхүүгийн сэжигтэй гүйлгээг илрүүлэхэд банкны салбар, хувийн хэвшилтэй хамтран ажиллах,
- химийн үйлдвэрлэлийн салбартай хамтран мансууруулах бодисын үйлдвэрлэлд ашиглагдаж болзошгүй бодис, тоног төхөөрөмжийн урсгалыг хяналтдаа байлгах.

3.2.Гадаад орны эрх зүйн зохицуулалт, туршлагаас

Гадаад орны туршлагаас судлахдаа 2 түвшний улсыг сонгон авч судаллаа.

1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, яллах, урьдчилан сэргийлэх чиглэлээр сайн ажилладаг, эрх зүйн орчин тодорхой, сайн туршлага бүхий улс (Нидерланд улс);

2.Эрх зүйн орчин төлөвшсөн нэлээдгүй туршлага хуримтлуулж байгаа 2 улс (ХБНГУ, Тайвань) сонгосон.

Харьцуулсан судалгааг хийхдээ эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийг нарийвчлан судаллаа. Тухайлбал, 1. Ямар үйлдлийг хар тамхины гэмт хэрэг гэж тооцдог, хар тамхи, бодисын хэмжээнээс шалтгаалж гэмт хэргийн хүнд хөнгөнийг ялгах эсэх, хэрэглэхийг гэмт хэрэгт тооцох эсэх, аль хуулиар ял оногдуулдаг, ялын төрөл, торгох ялын хэмжээ, ялаас гадна нэмэгдэл авах арга хэмжээ, эмчилгээ /сэтгэл зүйн болон бусад төрлийн эмчилгээ гэх мэт/, хөрөнгө болон хар тамхийг хураан авах арга хэмжээ, давтан гэмт хэрэг

[prescription-drugs](#)

⁹⁵ Promoting Evidence-Based Prevention Strategies to Mitigate the Harms of Drug Use: The Role of the United Nations Office on Drugs and Crime Promoting Evidence-Based Prevention Strategies to Mitigate the Harms of Drug Use: The Role of the United Nations Office on Drugs and Crime <https://www.un.org/uk/node/218927>

⁹⁶ United Nations Office on Drugs and Crime (UNODC)

<https://sdgs.un.org/un-system-sdg-implementation/united-nations-office-drugs-and-crime-unodc-44139>

Үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хар тамхитай тэмцэх тусгай байгууллага, түүний бүтэц, чиг үүрэг, хар тамхитай тэмцэх урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр, стратеги, төлөвлөгөө, хуулийн этгээдийн болон зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн эрүүгийн хариуцлага, процессын асуудлуудыг нарийвчлан судалж, улс бүрийн онцлогт дүгнэлт өгөхийг хичээсэн болно.

3.2.1. Нидерланд Улсын эрүүгийн эрх зүйн зохицуулалт, ялын бодлого

Нидерланд улсын Хар тамхины хууль нь 1976 онд шинэчлэгдсэн “Opiumwet” буюу “Опиумын тухай хууль” нь хар тамхины хэрэглээ, үйлдвэрлэл, хадгалалт, борлуулалт, импорт, экспорт зэрэг бүх үйл ажиллагааг зохицуулдаг үндсэн хууль юм. Уг хууль нь мансууруулах бодисуудыг хоёр ангилалд (I болон II жагсаалт) хувааж, тус бүрд нь харилцан адилгүй эрх зүйн зохицуулалт, ял шийтгэлийн хэмжээг тогтоосон байдаг. Тус хууль нь мансууруулах бодисын хэрэглээ, худалдаа, хяналтыг тодорхойлдог бөгөөд зөөлөн мансууруулах бодисын зарим төрлийг тодорхой нөхцөлд хүлээн зөвшөөрдөг. Тус хуулийн дагуу хатуу болон зөөлөн хар тамхины төрөл, тэдгээрийн хууль ёсны болон хууль бус хэрэглээ, түүнтэй холбогдох эрүүгийн хариуцлага, ял шийтгэлийг тодорхойлогдсон байдаг.⁹⁷

Нидерланд улс нь мансууруулах бодисыг хатуу, зөөлөн гэж ангилсан цөөн тооны улсын нэг боловч олон улсын гэрээнд заасан мансууруулах бодисыг бүрэн хориглоно. Энэ нь эдгээр бодисыг тээвэрлэх, хадгалах, худалдах, үйлдвэрлэх үйл ажиллагааг 1 сараас 8 жил хүртэл ял шийтгэж байна.⁹⁸

Тус улсын Эрүүгийн хууль (Dutch Criminal Code) нь хар тамхитай холбоотой гэмт хэргийн эрүүгийн ял шийтгэлийг энэхүү хуульд заасан зүйл ангиудын хүрээнд оногдуулдаг. Жишээ нь: хар тамхи худалдах, үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах гэмт хэрэгт холбогдох ял шийтгэл оногдуулна.⁹⁹

Хар тамхины бодлогын хувьд "зөөлөн хар тамхи" (soft drugs) болон "хатуу хар тамхи" (hard drugs)-ыг ялган зохицуулдаг онцлогтой.¹⁰⁰ Зөөлөн мансууруулах бодис гэдэг нь хуульд зааснаар, каннабис (олсны ургамал) нь тодорхой нөхцөлд хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд энэ нь хэрэглэгчдэд зориулсан "кофе шоп"-уудад хязгаарлагдмал нөхцөлтэйгөөр зөвшөөрдөг. Жишээлбэл, 18 нас хүрээгүй хүмүүст худалдахыг хориглодог. хүлээн зөвшөөрдөг байна. Зөөлөн хар тамхины хувьд хувийн хэрэгцээнд зориулан 5 граммаас бага каннабис хадгалах нь хууль бус биш бөгөөд торгуультай боловч гэмт хэрэгт тооцогдохгүй.

Героин, кокаин, экстази зэрэг хатуу хар тамхийг хууль бусаар хадгалах, үйлдвэрлэх, худалдаалах нь гэмт хэрэг бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Харин хэрэглэх буюу өөртөө зориулан бага хэмжээний хар тамхи хадгалах үйлдлийг гэмт хэрэгт тооцдоггүй. Гэсэн хэдий ч хэрэглээний хэмжээ нь тодорхой хязгаарыг давах, бусдад дамжуулах, худалдаалах үйлдэл бол хууль бус бөгөөд гэмт хэрэгт тооцогдоно.¹⁰¹

⁹⁷ Opium act <https://wetten.overheid.nl/BWBR0001941/2009-07-01#BijlageI>

⁹⁸ The Netherlands Is At Risk Of Becoming A Narco State <https://www.addictioncenter.com/news/2020/01/netherlands-narco-state/>

⁹⁹ <https://www.government.nl/topics/drugs>

¹⁰⁰ How does the law distinguish between soft and hard drugs? <https://www.government.nl/topics/drugs/how-does-the-law-distinguish-between-soft-and-hard-drugs>

¹⁰¹ Drugs Law and Policy in the Netherlands – European Monitoring Centre for Drugs and Drug Addiction (EMCDDA)

Ял ба түүний төрөл

Хатуу хар тамхины хууль бус үйлдэл нь эрүүгийн гэмт хэрэгт тооцогдож, удаан хугацаагаар буюу 6 сараас 12 жилийн хүртэл хорих ял оноодог. Үүнийг “Опиумын тухай хууль”-ийн 10 дугаар зүйлд заасан.¹⁰² Зөөлөн хар тамхины хязгаарласан хэрэглээ: Хувийн хэрэглээнд бага хэмжээ хадгалах (жишээ нь, 5 граммаас бага каннабис) торгууль ногдуулж болдог. Түүнчлэн нэмж эмчилгээ, сэргээн засах дэмжлэг үзүүлэх бодлого голчлон баримталдаг.¹⁰³

Misuse of Drugs Act (Opiumwet) бол хар тамхины хэрэг, худалдаа, үйлдвэрлэл зэрэг үйлдлийг зохицуулдаг үндсэн хууль хэдий ч хар тамхитай холбоотой гэмт хэргүүдийн ял шийтгэлийг Эрүүгийн хуулийн холбогдох зүйл ангиар тогтоодог. Тус улсын хар тамхитай холбоотой гэмт хэргийн ял шийтгэлийг дараах төрөлд ангилдаг.

1. Торгох ял

- Жижиг хэмжээний зөөлөн хар тамхины хувийн хэрэглээ, хадгалалт зэрэгт ихэвчлэн ногдуулдаг.
- Байнга хэрэглэгчид, жижиг наймаачдад оногдуулдаг. Торгууль (торгох ял) нь үйлдлийн онцлог, хар тамхины төрөл, хэмжээ, нөхцөл байдлаас хамаарч өөр өөр байна. Торгох ялын хэмжээ нь зөөлөн хар тамхи (каннабис)-ны хэрэглээнд ихэвчлэн 100 евро орчим торгууль ногдуулдаг.

2. Хорих ял

- Хатуу хар тамхи үйлдвэрлэх, худалдах, их хэмжээний хадгалах, тээвэрлэх зэрэг ноцтой гэмт хэрэгт оногдуулдаг.
- Хорих ялын хугацаа нь үйлдлийн ноцтой байдлаас хамаарч 6 сараас 12 жил хүртэл, зарим тохиолдолд илүү ч байж болно.

3. Нийгэмд тустай ажил

- Хорих ял оноохоос өмнө нийгэмд тустай ажил хийлгэхээр шийдвэрлэдэг.

4. Эмчилгээ, сэргээн засах арга хэмжээ

- Хар тамхины хэрэглэгчдэд зориулсан эмчилгээ, нөхөн сэргээх үйлчилгээ явуулдаг.

5. Бусад арга хэмжээ. Тухайлбал, гэрийн хяналт, хорио цээр, тодорхой газар оронд орохыг хориглох зэрэг.

Зохион байгуулалттай гэмт бүлэглэл, хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага¹⁰⁴

¹⁰² Opiumwet <https://wetten.overheid.nl/BWBR0001941/2009-07-01#Artikel12>

¹⁰³The soft drug policy of the Netherland: What is legal? <https://www.expatica.com/nl/living/gov-law-admin/netherlands-drug-policy-100737/?utm>

¹⁰⁴ [European Monitoring Centre for Drugs and Drug Addiction \(EMCDDA\) – Netherlands](#)

Wetboek van Strafrecht (Эрүүгийн хууль)-ийн 140 дүгээр зүйлд болон Opiumwet (Опийн тухай хууль)-ийн 11 дүгээр зүйлийн 11.1-д зохион байгуулалттай гэмт бүлэглэл, хуулийн этгээдийн хариуцлагыг нарийвчлан тусгасан байдаг.¹⁰⁵

1. Зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн ял шийтгэл

Нидерланд улсын хуульд зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн үйл ажиллагаанд илүү хатуу ял оноох зохицуулалттай. Хар тамхины томоохон наймаа, үйлдвэрлэл, хууль бус сүлжээнд холбоотой бүлэглэлүүдэд хорих ялын дээд хэмжээ илүү өндөр бөгөөд торгууль, бусад нэмэлт арга хэмжээ оногдуулдаг. Зохион байгуулалттай гэмт бүлэглэлд хар тамхины гэмт хэрэгт олон хүнийг оролцуулсан, хууль бус үйл ажиллагааг зохион байгуулсан гэх үндэслэлээр илүү хүнд ял оногдуулдаг.

2. Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага

Нидерланд улсын хууль тогтоомжид хуулийн этгээд (компани, байгууллага)-ийн эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалттай. Хэрэв хуулийн этгээд хар тамхины гэмт хэрэгтэй холбоотой үйлдэл хийсэн нь тогтоогдвол, түүний эсрэг торгууль, хязгаарлалт, үйл ажиллагааг түр зогсоох, бусад хууль ёсны арга хэмжээ авдаг. Хуулийн этгээдийн хариуцлага нь хувь хүнтэй зэрэгцэн оногдуулах боломжтой.

Тус улсад хил давуулан буюу үндэстэн дамнасан хар тамхины гэмт хэрэгт ногдуулах ял шийтгэлийг дараах байдлаар оногдуулж байна.

Хил давуулан буюу үндэстэн дамнасан хар тамхины гэмт хэрэгт ногдуулах ял шийтгэл¹⁰⁶

- Хар тамхины тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаар хил дамнасан хар тамхины наймаа, зөөвөрлөлт, үйлдвэрлэл нь хамгийн ноцтой гэмт хэрэгт тооцогддог бөгөөд энэ төрлийн гэмт хэргүүдэд 12 жил хүртэл хорих ял оногдуулдаг.¹⁰⁷
- Гэмт хэрэгт холбогдсон этгээдийн үүрэг, оролцоо, хар тамхины хэмжээ, чанараас хамааран хорих ялын хугацаа нь ялгамжтай байдаг.
- Мөн өндөр хэмжээний торгох ял оногдуулах боломжтой.

Хил дамнасан хар тамхины гэмт хэрэг нь ял шийтгэлийг хүндрүүлэх нөхцөл болдог. Тухайн гэмт хэрэг нь олон улсын хэмжээнд үйлдэгдсэн, олон улсын сүлжээг ашигласан, эсвэл бусад улс орны хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай тохиолдолд ял шийтгэл илүү хүнд болдог. Давтан үйлдэл, зохион байгуулалттай бүлэглэлтэй холбогдсон тохиолдолд ял нь улам хүндэрнэ. Нидерланд улс нь олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, хил дамнасан хар тамхины гэмт хэрэгтэй тэмцэхэд идэвхтэй оролцдог.

Эмчилгээ, нийгэмшүүлэх нөхөн сэргээх хөтөлбөр

¹⁰⁵ Opiumwet <https://wetten.overheid.nl/BWBR0001941/2009-07-01#Artikel12>

¹⁰⁶ Criminal code <https://wetten.overheid.nl/BWBR0001854/2025-07-01>

¹⁰⁷ Opiumwet <https://wetten.overheid.nl/BWBR0001941/2009-07-01#Artikel12>

1. Мансууруулах бодисоос гаргах албадан эмчилгээ (Gedwongen opname/verplichte behandeling) нь Эрүүгийн хэрэг үйлдсэн боловч сэтгэцийн өвчтэй, донтолтой гэж үзсэн этгээдэд эрүүгийн ял оногдуулахын оронд буюу түүнтэй хамт сэтгэцийн эмнэлэгт албадан эмчлэх шийдвэр гаргаж болно. Энэ нь “TBS” буюу “terbeschikkingstelling” гэж нэрлэгддэг онцгой дэглэмтэй арга хэмжээ юм. Тус гэмт хэрэг үйлдсэн сэтгэцийн эмгэгтэй этгээд болон мансууруулах бодисонд донтсон этгээдийг нийгмээс тусгаарлан албадан эмчлэх дэглэм юм.

2.Нийгмийн ажилтантай албадан холбоо тогтоох (Reclassering/Probation supervision) нь шүүхээс хорих ял оногдуулалгүйгээр эсвэл хорих ялаас хугацаанаас нь өмнө сулласан тохиолдолд тухайн этгээдийг нийгмийн ажилтны хяналт дор нөхөн сэргээх үйлчилгээ авах, эмчилгээнд хамрагдахыг албадан даалгадаг.

3.Өвчтнөөр эмчилгээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхийг шаардсан захиргааны арга хэмжээ нь хүнд хэлбэрийн донтолтой хүмүүсийн хувьд орон нутгийн захиргаанаас тэднийг “өөртөө болон бусдад аюул учруулах магадлалтай” гэж үзвэл албадан ажиглалтад авах эсвэл эмчилгээ хийлгэх шийдвэр гаргаж болно.Жишээ нь: Wet verplichte ggz (Wvggz) буюу “сэтгэцийн эрүүл мэндийн албадан тусламжийн тухай хууль”-ийн дагуу.¹⁰⁸

4.Шүүхээс хорих ял дээр нөхцөлт эмчилгээ нэмж хийх¹⁰⁹ ба энэ нь шүүхээс нөхцөлт ял оноохдоо тухайн этгээдийг мансууруулах бодисын эмчилгээ хийлгэх нөхцөл тавьдаг. Хэрэв нөхцөлийг биелүүлээгүй бол ял бүтнээр хэрэгжиж хорих ялыг биечлэн эдлүүлнэ.

5.Хэрэглэгчийн эсрэг захиргааны арга хэмжээ (Bestuurlijke maatregel) нь зарим хотод (жишээ нь Амстердам) олон нийтийн газарт хар тамхи хэрэглэхийг хориглох, зөрчсөн тохиолдолд торгууль, оршин суух эрхийн хязгаарлалт зэрэг захиргааны шийтгэл оногдуулж болно.

6.Тусгай хяналтын дор урьдчилан сэргийлэх арга хэмжээ (Preventive supervision) нь “Problematic users” буюу асуудалтай хэрэглэгчдийг тусгайлсан хамгаалалтын, хяналтын хөтөлбөрт хамруулах ба энэ нь орон нутгийн захиргаа, эрүүл мэндийн байгууллагууд хамтран хэрэгжүүлдэг.

Хар тамхинд донтсон, сэтгэцийн өвчтэй, сэтгэлзүйн дэмжлэг шаардлагатай иргэдэд зориулсан төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтарсан сэтгэл зүйн болон эмнэлгийн цогц эмчилгээний тогтолцоо бүхий улс юм. Тус улсын эмчилгээний тогтолцоо, эмнэлгийн байгууламжуудын бүтэц, донтолт тодорхойлох, эмчилгээний үргэлжлэх хугацаа, нөхөн сэргээх хөтөлбөр, болон бусад албадлагын болон дэмжих үйлчилгээний талаарх мэдээллийг авч үзье.

1.Нидерланд улсын сэтгэл зүйн болон эмнэлгийн эмчилгээний тогтолцоог буюу сэтгэцийн болон донтох эмчилгээний үйлчилгээг дараах гурван чиглэлд хуваадаг:¹¹⁰

- GGZ instellingen (Geestelijke Gezondheidszorg) – Сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагууд
 - Verslavingszorginstellingen – Донтох эмчилгээний төвүүд (жишээ: Tactus, Jellinek)
 - Ziekenhuizen – Эмнэлгүүдийн дэргэдэх сэтгэцийн болон донтолтын тасаг
- Эдгээрийг улсын эрүүл мэндийн санхүүжилтээр эсвэл даатгалаар санхүүжүүлдэг.

¹⁰⁸Compulsory Mental Health Care Act .<https://wetten.overheid.nl/BWBR0040635/2020-01-01/0?utm>

¹⁰⁹ Criminal code [https Article 14c–14g https://wetten.overheid.nl/BWBR0001854/2025-07-01](https://wetten.overheid.nl/BWBR0001854/2025-07-01)

¹¹⁰ Drug use and addiction care <https://www.government.nl/topics/drugs/drug-use-and-addiction-care>

2.Эмчилгээ (Гэрээр болон хэвтэн эмчлүүлэх) нь Амбулаторийн эмчилгээ (outpatient): Сэтгэл зүйчид, эмчтэй тогтмол уулзалт, бүлгийн эмчилгээ, нөхөн сэргээх хөтөлбөр гэж хуваадаг. Хэвтэн эмчлүүлэх (inpatient): Хүнд хэлбэрийн донтолт, сэтгэцийн өөрчлөлттэй хүмүүст зориулсан клиник, detox хөтөлбөр юм.

3.Донтолтыг DSM-5 үзүүлэлтүүд дээр үндэслэн сэтгэцийн эмч, донтолтын мэргэжилтнүүд асуулгын арга (intake), сэтгэл зүйн оношилгоо, зан төлөвийн үнэлгээ ашиглан тодорхойлдог. Үүнд “gebruikspatroom” (хэрэглээний хэв маяг), “controleverlies” (хяналт алдсан эсэх), “ontweningsverschijnselen” (гэрлийн хамаарал, шалтгаан) зэргийг үнэлнэ.

4. Эмчилгээний үргэлжлэх хугацаа (Detox + psychotherapy + rehab) нь дунджаар:

- Detox (бие хоргүйжүүлэх): 1–3 долоо хоног
- Психотерапи ба эмчилгээ: 3 сар – 1 жил хүртэл
- Нөхөн сэргээх үе шат: 6 сараас дээш хугацаа

5. Нөхөн сэргээх (Rehabilitation / Aftercare) арга хэмжээнд дараах арга хэмжээг оруулна. Үүнд:

- Байнгын харилцаатай бүлгийн уулзалт (AA, NA);
- Хөдөлмөрт бэлтгэх сургалт;
- Нийгэмд дасан зохицох хөтөлбөр;
- Амьдрах байрны дэмжлэг, орон сууц.

6. Сэтгэл зүйн тусламж (Psychotherapy / Behavioral therapy)-д дараах арга хэмжээг оруулна. Үүнд:

- СВТ (Cognitive Behavioral Therapy) Танин мэдэхүйн болон зан үйлийн засал эсвэл: Сэтгэлгээ ба зан үйлийг өөрчлөх сэтгэл засал;
- Motivational Interviewing Сэдэлжүүлэлтийн ярилцлага эсвэл: Хүчилж шахахгүйгээр зорилгоо тодорхойлох ярилцлага
- Mindfulness-based relapse prevention Танин мэдэхүйн төвлөрөлд суурилсан дахилтаас сэргийлэх арга эсвэл: Анхаарал төвлөрөлд суурилсан дахилтаас урьдчилан сэргийлэх сэтгэл засал.

Эдгээрийг ганцаарчилсан болон бүлгийн байдлаар явуулдаг.

7. Бусад дэмжих арга хэмжээ (social care + housing + reintegration) Нийгмийн халамж, орон байрны дэмжлэг, нийгэмшүүлэлтийн цогц үйлчилгээ

Давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажиллагаа¹¹¹

1. Эмчилгээ, сэргээн засах дараах хөтөлбөрүүд байна.

- Хар тамхины гэмт хэрэгт холбогдсон хүмүүст зориулсан донтох эмчилгээ, сэтгэл зүйн дэмжлэг, нөхөн сэргээх хөтөлбөрүүд хэрэгждэг.
- Хэрвээ хорих ял авсан бол ял эдэлж байх хугацаандаа эдгээр хөтөлбөрт хамрагдах боломжтой.

2. Хяналт ба зөвлөгөөг дараах байдлаар өгдөг.

- Давтан гэмт хэрэг үйлдэх эрсдэлтэй хүмүүст цагдаагийн болон нийгмийн ажилтнуудын байнгын хяналт, зөвлөгөө өгдөг.

¹¹¹ Dutch Opium Act (Opiumwet) <https://wetten.overheid.nl/BWBR0001941/2009-07-01>

- Хяналт шалгалтыг тогтмол явуулж, шаардлагатай тохиолдолд нэмэлт дэмжлэг үзүүлдэг.
- 3. Нийгэмд дахин нэгтгэх үйл явц дараах арга хэмжээг хэрэгжүүлдэг.
 - Гэмт хэрэгтнийг нийгэмд эргэн оруулах, ажил мэргэжлийн сургалт, амьдралын ур чадвар олгох хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.
 - Энэ нь дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг бууруулахад чиглэнэ.
- 4. Олон талт хамтын ажиллагааг дараах байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна.
 - Цагдаа, прокурор, шүүх, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн байгууллагууд хамтран ажиллаж, мэдээлэл солилцон хамтран ажилладаг.
 - Орон нутгийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд оролцдог.
- 5. Боловсрол, мэдээллийг дараах байдлаар олгож байна.
 - Хар тамхины хор уршгийн талаар олон нийтэд чиглэсэн боловсрол, мэдээлэл өгөх үйл ажиллагааг идэвхтэй явуулдаг.
 - Гэмт хэрэгтнүүдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх ухамсар бий болгоход чиглэнэ.

Хөрөнгө, хар тамхийг хураан авах арга хэмжээ

1. Хар тамхины бодисыг хураан авахдаа хууль бус хар тамхины бодисыг баривчилж, мөрдөн шалгах явцад шууд хураан авдаг. Хэрэгт холбоотой хар тамхины бүх тохиолдолд мөрдөн байцаалт, шүүхийн шийдвэрийн дагуу хураан авалт хийгддэг.

2. Хэрэгт холбогдох хөрөнгийн хураан авахдаа хар тамхины хууль бус наймаа, үйлдвэрлэлээс олсон ашиг, мөнгө хөрөнгийг хураан авах арга хэмжээ авдаг. Түүнчлэн хөрөнгийг хууль бус үйлдэлд ашигласан эсвэл олсон гэж үзвэл шүүхийн шийдвэрээр хураан авдаг. Энэ нь мөнгө угаахтай тэмцэх, хар тамхины гэмт хэргийг санхүүжүүлэхийг таслан зогсоох чухал арга хэмжээ болдог.

Хар тамхитай тэмцэх тусгай байгууллага, түүний бүтэц, чиг үүрэг

(Дүрэм журам, Урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга, стратеги хөтөлбөр төлөвлөгөө)

Нидерланд улсын Засгийн газар хар тамхи, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд олон байгууллагын хамтын ажиллагаанд тулгуурласан “үр нөлөөтэй түншлэл бүхий хандлага”-ыг хэрэгжүүлдэг болохыг онцолж байна.

Нидерланд улсад хар тамхины хууль бус эргэлт, худалдаа, үйлдвэрлэлтэй тэмцэхэд тусгай чиг үүрэг бүхий байгууллагууд үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

- Үндэсний Цагдаагийн Газар (National Police Service): Хар тамхины гэмт хэрэгт шуурхай мөрдөн байцаалт явуулж, томоохон бүлэглэлүүдийг илрүүлэх, устгах үүрэгтэй.
- Хар тамхитай тэмцэх Тусгай Алба (Team High Impact Crime / Drug Enforcement Teams): Хар тамхины томоохон гэмт хэргийн эсрэг чиглэсэн тусгай алба, бүлэг.
- Прокурорын газар, татвар, гааль, санхүүгийн хяналтын байгууллагууд: Хар тамхины наймааг санхүүжүүлэх хөрөнгө мөнгийг илрүүлэх, саармагжуулахад оролцдог.
- Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд Europol, Interpol зэрэг байгууллагатай хамтран ажилладаг.
- RIVM нь Эрүүл мэнд, Халамж, Спортын яамны харьяа судалгаа, бодлого дэмжлэгийн төв байгууллага бөгөөд урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулах, эрүүл мэндийн мэдээлэл, олон нийтэд чиглэсэн төсөл зохион байгуулах, нянгийн

тархалт болон сэтгэц, донтошилтын чиглэлийн судалгаа хийхэд чиглэсэн судалгаа явуулдаг.

Дээрх байгууллагууд дараах чиглэлээр хамтран ажилладаг байна. Хамтын ажиллагааны түншлэл буюу “Integrated partnership approach”
Үүнд:

- Зохион байгуулалттай хар тамхи тээвэрлэгч сүлжээг илрүүлэх;
- Хохирогч болон гэмт хэрэгтнүүдийг шалгах;
- Нийтийн шударга ёсыг хамгаалж, хэрэглээний төвшинг бууруулах зорилттой үйл ажиллагаа явуулдаг.

1992 оноос хэрэгжиж эхэлсэн “Organised Crime in the Netherlands: Threats and Plan of Action” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулалттай гэмт хэрэгт зохион байгуулалт, адаптаци, өрсөлдөөний бодлого зэрэг суурь зарчмуудыг төлөвшүүлсэн.¹¹² Административ арга хэмжээ (лиценз, тендер хяналт, байгууллага хяналт гэх мэт) болон хууль хүчний ажиглалт, мөрдөн байцаалт зэрэг нь хосолсон нэгдмэл хандлагыг илтгэнэ.¹¹³

Урьдчилан сэргийлэх хөтөлбөр: Jellinek-ийн Unity peer education нь амралтын ба үдэшлэгийн орчинд үйлчлэгчдийг peer-education аргаар сургасан, Нидерланд улсын хамгийн өргөн тархсан урьдчилан сэргийлэх хөтөлбөр юм. Энэ нь эрүүл мэндийн мэдлэг, аюулгүй хэрэглээний ойлголтыг залуучуудад түгээгээд зогсохгүй олон улсад сурталчилж амжилт олсон арга баримтлал юм.

Хар тамхитай тэмцэх, урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр, стратеги, төлөвлөгөө

Нидерланд улс нь хар тамхины эсрэг тогтвортой үндэсний стратеги, урт хугацааны төлөвлөгөөтэй бөгөөд түүнийг төрийн олон салбар, байгууллага хамтран хэрэгжүүлдэг.¹¹⁴ Хэрэгжилт, зохион байгуулалтын хувьд төрийн төв байгууллага болох Хууль зүй аюулгүй байдлын яам (Ministry of Justice and Security) болон бусад холбогдох яамдууд хөтөлбөрийг удирдан зохион байгуулдаг. Оршин суугчид, орон нутгийн удирдлага, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажилладаг.

Тус стратеги нь хууль сахиулах, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, боловсрол зэрэг чиглэлээр холбогдох арга хэмжээг багтаадаг. Урьдчилан сэргийлэх нь олон нийтийн боловсрол, залуучуудын дунд хар тамхины хор уршгийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, эрсдэл багатай орчин бүрдүүлэх зорилготой юм. Хэрэглээг бууруулах хүрээнд хэрэглэгчдийг илрүүлэх, сэтгэл зүйн болон эрүүл мэндийн тусламж, эмчилгээ үзүүлдэг.

Хууль сахиулах хүрээнд хар тамхины хууль бус наймаа, үйлдвэрлэл, зөөвөрлөлтийг таслан зогсоох, гэмт хэргийн сүлжээг устгана. Нийгмийн дэмжлэг, нөхөн сэргээх хүрээнд гэмт хэрэгтнийг нийгэмд эргэн оруулах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд олон улсын хэмжээнд мэдээлэл солилцох,

¹¹² Partnerships in preventing organized crime in The Netherlands: Opportunities and pitfalls
<https://eucpn.org/sites/default/files/document/files/PreventingOrganizedCrimeNetherlandsEUCPNDEFINITIVE.28042022.pdf>

¹¹³ Organised Crime Prevention in the Netherlands
https://repub.eur.nl/pub/7385/manuscript_proefschrift_cathelijne_4_december_2005_bladwijze.pdf

хамтарсан ажиллагаа явуулна. Мэдээлэл, судалгааны хүрээнд хар тамхины асуудлын талаар тогтмол судалгаа хийж, бодлого, арга хэмжээг сайжруулна.

Нидерланд улсын үндэсний фокус төв нь 1999 онд Эрүүл мэнд, Халамж, Спортын сайдын захирамжаар байгуулагдсан үндэсний мансууруулах бодисын хяналтын (National Drug Monitor) хүрээнд ажилладаг. Тус төв нь улс даяар хийгдсэн бүртгэл, судалгаа, тандалтын өгөгдлийг цуглуулж, үнэлж дүгнэж, Улсын Доод танхим (Парламент), холбогдох яамд болон бусад үндэсний болон олон улсын оролцогч талуудад тайлагнах үүрэгтэй.¹¹⁵ Тус үндэсний фокус төв нь Trimbos Institute-ийн Мансууруулах Бодисын Тандалт ба Бодлого Хэлтсийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд Trimbos Institute нь сэтгэл зүйн эрүүл мэнд, хамааралтай тэмцэх үйлчилгээ, нийгмийн ажил эрхэлдэг үндэсний судалгааны институт юм. Энэ институт нь Нидерланд улсын ард иргэдийн сэтгэл зүйн эрүүл мэндтэй холбоотой асуудлаар бодлого боловсруулах, улс төрчдөд мэдээлэл хүргэх үүрэгтэй. Мөн тус төв нь Аюулгүй байдал ба Хууль зүйн яамны Судалгаа, баримтжуулах төвтэй ойрхон хамтран ажилладаг онцлогтой.

3.2.2. ХБНГУ-ЫН ТУРШЛАГААС

ХБНГУ-ын мансууруулах бодис, донтолттой тэмцэх бодлогын чиглэлээр үндэсний гол хууль тогтоомжид Мансууруулах бодисын тухай хууль Betäubungsmittelgesetz (BtMG) Шинэ төрлийн сэтгэцэд нөлөөт бодисын тухай хууль (NpSG), Эрүүгийн хууль зэрэг хуулиуд хамаардаг.

Мансууруулах бодисын тухай хуулийн 29–30b зүйлүүдэд мансууруулах бодисыг эзэмших, худалдах, үйлдвэрлэх, импортлох, экспортлох, тараах зэрэг үйлдлүүдийг ямар нөхцөлд гэмт хэрэгт тооцох, түүнд оноох ялын хэмжээг хэрхэн тогтоох талаар дэлгэрэнгүй заасан байдаг. Аливаа этгээд мансууруулах бодисыг өөрийн хэрэгцээний жижиг хэмжээтэйгээр хууль бусаар эзэмшсэн бол 29(1)-д заасны дагуу торгууль эсвэл 5 жил хүртэлх хугацаагаар хорих ял оногдуулах боломжтой. Бодисыг ашгийн зорилгоор худалдаалсан эсвэл бусдад түгээсэн бол энэ нь илүү хүнд гэмт хэрэгт тооцогдож, 29(3), 29a-д заасны дагуу доод тал нь 1 жилийн хорих ял оноох бөгөөд хэрэв их хэмжээний бодис (*nicht geringe Menge*) бол энэ ял 1-15 жилийн хорих ял оногдуулна.

Мансууруулах бодисыг хууль бусаар үйлдвэрлэсэн, импортолсон, экспортолсон, олж авсан, хадгалсан, илгээсэн, нийлүүлсэн этгээдэд тус хуулийн 22 дугаар зүйлийн дагуу торгох эсхүл хоёр жилээс илүүгүй хугацаагаар хорих ял шийтгэнэ. Гэмт хэргийн зохион байгуулалттай бүлэглэлээр үйлдсэн, эсвэл зэвсэг хэрэглэсэн тохиолдолд, 30 болон 30a заалтууд үйлчлэх ба 2-15 жилийн хорих ял оногдуулна.

Шинэ төрлийн сэтгэцэд нөлөөт бодисын тухай хууль (NpSG) нь 2016 оны 11-р сарын 26-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон. Энэхүү хууль нь шинэ төрлийн сэтгэцэд нөлөөлөх бодис (NPS) түгээхтэй тэмцэх буюу тэдгээрийг хэрэглэх, хордуулах бодис болгон ашиглах боломжийг хязгаарлах зорилготой. Уг хуульд захиргааны зөрчил болон эрүүгийн хуулиар хориглосон үйлдлүүдийг хооронд нь ялгамжтай зохицуулсан байдаг ба NPS-тэй харьцах (худалдан авах, эзэмших гэх мэт) өргөн хүрээтэй захиргааны хуулийн хоригийг агуулж байгаа бөгөөд энэ нь NPS-ийг хураан авч, шаардлагатай бол устгах үндэслэлийг бүрдүүлдэг.

¹¹⁵ Dutch National focal point https://www.euda.europa.eu/about/partners/reitox/netherlands_en

Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт Эрүүгийн хууль, Эрүүгийн процессын хуулийн ерөнхий заалтууд мөн хамаарна. Тухайлбал, мансууруулах бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох (316 дугаар зүйл) мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдэх (323б дугаар зүйл) Донтолтын эсрэг эмчилгээг зөрчих (64 дүгээр зүйл) зэрэг хар тамхины хэрэглээ, түүний үр дагаврыг тусгайлан тусгасан хэд хэдэн заалтыг агуулдаг. Хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй бол 10 жилээс илүүгүй хугацаагаар хорих ял оногдуулдаг. Үүнд: Бодисын төрөл, тоо хэмжээ, гэмт хэргийн онцлог гэх мэт. Тухайлбал, бодисын хэмжээ, төрөл нь ял шийтгэлийн хэмжээг тодорхойлох гол хүчин зүйл бөгөөд хиймэл бодис ашигласан бол илүү хүнд ял оноох хандлагатай байдаг. Мөн хэрэг үйлдсэн хүний нас, өмнө авсан ял шийтгэл, тухайн үйлдэл нь ашгийн зорилготой эсэх зэрэг нь ял шийтгэлийн хэмжээнд нөлөөлөх хүчин зүйл болж өгдөг.

Мансууруулах эмийг худалдаалах тухай хуульд тухайн бодисоос үүдэлтэй аюулын түвшингээр нь хатуу болон зөөлөн гэж ялгагдаггүй байна. Мөн хуулийн дагуу 1 дүгээр жагсаалтад багтсан бодисуудыг зөвхөн онцгой нөхцөлд шинжлэх ухааны судалгаа хийх эсвэл нийтийн ашиг сонирхолд нийцсэн зайлшгүй шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрлөөр ашиглах боломжтой. Харин 2 болон 3 дугаар жагсаалтад орсон бодисуудын хэрэглээг хуулиар тусгайлан зохицуулсан байдаг.¹¹⁶

Каннабисын жижиг хэрэглээний тохиолдолд, өөрийн хэрэгцээнд зориулан 6–10 граммаас бага хэмжээтэй каннабис хэрэглэсэн бол прокурор хэрэг үүсгэхгүй байх эрхтэй байдаг (StPO 153). Хэрэв хэрэгтэн хар тамхинд донтсон гэж тогтоогдсон бол түүнийг эмчилгээний төвд шилжүүлж, ял шийтгэлийг хойшлуулах буюу багасгах боломжтой (StGB 35). Түүнчлэн, 2024 оны каннабисын хууль шинэчлэлээр 25 граммаас хүртэл каннабис хэрэглэсэн өмнөх хэргүүдийг цуцлах боломж нээгдсэн бөгөөд энэ нь хууль эрх зүйн хувьд хэрэглэгчдэд эерэг өөрчлөлт авчирч байна. Ийнхүү ял шийтгэл оногдуулахдаа тухайн хэрэгт холбогдох бүх нөхцлийг нарийвчлан судалж, ялыг тогтоодог бөгөөд энэ нь илүү зохистой, хүний эрхийг хүндэтгэсэн хуулийн үйлчлэлийг хангахад чиглэгддэг.

Хэрэг	Эрүүгийн ял (дундаж)
Каннабис зарсан (100 гр)	1.5–2.5 жил хорих
Амфетамин их хэмжээгээр зарсан (50 гр)	4–6 жил хорих
Хүүхдэд мансууруулах бодис зарах	5–12 жил хорих
Өөрийн хэрэглээнд 5 гр хадгалсан	Хэрэг үүсгэхгүй байж болно

Дараах үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцдог. ¹¹⁷ Үүнд:

- Хувийн зөвшөөрөлгүй худалдан авах, эзэмших (Acquisition & Possession)
 - Зохих зөвшөөрөлгүйгээр хар тамхи худалдаж авах, эзэмших нь эрүүгийн гэмт хэрэг 29 (1) BtMG
 - “Их хэмжээ” буюу *nicht geringe Menge* буюу “үр нөлөөтэй агууламж”-ийг давсан бол (жишээ шиг: героин ≥ 1.5 г, кокаин ≥ 5 г, каннабис ≥ 7.5 г THC): хамгийн бага 1 жил хорих заалт хэрэгждэг 29a BtMG
- Тариалах, үйлдвэрлэх, нийлүүлэх (Cultivation, Production, Trafficking)

¹¹⁶ Сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтийн тухай хууль https://www.gesetze-im-internet.de/btmg_1981/

¹¹⁷ Law on the Trafficking Narcotics: §29 BtMG https://www.gesetze-im-internet.de/btmg_1981/_29.html

- Хар тамхи тарих, үйлдвэрлэх, худалдах, түгээх нь гэмт хэрэгт тооцогдоно 29 (1) BtMG
 - Хэрвээ энэ нь “их хэмжээ” буюу коммерсийн шинж чанартай бол гэмт хэргийн ял 2–15 жил хүртэл болох 29а, 30 BtMG
3. Импорт/Экспорт
- Хар тамхийг ХБНГУ руу оруулах эсвэл гаргах нь гэмт хэрэг бөгөөд “их хэмжээ”-д тооцогдвол хамгийн бага 2 жилийн хорих ялтай 30 BtMG .
 - Гол ял нэмэгдэх нөхцөл: бүлэглэлийн шинжтэй үйлдэл, зэвсэг ашиглах гэх мэт (5–15 жил) 30а BtMG.
4. Хувь хүний хэрэгцээнд жижиг хэмжээ авах/эзэмших
- Хэрвээ зөвхөн “жижиг хэмжээ” (жишээ: каннабис 6–10 г, героин 1.5 г) ашиглахад зориулсан бол прокурор зөрчил тулгахгүй байх боломжтой 29(5), 31а BtMG ¹¹⁸Гэхдээ жижиг ч гэсэн хууль зөрчиж байгаа тул техникийн хувьд гэмт хэрэг учраас баривчилгаа, торгууль, магадгүй хариуцлага хүлээх боломжтой.
5. Бусдад дамжуулах, хүүхдийн хэрэглээнд өдөөх
- Хуулиар хориотой ба 18 нас хүрээгүй хүнд өгсөн бол хамгийн бага 1 жилийн хорих ял 29а(1) BtMG. Бүлэглэх, зэвсэгтэй эрх зөрчигчидтэй хамтран үйлдсэн бол ял нь 5–15 жил 30а BtMG.

Ял ба түүний төрөл

ХБНГУ-д хар тамхитай холбоотой зөрчил, гэмт хэрэгт торгох ял (Geldstrafe) оногдуулах нь элбэг бөгөөд энэ нь тухайн хүний санхүүгийн чадавх, хэрэг үйлдсэн нөхцөл байдал, анхны зөрчил эсэх зэрэг хүчин зүйлээс хамаарч тооцогддог.

Торгууль нь өдөр тутмын орлоготой уялдаатайгаар тооцогддог. Анх удаа хар тамхи эзэмшсэн бол хорихын оронд торгууль оноох нь түгээмэл. Торгуулийг өндөр орлоготой хүмүүст илүү өндөр дүнтэй гэж үздэг.

ХБНГУ-д хар тамхитай холбоотой гэмт хэрэгт ял оноохоос гадна дараах нэмэлт арга хэмжээ, нөхөн сэргээх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. Энэ нь нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх, донтох эмгэгийг эмчлэх зорилготой юм.

Ялаас гадна нэмэлт арга хэмжээ (Nebenstrafen / Maßregeln der Besserung und Sicherung):

Арга хэмжээ	Тайлбар	Хууль зүйн үндэслэл
1. Донтох эмчилгээ / нөхөн сэргээх эмчилгээ		
(<i>Therapie statt Strafe</i>)	Хар тамхинд донтсон этгээдэд хорих ялын оронд сэтгэл заслын болон эмнэлгийн эмчилгээ онооно	35, 36 BtMG
2. Шүүхийн хяналттай эмчилгээ / Тэнсэн хугацаанд хяналт		
(<i>Bewährungsauflagen mit Therapie</i>)	Хорих ялыг тэнсэхийн зэрэгцээ эмчилгээ,	StGB 56с, 67

¹¹⁸ Law on the Trafficking Narcotics: §29 BtMG https://www.gesetze-im-internet.de/btmg_1981/_29.html

	ТОГТМОЛ үзлэг, сэтгэл заслын уулзалт хийнэ	
3. Нийгмийн ажил (Sozialstunden)	Шүүх эсвэл прокурор нийтийн ажил хийх үүрэг оноох боломжтой	StGB 10
4. Тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах		
(<i>Fahrverbot, Entziehung der Fahrerlaubnis</i>)	Мансуурсан үед жолоо барьсан бол жолооны эрх хасагдах	69, 69a StGB
5. Сургалт, боловсролын хөтөлбөрүүд		
(<i>Drogenpräventionsprogramme</i>)	Ялангуяа өсвөр насныхан болон анх удаа хэрэг үйлдсэн этгээдүүдийг урьдчилан сэргийлэх сургалтад хамруулна	Прокурорын шийдвэр, 31a BtMG
6. Шүүхийн хяналт дор дахин эмчилгээ / Хориотой нөхцөл		
(<i>Maßregel nach 64 StGB</i>)	Хүнд хэлбэрийн донтолттой этгээдийг эмчилгээний байгууллагад албадан байрлуулж эмчилнэ	64 StGB

ХБНГУ-ын хар тамхитай холбоотой гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд зөвхөн ял оноохоос гадна гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, хар тамхи, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл зэргийг улсад хураан авах (*Einziehung / Vermögensabschöpfung*) хууль зүйн арга хэмжээг хэрэглэдэг.

Хар тамхитай холбоотой гэмт хэргийг давтан үйлдсэн тохиолдолд хуулиар ял шийтгэлийг хүндрүүлэн оногдуулдаг. Эрүүгийн хуульд (StGB) зааснаар: “Давтан гэмт хэрэг (*Rückfall / Wiederholungstäter*) нь ял шийтгэхдээ хүндрүүлэх нөхцөл гэж үзнэ.”¹¹⁹

Давтан гэмт хэрэгт хамаарах нэмэлт нөхцөлүүд:

- Давтан гэмт хэрэг хийсэн нь сүүлийн 5 жилийн дотор байх
- Өмнөх ялыг тэнсэн байсан ч шинээр гэмт хэрэг үйлдсэн бол шинэ хэргийн ялд нөлөөлнө
- Прокурорын шүүхэд өргөн барих саналыг зогсоохгүй, харин ч хатуу арга хэмжээ авах үндэслэл болдог.

Давтан гэмт хэрэг нь ХБНГУ-д ял шийтгэлийг хүндрүүлэх онц чухал хүчин зүйл юм. Давтан гэмт хэрэг хийсэн тохиолдолд тэнсэн ял өгөх магадлал буурч, хорих хугацаа уртсах, зарим тохиолдолд нэмэлт хамгаалалтын хорих арга хэмжээ (*Sicherungsverwahrung*) хэрэгжиж болно.

¹¹⁹Criminal Code (StGB) https://www.gesetze-im-internet.de/stgb/_46.html

Хар тамхитай холбоотой давтан гэмт хэрэг (рецидив) үйлдэхээс урьдчилан сэргийлэхийн тулд эрүүгийн эрх зүйн хариуцлагаас гадуур болон дотор дараах системтэй арга хэмжээ, бодлого, хяналтын тогтолцоо хэрэгжүүлдэг.

Давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх үндсэн арга замууд

I. Эрүүгийн шүүхийн хүрээнд (хуульд заасан урьдчилан сэргийлэлт)

Арга хэмжээ	Тайлбар	Хууль зүйн үндэслэл
1. Сэтгэл заслын болон донтох эмчилгээ		
<i>(Therapie statt Strafe)</i>	Хар тамхинд донтсон этгээдэд хорих ял оноохын оронд эмчилгээний хөтөлбөрт хамруулна	BtMG 35, 36 ¹²⁰
2. Тэнсэн харгалзах хугацаанд хяналт тавих		
<i>(Bewährung mit Auflagen)</i>	Хорих ял тэнссэн тохиолдолд сэтгэл зүйн уулзалт, эмчилгээ, хяналтын тайлагнал шаардана	StGB 56c, 67
3. Нийгмийн ажил, сургалтанд хамруулах	Ялангуяа өсвөр насныхан, анхны гэмт хэрэгт хамрагдагсад → сэргийлэх сургалтад хамруулна	Прокурорын шийдвэр, BtMG 31a
4. Гэмт хэрэгтнийг хамгаалалт дор байлгах		
<i>(Sicherungsverwahrung)</i>	Аюултай, олон дахин гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял дууссан ч хорих хамгаалалтын байрлалд үлдээнэ	StGB 66

II. Нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн тогтолцооны хүрээнд

Арга хэмжээ	Хэрэгжүүлэгч байгууллага	Тайлбар
1. Донтох эмгэгийн эмчилгээний төвүүд	Caritas, Diakonie, Deutsche Aidshilfe, gGmbH зэрэг ТББ	Сэтгэл заслын эмчилгээ, групп уулзалт, гэр бүлд зөвлөгөө
2. Превенцийн хөтөлбөрүүд	Хүн амын дунд, сургуульд	Drogenprävention (Урьдчилан сэргийлэх сургалт)

¹²⁰ Law on the Trafficking of Narcotics (Narcotics Act - BtMG) Section 35 Deferment of Sentence Execution https://www.gesetze-im-internet.de/btmg_1981/35.html

3. Эрүүл мэндийн хяналт	Эрүүл мэндийн даатгалтайгаар үнэ төлбөргүй	Эмчийн хяналт, дахин донтохоос сэргийлэх тусламж
4. Донтсон хүмүүсийн нийгэмд дасан зохицох хөтөлбөр	Үйлдвэрлэл, сургалт, ажилд зуучлах	Дахин гэмт хэрэг үйлдэхгүй байхад чиглэсэн урт хугацааны дэмжлэг

III. Цагдаа, прокурорын шатанд хэрэгждэг урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Арга хэмжээ	Тайлбар
1. “Freispruch unter Auflage” буюу анхааруулга, шаардлагын дагуу хэрэгсэхгүй болгох	Хэрэв бага зөрчил бол прокурор эмчилгээний эсвэл сургалтын шаардлагыг тавьж хэрэг үүсгэхээс татгалзана
2. “Therapie statt Strafe” гэх прокурорын саналаар ял завсрын эмчилгээгээр орлуулах	Хууль бус хар тамхины хэрэглээтэй залуусыг албадан эмчилгээнд оруулах, тэндээсээ хяналттай буцаах
3. Давтан зөрчилтэй хүмүүсийг урьдчилан бүртгэх, хянах систем	Бүсийн прокурор, цагдаа нар сэжигтэй этгээдүүдэд нэмэлт анхаарал тавьдаг

Нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргэн оруулах хөтөлбөр

1. Эмчилгээний болон сэргээн засах хөтөлбөр (Rehabilitationsprogramme)¹²¹
 - Донтолтын эмчилгээ (Suchttherapie): Хар тамхинаас салах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх эмчилгээний төрөл бүрийн арга хэмжээг хэрэгжүүлж амбулатор, стационар эмчилгээ, бүлгийн уулзалт, зөвлөгөө өгөх үйлчилгээ.
 - Гэр бүл, нийгмийн дэмжлэг: Гэр бүлийн харилцааг сайжруулах, нийгэмд дахин бүртгэхэд туслах үйлчилгээ.
 - Эрүүл мэндийн хяналт, урьдчилан сэргийлэлт: Эмч, сэтгэл зүйчийн тогтмол хяналт, дахин донтохоос сэргийлэх арга хэмжээ.
2. Хөдөлмөр эрхлэлт, ур чадварын сургалт
 - Ажлын байранд бэлтгэх сургалт: Мэргэжил эзэмшүүлэх, ажлын дадлагажуулалт явуулах хөтөлбөрүүд.
 - Ажилд зуучлах үйлчилгээ: Гэмт хэрэгтэнг ажлын байртай болгох, нийгмийн халамжийн байгууллагуудтай хамтран ажиллах.
 - Нийгмийн ажлын оролцоо: Нийгмийн ажил, сайн дурын үйл ажиллагаанд оролцуулах замаар нийгэмд дасан зохицох чадварыг сайжруулах.
3. Нийгмийн орчин дахь дэмжлэг
 - Оршин суух орчин, байр байрлуулах: Хямд төсөр орон сууц, хамгаалалтын байр, түр орон сууцны төвүүд
 - Хууль эрх зүйн зөвлөгөө: Гэмт хэрэгтэнг хууль эрх зүйн зөвлөгөөгөөр хангах, хөдөлмөр эрхлэлт, гэр бүлийн асуудлаар дэмжлэг үзүүлэх.

¹²¹ Law on the Trafficking of Narcotics (Narcotics Act - BtMG) Section 35 Deferment of Sentence Execution https://www.gesetze-im-internet.de/btmg_1981/_35.html

- Нийгмийн сүлжээ бий болгох: Ижил төстэй нөхцөлтэй хүмүүсийн бүлгэм, дэмжих бүлгүүдийг бий болгох.

4. Төрийн болон төрийн бус байгууллагуудЫН Хамтын ажиллагаа

Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн халамжийн яамдууд, цагдаа, прокурор, шүүх зэрэг төрийн байгууллагууд болон Caritas, Diakonie, Deutsche Aidshilfe зэрэг олон нийтийн сайн дурын ТББ-ууд, Орон нутгийн засаг захиргаа хамтран ажиллана.

5. Хууль эрх зүйн үндэслэл

- Betäubungsmittelgesetz (BtMG) 35, 36 – Донтох эмчилгээний заалтууд
- Sozialgesetzbuch (SGB) XII – Нийгмийн халамжийн хууль
- Strafgesetzbuch (StGB) 56c, 67 – Тэнсэн ялтай холбоотой нөхцөлүүд

Дээрх хөтөлбөрүүд нь эмчилгээ, сургалт, хөдөлмөр эрхлэлт, орон сууц, хууль эрх зүйн болон нийгмийн дэмжлэг гэсэн олон шатлалтай бөгөөд төр, хувийн хэвшил, ТББ-ууд хамтран хэрэгжүүлдэг иж бүрэн тогтолцоо юм.

Зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн ял шийтгэл

Тус улсад хар тамхитай холбоотой гэмт хэрэг зохион байгуулалттай бүлэглэл болон хуулийн этгээдийн оролцоотой үйлдэгдсэн тохиолдолд ял шийтгэл болон эрүүгийн хариуцлага нь илүү хатуу, тусгай журамтай байдаг.

Зохион байгуулалттай бүлэглэлд хар тамхины гэмт хэрэг үйлдсэн бол Эрүүгийн хууль (StGB)-ийн холбогдох заалтуудаар илүү хүнд ял оногдуулна. Үүнд: BtMG 30a – Зохион байгуулалттай бүлэглэлээр мансууруулах бодисыг худалдан борлуулах, үйлдвэрлэхэд оногдуулах ял. StGB 129 – Гэмт бүлэглэл байгуулах, удирдах, оролцох гэмт хэрэг.

Ял шийтгэл:

- 2-оос 15 жилийн хорих ял хүртэл (хэрэв хүнд нөхцөлтэй, их хэмжээтэй бол)
- Мөн эд хөрөнгө хураах, бусад нэмэлт шийтгэл оногдуулах
- Хэрэг явдалд хориглосон эд зүйлс (Tatmittel) хураах

Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага

ХБНГУ-ын хуулиар хуулийн этгээд (компани, байгууллага) хууль зүйн хариуцлага хүлээх боломжтой. Үүнд:

- Орчин үеийн хуулийн зохицуулалт болох "Verbandsverantwortlichkeit" буюу байгууллагын хариуцлага;
- Хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтнуудын зөрчилд хариуцлага хүлээлгэх;
- Хууль бус үйлдлүүдийг зогсоох, сэргийлэх дотоод хяналт, зохицуулалтын арга хэмжээ авах үүрэг.

Шийтгэл:

- Торгууль
- Захиргааны арга хэмжээ
- Хувь хүний эсвэл байгууллагын эрхийг хязгаарлах

Зохион байгуулалттай бүлэглэлээр хар тамхины гэмт хэрэг үйлдсэн бол хүнд, урт хугацааны хорих ял оноодог. Хуулийн этгээдүүд мөн эрүүгийн хариуцлага хүлээж, өндөр хэмжээний торгууль, захиргааны арга хэмжээ хүлээх боломжтой. Энэ нь гэмт хэргийн

өргөн цар хүрээ, эдийн засгийн нөлөөг бууруулах, хууль бус бүлэглэлийн үйл ажиллагааг таслан зогсооход чиглэсэн арга хэмжээ юм.

1. Үндэстэн дамнасан хар тамхины гэмт хэргийн онцлог

- Хар тамхийг улсын хилээр нэвтрүүлэх, олон улсын бүлэглэлтэй холбоотой үйлдэл
- Их хэмжээний мансууруулах бодис тээвэрлэх, наймаалах
- Тээвэрлэлтийн сүлжээ зохион байгуулах
- Их хэмжээтэй үйлдсэн бол (жишээ: 10 кг-с дээш героин, кокаин гэх мэт) ял хэт хүндэрч, хорих ял уртсах магадлалтай.
- Тээвэрлэлт болон наймааны олон шат дамжлагатай, бүлэглэлийн оролцоотой бол ял бүр илүү хатуу болно.

3. Ялыг хүндрүүлэх үндэслэлүүд

- Гэмт хэргийн оролцоо (мансууруулах бодисын хэмжээгээр)
- Гэмт бүлэглэлийн оролцоо, удирдлага, зохион байгуулалт
- Үндэстэн дамнасан байдал, олон улсын холбогдолтой үйлдэл
- Урьдчилан сэргийлэх болон шүүхийн өмнөх хяналтанд үлдэж байгаа эсэх

Хил дамнан хар тамхины гэмт хэрэгт хамгийн хатуу ял оноодог бөгөөд хорих ял нь 1-15 жил хүртэлх хугацаатай байдаг. Зохион байгуулалттай бүлэглэл, олон улсын холбогдолтой гэмт хэргийг тусгайлан онцгойлон авч үзнэ. Хэрвээ хэрэг нь зохион байгуулалттай бүлэглэлийн хүрээнд үйлдэгдсэн бол 2-15 жилийн хорих ял оногдуулдаг.

ХБНГУ-д хар тамхитай холбоотой гэмт хэрэгтэй тэмцэхэд цагдаа, прокурор, шүүх, бусад төрийн болон төрийн бус байгууллагуудын салбар хоорондын хамтын ажиллагаа нэн чухал үүрэгтэй бөгөөд энэ нь гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, ял шийтгэл оногдуулах үйл явцыг үр дүнтэй болгодог. Цагдаа, прокурор, шүүх, нийгмийн болон эрүүл мэндийн байгууллагууд, ТББ-ууд нь хар тамхитай холбоотой гэмт хэрэгтэй тэмцэхэд хамтран ажиллах, мэдээлэл солилцох, уялдаа холбоотой хяналт тавих системтэй. Энэ хамтын ажиллагаа нь гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг эрүүлжүүлэх, ял шийтгэл оногдуулах үйл явцыг үр дүнтэй болгодог.

Гэмт хэрэгтний мэдээллийн нэгдсэн сан (Datenbank) байдаг бөгөөд энэ нь хууль сахиулах байгууллагуудын хооронд мэдээлэл хуваалцах, гэмт хэрэгтэнг хянах, мөрдөн байцаалтын ажлыг эрчимжүүлэх зорилготой юм. ХБНГУ-д гэмт хэрэгтний мэдээллийн нэгдсэн сан бий бөгөөд энэ нь хууль сахиулах байгууллагуудын мэдээлэл солилцох, гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал хэрэгсэл болдог. Мэдээллийг ашиглахдаа хувийн нууцлал, хүний эрхийг хамгаалах хууль журмыг чанд мөрддөг.¹²²

Хар тамхитай холбоотой гэмт хэргийн эсрэг үр дүнтэй тэмцэхийн тулд цагдаа, прокурор, шүүхийн ажилтнууд болон нийгмийн ажилтнуудын чадавхжуулах сургалт маш чухал үүрэгтэй байдаг. Энэ сургалтууд нь мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хар тамхины гэмт хэргийн онцлогийг ойлгох, хуулийн дагуу зөв шийдвэр гаргахад чиглэгддэг. Цагдаа, прокурор, шүүхийн болон нийгмийн ажилтнуудын хар тамхитай холбоотой гэмт

хэрэгтэй тэмцэхэд чиглэсэн чадавхижуулах сургалт нь мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, салбар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах чухал хэрэгсэл юм.

ХБНГУ-д хар тамхины гэмт хэрэгт холбогдогсдын шатсан шалтгаан, нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг олон талт, системтэйгээр авч хэрэгжүүлдэг. Энэ нь гэмт этгээдийг дахин гэмт хэрэгт уруу татах шалтгааныг бууруулахад чиглэсэн нийгэм, сэтгэл зүйн, хууль эрх зүйн, боловсролын арга хэмжээний цогц юм.

Хар тамхины хууль бус эргэлтийг таслан зогсоох зориулалттай тусгай, төвлөрсөн байгууллагууд бий бөгөөд эдгээр нь холбооны болон мужийн төвшинд үйл ажиллагаа явуулдаг. Олон улсын болон дотоодын харилцан уялдаатай хамтын ажиллагааг чухалчилдаг.

3.2.3. ТАЙВАНЬ ТУРШЛАГААС

Тайваньд Мансууруулах бодисын аюулаас урьдчилан сэргийлэх тухай хууль (narcotics hazard prevention act)¹²³ эрх зүйн үндсэн зохицуулалт болдог. Тайвань "Шинэ үеийн мансууруулах бодисын эсрэг стратегийн удирдамж"-ийг (2017-2020, 2021-2024) хэрэгжүүлснээр чухал ахиц дэвшил гаргасан. Засгийн газар яамдын хоорондын чадавхыг нэгтгэн, их хэмжээний мансууруулах бодисыг хураан авч, жил бүр мансууруулах бодис хэрэглэгчдийн нийт тоо болон анх удаа зөрчил гаргасан хүмүүсийн тоог амжилттайгаар бууруулсан.

Тайвань Гүйцэтгэх Юань (Executive Yuan) бол Тайвань буюу Бүгд Найрамдах Хятад Улсын (Тайвань) гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч дээд байгууллага ба Ерөнхий сайд нь тэргүүлж ажилладаг. Энэ нь засгийн газрын үндсэн бүтэц дэх таван Юанийн нэг бөгөөд Тайванийн Үндсэн хуульд заасны дагуу үйл ажиллагаа явуулдаг.¹²⁴ Мансууруулах бодисын эсрэг тэмцэл нь үргэлжилж буй, урт хугацааны кампанит ажил юм. Дотоодын мансууруулах бодисын асуудлыг шийдвэрлэхийн тулд Гүйцэтгэх Юань 2024 оны 11 сард стратегийн удирдамжийн гуравдугаар үе шат (2025-2028)-ыг баталсан бөгөөд энэ нь мансууруулах бодисын хяналт, сэргээн засах зэрэг салбарт ойролцоогоор NT\$15 тэрбум (461.4 сая ам.доллар) зарцуулахаар төлөвлөж байна.¹²⁵ Мөн мансууруулах бодисын хэрэглэгчдэд зориулсан сэргээн засах нөөцийг идэвхтэй өргөжүүлж, эмнэлгийн зөвлөгөө, нийгмийн дэмжлэгийг бэхжүүлэх зорилгоор тогтвортой дахин нэгдэхийг дэмжихээ илэрхийлж байна.

1. Хориотой бодисын ангилал:¹²⁶

Тайванд хориотой бодисуудыг нөлөөнөөс нь хамаарч I–IV зэрэгт ангилалд хувааж байна. Үүнд:

¹²³ Narcotics Hazard Prevention Act <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=C0000008>

¹²⁴ Structure and functions <https://english.ey.gov.tw/Page/E43650B2CB14861B>

¹²⁵ New generation Anti-drug Strategy Guidelines (Phase 3) <https://english.ey.gov.tw/Page/E43650B2CB14861B>

¹²⁶ Narcotics Hazard Prevention Act <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=C0000008>

I зэрэгт бодис (жишээ: героин, морфин, кокаин, опиум) оруулж байна. Үүнд:

- Үйлдвэрлэх, тээвэрлэх, худалдах: цаазаар авах ял эсвэл үргэлжлэх хорих, мөн 10 сая NTD хүртэл торгууль оногдуулна;
- Худалдах зорилготой бие даасан эзэмшил: үргэлжлэх хорих эсвэл 10+ жил, 7 сая NTD хүртэл торгууль оногдуулна;
- Хүч хэрэглэж хэрэглүүлэх: цаазаар авах ял, үргэлжлэх хорих эсвэл 10+ жил + 10 сая NTD хүртэл торгууль оногдуулна;
- Хадгалах: 3 жил хүртэл хорих эсвэл баривч, 30 000 NTD хүртэл торгууль; 10 г-аас их бол 1–7 жил + 1 000 000 NTD хүртэл торгууль оногдуулна.

II зэрэгт бодис (жишээ: кока, амфетамин, марихуан) оруулж байна. Үүнд:

- Үйлдвэрлэх, тээвэрлэх, худалдах: үргэлжлэх хорих буюу 7+ жил + 7 сая NTD хүртэл торгууль оногдуулна;
- Худалдах зорилготой эзэмшил: 5+ жил + 5 сая NTD хүртэл торгууль оногдуулна;
- Хүндрүүлсэн жинг тохируулах; бодисоос хамаарсан ял сонсох жишээ: 20 г-аас их бол 6 сар–5 жил, 70 сая хүртэл торгууль оногдуулна;
- Хүч хэрэглэж хэрэглүүлэх: үргэлжлэх хорих эсвэл 7+ жил + 7 сая хүртэл торгууль оногдуулна.

III, IV зэрэгт болон хэрэгслийн хувьд дараах байдлаар ял шийтгэлийг оногдуулж байна. Үүнд:

- III зэрэг: үйлдвэрлэх/тээвэрлэх/худалдах бол 5+ жил; хадгалах — 2+ жил, 20 сая хүртэл торгууль оногдуулна;
- IV зэрэг: 3+ жил эсвэл 10 сая хүртэл торгууль оногдуулна;
- Хэрэгсэл (борлуулах/эзэмших): 1+ жил; хадгалах — 1 жил хүртэл хорих ял оногдуулна.

Урьдчилсан заалт:

- Паппас, кока, каннабис тарих:
I/II зэрэг — үргэлжлэх хорих;
III-д ч мөн цаазаар авах тохиолдол байх.
I–IV зэрэгт зориулсан урьдчилсан гэмт хэрэгт ял шийтгэл оногдуулж болно.

Урьдчилсан гэмт үйлдэл (түүний үр дүнд арга хэмжээ авахгүй байх): ял шийтгэл хасагдахгүй.

Төрийн албан хаагчид дараах шийтгэлийг оногдуулна:

- Хуулийн дагуу хориглосон үйлдэлд хамтрагдсан эсвэл хамгаалалт үзүүлсэн бол ял шийтгэл хүндэрнэ.

Арван нэгдүгээр зүйл. (Хадгалалт)¹²⁷

- I зэрэгт бодис хадгалах: 3 жил хүртэл хорих, эсхүл баривч, эсхүл 300,000 NTD хүртэл торгууль оногдуулна;
- I зэрэгт цэвэр "цэвэр жингийн" 10 г-аас илүү бол 1–7 жил хорих, болон 1 000,000 NTD хүртэл торгууль оногдуулна;

¹²⁷ Narcotics Hazard Prevention Act

<https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=C0000008>

- II зэрэг: 2 жил хүртэл хорих, эсхүл баривчилалт, эсхүл 200,000 NTD хүртэл торгууль оногдуулж байна;
- 20 г-аас илүү бол 6 сар–5 жил + 700,000 NTD хүртэл торгууль оногдуулна;
- III зэрэгт 5 г-аас их бол 2 жил хүртэл хорих, эсхүл 200,000 NTD хүртэл оногдуулна;
- IV зэрэгт 5 г-аас их бол 1 жил хүртэл хорих, эсхүл 100,000 NTD хүртэл оногдуулна;
- I болон II зэрэгт хэрэглэгдэх хэрэгсэл хадгалах: 1 жил хүртэл хорих, баривчилалт, эсхүл 100,000 NTD торгууль оногдуулна.

Арван хоёрдугаар зүйл. (Паппас, кока, каннабис тарих)

- I зэрэгт зориулан тариалах: үргэлжлэх хорих эсхүл 7+ жил + 7 000,000 NTD хүртэл торгууль оногдуулна;
- II зэрэгт зориулан тариалах (каннабис): 5+ жил + 5 000,000 NTD хүртэл торгууль оногдуулна.

Тайваньд бодисын хүчтэй хор хөнөөл, нийгмийн аюул заналыг үндэслэн I–IV зэрэгт ангилж хатуу ялтай байхаар зохицуулсан. Хамгийн хүнд I зэрэгт заасан героин, морфин, кокаин зэрэг бодист ял суларж байгааг анхаарах хэрэгтэй.

Тайванийн “Наркотикийн аюулыг таслан зогсоох тухай хууль” (毒品危害防制條例, англиар: *Narcotics Hazard Prevention Act*)-ийн дагуу хар тамхитай холбоотой дараах үйлдлүүдийг гэмт хэрэг гэж тооцдог.¹²⁸

Эдгээр нь бодисын зэрэглэл (I–IV) болон гэмт хэргийн шинж чанараас хамааран ял шийтгэл нь ялгаатай байна.

Хар тамхитай холбоотой гэмт хэргийн төрөл

1. Үйлдвэрлэх

Хар тамхи (төрөл ангиллаас үл хамааран) бэлтгэх, боловсруулах, үйлдвэрлэх, синтез хийх зэрэг үйлдлүүд орж байна. Жишээ нь героины лаборатори ажиллуулах, синтетик мансууруулах бодис үйлдвэрлэх.

2. Хил дамжуулан зөөвөрлөх / тээвэрлэх

Тайвань хилээр хар тамхи зөөвөрлөх, гаалийн мэдүүлэггүйгээр оруулах, гаргах зэрэг орно. Жишээ нь чемоданд нууж авчрах, шуудангаар илгээх.

3. Худалдах / Борлуулах / Түгээх

Мансууруулах бодисыг мөнгөөр эсвэл ямар нэг ашигтай нөхцөлөөр бусдад өгөх мөн зөвхөн борлуулсан биш, тараасан, бусдад хэрэглүүлсэн бол мөн ял шийтгэл оногдуулна.

4. Худалдах зорилгоор хадгалах

Томоохон хэмжээтэй хар тамхи хадгалж байгаа бол "худалдах зорилготой" гэж үзнэ. Энэ тохиолдолд жирийн хадгалалтаас ялгаатайгаар хүнд шийтгэл оногдуулна.

5. Хэрэглүүлэх /Хүндрүүлсэн нөхцөлтэй хэрэглэх

Бусдад хүч хэрэглэн, эсвэл хууралт, уруу татаж хар тамхи хэрэглүүлэх. Жишээ нь согтууруулах ундаа руу хар тамхи хольж өгөх, эмзэг бүлгийн хүнд хэрэглүүлэх.

6. Тарих

Кока мод, опиумын ногоо, каннабис (марихуан) зэрэг хар тамхи гарган авах зориулалттай ургамал тарих.

7. Хадгалах

¹²⁸ Narcotics Hazard Prevention Act

<https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=C0000008>

Хувийн хэрэгцээний зорилгоор ч байсан, хуульд хориглосон бодис хадгалж байвал гэмт хэрэгт тооцно. Хадгалж буй хэмжээ болон төрөлд үндэслэн ял ялгаатай (жишээ нь: 10 гр героин vs 5 гр каннабис).

8. Хэрэглэсэн байх

Хар тамхи хэрэглэсэн нь шээсний шинжилгээгээр илэрвэл ял оногдуулна; (ялангуяа I/II зэрэгт) Тайваньд хэрэглэгчид эмчилгээний чиглэлээр дахин нийгэмшүүлэхийг зорьдог ч давтан хэрэглээ хүнд ял оногдуулна.

9. Бодис тээвэрлэх хэрэгсэл хадгалах, үйлдвэрлэх

Шприц, ампул, тамхи хольж татдаг хэрэгсэл, мөхлөг шахагч гэх мэт хэрэгслийг зориулалтаар нь хадгалах, ашиглах.

10. Хар тамхины урьдчилсан гэмт хэрэг / бэлтгэл хийх

Тухайн гэмт хэргийг гүйцэлдүүлээгүй ч түүний бэлтгэлийг хийж буй үйлдэлд ял оногдуулна.

Тайваний хар тамхитай холбоотой гэмт хэрэгт хариуцлага оногдуулах хууль нь маш хатуу бөгөөд бодисын төрөл, хэмжээ, хэрэглэсэн болон бусдад нөлөөлсөн нөхцөл байдал зэргээс шалтгаалан ял шийтгэлийн түвшин эрс ялгаатай байдаг. Жишээлбэл, каннабис тарих нь хууль зөрчсөн үйлдэлд тооцогддог бөгөөд энэ нь ашгийн зорилготой эсэх, хэмжээ зэргээс хамааран 5 жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулах нөхцөл бүрдүүлдэг. Харин амфетамин хэрэглэсэн тохиолдолд хэрэглэгчийг 1 жил хүртэл хорих эсвэл донтолт тогтоогдсон бол эмчилгээний төвд шилжүүлэх боломжтой. Хэрэв тухайн этгээд өөр хүнийг хүчээр буюу албадлагаар хар тамхи хэрэглүүлсэн бол энэ нь Тайваний хуулиар онц хүнд гэмт хэрэгт тооцогдож, 10 жилээс дээш хугацаагаар хорих ял, зарим тохиолдолд бүр цаазаар авах ял хүртэл оногдуулах нөхцөлтэй. Мөн 20 грамм амфетамин хадгалсан тохиолдолд энэ нь их хэмжээний бодис хадгалсан гэж үзэгдэж, холбогдогчид 6 сараас 5 жил хүртэлх хорих ял оноох боломжтой байдаг. Ийнхүү Тайваний хууль тогтоомж нь мансууруулах бодисын хэрэглээ, хадгалалт, түгээлттэй холбоотой аливаа үйлдлийг хуулийн хатуу зохицуулалтаар хянаж, олон нийтэд хүчтэй сэрэмжлүүлэг өгдөг тогтолцоотой юм.

Тайваньд мансууруулах бодис (хар тамхи) хэрэглэх, хадгалах, үйлдвэрлэх, тээвэрлэх зэрэгтэй холбоотой гэмт хэргийн ял шийтгэлийг дараах хуулиар зохицуулж байна. Үүнд:¹²⁹

(*Narcotics Hazard Prevention Act*) Хар тамхины хорт нөлөөгөөс сэргийлэх тухай хууль <https://mojlaw.moj.gov.tw/ENG/LawContentE.aspx?LSID=FL001431>

Хар тамхины хорт нөлөөгөөс сэргийлэх тухай хуульд дараах зүйл заалтаар ял оногдуулж байна. Үүнд:

Зүйлийн дугаар	Үйлдэл	Ял
13-р зүйл (Article 13)	I зэрэгт бодис хэрэглэх	6 сар – 5 жил хүртэл хорих
14-р зүйл	II зэрэгт бодис хэрэглэх	3 жил хүртэл хорих

¹²⁹ Narcotics Hazard Prevention Act

<https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=C0000008>

20-р зүйл	III/IV зэрэгт бодис хэрэглэх	Захиргааны шийтгэл: 10,000–50,000 NTD торгууль + эмчилгээ / сургалт
-----------	------------------------------	--

Мансууруулах бодис хэрэглэсэн бол эрүүгийн хэрэг үүсгэж дараах ял шийтгэлийг оногдуулна. Үүнд:

- Героин (I зэрэг) хэрэглэсэн бол – эрүүгийн хэрэг → 6 сар – 5 жил хорих ял оногдуулна;
- Амфетамин (II зэрэг) хэрэглэсэн бол – эрүүгийн хэрэг → 3 жил хүртэл ял оногдуулна;
- Зарим тайвшруулах эм (IV зэрэг) буруу хэрэглэсэн бол – захиргааны шийтгэл оногдуулна.

Нэмэлт хуулиуд:

1. **(Criminal Code of the Republic of China)** – эрүүгийн бусад хариуцлагыг агуулдаг
- Жишээ: урьдчилан сэдсэн, бүлэглэлийн шинжтэй хэрэг гэх мэт.
2. **(Code of Criminal Procedure)** – хэрэг бүртгэл, мөрдөн шалгах, шүүх ажиллагааны журам
3. Тайваний “**Хар тамхины хорт нөлөөгөөс сэргийлэх тухай хууль**” / *Narcotics Hazard Prevention Act*)-д зааснаар, хар тамхитай холбоотой үйлдэлд оноох ялын төрөл дараах байдлаар ангилж байна.
Энэ нь тухайн бодисын зэрэглэл (I–IV), үйлдлийн шинж чанар (үйлдвэрлэх, хэрэглэх, тээвэрлэх гэх мэт) болон тоон хэмжээнээс хамаарч ялгаатай байна.

Ялын төрлийг дараах хүснэгтээр харуулбал:¹³⁰

Ялын төрөл	Тайлбар	Жишээ
1. Цаазаар авах ял	Хамгийн ноцтой I зэрэгт хар тамхи (жишээ: героин) их хэмжээгээр үйлдвэрлэх, тээвэрлэх, борлуулах үед онооно	I зэрэг бодис ≥ 1 кг
2. Үргэлжлэн (насан туршийн) хорих	Цаазаар авах ялтай ижил түвшний гэмт хэрэгт сонголт байдлаар оноож болно	I зэрэг бодис ≥ 200 г
3. 10 жилээс дээш хорих ял	Худалдах зорилгоор хадгалсан, бусдад хэрэглүүлсэн зэрэг ноцтой үйлдэл	II зэрэг бодис ≥ 400 г
4. 5–10 жил хорих	II зэрэгт бодисыг борлуулах, тараах, үйлдвэрлэх	50 г–400 г

¹³⁰ Narcotics Hazard Prevention Act

<https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=C0000008>

5. 1–7 жил хорих	I/II зэрэг бодис хадгалсан, жижиг хэмжээгээр тээвэрлэсэн	Жишээ: 10 г героин хадгалсан
6. 6 сар–5 жил хорих	I зэрэгт бодис хэрэглэсэн	Героин, морфин хэрэглэсэн
7. 3 жил хүртэл хорих	II зэрэгт бодис хэрэглэсэн	Амфетамин хэрэглэсэн
8. Захиргааны шийтгэл (торгууль, сургалт)	III/IV зэрэгт бодис хэрэглэсэн бол эрүүгийн ял биш, харин торгууль + эмчилгээ онооно	Сэтгэл засах эм буруу хэрэглэсэн

Бодисын зэрэглэл ба шийтгэлийн ялгааг дараах хүснэгтээр харуулбал:¹³¹

Бодисын зэрэг	Бодисын жишээ	Шийтгэл (ойролцоогоор)
I зэрэг	Героин, морфин, опиум	Цаазаар авах / Насан турш хорих / 10+ жил
II зэрэг	Амфетамин, каннабис	3–10 жил, хэрэглэхэд 3 жил хүртэл
III зэрэг	Тайвшруулах эм, зарим сэтгэл засах бодис	Торгууль / сургалт
IV зэрэг	Бага аюултай эм бэлдмэл	Торгууль / сургалт

4 дүгээр зүйл Хориотой бодисын ангилал¹³²

Нэгдүгээр ангиллын мансууруулах бодисыг үйлдвэрлэсэн, тээвэрлэсэн, борлуулсан этгээдийг цаазаар авах эсвэл бүх насаар нь хорих ял онооно. Бүх насаар хорих ял авсан этгээдэд 30 сая хүртэл Тайвань шинэ долларын торгууль ногдуулж болно.

Хоёрдугаар ангиллын мансууруулах бодисыг үйлдвэрлэсэн, тээвэрлэсэн, борлуулсан этгээдийг бүх насаар хорих буюу 10 жилээс доошгүй хугацаагаар хорих ял оноох ба 15 сая хүртэл Тайвань шинэ долларын торгууль ногдуулж болно.

Гуравдугаар ангиллын мансууруулах бодисыг үйлдвэрлэсэн, тээвэрлэсэн, борлуулсан этгээдийг 7 жилээс доошгүй хугацаагаар хорих ял оноох ба 10 сая хүртэл Тайвань шинэ долларын торгууль ногдуулж болно.

Дөрөвдүгээр ангиллын мансууруулах бодисыг үйлдвэрлэсэн, тээвэрлэсэн, борлуулсан этгээдийг 5-12 жилийн хооронд хугацаатай хорих ял оноох ба 5 сая хүртэл Тайвань шинэ долларын торгууль ногдуулж болно.

Мансууруулах бодис үйлдвэрлэх болон хэрэглэхэд ашиглагддаг тоног төхөөрөмжийг үйлдвэрлэсэн, тээвэрлэсэн, борлуулсан этгээдийг 1-7 жилийн хооронд хугацаатай хорих ба 1.5 сая хүртэл Тайвань шинэ долларын торгууль ногдуулж болно.

Дээрх таван хэсэгт заасан үйлдлийг хийхээр завдсан этгээдэд мөн адил ял ногдуулна.

¹³¹ Narcotics Hazard Prevention Act
<https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=C0000008>

¹³² Narcotics Hazard Prevention Act
<https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=C0000008>

Тайваний хар тамхины хэрэглээг гэмт хэрэгт тооцох эсэх¹³³

Тайваньд хар тамхины хэрэглээг хууль ёсоор гэмт хэрэгт тооцож, ял шийтгэл оногдуулдаг. Хар тамхины хэрэглээ нь тусгай хууль болон Эрүүгийн хуулийн хүрээнд зохицуулагддаг бөгөөд хэрэглээнд холбогдсон этгээдэд ял шийтгэл, торгууль, сэтгэл зүйн болон эмчилгээний арга хэмжээ авах боломжтой.

Тайваний хуульд хар тамхины хэрэглээ нь зөвхөн бие даасан хэрэг биш, харин олон тохиолдолд хар тамхины бусад гэмт хэрэгтэй (жишээ нь худалдан авалт, хадгалалт) холбогдож, хамт шийтгэгддэг. Мөн хар тамхины хэрэглэгчдэд зориулсан сэргээн засах, эмчилгээний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг

Тайваньд хар тамхины гэмт хэрэгт оногдуулдаг ял шийтгэлийн тухай хууль

Тайваньд хар тамхины хэрэгтэй холбоотой гол хуулийн баримт бичиг нь “Narcotics Hazard Prevention Act” буюу Хар тамхины хор уршгийг хориглох тухай хууль юм. Мөн хар тамхины холбогдолтой гэмт хэрэгт Эрүүгийн хуулийн холбогдох зүйл заалтууд хэрэглэгддэг. Энэ хуулиудаар хар тамхи үйлдвэрлэх, худалдах, зөөвөрлөх, хадгалах, хэрэглэсэн тохиолдолд ял шийтгэл оногдуулж байна.

Ял шийтгэл нь гэмт хэргийн ноцтой байдлаас хамааран торгууль, хорих ял, нийгмийн үйлчилгээний арга хэмжээ хүртэл ял оногдох боломжтой.

Тайваньд хар тамхины гэмт хэрэгт оногдуулдаг ялын төрлийг дараах байдлаар ангилж авч үзэх боломжтой байна. Үүнд:¹³⁴

1. Торгох ял

Хар тамхины жижиг хэмжээтэй холбогдсон тохиолдолд торгох ял оногдуулах нь нийтлэг байдаг.

2. Хорих ял

Хар тамхины үйлдвэрлэл, худалдаа, зөөвөрлөлт, хадгалалт зэрэг ноцтой гэмт хэрэгт хорих ял оногдуулдаг. Хорих ялын хугацаа гэмт хэргийн ноцтой байдлаас шалтгаалан ялгамжтай байна.

3. Нийгмийн үйлчилгээ

Зарим хөнгөн гэмт хэргийг нийгмийн сайн дурын ажил, сэргээн засах хөтөлбөрт хамруулах арга хэмжээ авдаг.

4. Эмчилгээ, сэргээн засах хөтөлбөр

Хар тамхины донтохтой холбогдуулан сэтгэл зүйн болон эмнэлгийн тусламж, сэргээн засах үйлчилгээ үзүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

Тайваньд хар тамхины хэрэгт оногдуулах торгуулийн хэмжээ

Хар тамхины хэрэгтэй холбогдуулан яллагдагчид торгуулийн ял оногдуулах бөгөөд торгуулийн хэмжээ нь үйлдлийн ноцтой байдлаас шалтгаалдаг. Жижиг хэмжээний хар тамхины хэрэглээ, хадгалалт зэрэг хөнгөн гэмт хэрэгт торгуулийн хэмжээ харьцангуй бага байж болох бөгөөд хэдэн мянган тайвань доллароор тоологддог.

¹³³ Мөн тэнд.

¹³⁴ Narcotics Hazard Prevention Act

<https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=C0000008>

Харин томоохон хэмжээтэй үйлдвэрлэл, худалдаа, зөөвөрлөлтийн гэмт хэрэгт оногдуулах торгууль илүү өндөр, сая сая тайвань доллар хүрч болно. Зарим тохиолдолд торгуулийн хамт хорих ял оногдуулах тохиолдол байдаг.

Тайваньд хар тамхины хэрэгт ял шийтгэлээс гадна авах нэмэлт арга хэмжээ

1. Сэтгэл зүйн болон эмнэлгийн эмчилгээ

Narcotics Hazard Prevention Act (Хар тамхины хор уршгийг хориглох тухай хууль) нь хар тамхины хэрэглэгчдэд сэтгэл зүйн болон эмнэлгийн эмчилгээ, сэргээн засах үйлчилгээ авах үүрэг, эрхийг тусгайлан заасан байдаг.

Хар тамхины хэрэглээг илрүүлсэн этгээдүүдийг эрх бүхий байгууллагаас эмчилгээ, сэргээн засах төвд хамруулах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх зохицуулалттай. Хууль тогтоомжийн дагуу шүүх, прокурор, шоронгийн байгууллагууд дараах нэмэлт арга хэмжээг авч хэрэгжүүлж болдог:

Албадан эмчилгээ (Mandatory Treatment):

Сэтгэцэд нөлөөлөх бодисын хэрэглээнээс шалтгаалсан хамаарал бүхий этгээдүүдийг сэтгэл зүйн болон эмнэлгийн байгууллагад эмчлүүлэхээр илгээх эрх шүүхэд бий. Эмчилгээний хугацаа нь 2 сараас 1 жил хүртэл, тухайн хүний хамаарал, зан үйлийн байдлаас хамаарч сунгаж болдог.

Сэтгэл заслын үйлчилгээ (Psychological Counseling):

Шоронгийн болон засгийн газрын харьяа сэргээн засах төвүүд дээр сэтгэл заслын үйлчилгээ үзүүлдэг. Үүнд өөрийгөө танин мэдэх, уур уцаараа зохицуулах, харилцаа сайжруулах, хамааралтай тэмцэх арга техникийг заах зэрэг хөтөлбөр багтана.

Шүүхийн өмнөх эмчилгээний хөтөлбөр (Deferred Prosecution with Treatment):

Хөнгөн зэргийн хэрэгт холбогдсон, хар тамхи хэрэглэсэн нь тогтоогдсон боловч борлуулалт хийдэггүй этгээдийг шийтгэхээс өмнө эмчилгээний хөтөлбөрт хамруулж болдог. Тус хөтөлбөрт амжилттай хамрагдсан тохиолдолд ял оноохоос татгалзах боломжтой.

“Наркотикийн аюулыг таслан зогсоох тухай хууль”-ийн хар тамхитай холбоотой ял шийтгэлээс гадна авах нэмэлт арга хэмжээнүүдэд дараах зүйл заалт ордог:

1. Үзлэг, хяналт, албадан эмчилгээ 20 дугаар зүйл

Тус арга хэмжээг (ажиглалт, журам, эсвэл албадан шалтгаантай эмчилгээ) шүүх, прокурорын шийдвэрээр хэрэгжүүлэх эрхтэй. Эмчилгээ нь 6 сар – 1 жил хүртэл үргэлжилж, тухайн хүний хамаарал, зан үйлийн байдалд үндэслэн сунгагддаг.

2. Хөнгөлөлт бүхий шүүхийн шийдвэр 24 дүгээр зүйл

Хэрэв хэрэгт холбогдсон этгээдийг амжилттай гүйцэтгэж чадвал засгийн шийтгэлгүй болох буюу (Deferred Prosecution) -ын боломжтой. Энэ нь хөнгөн зэргийн хэрэгт холбогдсон, хар тамхи хэрэглэж байгааг баталсан боловч борлуулалт хийсэнгүй бол ял оноохоос татгалзаж, эмчилгээний хөтөлбөрт хамруулах боломж олгодог.

3. Хяналт, дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх - 23 дугаар зүйл

“20-р зүйлээр” эмчилгээ амжилттай дууссаны дараа, иргэн 3 жилийн хугацаанд дахин хар тамхи хэрэглэвэл прокурор эсвэл хурлын шийдвэрээр ял тулган мөрдөж, эрүүгийн хариуцлага тооцохоор зохицуулсан байдаг.

Хүснэгтээр харуулбал:

Зүйл	Агуулга	Үр дүн
20 дугаар зүйл	Албадан эмчилгээ	6–12 сар, хяналт
24 дүгээр зүйл	Deferred Prosecution	Эмчилгээ амжилттай бол, ялгүй
23 дугаар зүйл	Суллагдсаны дараах хяналт	3 жил хүртэл хугацаанд хянаж, дахин хэрэглэвэл ял

2. Нийгмийн дэмжлэг, нөхөн сэргээх хөтөлбөр

Хэрэглэгчдийг нийгэмд эргэн оруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийгмийн ажилтнууд, мэргэжлийн баг хамтран ажиллах хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг.

3. Хууль дахь холбогдох заалтууд

Narcotics Hazard Prevention Act, Арван гуравдугаар бүлэг (Prevention and Control Measures): Хэрэглэгчдэд эмчилгээ, сэргээн засах үйлчилгээ үзүүлэх тухай зохицуулалт.

Эрүүгийн хууль: Хэрэглэгчид ял шийтгэлээс гадна сэтгэл зүйн болон нийгмийн арга хэмжээнд хамрагдах заалтуудыг багтаасан.

Тайваньд хар тамхины хэрэгтэй холбоотой хөрөнгө, хар тамхийг хураан авах арга хэмжээ¹³⁵

1. Хар тамхи болон холбогдох эд зүйлсийг хураан авахдаа Эрүүгийн хэрэг үүссэн тохиолдолд хар тамхины хууль бус эргэлтэд оролцсон бүх төрлийн бодис, бүтээгдэхүүнийг хураан авдаг. Хураан авсан хар тамхи нь тухайн хэргийг шалгах, нотлох баримт болохоос гадна устгалд оруулна.

2. Холбогдох хөрөнгө, эд хөрөнгийг хураан авахдаа хар тамхины гэмт хэргээс олсон хөрөнгө, мөнгө, бусад эд хөрөнгийг хууль бусаар олсон гэж үзэж хураан авдаг. Энэ нь хууль бус үйл ажиллагааг санхүүжүүлсэн хөрөнгө, тээвэрлэлт, хадгалалт зэрэгтэй холбоотой хөрөнгийг багтаана.

¹³⁵ Narcotics Hazard Prevention Act

<https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=C0000008>

3. Хураан авах ажиллагаа явуулахдаа хураан авах ажиллагааг шүүхийн захирамж, прокурорын зөвшөөрлөөр явуулна. Хураасан хөрөнгийг устгах, улсын орлого болгох эсвэл бусад хуульд заасан журмаар зохицуулна.

4. Хууль эрх зүйн үндэс нь энэ арга хэмжээ нь Тайваний Narcotics Hazard Prevention Act болон Эрүүгийн хуульд тусгагдсан. Хөрөнгө хураах нь хар тамхины гэмт хэрэгтэй тэмцэх чухал хэсэг бөгөөд хууль бус үйл ажиллагааны санхүүжилтийг таслан зогсоодог

Тайваньд хар тамхины гэмт хэрэг давтан үйлдсэн тохиолдолд ял¹³⁶

Хар тамхины гэмт хэргийг давтан үйлдсэн этгээдэд ял шийтгэлийг илүү хүнд, чанга болгож оноодог. Давтан үйлдэл нь эрүүгийн хуулийн дагуу хариуцлагыг нэмэгдүүлэх үндэслэл болж, хорих ялын хугацааг уртасгах, торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг хариуцлагын хүндрэлийг авчирдаг. Мөн зарим тохиолдолд сэтгэл зүйн болон сэргээн засах үйлчилгээ авах хугацаа, шаардлага нэмэгдэж болно.

Зохион байгуулалттай гэмт бүлэглэл, хуулийн этгээд үйлдсэн хар тамхины гэмт хэргийн ял шийтгэл¹³⁷

1. Зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн ял шийтгэл

Зохион байгуулалттай гэмт бүлэглэлээр хар тамхины гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд ял шийтгэл нь илүү хүнд, чанга байдаг. Ийм гэмт хэрэгт холбогдсон этгээдүүдэд урт хугацааны хорих ял, өндөр торгууль оногдуулж, гэмт хэргийн сүлжээг устгах, санхүүгийн хөрөнгийг хураах арга хэмжээг авдаг. Мөн зохион байгуулалттай гэмт бүлэглэлд холбогдсон хүмүүсийг Эрүүгийн хуулийн тусгай заалтуудын дагуу нэмэлт ял шийтгэдэг.

2. Хуулийн этгээдийн хариуцлага

Хуулийн этгээд (компани, байгууллага, аж ахуйн нэгж гэх мэт) хар тамхины гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд хууль ёсны хариуцлага хүлээнэ. Хуулийн этгээдийн эсрэг авдаг арга хэмжээ нь торгуулиас гадна үйл ажиллагааг түр зогсоох, татан буулгах хүртэлх арга хэмжээ байж болно. Хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтнууд нь хувь хүн хувиараа эрүүгийн хариуцлага хүлээж болно.

Зохион байгуулалттай хар тамхины гэмт хэрэгтэн, бүлэглэлийн гишүүдэд холбогдох эрүүгийн хариуцлагыг өндөржүүлсэн заалтууд байдаг. Энэ нь гэмт хэргийн ноцтой байдлыг харгалзан үзэж, яллах, хорих ялын хугацааг уртасгах, торгууль өндөр байхаар зохицуулагдсан.

¹³⁶ Narcotics Hazard Prevention Act

<https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=C0000008>

¹³⁷ Narcotics Hazard Prevention Act

<https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=C0000008>

Хил давуулан буюу үндэстэн дамнасан хар тамхины гэмт хэрэгт оногдуулах ял¹³⁸

1. Хилийн чанад дахь хар тамхины гэмт хэрэгтэй хамтран ажиллах, хил давуулан зөөвөрлөх нь эрүүгийн ноцтой төрлийн гэмт хэрэгт тооцогддог.
2. Ялын хэмжээ нь хатуу, урт хугацааны хорих ял болон өндөр торгуулийг хамардаг.
 - Хорих ялын хугацаа ихэвчлэн олон жил (жишээ нь 5-аас дээш жил) байж болох бөгөөд зарим тохиолдолд насаар хорих хүртэл ял оногдуулдаг.
3. Ял хүндэрдэг онцлог
 - Хил дамнасан болон олон улсын хар тамхины гэмт хэргийн сүлжээтэй холбоотой үйлдлийг онцгой хүнд гэмт хэрэг гэж үздэг тул ял шийтгэл илүү хүндэрдэг.
 - Гэмт хэргийн сүлжээг удирдсан, зохион байгуулсан, санхүүжүүлсэн зэрэг тохиолдолд нэмэлт ял оногдуулах боломжтой.
4. Хөрөнгө хураалт болон бусад нэмэлт арга хэмжээ
 - Гэмт хэргээс олсон хөрөнгийг хураан авах, мөнгө угаахтай тэмцэх онцгой арга хэмжээ авч хэрэгжүүлдэг.

Хар тамхины гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээ

1. Урьдчилан сэргийлэх сургалт, боловсрол
 - Сурагч, оюутан, залуучууд болон олон нийтэд зориулсан хар тамхины хор уршгийг ойлгуулах, сөрөг нөлөөллийг бууруулах сургалт, кампанит ажил зохион байгуулдаг.
2. Сэтгэл зүйн болон нийгмийн дэмжлэг
 - Хар тамхины хэрэглээ, донтох эрсдэлтэй хүмүүст зориулсан сэтгэл зүйн зөвлөгөө, эмчилгээ, сэргээн засах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.
 - Гэр бүл, орчин тойрны дэмжлэгийг сайжруулах, сөрөг нөлөөллийг багасгах үйл ажиллагаа явуулдаг.
3. Ажлын байр, боловсрол олгох хөтөлбөр
 - Гэмт хэрэгтэн, өндөр эрсдэлтэй бүлэгт ажил хөдөлмөр эрхлэх, мэргэжил эзэмших боломж олгож, нийгэмд дахин оруулах замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлдэг.
4. Хууль эрх зүйн зохицуулалт, сахилга бат
 - Хар тамхитай холбоотой хууль сахиулах ажиллагааг сайжруулж, гэмт хэрэгтнүүдийг хурдан илрүүлж, хариуцлага тооцох замаар гэмт хэргийн гаралтыг бууруулдаг.
5. Олон улсын хамтын ажиллагаа
 - Хар тамхины гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын туршлага, мэдлэгийг нэвтрүүлж, хамтарсан арга хэмжээг хэрэгжүүлдэг.

Тайваньд хар тамхины хууль бус эргэлттэй тэмцэх тусгай байгууллага

Тайваньд хар тамхины хууль бус эргэлт, гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр тусгай эрх, үүрэг бүхий байгууллага байдаг. Энэ байгууллага нь ихэвчлэн Цагдаагийн Ерөнхий

¹³⁸ Narcotics Hazard Prevention Act

<https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=C0000008>

Газрын Хар тамхитай тэмцэх хэлтэс бөгөөд хар тамхины гэмт хэрэг илрүүлэх, мөрдөн шалгах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг гүйцэтгэдэг. Мөн прокурор, шүүх, хууль сахиулах бусад байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, хар тамхины эсрэг бодлого, хэрэгжилтийг хангадаг. Хар тамхитай тэмцэхэд зориулсан олон улсын хамтын ажиллагааны төв болох зэрэг олон чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Тайваньд хар тамхитай тэмцэх, урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр, стратеги, төлөвлөгөө¹³⁹

Үндэсний хөтөлбөр, стратеги, төлөвлөгөө

Тайваньд төрөөс хар тамхитай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр үндэсний хэмжээний хөтөлбөр, стратеги, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлдэг. Энэхүү хөтөлбөр нь холбогдох бүх байгууллага, түүний дотор хууль сахиулах, эрүүл мэндийн байгууллага, боловсролын салбар, нийгмийн үйлчилгээний байгууллагуудыг оролцуулан нэгдсэн зохион байгуулалттай хэрэгждэг.

Хөтөлбөрийн үндсэн агуулга

1. Хар тамхины хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх
 - Олон нийтэд хар тамхины хор уршгийг таниулах, боловсрол, сургалт явуулах.
 - Залуучуудыг онцгойлон хамгаалах, эрсдэлтэй бүлгүүдэд чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль сахиулах ажиллагааг сайжруулах
 - Хар тамхины хууль бус эргэлтийг таслан зогсоох, гэмт хэрэгтнүүдийг илрүүлэх, ял шийтгэл оногдуулах ажлыг эрчимжүүлэх.
3. Сэргээн засах, эмчилгээний үйлчилгээ
 - Донтох эмгэгтэй хүмүүст зориулсан эмчилгээ, сэтгэл зүйн тусламж, нийгмийн дэмжлэгийг сайжруулах.
4. Олон улсын хамтын ажиллагаа
 - Хар тамхитай тэмцэхэд олон улсын туршлага, мэдээлэл солилцох, хамтарсан ажиллагаа эрхлэх.
5. Мэдээллийн сан, судалгаа, үнэлгээ
 - Хар тамхитай холбоотой гэмт хэргийн тархалт, үр дагаврыг судлах, хөтөлбөрийн үр дүнг үнэлэх.

Тайваньд хар тамхины хэрэгт Эрүүгийн хуулиас гадна өөр хуульд шийтгэл оногдуулах тухай

Тайваньд хар тамхины гэмт хэрэгтэй холбоотой үндсэн ял шийтгэлийг эрүүгийн хуулиар зохицуулдаг. Харин Зөрчлийн тухай хууль болон бусад хөнгөн зөрчлүүдийг зохицуулсан хуульд хар тамхины хэрэглээ, жижиг хэмжээний хадгалалт зэрэг хөнгөн зөрчилд торгууль, анхааруулга зэрэг шийтгэл оногдуулах боломж байдаг. Жишээлбэл,

¹³⁹ UNODC – Taiwan Drug Control Strategies

жигжиг хэмжээний хар тамхи хэрэглэсэн тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэхээс гадна, зөрчлийн журмаар торгууль ногдуулах зохицуулалт байж болно. Ийм хөнгөн шийтгэл нь голчлон урьдчилан сэргийлэх, дахин гэмт хэрэг Тайваньд хар тамхитай холбоотой бусад онцлог эрх зүйн зохицуулалт

1. Эрүүл мэнд, сэргээн засах чиглэлийн хууль тогтоомж
 - Хар тамхины хэрэглэгчид, донтох эмгэгтэй хүмүүст зориулсан сэтгэл зүйн болон эмнэлгийн эмчилгээ, сэргээн засах үйлчилгээг хуульчилсан.
 - Донтохоос сэргийлэх, эрүүл мэндийг хамгаалах тусгай хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг.
2. Хууль сахиулах байгууллагуудын эрх мэдэл, хамтын ажиллагаа
 - Хар тамхитай тэмцэхэд цагдаа, прокурор, шүүх, тусгай албаныхан хоорондын харилцан уялдаа, мэдээлэл солилцоог хуулиар баталгаажуулсан.
 - Олон улсын хар тамхитай тэмцэх хэлэлцээр, протоколд нэгдэн орсон.
3. Хөрөнгө хураах, мөнгө угаахтай тэмцэх эрх зүйн зохицуулалт
 - Хар тамхины гэмт хэрэгт ашиглагдсан хөрөнгө, эд хөрөнгийг хураах, мөнгө угаахтай тэмцэх хууль эрх зүйн зохицуулалттай.
4. Олон улсын хамтын ажиллагаа
 - Тайвань олон улсын хар тамхитай тэмцэх байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцох, хамтарсан мөрдөн шалгах ажиллагаанд оролцдог.
5. Хүмүүнлэг, хүний эрхийн хэм хэмжээ
 - Хар тамхины хэрэглэгчдийн эрхийг хамгаалах, ял шийтгэлийг хүний эрх, хүмүүнлэгийн зарчмын хүрээнд зохицуулдаг.

Харьцуулсан судалгааны үүднээс дээрх 3 улсын туршлагыг дүгнэхэд Монгол Улсын мансууруулах бодистой тэмцэх тогтолцоо нь илүү уялдаа холбоотой, салбар хоорондын хамтын ажиллагаанд суурилсан, урьдчилан сэргийлэх, эмчилгээ, нөхөн сэргээх, хууль сахиулалтыг хослуулсан иж бүрэн систем рүү шилжих шаардлагатай байна. ХБНГУ болон Нидерланд улсын дараах туршлагаас нэвтрүүлэх нь энэхүү шинэчлэлийг хэрэгжүүлэхэд жишиг болохуйц гэж үзлээ.

Нэгдүгээрт, Германд мөрдөгдөж буй Эрүүгийн хууль (StGB), Мансууруулах бодисын тухай хууль (BtMG), Зөрчлийн хууль (OWiG) зэрэг нь мансууруулах бодистой холбоотой үйлдэл бүрийг тодорхой зааж, хариуцлага, ял шийтгэл, нөхөн сэргээх болон сэргийлэх арга хэмжээг багтаасан нь эрх зүйн уялдаа, хэрэгжилтийн үр нөлөөг хангаж өгдөг. Монгол Улсын хувьд ч мөн адил Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд хар тамхитай холбоотой үйлдлийг хориглож, ял шийтгэл тогтоосон хэдий ч **эмчилгээ, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрх зүйн хүрээнд системтэйгээр тусгасан зохицуулалт дутмаг** байгаа нь анхаарах шаардлагатай асуудал юм.

Хоёрдугаарт, Германд хэрэгжүүлж буй урьдчилан сэргийлэх бодлого нь зөвхөн хууль сахиулах түвшинд бус, боловсрол, олон нийтэд мэдээлэл түгээх, сургалтын тогтолцоотой уялдаж ажилладаг. Харин Монгол Улсад энэ чиглэлийн сургалт, мэдээлэл түгээх ажил хэсэгчилсэн, төсөл хөтөлбөрийн хүрээнд хязгаарлагдсан байдлаар явагдаж, **байнгын тогтолцоогүй, залуучуудад чиглэсэн тасралтгүй урьдчилан сэргийлэх тогтолцоо бүрдээгүй** байна.

Гуравдугаарт, Германд донтсон хүмүүсийг эмчлэх, нийгэмд дахин нэгтгэх иж бүрэн үйлчилгээ, эмнэлэг, мэргэжлийн байгууллагын сүлжээ бий. Монгол Улсад ийм үйлчилгээ байгаа ч хүртээмж багатай, мэргэшсэн боловсон хүчин дутмаг, **эмчилгээний үр нөлөө, дахин нийгэмшүүлэх арга хэмжээ сул** байгааг засах шаардлагатай. Нидерландын хохирол бууруулах, нийгэмшүүлэхэд чиглэсэн туршлагад тулгуурлан мансууруулах бодис хэрэглэсэн этгээдийг ял шийтгэхээс илүүтэйгээр эмчилгээ нөхөн сэргээх сэтгэл заслын болон нийгмийн үйлчилгээ үзүүлэх зохицуулалтыг манай улсын эрх зүйн зохицуулалтад тусгах нь зүйтэй. Мөн улсын хэмжээнд донтолтын эмчилгээ, нөхөн сэргээх төвүүдийн бий болгох.

Дөрөвдүгээрт, Тайваний эрх зүйн тогтолцоо нь мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт эрүүгийн хатуу хариуцлага хүлээлгэхээс гадна, хөнгөн зөрчлийг торгууль, анхааруулга, эмчилгээний арга хэмжээгээр зохицуулах уян хатан бүтэцтэй байна. Энэ нь гэмт хэргийн ноцтой байдлаас шалтгаалан ял шийтгэлийг олон түвшинд оногдуулах боломжийг бүрдүүлдэг. Тайваньд мансууруулах бодист донтолтыг эмнэлгийн байдал гэж үзэн, эмчилгээний төвүүдэд шилжүүлэх замаар дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлдэг байна.

Тавдугаарт, хууль сахиулах байгууллагуудын уялдаа холбоо, мэдээлэл солилцоо, олон улсын хамтын ажиллагаа нь хар тамхины эсрэг тэмцэлд амжилттай хэрэгжих гол үндэс болдог. Монгол Улсын хувьд холбогдох байгууллагууд хоорондын уялдаа хангалтгүй, мэдээллийн нэгдсэн сан үгүйлэгдэж байгаа нь хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах үйл явцад **саад болж болзошгүй.**

Зургаадугаарт, хүний эрх, хувийн нууцыг хамгаалах зарчимд суурилсан мөрдөн шалгах ажиллагаа нь шударга шүүх ажиллагааг хангадаг. Монгол Улсад хүний эрхийг хамгаалах зохицуулалт Эрүүгийн болон Прокурорын тухай хуульд тусгагдсан боловч практикт мөрдөн шалгах үйл явц дахь **эрх зүйн хамгаалалт сул, дотоод хяналт муу** байж болзошгүй эрсдэл ажиглагддаг.

ДҮГНЭЛТ

Монгол Улс Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай тусгайлсан хууль 2002 онд баталж, олон улсын 3 конвенцод нэгдсэний зэрэгцээ Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Засгийн газрын 2024-2028 оны мөрийн хөтөлбөр зэрэг цөөнгүй бодлогын баримт бичгүүдэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар эрх зүйн орчин бүрдүүлж ирсэн.

Гэсэн хэдий ч Монгол Улсад 2014-2024 он хүртэл 10 жилийн хугацаанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ болон түүнтэй холбоотой гэмт хэрэг тогтмол өсч, үндэстэн дамнасан шинжтэй болж, дамжуулагч улсаас хэрэглэгч улс руу шилжиж, гэмт хэргийн нөхцөл байдал улам доройтон байгаа нь түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ үр дүн муутайг харуулж байна.

Эрүүгийн хариуцлага оногдуулж байгаа эрх зүйн зохицуулалт нь Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн 1-4 дэх хэсэгт зааснаар “...нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”, “...хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”, “...таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”, “...арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.” гэсэн нь хорихоос өөр төрлийн альтернатив ялын төрөл хомс зөвхөн хорих ял оногдуулахаар заажээ. Хуулийн заалт практикт хэрэгжиж буй байдлыг авч үзэхэд 2022-2024 оны 3 жилээр байдлаар шүүхээс торгох ялаар 1, нийтэд тустай ажил хийлгэх ял 5, зорчих эрхийг хязгаарлах ял 215 байгаа бол хорих ялыг хамгийн түгээмэл буюу 454 байгаа нь нийт оногдуулсан ялын 67 хувийг хорих ял эзэлж байна.

Гэтэл давтан гэмт хэрэг үйлдэж, хорих ялаар шийтгүүлэх явдал өндөр хувьтай байгаа юм. Тухайлбал, 2023 онд хорих ял эдэлж буй этгээдийн 65.3%, 2024 онд 71% нь давтан гэмт хэрэг үйлдэж хорих ял эдэлж байна. Энэ нь хорих ялын үр нөлөө маш муу байгааг нотолж буй хэрэг бөгөөд донтолттой хоригдолд ямар ч эмчилгээ хийхгүйгээр хорих нь олон удаа шоронд хоригдох нөхцөлийг үүсгэж хорих ангийн ачаалал, хоригдлын тоог нэмэгдүүлж байна.

Хорих ял оногдуулах хувь ихээхэн өндөр, эмчилгээний арга хэмжээ авдаггүй Монгол Улсын ялын бодлогын тогтолцоо нь өвчтөн бус-гэмт хэрэгтэн гэж үзэх хандлага зонхилсон, эмчлэх бус цээрлүүлэх ёстой гэсэн зарчмын хүрээнд хэрэгжиж байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, бусад улс оронд яллахад суурилсан ялын бодлогоос татгалзаж, эмчилгээнд төвлөрсөн төрийн бодлого баримталж буй өнөө цагт Монгол Улсад олон улсын гэрээ болон гадаадын орнуудад энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд хамгийн чухалд тооцогдож буй эмчилгээ, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байгаа нь давтан гэмт хэргийн хувь болон гэмт хэргийн өсөлтөд нөлөөлж байна гэж дүгнэлээ. Эрүүгийн хуулийн 6.4 дүгээр зүйлийн 9 дэх хэсэгт “шүүх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл, согтуурах, мансуурах донтой байдлыг харгалзан сэтгэл заслын, донтох зуршлын эсрэг эмчилгээ хийлгэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулж болно”¹⁴⁰ гэсэн нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд донтох

¹⁴⁰ Эрүүгийн хууль, 7.4 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг.

зуршлын эсрэг эмчилгээ хийлгэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авч болох суурь эрх зүйн зохицуулалт юм. Гэсэн хэдий ч шүүхээс ял оногдуулж буй байдлыг үзэхэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэхгүй байна. Тухайлбал, 2025 онд (1-6 дугаар сар) ЭХ-ийн 20.7.1 дэх хэсэгт зааснаар ял оногдуулсан шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж үзэхэд ЭХ-ийн 7.4 дүгээр зүйлийн 9 дэх хэсэгт зааснаар эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авсан тохиолдол нэг ч байхгүй байна.

Иймд цаашид хорихоос өөр төрлийн ял ялангуяа торгох, зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулах эрх зүйн зохицуулалтыг өргөжүүлэхийн зэрэгцээ ял дээр нэмэгдэл болгон эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ болох эмчилгээ хийх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, практикт өргөнөөр хэрэгжүүлэх ялын бодлого баримтлах шаардлагатай.

Судалгаагаар олон улсын нэгдэн орсон гэрээ конвенциудын хүрээнд тодорхойлогдсон үндсэн асуудлуудыг Монгол Улсын эрх зүйн зохицуулалт, өнөөгийн байдалтай харьцуулсан бөгөөд нэгдүгээрт гэмт хэргийн зарим төрлийг хуульчлаагүй орхисон, хоёрдугаарт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хор уршгийн төрөл, хэмжээгээр ангилал, ангиллын дагуу гэмт хэргийн хөнгөн хүндэд хуваах, гуравдугаарт хорих ялын зэрэгцээ нэмэлт арга хэмжээ авах буюу эмчлэх, хүмүүжүүлэх, эмнэлгийн дараахь эмчилгээ хийх, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргүүлэн оруулах арга хэмжээг хэрэгжүүлэх, дөрөвдүгээрт хөрөнгө хураан авах, хэрэгтнийг шилжүүлэх өгөхтэй холбоотой процессын зарим асуудалд конвенцын дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх зэрэг юм.

Тодруулбал, Эрүүгийн хуулийн дээрх 4 зүйлд заасан гэмт хэргийн объектив талын үйлдлүүдийг олон улсын гэрээнд заасан харьцуулан үзэхэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг үйлдвэрлэх, гаргаж авах, санал болгох, түгээх, хүргэх, зуучлах, дамжуулан өнгөрүүлж илгээх, экспортлох, импортлох үйлдлүүдийг Эрүүгийн хуульд тусгаагүй бөгөөд Зөрчлийн тухай хуулийн 6.4 дүгээр зүйлд үйлдвэрлэх, бэлтгэх, боловсруулах, тээвэрлэх, улсын хилээр нэвтрүүлэх зэргээр заасан зарим үйлдлийг зөрчилд тооцож, ял хөнгөдүүлж байгаагийн зэрэгцээ зарим үйлдлүүд огт тусгагдаагүй нь гэмт этгээд ял завших боломжийг бий болгожээ. Мөн конвенцод заасан худалдаж авах үйлдлийг Эрүүгийн хуульд тусгаагүй нь учир дутагдалтайн зэрэгцээ санхүүгийн үйл ажиллагаа явуулах, үйлдэхээр үгсэн тохиролцох зэрэг үйлдлийг тухайлан дурдсаныг Эрүүгийн хуульд нарийвчлан тусгах нь зүйтэй.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын төрөл, хэмжээг ялгахгүйгээр зүйлчилж байгаа нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.3 дугаар зүйлд заасан “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна” гэсэн шударга ёсны зарчмын үзэл санаатай нийцэхгүй байна гэж дүгнэлээ. Түүнчлэн бодисын ангилалтай холбоотой Манай улсын хууль, эрх зүйн орчин бүрхэг, зохицуулалт дутмаг байгаагаас шинэ төрлийн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис олон улсын гэрээнд заасан жагсаалтад байхгүй гэдэг үндэслэлээр гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх боломжгүй нөхцөл байдалтай байна.

Гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүний талаар анхааран үзэх зохих дараах асуудлуудыг тодорхойлсон нь олон улсын зохион байгуулалттай гэмт бүлгийн үйлдсэн гэмт хэрэгт оролцсон, тухайн гэмт хэрэг үйлдсэний улмаас хууль бус бусад үйл ажиллагаанд оролцсон, гэмт этгээд хүч, эсхүл галт зэвсэг хэрэглэсэн, гэмт этгээд албан тушаалтан бөгөөд гэмт хэрэг нь албан тушаалтай нь холбоотой, гэмт хэргийг үйлдэхэд

насанд хүрээгүй хүнийг татан оруулсан, ашигласан, гэмт хэргийг хорих ял эдлүүлэх газар, сургууль, олон нийтийн үйлчилгээний газар, эсхүл сурагч, оюутны сургалт, олон нийтийн үйл ажиллагаа явуулдаг газарт үйлдсэн, дотоодын хуулиар хуульчилсан хэмжээнд гадаад улсад болон эх орондоо урьд нь ял шийтгэгдсэн, ялангуяа ижил төрлийн гэмт хэрэгт шийтгэгдсэн нөхцөл байдал байвал ял хүндрүүлнэ гэсэн байдаг.

Гадаад улсын туршлагыг судлахад эмчилгээнд суурилсан ялын бодлого баримтлах явдал нэгдүгээрт тавигдаж буй бөгөөд донтох эмчилгээний үе шаттай тогтолцоо нэвтрүүлэх, хохирол бууруулах бодлого нэвтрүүлэх, залуучуудын эрсдэлийг бууруулах анхаарсан хөтөлбөр хэрэгжүүлэх, мэдээлэл, судалгаа, үнэлгээний тогтолцоог сайжруулах, албадан эмчилгээ, нөхөн сэргээх тогтолцоог сайжруулах зэрэг асуудлуудыг анхаарч хэрэгжүүлж байна. Хууль сахиулах байгууллагуудын уялдаа холбоо, мэдээлэл солилцоо, олон улсын хамтын ажиллагаа нь хар тамхины эсрэг тэмцэлд амжилттай хэрэгжих гол үндэс болдог. Монгол Улсын хувьд холбогдох байгууллагууд хоорондын уялдаа хангалтгүй, мэдээллийн нэгдсэн сан үгүйлэгдэж байгаа нь хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах үйл явцад сөргөөр нөлөөлж байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Дээрх судалгааны ажлын үр дүнд дараах санал зөвлөмжийг дэвшүүлж байна.

1. Эрүүгийн хуульд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн зарим үйлдлийг хуульчлахгүй орхигдуулсан нь гэмт хэрэгтнийг ял завшуулах нөхцөл байдалд хүргэжээ. Иймд олон улсын гэрээнд нийцүүлэн гадаадын туршлагаас суралцан гэмт хэргийг үйлдлүүдийг нарийвчлан тусгахаар Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах. Үүнд: мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг үйлдвэрлэх, бусдад зуучлах, санал болгох, хэрэглүүлэх, худалдахаар санал болгох, худалдах, худалдан авах, түгээх, зуучлах, импортлох болон экспортлох, захиалах, тарималжуулах зэрэг болно.

2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ангиллыг олон улсын гэрээнд нийцүүлэн тодорхойлж, бодисын төрөл болон хэмжээтэй уялдуулан ялыг ялгамжтай оногдуулах шаардлагатай. Тухайлбал, байгалийн болон синтетик бодисын хор хөнөөлийн ялгаатай байдал буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын төрөл болон түүний хэмжээг тооцон ял оногдуулах эрх зүйн зохицуулалт бий болгох.

3. Хорих ял нь үр нөлөө муутай байгаа нь тогтоогдож байгаа тул хорихоос өөр төрлийн ял оногдуулах альтернатив хувилбарыг Эрүүгийн хуульд нарийвчлан зохицуулах. Хорих ялаас илүүтэй зорчих эрхийг хязгаарлах, торгох, эрх хасах зэрэг ялуудыг оногдуулах талаар хуульчид, хууль хэрэгжүүлэгчид сургалт оруулах.

4. Ялын зэрэгцээ эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох. Эмчилгээнд суурилсан ялын бодлогыг түлхүү баримтлах талаар холбогдох төрийн байгууллагууд, бодлого боловсруулагчид анхааран үзэх.

5. Эмнэлгийн болон сэтгэл зүйн туслалцаа авах эмчилгээний арга хэмжээг ялтанд хэрэглэх дэд бүтцийг бүрдүүлэх. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдсэн этгээдийг зориулалтын эмнэлэг, эмчилгээний байгууллагад хамрагдах боломжийг төрөөс бүрэн хариуцан байгуулах. Ингэхдээ төрийн болон төрийн бус байгууллагын нөөц боломж, хүний нөөцөд тулгуурлан явуулах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх.

6. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх эрх зүйн зохицуулалт, тусгайлсан хуулийг шинэчлэн батлах. Үндэсний хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх. Энэхүү хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулахдаа харьцуулсан судалгааны үр дүнд суурилан гадаадын сайн туршлагыг нэвтрүүлэх.

7. Гэмт хэргээс урьдчилан тусгай хөтөлбөрүүдийг хэсэгчилсэн, төсөл хөтөлбөрийн хүрээнд хязгаарлагдсан байдлаар бус хэрэгжүүлэх буюу байнгын тогтолцоотой, залуучуудад чиглэсэн тасралтгүй урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох.

8. Гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх ажиллагааг хорих ангид болон нийгэмд суурилж хэрэгжүүлэх. ТББ болон олон нийтийн дэмжлэгтэйгээр гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх талаар хөтөлбөр хэрэгжүүлэх.

ЭХ СУРВАЛЖ

Монгол хэл дээрх эх сурвалж

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц, 1961
3. Сэтгэцэд нөлөөт бодисын тухай конвенц, 1971
4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц, 1988
5. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, 2002
6. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2019
7. ЭХХШТХ, 2017
8. Эрүүгийн хууль, 2015
9. Зөрчлийн тухай хууль, 2015
10. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010
11. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр,
12. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
13. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар товч танилцуулга, <https://www.mojha.gov.mn/content/663c3d4d9fea4ca6d5e6d21f>
14. Хүний эрх болон хар тамхины бодлого дахь олон улсын удирдамж, НҮБХХ, ДЭМБ, Хүний эрх ба хар тамхины бодлогын олон улсын төв зэрэг байгууллагуудаас гаргасан. 2019 он <https://www.undp.org/publications/international-guidelines-human-rights-and-drug-policy>

Ном, сурах бичиг, судалгааны тайлан

1. Гэмт хэргийн цагаан ном, Уб., 2023 он
2. ХЗҮХ, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” сэдэвт судалгаа, Уб., 2024 он.
3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэхэд байгууллагуудын хамтын ажиллагаа эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, Уб., 2025 он.
4. Монгол Улс дахь мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэрэгт ногдуулж буй ял шийтгэл, тулгамдаж буй асуудал, сэдэвт судалгааны тайлан, Уб., 2013 он.
5. Хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал” сэдэвт судалгаа, Уб., 2016 он.
6. Хар тамхины гэмт явдал: шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, Уб., 2018 он.

7. Б.Энхболд, С.Гантулга, Эрүүгийн эрх зүй тусгай анги, Уб., 2024 он
8. Судалгааны тайлангийн эмхэтгэл XXII боть, ХЗҮХ, Уб., 2025 он

Гадаадын хэл дээрх сурвалж

Хууль тогтоомж

1. Нидерланд улсын хар тамхины бодлогын талаарх ерөнхий мэдээлэл, зөөлөн болон хатуу хар тамхины ялгаа, кофешопуудын зохицуулалт зэрэг мэдээллийг агуулсан. <https://www.government.nl/topics/drugs>
2. Нидерланд улсын хуулиар зөөлөн хар тамхи нь эрүүл мэндэд илүү бага аюултай гэж үздэг бөгөөд каннабисыг зөөлөн хар тамхинд тооцдог. <https://www.government.nl/topics/drugs>
3. Нидерланд улсын кофешопууд нь каннабисыг тодорхой нөхцөлтэйгөөр борлуулахыг зөвшөөрдөг бөгөөд энэ нь Засгийн газрын тэвчээрийн бодлогын хүрээнд хийгддэг. <https://www.government.nl/topics/drugs>
4. <https://www.government.nl/topics/drugs>
5. Criminal code <https://wetten.overheid.nl/BWBR0001854/2025-07-01>
6. Dutch Opium Act (Opiumwet) <https://wetten.overheid.nl/BWBR0001941/2009-07-01>
7. Dutch national focal point https://www.euda.europa.eu/about/partners/reitox/netherlands_en
8. Dutch National Prosecution Service and police launch Hidden Service in global Darknet enforcement operation <https://www.prosecutionservice.nl/latest/news/2019/10/31/dutch-national-prosecution-service-and-police-launch-hidden-service-in-global-darknet-enforcement-operation>
9. Ministry of Justice (АНУ-ны ангилалтай) – *Narcotics Hazard Prevention Act* <https://mojlaw.moj.gov.tw/ENG/LawContentE.aspx?LSID=FL001431>
10. Ministry of Justice– хятад хэл дээрх хууль, хавсралтууд <https://mojlaw.moj.gov.tw/LawContentSearch.aspx?LSID=FL001431>
11. Judicial§ Law and Regulations Retrieving System <https://legal.judicial.gov.tw/LAWENG/FLAW/dat02.aspx?lsid=FL001431>
12. Rootlaw-зарим заалтууд болон урьдчилсан арга хэмжээний тухай: <https://www.rootlaw.com.tw/en/LawContent.aspx?LawID=A060050000000900-1060614>
13. Taipei Times мэдээлэл – шинэчилж батлагдсан нэмэлт өөрчлөлтийн тухай тайлбар: <https://www.taipeitimes.com/News/front/archives/2019/12/18/2003727740>
14. Third phase of anti-drug strategy aims for a drug-free, healthier Taiwan <https://english.ey.gov.tw/Page/61BF20C3E89B856/a09da8ba-b68a-4a57-a817-ce2249b522ad>
15. New Generation Anti-drug Strategy 2.0 <https://english.ey.gov.tw/News3/9E5540D592A5FECD/6d06eb32-bec0-4858-8ba4-eb5b0ae859a3>
16. Operation 'safe home': Eliminating the threat of illegal drugs in communities <https://english.ey.gov.tw/News3/9E5540D592A5FECD/43d7c244-873c-4792-ac35-1803564bebe9>
17. Operation "safe home" combats drugs at the source <https://english.ey.gov.tw/Page/61BF20C3E89B856/db4f5cbf-5753-48dc-a140-50f0997931b4>

18. Premier highlights 3 major measures in all-out fight against drugs
<https://english.ey.gov.tw/Page/61BF20C3E89B856/fe0a0742-3007-4558-bd3a-2b33ab07b400>
19. Taiwan's new-generation strategy to combat drug abuse
<https://english.ey.gov.tw/News3/9E5540D592A5FECD/e5c66b8d-ab0c-45a0-ae9e-395849b75681#U>
20. “Drug offences and narcotics criminal law” – Hanse Strafrecht: VtMG-ийн §29–30a болон ял шийтгэлийн нарийн тайлбар <https://hanse-strafrecht.de/de/160526-betaeubungsmittelstrafrecht>
21. Threshold quantity sheet – EUDA: ХБНГУ-ын жижиг хэмжээний гадна бусад орнуудтай харьцуулсан хэмжээний жагсаалт
<https://www.euda.europa.eu/publications/topic-overviews/threshold-quantities-for-drug-offences>
22. “Issues in Narcotics Criminal Law” – Criminal Defense Munich: Жижиг ба их хэмжээний тодорхойлолт, прокурорын болон шүүхийн практик
23. Munich өмгөөлөгч нарын тайлбар – §29 §30/§30a зэрэгт заасан хэрэг үүсэх нөхцөлүүд
<https://www.criminal-defense-munich.com>
24. Drug offences and narcotics criminal law <https://hanse-strafrecht.de/en/161212-Drug-offences-and-narcotics-criminal-law>
25. Issues in Narcotics Criminal Law | Criminal Defense Munich <https://www.criminal-defense-munich.com/issues-in-narcotics-criminal-law>

Ном, сурах бичиг, судалгааны тайлан

1. OSCE, National Referral Mechanisms: Joining Efforts to Protect the Rights of Trafficked Persons.
2. Declaration of Basic Principles of Justice for Victims of Crime and Abuse of Power | OHCHR [Lee Ann Dunbar, Getting Restitution into the Hands of Trafficking Victims, 2024](#)
3. Damages in Florida Human Trafficking Lawsuits February 3, 2021 | Attorney, Matthew Dolman, <https://www.dolmanlaw.com/blog/human-trafficking-lawsuit-damages/>
4. Best v. Taylor Mach. Works, 689 NE 2d 1057 - Ill: Supreme Court 1997.
5. The Ryan Law Group, How To Calculate Pain And Suffering In California, <https://theryanlawgroup.com/how-to-calculate-pain-and-suffering-in-california/>
6. Perenich, Caulfield, Avril & Noyes Personal Injury Lawyers, The Two Calculation Methods for Pain and Suffering Damages
<https://usalaw.com/personal-injury-resources/how-are-pain-and-suffering-damages-calculated/>

ХАВСРАЛТ. ГАДААД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУРШЛАГА¹⁴¹

№	Асуудал	Нидерланд улс	ХБНГУ	Тайвань
1.	Ямар үйлдлийг хар тамхины гэмт хэрэг гэж тооцдог	<p>Нидерланд улсад хар тамхитай холбоотой дараах үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцдог. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> Хар тамхи үйлдвэрлэх, боловсруулах; <ul style="list-style-type: none"> Героин, кокаин, экстази, метамфетамин зэрэг хатуу хар тамхины хууль бус үйлдвэрлэл, боловсруулах, эсвэл химийн бодис ашиглан гарган авах үйлдэл. Хар тамхины худалдаа, тээвэрлэлт; <ul style="list-style-type: none"> Хуурамч буюу хууль бус аргаар хар тамхи худалдан борлуулах, дамжуулах, экспортлох, импортлох. Хар тамхи хадгалах, тээвэрлэх; <ul style="list-style-type: none"> Хатуу хар тамхи хадгалах, хувийн хэрэгцээнээс хэтрүүлэн их хэмжээгээр хадгалах. Зөөлөн хар тамхины хувьд хууль ёсоор зөвшөөрөгдсөн хэмжээнээс давсан тохиолдолд гэмт хэрэгт тооцогдоно. Хар тамхины наймаа, хэрэглээг зохион байгуулах; <ul style="list-style-type: none"> Хар тамхи хэрэглэх, хар тамхины хэрэгцээтэй орчинг бий болгох, эсвэл хар тамхины хэрэглээг урамшуулах үйлдэл болон хар тамхины хэрэглээг дэмжих, сурталчлах, хар тамхины наймааг зохион байгуулах. <p>5. Хар тамхитай холбоотой бусад гэмт хэрэг</p> <ul style="list-style-type: none"> Хар тамхитай холбоотой бусад гэмт хэрэг, жишээ нь, залилан, хүчирхийлэл, гэмт этгээдүүдийн бүлэглэлд хар тамхи ашиглах зэрэг. 	<p>ХБНГУ-д хар тамхитай холбоотой дараах үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцдог. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> Хувийн зөвшөөрөлгүй худалдан авах, эзэмших (Acquisition & Possession) <ul style="list-style-type: none"> Зохих зөвшөөрөлгүйгээр хар тамхи худалдаж авах, эзэмших, авах нь эрүүгийн гэмт хэрэг 29 (1) BtMG “Их хэмжээ” буюу <i>nicht geringe Menge</i> буюу “үр нөлөөтэй агууламж”-ийг давсан бол (жишээ шиг: героин ≥ 1.5 г, кокаин ≥ 5 г, каннабис ≥ 7.5 г ТНС): хамгийн бага 1 жил хорих заалт хэрэгждэг 29a BtMG Тариалах, үйлдвэрлэх, нийлүүлэх (Cultivation, Production, Trafficking) <ul style="list-style-type: none"> Хар тамхи тарих, үйлдвэрлэх, худалдах, түгээх нь гэмт хэрэгт тооцогдоно 29 (1) BtMG Хэрвээ энэ нь “их хэмжээ” буюу коммерсийн шинж чанартай бол гэмт хэргийн ял 2–15 жил хүртэл болох 29a, 30 BtMG Импорт/Экспорт <ul style="list-style-type: none"> Хар тамхийг ХБНГУ руу оруулах эсвэл гаргах нь гэмт хэрэг бөгөөд “их хэмжээ”-д тооцогдвол хамгийн бага 2 жилийн хорих ялтай 30 BtMG . Гол ял нэмэгдэх нөхцөл: бүлэглэлийн шинжтэй үйлдэл, зэвсэг ашиглах гэх мэт (5–15 жил) 30a BtMG. Хувь хүний хэрэгцээнд жижиг хэмжээ авах/эзэмших <ul style="list-style-type: none"> Хэрвээ зөвхөн “жижиг хэмжээ” (жишээ: каннабис 6–10 г, героин 1.5 г) ашиглахад 	<p>Тайваньд хар тамхитай холбоотой дараах үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцогддог. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> Үйлдвэрлэх, зөөвөрлөх, зарах, хадгалах, хэрэглэх; Хүчинд хүргэх, уруу тагах, шилжүүлэх, тариалах; Хэрэглэсэн, эсхүл борлуулах санаатай хадгалах; Мансууралтын хэрэгсэл зохион бүтээх, хадгалах. <p>Хэдийгээр зарим доод зэрэг (III/IV) дээр хэрэглэгчдэд торгуулийн ял байдаг ч I–II зэрэгт үйлдэх аливаа үйлдэл нь хатуу хорих, заримд нь цаазаар авах ялтай оногдуулж болно. Тайваний (Narcotics Hazard Prevention Act) нь хар тамхийг хэрэглэсэн үйлдлийг тодорхой тохиолдолд гэмт хэрэг гэж тооцдог, үүнд ялгах ял шийтгэл заасан байдаг.</p> <p>Хэрэглэх – Ял бүхий үйлдэл</p> <p>I зэрэгт хэрэглэсэн бол 6 сараас 5 жил хүртэл хорих ял оногдоно.</p> <p>II зэрэгт хэрэглэсэн бол 3 жил хүртэл хорих ял оноохоор заасан.</p> <p>Административ ялтай тохиолдлууд (III & IV)</p> <p>III, IV зэрэгт хар тамхи (хөнгөвчилсөн, эмнэлгийн хэрэглээнд ордог бодис) хэрэглэсэн бол шууд эрүүгийн хэрэгт бус, административ буюу захиргааны хариуцлага тооцно;</p>

¹⁴¹ Сайн туршлага болохуйц 3 улсын эрх зүйн зохицуулалтыг хүснэгтлэн жагсаав.

		<ul style="list-style-type: none"> - Хатуу хар тамхи үйлдвэрлэх, худалдах, хадгалах, тээвэрлэх бол шууд гэмт хэрэг. - Зөөлөн хар тамхийг зөвшөөрөгдсөн хэмжээнээс давсан тохиолдолд гэмт хэрэг болно. - Хар тамхины хэрэглээ дэмжих, сурталчлах үйлдэл мөн гэмт хэрэгт тооцогдоно. <p>Хар тамхины хэрэглээний зарим нөхцөлд зөрчил болох тохиолдолд зарим мужид хэрэглээг зөрчлийн хэрэг гэж тооцож, хөнгөн шийтгэл ногдуулдаг.</p>	<p>зориулсан бол прокурор зөрчил тулгахгүй байх боломжтой Мансууруулах бодисын тухай хууль 29(5), 31a BtMG¹⁴² Гэхдээ жижиг ч гэсэн хууль зөрчиж байгаа тул техникийн хувьд гэмт хэрэг учраас баривчилгаа, торгууль, магадгүй хариуцлага хүлээх боломжтой.</p> <p>10. Бусдад дамжуулах, хүүхдийн хэрэглээнд өдөөх</p>	<p>Зөрчилд тооцож: 10,000 – 50,000 NTD торгуулийн шийтгэл + 4–8 цагийн сургалтад хамрагдана.</p> <p>Тайлбар</p> <p>I–II зэрэгт хар тамхи хэрэглэсний үр дүнд хадгалалт болон хорих ял оногдуулах бөгөөд энэ нь жинхэнэ эрүүгийн гэмт хэрэгт тооцогдоно.</p> <p>Харин III–IV зэрэг (энгийн эмчилгээнд ордог бодис) бол ял шийтгэлгүй ч, захиргааны байгууллагаас торгуулийн арга хэмжээ хүлээлгэдэг.</p>
2.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэхийг гэмт хэрэгт тооцох эсэх	<p>Нидерланд нь хар тамхины бодлогын хувьд "зөөлөн хар тамхиууд" (soft drugs) болон "хатуу хар тамхиууд" (hard drugs)-ыг ялган харьцдаг онцлогтой.¹⁴³ Каннабисыг зөөлөн хар тамхинд тооцож, тодорхой хязгаарлалттайгаар зөөлрүүлсэн хууль хэрэгжүүлдэг бол хатуу хар тамхины хэрэглээ, худалдаа, үйлдвэрлэл нь хууль бус бөгөөд хатуу шийтгэлтэй.¹⁴⁴ Зөөлөн хар тамхины хувьд (Каннабис): Хувийн хэрэгцээнд зориулан 5 граммаас бага каннабис хадгалах нь хууль бус биш бөгөөд торгуультай боловч гэмт хэрэгт тооцогдохгүй. Каннабисыг зөвшөөрөгдсөн "кофе шоп"-уудад зөвшөөрсөн нөхцөлөөр худалдаалахыг зөвшөөрдөг бөгөөд хүүхдэд</p>	<p>Хар тамхи бие даан хэрэглэх нь шууд шийтгэгдэхгүй. Гэхдээ түүнд зориулсан агуулах буюу хадгалах, худалдан авах, тээвэрлэх г.м. үйлдлүүд нь 29–30b гэх зэрэг заалтад багтдаг бөгөөд хариуцлага хүлээлгэгддэг.¹⁴⁵ Гэрийн бага хэмжээ (жишээ нь ганц хэрэглээнд хүрэхүйц хэмжээ) тохиолдолд прокуророос яллах эсэхийг шийдвэрлэж болно Мансууруулах бодисын тухай хууль (29(5) BtMG) Ихэнх мужид, жишээ нь каннабисын хувьд 6 – 15 гр гэж тооцно Мансууруулах бодисын тухай хууль 29 BtMG Мансууруулах бодис эзэмших, олж авах гэх мэт нь гэмт хэрэг</p>	<p>Тайваньд хар тамхины хэрэглээг хууль ёсоор гэмт хэрэгт тооцож, ял шийтгэл оногдуулдаг. Хар тамхины хэрэглээ нь тусгай хууль болон Эрүүгийн хуулийн хүрээнд зохицуулагддаг бөгөөд хэрэглээнд холбогдсон этгээдэд ял шийтгэл, торгууль, сэтгэл зүйн болон эмчилгээний арга хэмжээ авах боломжтой.</p> <p>Тайванийн хуульд хар тамхины хэрэглээ нь зөвхөн бие даасан хэрэг биш, харин олон тохиолдолд хар тамхины бусад гэмт хэрэгтэй (жишээ нь худалдан авалт, хадгалалт) холбогдож, хамт шийтгэгддэг. Мөн хар тамхины хэрэглэгчдэд зориулсан сэргээн засах,</p>

¹⁴² Law on the Trafficking Narcotics: 29 BtMG https://www.gesetze-im-internet.de/btmg_1981/_29.html

¹⁴³ How does the law distinguish between soft and hard drugs? <https://www.government.nl/topics/drugs/how-does-the-law-distinguish-between-soft-and-hard-drugs>

¹⁴⁴ Am I committing a criminal offence if I possess, produce or deal in drugs? <https://www.government.nl/topics/drugs/am-i-committing-a-criminal-offence-if-i-possess-produce-or-deal-in-drugs>

¹⁴⁵ When is mere consumption of narcotics and drugs punishable? <https://www.strafrechtsiegen.de/strafatbestand-drogenkonsum>

		худалдахгүй, сурталчилгаа хийхгүй байх зэрэг хатуу дүрмүүдтэй. Хувийн хэрэглээнд 5 граммаас бага хэмжээтэй каннабисыг хууль бус гэж үздэггүй бөгөөд худалдааг зөвшөөрөгдсөн кофешопуудад хязгаарлагдмал нөхцөлтэйгөөр зөвшөөрдөг. Жишээлбэл, 18 нас хүрээгүй хүмүүст худалдахыг хориглодог. Хатуу хар тамхины хувьд: Героин, кокаин, экстази зэрэг хатуу хар тамхийг хууль бусаар хадгалах, үйлдвэрлэх, худалдаалах нь гэмт хэрэг бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.		эмчилгээний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг
3.	Ял оногдуулж буй хууль тогтоомж	Нидерланд улсын Хар тамхины хууль нь 1976 онд шинэчлэгдсэн “Opiumwet” буюу “Опиумын тухай хууль” нь хар тамхины хэрэглээ, үйлдвэрлэл, хадгалалт, борлуулалт, импорт, экспорт зэрэг бүх үйл ажиллагааг зохицуулдаг үндсэн хууль юм. Уг хууль нь мансууруулах бодисуудыг хоёр ангилалд (I болон II жагсаалт) хувааж, тус бүрд нь харилцан адилгүй эрх зүйн зохицуулалт, ял шийтгэлийн хэмжээг тогтоосон байдаг. Тус хууль нь мансууруулах бодисын хэрэглээ, худалдаа, хяналтыг тодорхойлдог бөгөөд зөөлөн мансууруулах бодисын зарим төрлийг тодорхой нөхцөлд хүлээн зөвшөөрдөг. Тус хуулийн дагуу хатуу болон зөөлөн хар тамхины төрөл, тэдгээрийн хууль ёсны болон хууль бус хэрэглээ, түүнтэй холбогдох эрүүгийн хариуцлага, ял шийтгэлийг тодорхойлогдсон байдаг. ¹⁴⁶ Нидерланд улс нь мансууруулах бодисыг хатуу, зөөлөн гэж ангилсан цөөн тооны улсын нэг боловч олон улсын гэрээнд заасан	Мансууруулах бодисын тухай хууль Betäubungsmittelgesetz (BtMG) Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад (ХБНГУ) мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийг зохицуулах үндсэн хууль нь Betäubungsmittelgesetz (BtMG) буюу Мансууруулах бодисын тухай хууль юм. Тус хуулийн 29–30b зүйлүүдэд мансууруулах бодисыг эзэмших, худалдах, үйлдвэрлэх, импортлох, экспортлох, тараах зэрэг үйлдлүүдийг ямар нөхцөлд гэмт хэрэгт тооцох, түүнд оноох ялын хэмжээг хэрхэн тогтоох талаар дэлгэрэнгүй заасан байдаг. Мансууруулах бодисын тухай хууль /BtMG/-ийн дагуу эрүүгийн хариуцлага нь үйлдсэн хэрэг, түүний ноцтой байдлаас шалтгаалан ялгаатай байна. Хэрвээ этгээд мансууруулах бодисыг өөрийн хэрэгцээний жижиг хэмжээтэйгээр хууль бусаар эзэмшсэн бол 29(1)-д заасны дагуу торгууль эсвэл 5 жил хүртэлх хугацаагаар хорих ял оногдуулах боломжтой. Харин хэрвээ тухайн этгээд	Тайваний Narcotics Hazard Prevention Act-д заагдсан хар тамхитай холбоотой гэмт хэргийн үйлдлүүд ба тэдгээрийн үндсэн заалтууд: ¹⁵² 1. Үйлдвэрлэх, тээвэрлэх, борлуулах (manufacturing, transporting, selling) - I зэрэг (героин, кокаин г.м.): Цаазаар авах эсвэл үргэлжлэх хорих, мөн NTD 30 хүртэл торгууль оногдуулна; - II зэрэг: Үргэлжлэх хорих эсвэл 10+ жил + NTD 15 млн хүртэл торгууль оногдуулна; - III зэрэг: Минимум 7 жил + NTD 10 млн хүртэл торгууль оногдуулна; - IV зэрэг: 5–12 жил + NTD 5 млн хүртэл торгууль оногдуулна. 2. Худалдах зорилготой хадгалах (intent to sell by possession) - I зэрэг: Үргэлжлэх хорих эсвэл 10+ жил + NTD 7 хүртэл торгууль оногдуулна;

¹⁴⁶ Opium act <https://wetten.overheid.nl/BWBR0001941/2009-07-01#BijlageI>

¹⁵² Narcotics Hazard Prevention Act <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=C0000008>

	<p>мансууруулах бодисыг бүрэн хориглоно. Энэ нь эдгээр бодисыг тээвэрлэх, хадгалах, худалдах, үйлдвэрлэх үйл ажиллагааг 1 сараас 8 жил хүртэл ял шийтгэж байна.¹⁴⁷</p> <p>Тус улсын Эрүүгийн хууль (Dutch Criminal Code) нь хар тамхитай холбоотой гэмт хэргийн эрүүгийн ял шийтгэлийг энэхүү хуульд заасан зүйл ангиудын хүрээнд оногдуулдаг. Жишээ нь, хар тамхи худалдах, үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах гэмт хэрэгт холбогдох ял шийтгэл тусгай заалтаар тогтоогдсон.¹⁴⁸</p> <p>Нидерланд нь хар тамхины бодлогын хувьд "зөөлөн хар тамхиууд" (soft drugs) болон "хатуу хар тамхиууд" (hard drugs)-ыг ялган харьцдаг онцлогтой.¹⁴⁹ Зөөлөн мансууруулах бодис гэдэг нь хуульд зааснаар, каннабис (олсны ургамал) нь тодорхой нөхцөлд хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд энэ нь хэрэглэгчдэд зориулсан "кофе шоп"-ууд хүлээцтэй ханаддаг байна. Каннабисыг зөөлөн хар тамхинд тооцож, тодорхой хязгаарлалттайгаар зөөлрүүлсэн хууль хэрэгжүүлдэг бол хатуу хар тамхины хэрэглээ, худалдаа, үйлдвэрлэл нь хууль бус бөгөөд хатуу шийтгэлтэй.¹⁵⁰ Зөөлөн хар тамхины хувьд (Каннабис): Хувийн хэрэгцээнд зориулан 5 граммаас бага каннабис хадгалах нь хууль бус биш бөгөөд торгуультай боловч гэмт хэрэгт</p>	<p>бодисыг ашгийн зорилгоор худалдаалсан эсвэл бусдад хуваарилсан бол энэ нь илүү хүнд гэмт хэрэгт тооцогдож, 29(3), 29а-д заасны дагуу доод тал нь 1 жилийн хорих ял оноох бөгөөд хэрэв их хэмжээний бодис (<i>nicht geringe Menge</i>) хамрагдсан бол энэ ял 1-15 жилийн хооронд хэлбэлзэнэ.</p> <p>Мансууруулах бодисыг хууль бусаар үйлдвэрлэсэн, импортолсон, экспортолсон, олж авсан, хадгалсан, илгээсэн, нийлүүлсэн этгээдэд тус хуулийн 22 дугаар зүйлийн дагуу торгох эсхүл хоёр жилээс илүүгүй хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>Гэмт хэргийн зохион байгуулалттай бүлэглэлээр үйлдсэн, эсвэл зэвсэг хэрэглэсэн тохиолдолд, 30 болон 30а заалтууд үйлчлэх ба 2-15 жилийн хорих ял оноох хуультай.</p> <p>Германы шинэ төрлийн сэтгэцэд нөлөөт бодисын тухай хууль (NpSG) нь 2016 оны 11-р сарын 26-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон. Энэхүү хууль нь шинэ төрлийн сэтгэцэд нөлөөлөх бодис (NPS) түгээхтэй тэмцэх буюу тэдгээрийг хэрэглэх, хордуулах бодис болгон ашиглах боломжийг хязгаарлах зорилготой. Уг хуульд захиргааны зөрчил болон эрүүгийн хуулиар хориглосон үйлдлүүдийг хооронд нь ялгамжтай зохицуулсан байдаг ба NPS-тэй харьцах (худалдан авах, эзэмших гэх мэт) өргөн хүрээтэй захиргааны хуулийн хоригийг</p>	<ul style="list-style-type: none"> - II зэрэг: 5+ жил + NTD 5 млн хүртэл торгууль оногдуулна; - III зэрэг: 3–10 жил + NTD 3 млн хүртэл торгууль оногдуулна; - IV зэрэг: 1–7 жил + NTD 1 млн хүртэл торгууль оногдуулна. <p>3. Хүчинд хүргэх буюу албадан хэрэглүүлэх (forcing or coercing use)</p> <ul style="list-style-type: none"> - I зэрэгт: Цаазаар авах, үргэлжлэх хорих эсвэл 10+ жил; NTD 10 млн хүртэл торгууль оногдуулна; - II зэрэг: Үргэлжлэх хорих эсвэл 7+ жил + NTD 7 млн хүртэл торгууль оногдуулна; - III зэрэг: 5+ жил + NTD 5 млн; IV зэрэг: 3–10 жил + NTD 3 млн торгууль оногдуулна. <p>4. Уруу татах (inducing use)</p> <ul style="list-style-type: none"> - I зэрэг: 3–10 жил + NTD 3 млн; II: 1–7 жил + NTD 1 млн; III: 6 сар–5 жил + NTD 0.7 млн; IV: 3 жил хүртэл + NTD 0.5 млн торгуул оногдуулна. <p>5. Шууд шилжүүлэх (transfer)</p> <ul style="list-style-type: none"> - I: 1–7 жил + NTD 1 млн; II: 6 сар–5 жил + NTD 0.7 млн торгууль оногдуулна; - III: 3 жил хүртэл + NTD 0.3 млн; IV: 1 жил хүртэл + NTD 0.1 млн оногдуулна.
--	---	---	--

¹⁴⁷The Netherlands Is At Risk Of Becoming A Narco State
<https://www.addictioncenter.com/news/2020/01/netherlands-narco-state/>

¹⁴⁸ Drug <https://www.government.nl/topics/drugs>

¹⁴⁹ How does the law distinguish between soft and hard drugs? <https://www.government.nl/topics/drugs/how-does-the-law-distinguish-between-soft-and-hard-drugs>

¹⁵⁰ Am I committing a criminal offence if I possess, produce or deal in drugs? <https://www.government.nl/topics/drugs/am-i-committing-a-criminal-offence-if-i-possess-produce-or-deal-in-drugs>

	<p>тооцогдохгүй. Каннабисыг зөвшөөрөгдсөн "кофе шоп"-уудад зөвшөөрсөн нөхцөлөөр худалдаалахыг зөвшөөрдөг бөгөөд хүүхдэд худалдахгүй, сурталчилгаа хийхгүй байх зэрэг хатуу дүрмүүдтэй. Хувийн хэрэглээнд 5 граммаас бага хэмжээтэй каннабисыг хууль бус гэж үздэггүй бөгөөд худалдааг зөвшөөрөгдсөн кофешопуудад хязгаарлагдмал нөхцөлтэйгөөр зөвшөөрдөг. Жишээлбэл, 18 нас хүрээгүй хүмүүст худалдахыг хориглодог.</p> <p>Хатуу хар тамхины хувьд: Героин, кокаин, экстази зэрэг хатуу хар тамхийг хууль бусаар хадгалах, үйлдвэрлэх, худалдаалах нь гэмт хэрэг бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.</p> <p>Нидерланд улсын хуульд хэрэглэх буюу өөртөө зориулан бага хэмжээний хар тамхи хадгалах үйлдлийг ихэвчлэн гэмт хэрэгт тооцдоггүй. Гэсэн хэдий ч хэрэглээний хэмжээ нь тодорхой хязгаарыг давах, бусдад дамжуулах, худалдаалах үйлдэл бол хууль бус бөгөөд гэмт хэрэгт тооцогдоно.¹⁵¹</p>	<p>агуулж байгаа бөгөөд энэ нь NPS-ийг хураан авч, шаардлагатай бол устгах үндэслэлийг бүрдүүлдэг.</p> <p>Эрүүгийн хууль (StGB)</p> <p>Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт эрүүгийн хууль, эрүүгийн процессын хуулийн ерөнхий заалтууд мөн хамаарна. Тухайлбал, мансууруулах бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох (316 дугаар зүйл) мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдэх (323б дугаар зүйл) Донтолтын эсрэг эмчилгээг зөрчих (64 дүгээр зүйл) зэрэг хар тамхины хэрэглээ, түүний үр дагаврыг тусгайлан тусгасан хэд хэдэн заалтыг агуулдаг.</p> <p>Мансууруулах бодисыг хүндрүүлсэн гэмт хэрэгт 10 жилээс илүүгүй хугацаагаар хорих ял оногдуулдаг. Гэмт хэргийг хүндрүүлсэн эсэхийг дараах нөхцөл байдлаар тогтоодог. Үүнд: Бодисын төрөл, Тоо хэмжээ, Гэмт хэргийн мөн чанар гэх мэт. Энэ төрлийн гэмт хэргийг болгоомжгүйгээр үйлдсэн хүндрүүлсэн гэмт хэргийн нөхцөлтэй үйлдсэн бол зургаан жилээс илүүгүй хугацаагаар хорих ял оногдуулж болно.</p> <p>Мансууруулах эмийг худалдаалах тухай хуульд тухайн бодисоос үүдэлтэй аюулын түвшингээр нь хатуу болон зөөлөн гэж ялгагдаггүй байна. Мөн хуулийн дагуу 1 дүгээр жагсаалтад багтсан бодисуудыг зөвхөн онцгой нөхцөлд шинжлэх ухааны судалгаа хийх эсвэл нийтийн ашиг сонирхолд нийцсэн зайлшгүй шаардлагатай тохиолдолд</p>	<p>6. Хэрэглэх (use)</p> <ul style="list-style-type: none"> - I зэрэг: 6 сар–5 жил хорих ял оногдуулна; - II зэрэг: 3 жил хүртэл хорих ял оногдуулна. <p>7. Хадгалах (possession)</p> <ul style="list-style-type: none"> - I зэрэг: 3 жил хүртэл хорих эсвэл NTD 300,000 торгуультай торгуультай болно.10 г бол 1–7 жил + NTD 1 млн торгууль оногдуулна; - II зэрэг: 2 жил хүртэл хорих эсвэл NTD 200,000 торгууль; >20 г бол 6 сар–5 жил + NTD 700,000 торгууль оногдуулна; - III зэрэг: >5 г бол 2 жил хүртэл хорих + NTD 200,000 торгууль оногдуулна; - IV зэрэг: >5 г бол 1 жил хүртэл хорих + NTD 100,000 торгууль оногдуулна. <p>8. Тариалах (cultivation)</p> <ul style="list-style-type: none"> - кока, опиум тарих (manufacture): Үргэлжлэх хорих эсвэл 7+ жил + NTD 7 млн; Каннабис тарих: 5+ жил + NTD 5 млн торгууль оногдуулна. <p>9. Санаатай хэрэгсэл ашиглах</p> <ul style="list-style-type: none"> - Мансууралтыг гэсэн шприц, хэрэгсэл хадгалах: 1–7 жил + NTD 150,000 торгууль оногдуулна. <p>Мансууруулах бодис хэрэглэсэн бол эрүүгийн хэрэг үүсгэж дараах ял шийтгэлийг оногдуулна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Героин (I зэрэг) хэрэглэсэн бол – эрүүгийн хэрэг → 6 сар – 5 жил хорих ял оногдуулна;
--	---	--	--

¹⁵¹ Drugs Law and Policy in the Netherlands – European Monitoring Centre for Drugs and Drug Addiction (EMCDDA)

		<p>л тусгай зөвшөөрлөөр ашиглах боломжтой. Харин 2 болон 3 дугаар жагсаалтад орсон бодисуудын хэрэглээг хуулиар тусгайлан зохицуулсан байдаг.</p> <p>Мансууруулах бодисын тухай хуулийн (BtMG)</p> <p>29 дүгээр зүйл: Мансууруулах бодисыг зөвшөөрөлгүйгээр тарих, үйлдвэрлэх, худалдаалах, худалдан авах, эзэмших, хадгалах, оруулж ирэх, гаргах, бусад өгөх, дамжуулах болон эдгээртэй ижил төстэй аливаа үйл ажиллагаа нь гэмт хэрэгт тооцогдоно.</p> <p>30 дугаар зүйл: Мансууруулах бодисыг зөвшөөрөлгүйгээр импортлох, экспортлох, тээвэрлэх, хил дамжуулах зэрэг үйлдлүүд нь хүнд гэмт хэрэгт тооцогдож, илүү өндөр торгууль, хорих ялтай байж болно.</p> <p>32 дугаар зүйл: Мансууруулах бодисыг зөвшөөрөлгүйгээр үйлдвэрлэх, худалдаалах, эзэмших зэрэг үйлдлүүд нь захиргааны зөрчилд тооцогдож, торгууль, хураамж, бусад захиргааны арга хэмжээ авах үндэслэл болно.</p> <p>Мансууруулах бодисыг зөвшөөрөлгүйгээр эзэмших, ялангуяа хувийн хэрэгцээний зориулалттай ч бай, хууль ёсоор олж аваагүй бол энэ нь хуулийн зөрчилд тооцогдоно. Үүнээс гадна, импорт, экспортын журмыг зөрчих буюу хуульд заасан тусгай зөвшөөрөлгүйгээр хил дамнуулан мансууруулах бодис зөөвөрлөх, тээвэрлэх нь ч мөн хариуцлага хүлээлгэх үндэслэл болно. Мөн эмч, эм зүйч, эмнэлгийн ажилтан зэрэг эрх бүхий этгээдүүд мансууруулах бодисыг эмчилгээний зориулалтаар зохисгүй</p>	<ul style="list-style-type: none"> - Амфетамин (II зэрэг) хэрэглэсэн бол – эрүүгийн хэрэг → 3 жил хүртэл ял оногдуулна; - Зарим тайвшруулах эм (IV зэрэг) буруу хэрэглэсэн бол – захиргааны шийтгэл оногдуулна.
--	--	--	---

			байдлаар бичиж өгөх, олгох, хэрэглэхийг зөвшөөрөх, эсвэл өөрийн үүрэг, мэргэжлийн хэм хэмжээг зөрчин бусдад олгосон тохиолдолд энэ зүйл ангиар хариуцлага тооцно.	
4.	Ялын төрөл	<p>Хатуу хар тамхины хууль бус үйлдэл: Эрүүгийн хэрэгт тооцогдож, удаан хугацаагаар хорих ял оноож болно (зарим тохиолдолд 6 сараас 12 жилийн хүртэл) “Опиумын тухай хууль”-ийн 10 дугаар зүйлд заасан.¹⁵³Зөөлөн хар тамхины хязгаарласан хэрэглээ: Хувийн хэрэглээнд бага хэмжээ хадгалах (жишээ нь, 5 граммаас бага каннабис) торгууль ногдуулж болох ч хорих ял оногдуулдаггүй байна. Зөөлөн хар тамхины хэрэгт сэжиглэгдсэн хүмүүст эмчилгээ, сэргээн засах дэмжлэг үзүүлэх бодлого голчлон баримталдаг.¹⁵⁴</p> <p>Misuse of Drugs Act (Opiumwet) бол хар тамхины хэрэг, худалдаа, үйлдвэрлэл зэрэг үйлдлийг зохицуулдаг үндсэн хууль хэдий ч хар тамхитай холбоотой гэмт хэргүүдийн ял шийтгэлийг Эрүүгийн хуулийн холбогдох зүйл ангиар тогтоодог. Тус улсын хар тамхитай холбоотой гэмт хэргийн ял шийтгэлийн төрөл ерөнхийд нь дараах байдлаар ангилагддаг.</p> <p>1. Торгох ял</p> <ul style="list-style-type: none"> - Жижиг хэмжээний зөөлөн хар тамхины хувийн хэрэглээ, хадгалалт зэрэгт ихэвчлэн ногдуулдаг. - Торгууль нь байнга хэрэглэгчид, жижиг наймаачдад ногдуулагддаг. <p>2. Хорих ял</p>	<p>ХБНГУ-д хар тамхитай холбоотой гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд Betäubungsmittelgesetz (BtMG) буюу Мансууруулах бодисын тухай хуульд заасны дагуу ял шийтгэл оноодог. Ял нь үйлдлийн шинж чанар, бодисын төрөл ба хэмжээ, үйлдлийн давтамж зэргээс хамаарч өөр өөр байна.¹⁵⁵</p>	<p>1. Үйлдвэрлэх</p> <p>Хар тамхи (төрөл ангиллаас үл хамааран) бэлтгэх, боловсруулах, үйлдвэрлэх, синтез хийх зэрэг үйлдлүүд орж байна. Жишээ нь героины лаборатори ажиллуулах, синтетик мансууруулах бодис үйлдвэрлэх.</p> <p>2. Хил дамжуулан зөөвөрлөх / тээвэрлэх</p> <p>Тайвань хилээр хар тамхи зөөвөрлөх, гаалийн мэдүүлэггүйгээр оруулах, гаргах зэрэг орно. Жишээ нь чемоданд нууж авчрах, шуудангаар илгээх.</p> <p>3. Худалдах / Борлуулах / Түгээх</p> <p>Мансууруулах бодисыг мөнгөөр эсвэл ямар нэг ашигтай нөхцөлөөр бусдад өгөх мөн зөвхөн борлуулсан биш, тараасан, бусдад хэрэглүүлсэн бол мөн ял шийтгэл оногдуулна.</p> <p>4. Худалдах зорилгоор хадгалах</p> <p>Томоохон хэмжээтэй хар тамхи хадгалж байгаа бол "худалдах зорилготой" гэж үзнэ. Энэ тохиолдолд жирийн хадгалалтаас ялгаатайгаар хүнд шийтгэл оногдуулна.</p> <p>5. Хэрэглүүлэх /Хүндрүүлсэн нөхцөлтэй хэрэглэх</p>

¹⁵³ Opiumwet <https://wetten.overheid.nl/BWBR0001941/2009-07-01#Artikel12>

¹⁵⁴The soft drug policy of the Netherland: What is legal? <https://www.expat.com/nl/living/gov-law-admin/netherlands-drug-policy-100737/?utm>

¹⁵⁵ Law on the Trafficking of Narcotics https://www.gesetze-im-internet.de/btmg_1981/

		<ul style="list-style-type: none"> - Хатуу хар тамхи үйлдвэрлэх, худалдах, их хэмжээний хадгалах, тээвэрлэх зэрэг ноцтой гэмт хэрэгт ногдуулагддаг. - Хорих ялын хугацаа нь үйлдлийн ноцтой байдлаас хамаарч 6 сараас 12 жил хүртэл, зарим тохиолдолд илүү ч байж болно. <p>3. Нийгэмд тустай ажил</p> <ul style="list-style-type: none"> - Зарим тохиолдолд шүүх ялтанг хорих ял оноохоос өмнө нийгмийн ажил хийхээр шийдвэрлэдэг. <p>4. Эмчилгээ, сэргээн засах арга хэмжээ</p> <ul style="list-style-type: none"> - Хар тамхины хэрэглэгчдэд зориулсан эмчилгээ, нөхөн сэргээх үйлчилгээ авуулах шийдвэр гаргах боломжтой. <p>5. Бусад арга хэмжээ. Тухайлбал, гэрийн хяналт, хорио цээр, тодорхой газар оронд орохыг хориглох зэрэг.</p> <p>Торгууль (торгох ял) нь үйлдлийн онцлог, хар тамхины төрөл, хэмжээ, нөхцөл байдлаас хамаарч өөр өөр байна. Торгох ялын хэмжээ нь зөөлөн хар тамхи (каннабис)-ны хэрэглээнд ихэвчлэн 100 евро орчим торгууль ногдуулдаг. Заримдаа анх удаа хэрэглэх, бага хэмжээтэй бол торгууль зөөлөн, эсвэл хөнгөрсөн байдаг.</p>	<p>Бусдад хүч хэрэглэн, эсвэл хууралт, уруу татаж хар тамхи хэрэглүүлэх. Жишээ нь согтууруулах ундаа руу хар тамхи хольж өгөх, эмзэг бүлгийн хүнд хэрэглүүлэх.</p> <p>6. Тарих Кока мод, опиумын ногоо, каннабис (марихуан) зэрэг хар тамхи гарган авах зориулалттай ургамал тарих.</p> <p>7. Хадгалах Хувийн хэрэгцээний зорилгоор ч байсан, хуульд хориглосон бодис хадгалж байвал гэмт хэрэгт тооцно. Хадгалж буй хэмжээ болон төрөлд үндэслэн ял ялгаатай (жишээ нь: 10 гр героин vs 5 гр каннабис).</p> <p>8. Хэрэглэсэн байх Хар тамхи хэрэглэсэн нь шээсний шинжилгээгээр илэрвэл ял оногдуулна; (ялангуяа I/II зэрэгт) Тайваньд хэрэглэгчид эмчилгээний чиглэлээр дахин нийгэмшүүлэхийг зорьдог ч давтан хэрэглээ хүнд ял оногдуулна.</p> <p>9. Бодис тээвэрлэх хэрэгсэл хадгалах, үйлдвэрлэх Шприц, ампул, тамхи хольж татдаг хэрэгсэл, мөхлөг шахагч гэх мэт хэрэгслийг зориулалтаар нь хадгалах, ашиглах.</p> <p>10. Хар тамхины урьдчилсан гэмт хэрэг / бэлтгэл хийх Тухайн гэмт хэргийг гүйцэлдүүлээгүй ч түүний бэлтгэлийг хийж буй үйлдэлд ял оногдуулна. Тайваний хар тамхитай холбоотой гэмт хэрэгт хариуцлага оногдуулах хууль нь маш хатуу бөгөөд бодисын төрөл, хэмжээ, хэрэглэсэн болон бусдад нөлөөлсөн нөхцөл байдал зэргээс</p>
--	--	---	---

				шалтгаалан ял шийтгэлийн түвшин эрс ялгаатай байдаг. Жишээлбэл, каннабис тарих нь хууль зөрчсөн үйлдэлд тооцогддог бөгөөд энэ нь ашгийн зорилготой эсэх, хэмжээ зэргээс хамааран 5 жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулах нөхцөл бүрдүүлдэг. Харин амфетамин хэрэглэсэн тохиолдолд хэрэглэгчийг 1 жил хүртэл хорих эсвэл донтолт тогтоогдсон бол эмчилгээний төвд шилжүүлэх боломжтой. Хэрэв тухайн этгээд өөр хүнийг хүчээр буюу албадлагаар хар тамхи хэрэглүүлсэн бол энэ нь Тайваний хуулиар онц хүнд гэмт хэрэгт тооцогдож, 10 жилээс дээш хугацаагаар хорих ял, зарим тохиолдолд бүр цаазаар авах ял хүртэл оногдуулах нөхцөлтэй. Мөн 20 грамм амфетамин хадгалсан тохиолдолд энэ нь их хэмжээний бодис хадгалсан гэж үзэгдэж, холбогдогчид 6 сараас 5 жил хүртэл хорих ял оноох боломжтой байдаг. Ийнхүү Тайваний хууль тогтоомж нь мансууруулах бодисын хэрэглээ, хадгалалт, түгээлтэй холбоотой аливаа үйлдлийг хуулийн хатуу зохицуулалтаар хянаж, олон нийтэд хүчтэй сэрэмжлүүлэг өгдөг тогтолцоотой юм.
5.	Торгох ялын хэмжээ	Торгууль (торгох ял) нь үйлдлийн онцлог, хар тамхины төрөл, хэмжээ, нөхцөл байдлаас хамаарч өөр өөр байна. Торгох ялын хэмжээ нь зөөлөн хар тамхи (каннабис)-ны хэрэглээнд ихэвчлэн 100 евро орчим торгууль ногдуулдаг. Заримдаа анх удаа хэрэглэх, бага хэмжээтэй бол торгууль зөөлөн, эсвэл хөнгөрсөн байдаг.	ХБНГУ-д хар тамхитай холбоотой зөрчил, гэмт хэрэгт торгох ял (Geldstrafe) оногдуулах нь элбэг бөгөөд энэ нь тухайн хүний санхүүгийн чадавх, хэрэг үйлдсэн нөхцөл байдал, анхны зөрчил эсэх зэрэг хүчин зүйлээс хамаарч тооцогддог. Торгох ялын хэмжээ (Geldstrafe) – Ерөнхий зарчим	Хар тамхины хэрэгтэй холбогдуулан яллагдагчид торгуулийн ял оногдуулах бөгөөд торгуулийн хэмжээ нь үйлдлийн ноцтой байдлаас шалтгаалдаг. Жижиг хэмжээний хар тамхины хэрэглээ, хадгалалт зэрэг хөнгөн гэмт хэрэгт торгуулийн хэмжээ харьцангуй бага байж болох бөгөөд

			ХБНГУ-д торгууль нь өдрийн торгууль (Tagessatz)-аар хэмжигддэг. Торгууль нь өдөр тутмын орлоготой уялдаатайгаар тооцогддог. Анх удаа хар тамхи эзэмшсэн бол хорихын оронд торгууль оноох нь түгээмэл. Торгууль өндөр орлоготой хүмүүст илүү өндөр дүнтэй байж болно.	хэдэн мянган тайваний доллароор тоологддог. Харин томоохон хэмжээтэй үйлдвэрлэл, худалдаа, зөөвөрлөлтийн гэмт хэрэгт оногдуулах торгууль илүү өндөр, сая сая тайваний доллар хүрч болно. Зарим тохиолдолд торгуулийн хамт хорих ял оногдуулах тохиолдол байдаг.
6.	Ялаас гадна нэмэгдэл авах арга хэмжээ /сэтгэл зүйн эмчилгээ гэх мэт/	<p>1. Сэтгэл зүйн болон донтох эмчилгээ</p> <p>Нидерланд улсад хар тамхины хэрэглэгчдийн донтолт болон сэтгэл зүйн асуудлыг эмчлэх зориулалттай олон төрлийн эмнэлэг, төвүүд үйл ажиллагаа явуулдаг.</p> <p>Донтох эмчилгээ нь хэрэглэгчдийг эрүүлжүүлэх, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр мэргэжлийн баг ажилладаг бөгөөд гол зорилго нь хэрэглээг таслан зогсоож, эрүүл мэндийг сэргээхэд оршино.</p> <p>Эмчилгээ нь ял шийтгэлтэй буюу хорих ялтай хослуулан хэрэгжихээс гадна, ял шийтгэлгүйгээр бие даан явагдах боломжтой.</p> <p>Хэрэглэгчийн нөхцөл байдлаас хамаарч, эмчилгээний хөтөлбөрүүд нь амьдралд дасан зохицох, нийгэмд эргэн оролцох чадварыг сайжруулахад чиглэгддэг.</p> <p>1. Trimbos Institute (Dutch Institute of Mental Health and Addiction)</p> <p>Энэ байгууллага нь Нидерланд улсын засгийн газрын дэмжлэгтэйгээр сэтгэл заслын болон донтох эмчилгээний судалгаа, үйлчилгээний үндэс суурийг тавьдаг.¹⁵⁶</p>	<p>Мансууруулах бодисын тухай хууль BtMG 35, 36 – Донтох эмчилгээний нөхцөл</p> <p>Мансууруулах бодисын тухай хуулийн 35 BtMG – Шүүхийн тогтоосон ялыг хойшлуулж эмчилгээ хийх боломж</p> <p>Хэрэв хүнд төрлийн мансууруулах бодис хэрэглэгч гэмт хэрэг үйлдсэн бол, шүүх түүнд оноосон ялыг эмчилгээ хийлгэх болзолтойгоор хойшлуулах боломжтой.</p> <p>Ингэснээр тухайн этгээд донтох эмчилгээ хийлгэх нөхцөлд эрх чөлөөгөө хасуулахгүйгээр дахин нийгэмд дасан зохицох боломж олдоно.</p> <p>Мансууруулах бодисын тухай хуулийн 36 BtMG Эмчилгээний хяналт, хамтын ажиллагаа</p> <p>Энэ зүйлд эмчилгээний чанар, үр дүнг хянах байгууллагуудын хамтын ажиллагаа, мөн донтогчийн эмчилгээнд хамрагдахын ач холбогдол болон үүрэг хариуцлагыг тодорхойлдог.</p> <p>Эрүүгийн хууль StGB 64 – Албадан эмчилгээний шийдвэр (Maßregelvollzug)</p> <p>Энэ зүйл заалтад зааснаар хэрэв хэн нэгэн сэтгэцийн эмгэг эсвэл архи/мансууруулах бодисын хамааралтай байж, үүнээс үүдэн</p>	<p>1. Сэтгэл зүйн болон эмнэлгийн эмчилгээ</p> <p>Narcotics Hazard Prevention Act (Хар тамхины хор уршгийг хориглох тухай хууль) нь хар тамхины хэрэглэгчдэд сэтгэл зүйн болон эмнэлгийн эмчилгээ, сэргээн засах үйлчилгээ авах үүрэг, эрхийг тусгайлан заасан байдаг.</p> <p>Хар тамхины хэрэглээг илрүүлсэн этгээдүүдийг эрх бүхий байгууллагаас эмчилгээ, сэргээн засах төвд хамруулах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх зохицуулалттай.</p> <p>Хууль тогтоомжийн дагуу шүүх, прокурор, шоронгийн байгууллагууд дараах нэмэлт арга хэмжээг авч хэрэгжүүлж болдог:</p> <p>Албадан эмчилгээ (Mandatory Treatment):</p> <p>Сэтгэцэд нөлөөлөх бодисын хэрэглээнээс шалтгаалсан хамаарал бүхий этгээдүүдийг сэтгэл зүйн болон эмнэлгийн байгууллагад эмчлүүлэхээр илгээх эрх шүүхэд бий. Эмчилгээний хугацаа нь 2 сараас 1 жил хүртэл, тухайн хүний хамаарал, зан үйлийн байдлаас хамаарч сунгаж болдог.</p>

¹⁵⁶Dutch Institute of Mental Health <https://www.trimbos.nl>

	<p>2. Dutch Government – Ministry of Health, Welfare and Sport¹⁵⁷ Хар тамхины хэрэглээ болон түүнтэй холбоотой хууль эрх зүйн, нийгмийн дэмжлэгийн бодлогыг боловсруулдаг.</p> <p>3. European Monitoring Centre for Drugs and Drug Addiction (EMCDDA)¹⁵⁸ Европын холбооны мансууруулах бодисын хэрэглээ, хууль эрх зүйн орчны талаар дэлгэрэнгүй судалгаа, тайлангуудыг гаргадаг. Нидерланд улсын нөхцөл байдал, эмчилгээний арга хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээлэлтэй.</p> <p>4. Dutch Ministry of Justice and Security¹⁵⁹ Хар тамхитай холбоотой эрүүгийн хууль болон нэмэлт арга хэмжээний талаар мэдээлэлтэй.</p>	<p>гэмт хэрэг үйлдсэн бол, шүүх тухайн этгээдийг шоронгийн оронд эмчилгээний байгууллагад албадан байлгах шийдвэр гаргаж болно.</p> <p>Үүнийг "Maßregelvollzug" буюу тусгай эмчилгээний хорих арга хэмжээ гэж нэрлэдэг.</p> <p>Эрүүгийн хууль StGB 56c, 67 – Тэнсэн харгалзах болон хяналтын нөхцөл Эрүүгийн хууль 56c StGB – Тэнсэн харгалзах шийтгэлтэй хүнд тавигдах нөхцөл: Шүүх тухайн этгээдийг тэнсэн харгалзах ялд шилжүүлэхдээ дараах нөхцөлийг тавьж болно: Сэтгэцийн эмчилгээ хийх, Донтолтоос ангижрах сургалтад хамрагдах, Гэм хорыг барагдуулах, Тогтмол хяналтанд байх гэх мэт.</p> <p>Эрүүгийн хуулийн 67-д StGB – Эмчилгээний арга хэмжээг ялаас урьтаж хэрэгжүүлэх: Хэрэв шүүх 64-д заасны дагуу албадан эмчилгээний шийдвэр гаргасан бол тэр нь ялаас өмнө эхэлж хэрэгжих ёстой. Хэрэв эмчилгээ амжилттай болвол, тухайн хүний ялыг бүрэн хэрэгжүүлэхгүй байж болох юм.</p> <p>Эрүүгийн хуулийн 31-д заасны дагуу прокурор хэрэг үүсгэхээс татгалзах боломж Энэ зүйл заалтад мансууруулах бодис хэрэглэсэн, гэхдээ бага хэмжээтэй, хувийн хэрэгцээнд хэрэглэсэн тохиолдолд прокурор эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах боломжтой.</p>	<p>Сэтгэл заслын үйлчилгээ (Psychological Counseling): Шоронгийн болон засгийн газрын харьяа сэргээн засах төвүүд дээр сэтгэл заслын үйлчилгээ үзүүлдэг. Үүнд өөрийгөө танин мэдэх, уур уцаараа зохицуулах, харилцаа сайжруулах, хамааралтай тэмцэх арга техникийг заах зэрэг хөтөлбөр багтана.</p> <p>Шүүхийн өмнөх эмчилгээний хөтөлбөр (Deferred Prosecution with Treatment): Хөнгөн зэргийн хэрэгт холбогдсон, хар тамхи хэрэглэсэн нь тогтоогдсон боловч борлуулалт хийдэггүй этгээдийг шийтгэхээс өмнө эмчилгээний хөтөлбөрт хамруулж болдог. Тус хөтөлбөрт амжилттай хамрагдсан тохиолдолд ял оноохоос татгалзах боломжтой.</p>
--	--	--	--

¹⁵⁷ Dutch Government – Ministry of Health, Welfare and Sport <https://www.government.nl/ministries/ministry-of-health-welfare-and-sport>

¹⁵⁸ European Monitoring Centre for Drugs and Drug Addiction (EMCDDA)¹⁵⁸

<https://www.emcdda.europa.eu/countries/netherlands>

¹⁵⁹ Dutch Ministry of Justice and Security <https://www.government.nl/ministries/ministry-of-justice-and-security>

			Хамгийн түгээмэл хэрэглэгддэг нөхцөл: Жижиг хэмжээний каннабис-ийг хувийн хэрэгцээнд зориулж хэрэглэсэн. Хүндрүүлэх нөхцөл байхгүй (жишээ нь, хүүхдэд зарсан, хилийн чанадтай холбоотой гэх мэт). Нийгмийн аюул багатай.	
7.	Хөрөнгө болон хар тамхийг хураан авах арга хэмжээ	1.Хар тамхины бодисыг хураан авахдаа хууль бус хар тамхины бодисыг баривчилж, мөрдөн шалгах явцад шууд хураан авдаг. Хэрэгт холбоотой хар тамхины бүх тохиолдолд мөрдөн байцаалт, шүүхийн шийдвэрийн дагуу хураан авалт хийгддэг. 2.Хэрэгт холбогдох хөрөнгийн хураан авахдаа хар тамхины хууль бус наймаа, үйлдвэрлэлээс олсон ашиг, мөнгө хөрөнгийг хураан авах арга хэмжээ авдаг. Түүнчлэн хөрөнгийг хууль бус үйлдэлд ашигласан эсвэл олсон гэж үзвэл шүүхийн шийдвэрээр хураан авдаг. Энэ нь мөнгө угаахтай тэмцэх, хар тамхины гэмт хэргийг санхүүжүүлэхийг таслан зогсоох чухал арга хэмжээ болдог.	Эрүүгийн хуулийн StGB 73–76-д заасны дагуу хөрөнгө хураах журмаар зохицуулдаг. ¹⁶⁰ “Хэрэг үйлдэж олсон орлого, мөн түүнийг орлож буй үнэ цэнтэй хөрөнгийг хурааж, төрийн өмч болгоно.”	1. Хар тамхи болон холбогдох эд зүйлсийг хураан авахдаа Эрүүгийн хэрэг үүссэн тохиолдолд хар тамхины хууль бус эргэлтэд оролцсон бүх төрлийн бодис, бүтээгдэхүүнийг хураан авдаг. Хураан авсан хар тамхи нь тухайн хэргийг шалгах, нотлох баримт болохоос гадна устгалд оруулна. 2. Холбогдох хөрөнгө, эд хөрөнгийг хураан авахдаа хар тамхины гэмт хэргээс олсон хөрөнгө, мөнгө, бусад эд хөрөнгийг хууль бусаар олсон гэж үзэж хураан авдаг. Энэ нь хууль бус үйл ажиллагааг санхүүжүүлсэн хөрөнгө, тээвэрлэлт, хадгалалт зэрэгтэй холбоотой хөрөнгийг багтаана. 3. Хураан авах ажиллагаа явуулахдаа хураан авах ажиллагааг шүүхийн захирамж, прокурорын зөвшөөрлөөр явуулна. Хураасан хөрөнгийг устгах, улсын орлого болгох эсвэл бусад хуульд заасан журмаар зохицуулна. 4. Хууль эрх зүйн үндэс нь энэ арга хэмжээ нь Тайваний Narcotics Hazard Prevention Act болон Эрүүгийн хуульд тусгагдсан. Хөрөнгө хураах нь хар

¹⁶⁰ Criminal code <https://www.gesetze-im-internet.de/stgb>

				тамхины гэмт хэрэгтэй тэмцэх чухал хэсэг бөгөөд хууль бус үйл ажиллагааны санхүүжилтийг таслан зогсоодог
8.	Давтан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулах	<p>1. Эмчилгээ, сэргээн засах дараах хөтөлбөрүүд байна.</p> <ul style="list-style-type: none"> - Хар тамхины гэмт хэрэгт холбогдсон хүмүүст зориулсан донтох эмчилгээ, сэтгэл зүйн дэмжлэг, нөхөн сэргээх хөтөлбөрүүд хэрэгждэг. - Хэрвээ хорих ял авсан бол ял эдэлж байх хугацаандаа эдгээр хөтөлбөрт хамрагдах боломжтой. <p>2. Хяналт ба зөвлөгөөг дараах байдлаар өгдөг.</p> <ul style="list-style-type: none"> - Давтан гэмт хэрэг үйлдэх эрсдэлтэй хүмүүст цагдаагийн болон нийгмийн ажилтнуудын байнгын хяналт, зөвлөгөө өгдөг. - Хяналт шалгалтыг тогтмол явуулж, шаардлагатай тохиолдолд нэмэлт дэмжлэг үзүүлдэг. <p>3. Нийгэмд дахин нэгтгэх үйл явц дараах арга хэмжээг хэрэгжүүлдэг.</p> <ul style="list-style-type: none"> - Гэмт хэрэгтнийг нийгэмд эргэн оруулах, ажил мэргэжлийн сургалт, амьдралын ур чадвар олгох хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. - Энэ нь дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг бууруулахад чиглэнэ. <p>4. Олон талт хамтын ажиллагааг дараах байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна.</p>	<p>ХБНГУ-ын Эрүүгийн хуульд (StGB) зааснаар: “Давтан гэмт хэрэг (Rückfall / Wiederholungstäter) нь ял шийтгэхдээ хүндрүүлэх нөхцөл гэж үзнэ.”¹⁶¹</p> <p>Давтан гэмт хэрэгт хамаарах нэмэлт нөхцөлүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Давтан гэмт хэрэг хийсэн нь сүүлийн 5 жилийн дотор байх - Өмнөх ялыг тэнсэн байсан ч шинээр гэмт хэрэг үйлдсэн бол шинэ хэргийн ялд нөлөөлнө - Прокурорын шүүхэд өргөн барих саналыг зогсоохгүй, харин ч хатуу арга хэмжээ авах үндэслэл болдог <p>Давтан гэмт хэрэг нь ХБНГУ-д ял шийтгэлийг хүндрүүлэх онц чухал хүчин зүйл юм. Давтан гэмт хэрэг хийсэн тохиолдолд тэнсэн ял өгөх магадлал буурч, хорих хугацаа уртсах, зарим тохиолдолд нэмэлт хамгаалалтын хорих арга хэмжээ (Sicherungsverwahrung) хэрэгжиж болно.</p> <p>ХБНГУ-д хар тамхитай холбоотой давтан гэмт хэрэг (рецидив) үйлдэхээс урьдчилан сэргийлэхийн тулд эрүүгийн эрх зүйн хариуцлагаас гадуур болон дотор дараах системтэй арга хэмжээ, бодлого, хяналтын тогтолцоо хэрэгжүүлдэг.</p>	Хар тамхины гэмт хэргийг давтан үйлдсэн этгээдэд ял шийтгэлийг илүү хүнд, чанга болгож оноодог. Давтан үйлдэл нь эрүүгийн хуулийн дагуу хариуцлагыг нэмэгдүүлэх үндэслэл болж, хорих ялын хугацааг уртасгах, торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг хариуцлагын хүндрэлийг авчирдаг. Мөн зарим тохиолдолд сэтгэл зүйн болон сэргээн засах үйлчилгээ авах хугацаа, шаардлага нэмэгдэж болно.

¹⁶¹Criminal Code (StGB) https://www.gesetze-im-internet.de/stgb/_46.html

		<ul style="list-style-type: none"> - Цагдаа, прокурор, шүүх, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн байгууллагууд хамтран ажиллаж, мэдээлэл солилцон хамтран ажилладаг. - Орон нутгийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд оролцдог. <p>5. Боловсрол, мэдээллийг дараах байдлаар олгож байна.</p> <ul style="list-style-type: none"> - Хар тамхины хор уршгийн талаар олон нийтэд чиглэсэн боловсрол, мэдээлэл өгөх үйл ажиллагааг идэвхтэй явуулдаг. - Гэмт хэрэгтнүүдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх ухамсар бий болгоход чиглэнэ. 		
9.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаа	<p>1. Мансууруулах бодисоос гаргах албадан эмчилгээ (Gedwongen orname/ verplichte behandeling) нь Эрүүгийн хэрэг үйлдсэн боловч сэтгэцийн өвчтэй, донтолттой гэж үзсэн этгээдэд эрүүгийн ял оногдуулахын оронд буюу түүнтэй хамт сэтгэцийн эмнэлэгт албадан эмчлэх шийдвэр гаргаж болно. Энэ нь “TBS” буюу “terbeschikkingstelling” гэж нэрлэгддэг онцгой дэглэмтэй арга хэмжээ юм. Тус гэмт хэрэг үйлдсэн сэтгэцийн эмгэгтэй этгээд болон мансууруулах бодисонд донтсон этгээдийг нийгмээс тусгаарлан албадан эмчлэх дэглэм юм.</p> <p>2. Нийгмийн ажилтантай албадан холбоо тогтоох (Reclassering/Probation supervision) нь шүүхээс хорих ял оногдуулалгүйгээр эсвэл хорих ялаас хугацаанаас нь өмнө сулласан тохиолдолд тухайн этгээдийг нийгмийн ажилтны хяналт дор нөхөн сэргээх үйлчилгээ авах, эмчилгээнд хамрагдахыг албадан даалгах боломжтой.</p>	<ul style="list-style-type: none"> - Шүүхийн тэнсэн ял + эмчилгээ - Прокурорын урьдчилан хөнгөн арга хэмжээ - Сэтгэл зүйн болон нийгмийн урт хугацааны хөтөлбөрүүд - Аюултай тохиолдолд тусгай хорих хамгаалалт (Sicherungsverwahrung) гэсэн олон давхар төвлөрсөн тогтолцоотой хэрэгждэг. <p>ХБНГУ-д хар тамхитай холбоотой давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажиллагаа</p> <p>1. Шүүхийн болон эрүүгийн эрх зүйн арга хэмжээ</p> <ul style="list-style-type: none"> - Сэтгэл заслын болон донтох эмчилгээ (Therapie statt Strafe): Хар тамхинд донтсон этгээдэд хорих ял оноохын оронд сэтгэл заслын болон эмнэлгийн эмчилгээ хийх боломжтой. <i>Хууль зүйн үндэслэл:</i> 	Хар тамхины гэмт хэргийг давтан үйлдсэн этгээдэд ял шийтгэлийг илүү чанга болгож оноодог. Давтан үйлдэл нь эрүүгийн хуулийн дагуу хариуцлагыг нэмэгдүүлэх үндэслэл болж, хорих ялын хугацааг уртасгах, торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг хариуцлагын хүндрэлийг авчирдаг. Мөн зарим тохиолдолд сэтгэл зүйн болон сэргээн засах үйлчилгээ авах хугацаа, шаардлага нэмэгдэж болно.

	<p>3.Өвчтөнөөр эмчилгээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхийг шаардсан захиргааны арга хэмжээ нь хүнд хэлбэрийн донтолттой хүмүүсийн хувьд орон нутгийн захиргаанаас тэднийг “өөртөө болон бусдад аюул учруулах магадлалтай” гэж үзвэл албадан ажиглалтад авах эсвэл эмчилгээ хийлгэх шийдвэр гаргаж болно. Жишээ нь: “сэтгэцийн эрүүл мэндийн албадан тусламжийн тухай хууль”-ийн дагуу.¹⁶²</p> <p>4.Шүүхийн нөхцөлт хорих ял дээр нэмж эмчилгээ хийх ба¹⁶³ энэ нь шүүхээс нөхцөлт ял оноохдоо тухайн этгээдийг мансууруулах бодисын эмчилгээ хийлгэх нөхцөл тавьдаг. Хэрэв нөхцөлийг биелүүлээгүй бол ял бүтнээр хэрэгжинэ.</p> <p>5.Хэрэглэгчийн эсрэг захиргааны арга хэмжээ (Bestuurlijke maatregel) нь зарим хотод (жишээ нь Амстердам) олон нийтийн газарт хар тамхи хэрэглэхийг хориглох, зөрчсөн тохиолдолд торгууль, оршин суух эрхийн хязгаарлалт зэрэг захиргааны шийтгэл оногдуулж болно.</p> <p>6.Тусгай хяналтын дор сэргийлэх арга хэмжээ (Preventive supervision) нь “Problematic users” буюу асуудалтай хэрэглэгчидийг тусгайлсан хамгаалалтын, хяналтын хөтөлбөрт хамруулах ба энэ нь орон нутгийн захиргаа, эрүүл мэндийн байгууллагууд хамтран хэрэгжүүлдэг.</p>	<p>- Мансууруулах бодисын тухай хуулийн 35, 36 дугаар зүйл Betäubungsmittelgesetz (BtMG)¹⁶⁴</p> <p>- Тэнсэн ялтай үед хяналт тавих: Хорих ял тэнссэн тохиолдолд шүүхийн шийдвэрээр сэтгэл зүйн уулзалт, эмчилгээ болон тогтмол хяналт тавих үүрэг онооно. Эрүүгийн хуулийн 56с, 67 дугаар зүйл¹⁶⁵ (StGB)</p> <p>Нийгмийн ажил болон сургалтын дараах хөтөлбөрүүд байна. Үүнд:</p> <p>Ялангуяа өсвөр насныхан, анх удаа гэмт хэрэг үйлдсэн хүмүүст нийгмийн ажил эсвэл урьдчилан сэргийлэх сургалтад хамруулна. Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хамгаалалт дор байх (Sicherungsverwahrung):</p> <p>Олон удаа гэмт хэрэг үйлдсэн, аюултай этгээдүүдийг хорих ял дууссаны дараа ч хамгаалалттай хорих байрлалд байлгах боломжтой.</p> <p>Хууль зүйн үндэслэл:</p> <p>- Эрүүгийн хууль StGB 66¹⁶⁶</p> <p>2. Нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн салбарын арга хэмжээ</p> <p>- Донтох эмгэгийн эмчилгээний төвүүд: Сэтгэл заслын эмчилгээ, дэмжлэг, гэр бүлд зөвлөгөө үзүүлэх, групп уулзалтуудыг зохион байгуулдаг. Тухайлбал Caritas, Diakonie, Deutsche Aidshilfe зэрэг төрийн бус байгууллагууд оролцдог.</p>	
--	---	---	--

¹⁶²Compulsory Mental Health Care Act .<https://wetten.overheid.nl/BWBR0040635/2020-01-01/0?utm>

¹⁶³ Criminal code https Article 14c–14g <https://wetten.overheid.nl/BWBR0001854/2025-07-01>

¹⁶⁴ Law on the Trafficking of Narcotics (Narcotics Act - BtMG) section 35 Deferment of Sentence Execution

¹⁶⁵Criminal Code https://www.gesetze-im-internet.de/stgb/_56c.html

¹⁶⁶ Criminal Code (StGB) § 66 Preventive detention https://www.gesetze-im-internet.de/stgb/_66.htm

			<ul style="list-style-type: none"> - Урьдчилан сэргийлэх сургалт, хөтөлбөрүүд: Сургуулиуд болон олон нийтэд зориулсан хар тамхины хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх сургалт явуулдаг. - Нийгэмд дасан зохицох хөтөлбөрүүд: Донтохоос гарах эмчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн дэмжлэг, нийгэмд буцааж оруулах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. <p>3.Цагдаа, прокурорын шатны урьдчилан сэргийлэх арга хэмжээ</p> <ul style="list-style-type: none"> - “Freispruch unter Auflage” буюу анхааруулга, нөхцөлтэй хэрэгсэхгүй болгох: Хэрэв бага хэмжээний зөрчил гаргасан бол прокурор эмчилгээний болон сургалтын шаардлагыг тавьж хэрэг үүсгэхээс татгалзаж болно. - Прокурорын саналаар ял завсрын эмчилгээгээр орлуулах: Хууль бус хэрэглээтэй залууст зориулсан эмчилгээний хөтөлбөрт хамруулах, тэндээс хяналттай буцаах арга хэмжээ авна. - Сэжигтэй этгээдүүдийг урьдчилан бүртгэх, хянах: Давтан гэмт хэрэгтнүүдэд цагдаа, прокурор нэмэлт хяналт тавьж урьдчилан сэргийлэх ажил хийдэг. <p>ХБНГУ-д хар тамхитай холбоотой давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх дараах ажиллагаа явагддаг.</p> <ul style="list-style-type: none"> - Шүүхийн тэнсэн ялтай хяналт, эмчилгээ - Нийгмийн дэмжлэг, сургалт - Хүчтэй хамгаалалтын хорих арга хэмжээ зэрэг олон давхар арга хэмжээг агуулдаг. - Мансууруулах бодисын тухай хууль 35, 36: дугаар зүйл (BtMG) 	
--	--	--	--	--

			<ul style="list-style-type: none"> - Эрүүгийн хууль 56с, 66, 67 дугаар зүйл (StGB) - Нийгмийн байгууллагууд:¹⁶⁷ <p>ХБНГУ-д хар тамхины гэмт хэрэгтнийг нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргэн оруулах хөтөлбөрүүд нь гэмт хэрэгтний дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх, нийгэмд амжилттай дасан зохицохыг дэмжихэд чиглэгддэг бөгөөд олон шатлалтай, олон байгууллагын оролцоотой системээр хэрэгждэг.</p>	
10.	Эмчилгээ, нийгэмшүүлэх, нөхөн сэргээх хөтөлбөр	<ol style="list-style-type: none"> 1. Нидерланд улсын сэтгэл зүйн болон эмнэлгийн эмчилгээний тогтолцоог сэтгэцийн болон донтох эмчилгээний үйлчилгээ нь дараах гурван чиглэлд хуваагддаг:¹⁶⁸ <ul style="list-style-type: none"> - GGZ instellingen (Geestelijke Gezondheidszorg) – Сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагууд - Verslavingszorginstellingen – Донтох эмчилгээний төвүүд (жишээ: Tactus, Jellinek) - Ziekenhuizen – Эмнэлгүүдийн дэргэдэх сэтгэцийн болон донтолтын тасаг Эдгээрийг улсын эрүүл мэндийн санхүүжилтээр эсвэл даатгалаар санхүүжүүлдэг. 2. Эмчилгээ (Гэрээр болон хэвтэн эмчлүүлэх) нь Амбулаторийн эмчилгээ (outpatient): Сэтгэл зүйчид, эмчтэй 	<p>Эмчилгээний болон сэргээн засах хөтөлбөрүүд (Rehabilitationsprogramme)¹⁶⁹</p> <ul style="list-style-type: none"> - Донтолтын эмчилгээ (Suchttherapie): Хар тамхинаас салах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх эмчилгээний төрөл бүрийн арга хэмжээ: амбулатор, стационар эмчилгээ, бүлгийн уулзалт, зөвлөгөө өгөх үйлчилгээ. - Гэр бүл, нийгмийн дэмжлэг: Гэр бүлийн харилцааг сайжруулах, нийгэмд дахин бүртгэхэд туслах үйлчилгээ. - Эрүүл мэндийн хяналт, дахин сэргийлэлт: Эмч, сэтгэл зүйчийн тогтмол хяналт, дахин донтохоос сэргийлэх арга хэмжээ. <p>2. Хөдөлмөр эрхлэлт, ур чадварын сургалт</p>	<ol style="list-style-type: none"> 1. Сэтгэл зүйн болон эмнэлгийн эмчилгээ <ul style="list-style-type: none"> - Narcotics Hazard Prevention Act (Хар тамхины хор уршгийг хориглох тухай хууль) нь хар тамхины хэрэглэгчдэд сэтгэл зүйн болон эмнэлгийн эмчилгээ, сэргээн засах үйлчилгээ авах үүрэг, эрхийг тусгайлан заасан байдаг. - Хар тамхины хэрэглээг илрүүлсэн этгээдүүдийг эрх бүхий байгууллагаас эмчилгээ, сэргээн засах төвд хамруулах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх зохицуулалттай. Хууль тогтоомжийн дагуу шүүх, прокурор, шоронгийн байгууллагууд дараах нэмэлт арга хэмжээг авч хэрэгжүүлж болдог:

¹⁶⁷<https://www.caritas.de>

¹⁶⁸ Drug use and addiction care <https://www.government.nl/topics/drugs/drug-use-and-addiction-care>

¹⁶⁹ Law on the Trafficking of Narcotics (Narcotics Act - BtMG) Section 35 Deferment of Sentence Execution https://www.gesetze-im-internet.de/btmg_1981/_35.html

		<p>тогтмол уулзалт, бүлгийн эмчилгээ, нөхөн сэргээх хөтөлбөр гэж хуваадаг. Хэвтэн эмчлүүлэх (inpatient): Хүнд хэлбэрийн донтолт, сэтгэцийн өөрчлөлттэй хүмүүст зориулсан клиник, detox хөтөлбөр юм.</p> <p>3. Донтолтыг DSM-5 үзүүлэлтүүд дээр үндэслэн сэтгэцийн эмч, донтолтын мэргэжилтнүүд асуулгын арга (intake), сэтгэл зүйн оношилгоо, зан төлөвийн үнэлгээ ашиглан тодорхойлдог. Үүнд “gebruikspatroom” (хэрэглээний хэв маяг), “controleverlies” (хяналт алдсан эсэх), “ontweningsverschijnselen” (гэрлийн хамаарал, шалтгаан) зэргийг үнэлнэ.</p> <p>4. Эмчилгээний үргэлжлэх хугацаа (Detox + psychotherapy + rehab) нь дунджаар:</p> <ul style="list-style-type: none"> - Detox (бие хоргүйжүүлэх): 1–3 долоо хоног - Психотерапи ба эмчилгээ: 3 сар – 1 жил хүртэл - Нөхөн сэргээх үе шат: 6 сараас дээш хугацаа <p>5. Нөхөн сэргээх (Rehabilitation / Aftercare) арга хэмжээнд дараах арга хэмжээг оруулна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Байнгын харилцаатай бүлгийн уулзалт (AA, NA); - Хөдөлмөрт бэлтгэх сургалт; - Нийгэмд дасан зохицох хөтөлбөр; - Амьдрах байрны дэмжлэг, орон сууц. <p>6. Сэтгэл зүйн тусламж (Psychotherapy / Behavioral therapy)-д дараах арга хэмжээг оруулна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - СВТ (Cognitive Behavioral Therapy) Танин мэдэхүйн болон зан үйлийн засал 	<ul style="list-style-type: none"> - Ажлын байранд бэлтгэх сургалт: Мэргэжил эзэмшүүлэх, ажлын дадлагажуулалт явуулах хөтөлбөрүүд. - Ажилд зуучлах үйлчилгээ: <p>Гэмт хэрэгтэнг ажлын байртай болгох, нийгмийн халамжийн байгууллагуудтай хамтран ажиллах.</p> <ul style="list-style-type: none"> - Нийгмийн ажлын оролцоо: <p>Нийгмийн ажил, сайн дурын үйл ажиллагаанд оролцуулах замаар нийгэмд дасан зохицох чадварыг сайжруулах.</p> <p>3. Нийгмийн орчинд дэмжлэг үзүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Оршин суух орчин, байр байрлуулах: <p>Хямд төсөр орон сууц, хамгаалалтын байр, түр орон сууцны төвүүд.</p> <ul style="list-style-type: none"> - Хууль эрх зүйн зөвлөгөө: <p>Гэмт хэрэгтэнг хууль эрх зүйн зөвлөгөөгөөр хангах, хөдөлмөр эрхлэлт, гэр бүлийн асуудлаар дэмжлэг үзүүлэх.</p> <ul style="list-style-type: none"> - Нийгмийн сүлжээ бий болгох: <p>Ижил төстэй нөхцөлтэй хүмүүсийн бүлгэм, дэмжих бүлгүүдийг бий болгох.</p> <p>4. Хамтын ажиллагаа ба зохион байгуулалт</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн байгууллагууд: <p>Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн халамжийн яамдууд, цагдаа, прокурор, шүүх.</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн бус байгууллагууд (ТББ): Caritas, Diakonie, Deutsche Aidshilfe зэрэг олон нийтийн сайн дурын байгууллагууд. - Орон нутгийн засаг захиргаа: <p>Орон нутгийн нийгмийн үйлчилгээ, орон сууц, сургалтад дэмжлэг үзүүлэх.</p> <p>ХБНГУ-д хар тамхины гэмт хэрэгтнийг нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргэн оруулах хөтөлбөрүүд нь эмчилгээ, сургалт, хөдөлмөр эрхлэлт, орон сууц, хууль эрх зүйн болон нийгмийн дэмжлэг гэсэн олон шатлалтай бөгөөд төр, хувийн хэвшил, ТББ-</p>	<p>Албадан эмчилгээ (Mandatory Treatment):</p> <ul style="list-style-type: none"> - Сэтгэцэд нөлөөлөх бодисын хэрэглээнээс шалтгаалсан хамаарал бүхий этгээдүүдийг сэтгэл зүйн болон эмнэлгийн байгууллагад эмчлүүлэхээр илгээх эрх шүүхэд бий. - Эмчилгээний хугацаа нь 2 сараас 1 жил хүртэл, тухайн хүний хамаарал, зан үйлийн байдлаас хамаарч сунгаж болдог. <p>Сэтгэл заслын үйлчилгээ (Psychological Counseling):</p> <ul style="list-style-type: none"> - Шоронгийн болон засгийн газрын харьяа сэргээн засах төвүүд дээр сэтгэл заслын үйлчилгээ үзүүлдэг. - Үүнд өөрийгөө танин мэдэх, уур удаараа зохицуулах, харилцаа сайжруулах, хамааралтай тэмцэх арга техникийг заах зэрэг хөтөлбөр багтана. <p>Шүүхийн өмнөх эмчилгээний хөтөлбөр (Deferred Prosecution with Treatment):</p> <ul style="list-style-type: none"> - Хөнгөн зэргийн хэрэгт холбогдсон, хар тамхи хэрэглэсэн нь тогтоогдсон боловч борлуулалт хийдэггүй этгээдийг шийтгэхээс өмнө эмчилгээний хөтөлбөрт хамруулж болдог. - Амжилттай хамрагдсан тохиолдолд ял онохоос татгалзах боломжтой.
--	--	--	---	---

		<p>эсвэл: Сэтгэлгээ ба зан үйлийг өөрчлөх сэтгэл засал;</p> <ul style="list-style-type: none"> - Motivational Interviewing Сэдэлжүүлэлтийн ярилцлага эсвэл: Хүчилж шахахгүйгээр зорилгоо тодорхойлох ярилцлага - Mindfulness-based relapse prevention Танин мэдэхүйн төвлөрөлд суурилсан дахилтаас сэргийлэх арга эсвэл: Анхаарал төвлөрөлд суурилсан дахилтаас урьдчилан сэргийлэх сэтгэл засал. <p>Эдгээрийг ганцаарчилсан болон бүлгийн байдлаар явуулдаг.</p> <p>7. Бусад дэмжих арга хэмжээ (social care + housing + reintegration) Нийгмийн халамж, орон байрны дэмжлэг, нийгэмшүүлэлтийн цогц үйлчилгээ</p>	<p>ууд хамтран хэрэгжүүлдэг иж бүрэн тогтолцоо юм.</p> <p>Тус улсад хар тамхитай холбоотой гэмт хэрэг зохион байгуулалттай бүлэглэл болон хуулийн этгээдийн оролцоотой үйлдэгдсэн тохиолдолд ял шийтгэл болон эрүүгийн хариуцлага нь илүү хатуу, тусгай журамтай байдаг.</p>	
4.	Гэмт хэрэгтнийг нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргэн оруулах хөтөлбөрийн хэрэгжилт	<ol style="list-style-type: none"> 1. Нөхөн сэргээх эмчилгээ, сэтгэл зүйн дараах дэмжлэгийг үзүүлж байна. <ul style="list-style-type: none"> - Хар тамхины донтох эмгэгийг эмчлэх, сэтгэл заслын тусламж үзүүлэх төвүүд байдаг. - Эдгээр үйлчилгээ нь гэмт хэрэгтнийг сэтгэл санааны хувьд тогтворжуулах, дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг бууруулахад чиглэсэн. 2. Нийгэмд дахин нэгтгэх хөтөлбөрүүдийг дурдвал: 	<ol style="list-style-type: none"> 1. Эмчилгээний болон сэргээн засах хөтөлбөрүүд (Rehabilitationsprogramme)¹⁷⁰ - Донтолтын эмчилгээ (Suchttherapie): Хар тамхинаас салах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх эмчилгээний төрөл бүрийн арга хэмжээг хэрэгжүүлж амбулатор, стационар эмчилгээ, бүлгийн уулзалт, зөвлөгөө өгөх үйлчилгээ. - Гэр бүл, нийгмийн дэмжлэг: Гэр бүлийн харилцааг сайжруулах, нийгэмд дахин бүртгэхэд туслах үйлчилгээ. 	Хэрэглэгчдийг нийгэмд эргэн оруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийгмийн ажилтнууд, мэргэжлийн баг хамтран ажиллах хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг.

¹⁷⁰ Law on the Trafficking of Narcotics (Narcotics Act - BtMG) Section 35 Deferment of Sentence Execution https://www.gesetze-im-internet.de/btmg_1981/_35.html

		<ul style="list-style-type: none"> - Гэмт хэрэгтнийг ажил мэргэжлийн сургалт, боловсрол, амьдралын ур чадвар олгох хөтөлбөрүүдэд хамруулдаг. - Орон нутгийн нийгмийн ажилтнууд, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлдэг. <p>3. Хяналт, зөвлөгөө дараах байдлаар хэрэгжүүлж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Нийгэмд эргэн орсон хүнд цагдаагийн болон нийгмийн ажилтны байнгын хяналт, зөвлөгөө үргэлжилдэг. - Дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилготой. <p>4. Олон талын хамтын ажиллагааг дараах байгууллагатай хамтран мансууруулах бодистой холбоотойгоор шүүх, прокурор, цагдаа, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн байгууллага зэрэг байгууллагууд хамтран, гэмт хэрэгтнийг дэмжих, эргэн нийгэмшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулдаг.</p> <p>5. Нийгмийн оролцоо, дэмжлэгийг гэр бүл, орон нутгийн хамт олон, төрийн бус байгууллагууд оролцож, гэмт хэрэгтнийг нийгэмдээ эргэн оруулахад тусалдаг. Нийгмийн дэмжлэг нь дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг бууруулахад чухал үүрэгтэй.</p> <p>Нидерланд улсад хар тамхинд донтох эмчилгээ нь зуршлаа хаяхад туслах үйлчилгээ, тусгай зориулалтын хэрэглээний төвүүд, сайн дурын болон албадан эмчилгээ, мөн хэвтэн болон амбулаторийн аргаар үзүүлэх тусламж зэргийг хамардаг. Хар тамхины асуудалтай хүмүүсийн ихэнх нь</p>	<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн хяналт, дахин сэргийлэлт: Эмч, сэтгэл зүйчийн тогтмол хяналт, дахин донтохоос сэргийлэх арга хэмжээ. <p>2. Хөдөлмөр эрхлэлт, ур чадварын сургалт</p> <ul style="list-style-type: none"> - Ажлын байранд бэлтгэх сургалт: Мэргэжил эзэмшүүлэх, ажлын дадлагажуулалт явуулах хөтөлбөрүүд. - Ажилд зуучлах үйлчилгээ: Гэмт хэрэгтэнг ажлын байртай болгох, нийгмийн халамжийн байгууллагуудтай хамтран ажиллах. - Нийгмийн ажлын оролцоо: Нийгмийн ажил, сайн дурын үйл ажиллагаанд оролцуулах замаар нийгэмд дасан зохицох чадварыг сайжруулах. <p>3. Нийгмийн орчинд дараах дэмжлэгийг үзүүлж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Оршин суух орчин, байр байрлуулах: Хямд төсөр орон сууц, хамгаалалтын байр, түр орон сууцны төвүүд. - Хууль эрх зүйн зөвлөгөө: Гэмт хэрэгтэнг хууль эрх зүйн зөвлөгөөгөөр хангах, хөдөлмөр эрхлэлт, гэр бүлийн асуудлаар дэмжлэг үзүүлэх. - Нийгмийн сүлжээ бий болгох: Ижил төстэй нөхцөлтэй хүмүүсийн бүлгэм, дэмжих бүлгүүдийг бий болгох. <p>4. Хамтын ажиллагаа ба зохион байгуулалтын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагууд ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн байгууллагууд: Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн халамжийн яамдууд, цагдаа, прокурор, шүүх. - Төрийн бус байгууллагууд (ТББ): Caritas, Diakonie, Deutsche Aidshilfe зэрэг олон нийтийн сайн дурын байгууллагууд. 	
--	--	---	---	--

		<p>амбулаторийн донтох эмчилгээ авдаг. Энэ нь дараах үйл ажиллагааг багтаана:</p> <ul style="list-style-type: none"> - Гэнэтийн хүндрэлд хариу арга хэмжээ авах; - Зуршлаа хаяхад туслах; - Амьдралын чанарыг сайжруулах; - Хэрэглээгээ зохицуулах, эрүүл мэндэд учирч болзошгүй хор хөнөөлийг бууруулах; - Өөрсдөө тусламж хүсдэггүй хүмүүст хүрч ажиллах (идэвхтэй хандлага бүхий арга хэмжээ); - Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах. <p>Хэвтэн эмчлүүлэх тусламж нь дараах үйлчилгээг багтдаг. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хямралын үеийн тусламж; - Бие махбодыг хоргүйжүүлэх хөтөлбөр; - Эмнэлэг, сэтгэцийн эмнэлгийн тасаг, эмчилгээний хамт олонд суурилсан клиник эмчилгээ. <p>Энэ нь амбулаторийн тусламжаас илүү эрчимтэй байдаг бөгөөд хүнийг нийгэмд дахин нэвтрэхэд бэлтгэхэд чиглэдэг.</p>	<p>- Орон нутгийн засаг захиргаа: Орон нутгийн нийгмийн үйлчилгээ, орон сууц, сургалтад дэмжлэг үзүүлэх.</p> <p>5. Хууль эрх зүйн үндэслэл</p> <ul style="list-style-type: none"> - Мансууруулах бодисын тухай хууль Betäubungsmittelgesetz (BtMG) 35, 36 – Донтох эмчилгээний заалтууд - Sozialgesetzbuch (SGB) XII – Нийгмийн халамжийн хууль - Strafgesetzbuch (StGB) 56c, 67 – Тэнсэн ялтай холбоотой нөхцөлүүд <p>ХБНГУ-д хар тамхины гэмт хэрэгтнийг нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргэн оруулах хөтөлбөрүүд нь эмчилгээ, сургалт, хөдөлмөр эрхлэлт, орон сууц, хууль эрх зүйн болон нийгмийн дэмжлэг гэсэн олон шатлалтай бөгөөд төр, хувийн хэвшил, ТББ-ууд хамтран хэрэгжүүлдэг иж бүрэн тогтолцоо юм.</p> <p>Тус улсад хар тамхитай холбоотой гэмт хэрэг зохион байгуулалттай бүлэглэл болон хуулийн этгээдийн оролцоотой үйлдэгдсэн тохиолдолд ял шийтгэл болон эрүүгийн хариуцлага нь илүү хатуу, тусгай журамтай байдаг.</p>	
3.	Зохион байгуулалттай гэмт бүлэглэл, хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага, ялын бодлого	<p>1. Зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн ял шийтгэл</p> <p>Нидерланд улсын хуульд зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн үйл ажиллагаанд илүү хатуу ял оноох зохицуулалттай. Хар тамхины томоохон наймаа, үйлдвэрлэл, хууль бус сүлжээнд холбоотой бүлэглэлүүдэд хорих ялын дээд хэмжээ илүү өндөр бөгөөд торгууль, бусад нэмэлт арга хэмжээ ногдуулагддаг. Зохион байгуулалттай гэмт бүлэглэлд хар тамхины гэмт хэрэгт олон хүнийг оролцуулсан, хууль бус үйл ажиллагааг зохион байгуулсан гэх үндэслэлээр илүү хүнд ял ногдуулдаг.</p>	<p>Зохион байгуулалттай бүлэглэлд хар тамхины гэмт хэрэг үйлдсэн бол Эрүүгийн хууль (StGB)-ийн холбогдох заалтуудаар илүү хүнд ял оногдуулна. Үүнд:</p> <p>Мансууруулах бодисын тухай хуулийн 30a BtMG зохион байгуулалттай бүлэглэлээр мансууруулах бодисыг худалдан борлуулах, үйлдвэрлэхэд оногдуулах ялын талаар зохицуулсан.</p> <p>Эрүүгийн хуулийн 129 StGB гэмт бүлэглэл байгуулах, удирдах, оролцох талаар заасан.</p> <p>Ял шийтгэл:</p> <ul style="list-style-type: none"> - 2-оос 15 жилийн хорих ял хүртэл (хэрэв хүнд нөхцөлтэй, их хэмжээтэй бол) 	<p>1. Зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн ял шийтгэл</p> <p>Зохион байгуулалттай гэмт бүлэглэлээр хар тамхины гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд ял шийтгэл нь илүү хүнд, чанга байдаг. Ийм гэмт хэрэгт холбогдсон этгээдүүдэд урт хугацааны хорих ял, өндөр торгууль оногдуулж, гэмт хэргийн сүлжээг устгах, санхүүгийн хөрөнгийг хураах арга хэмжээг авдаг. Мөн зохион байгуулалттай гэмт бүлэглэлд холбогдсон хүмүүсийг Эрүүгийн</p>

		<p>2. Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага Нидерланд улсын хууль тогтоомжид хуулийн этгээд (компани, байгууллага)-ийн эрүүгийн хариуцлага тогтоох зохицуулалт бий. Хэрэв хуулийн этгээд хар тамхины гэмт хэрэгтэй холбоотой үйлдэл хийсэн нь тогтоогдвол, түүний эсрэг торгууль, хязгаарлалт, үйл ажиллагааг түр зогсоох, бусад хууль ёсны арга хэмжээ авдаг. Хуулийн этгээдийн хариуцлага нь хувь хүнтэй зэрэгцэн оногдуулах боломжтой. Wetboek van Strafrecht (Эрүүгийн хууль)-ийн 140 дүгээр зүйлд болон Opiumwet (Опийн тухай хууль)-ийн 11 дүгээр зүйлийн 11.1-д зохион байгуулалттай гэмт бүлэглэл, хуулийн этгээдийн хариуцлагыг нарийвчлан тусгасан байдаг.¹⁷¹</p> <p>Нидерланд улсад хил давуулан буюу үндэстэн дамнасан хар тамхины гэмт хэрэгт ногдуулах ял шийтгэлийг дараах байдлаар оногдуулж байна.</p>	<ul style="list-style-type: none"> - Мөн эд хөрөнгө хураах, бусад нэмэлт шийтгэл оногдуулах - Хэрэг явдалд хориглосон эд зүйлс (Tatmittel) хураах 	<p>хуулийн тусгай заалтуудын дагуу нэмэлт ял шийтгэдэг.</p> <p>2. Хуулийн этгээдийн хариуцлага Хуулийн этгээд (компани, байгууллага, аж ахуйн нэгж гэх мэт) хар тамхины гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд хууль ёсны хариуцлага хүлээнэ.</p> <p>Хуулийн этгээдийн эсрэг авдаг арга хэмжээ нь торгуулиас гадна үйл ажиллагааг түр зогсоох, татан буулгах хүртэлх арга хэмжээ байж болно. Хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтнууд нь хувь хүн хувиараа эрүүгийн хариуцлага хүлээж болно.</p> <p>3. Эрүүгийн хариуцлага Зохион байгуулалттай хар тамхины гэмт хэрэгтэн, бүлэглэлийн гишүүдэд холбогдох эрүүгийн хариуцлагыг өндөржүүлсэн заалтууд байдаг. Энэ нь гэмт хэргийн ноцтой байдлыг харгалзан үзэж, яллах, хорих ялын хугацааг уртасгах, торгууль өндөр байхаар зохицуулагдсан.</p>
4.	Хил давуулан буюу үндэстэн дамнасан гэмт хэрэгт оногдуулах ял, онцлог	<ul style="list-style-type: none"> - Хил дамнасан хар тамхины наймаа, зөөвөрлөлт, үйлдвэрлэл нь хамгийн ноцтой гэмт хэрэгт тооцогддог бөгөөд энэ төрлийн гэмт хэргүүдэд 12 жил хүртэл хорих ял оногдуулдаг.¹⁷² Хар тамхины тухай хуулийн 10 дугаар зүйл - Гэмт хэрэгт холбогдсон этгээдийн үүрэг, оролцоо, хар тамхины хэмжээ, чанараас хамааран хорих ялын хугацаа нь ялгамжтай байдаг. - Мөн өндөр хэмжээний торгууль оногдуулах боломжтой. 	<p>Хэрэв мансууруулах бодисыг гадаад улс орноос оруулж ирсэн эсвэл гаргасан бол энэ нь “хил дамнасан” (grenzüberschreitender oder internationaler Drogenhandel) гэж үздэг. Энэ нь Мансууруулах бодисын тухай хуулийн 30 дугаар зүйлийн BtMG (1) №4-ийн “их хэмжээний мансууруулах бодисыг хууль бусаар импортлох”-той холбоотой ба илүү хүнд гэмт хэрэг гэж ангилагддаг. Хууль ёсны доод ял 2 жил хорих ялтай байна.</p>	<p>5. Хилийн чанад дахь хар тамхины гэмт хэрэгтэй хамтран ажиллах, хил давуулан зөөвөрлөх нь эрүүгийн ноцтой төрлийн гэмт хэрэгт тооцогддог.</p> <p>6. Ялын хэмжээ нь хатуу, урт хугацааны хорих ял болон өндөр торгуулийг хамардаг.</p> <ul style="list-style-type: none"> - Хорих ялын хугацаа ихэвчлэн олон жил (жишээ нь 5-аас дээш жил) байж болох бөгөөд зарим

¹⁷¹ Opiumwet <https://wetten.overheid.nl/BWBR0001941/2009-07-01#Artikel12>

¹⁷² Opiumwet <https://wetten.overheid.nl/BWBR0001941/2009-07-01#Artikel12>

		Хил дамнасан хар тамхины гэмт хэрэг нь ял шийтгэлийг хүндрүүлэх нөхцөл болдог. Тухайн гэмт хэрэг нь олон улсын хэмжээнд үйлдэгдсэн, олон улсын сүлжээг ашигласан, эсвэл бусад улс орны хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай тохиолдолд ял шийтгэл илүү хатуу, хүндхэн болдог. Давтан үйлдэл, зохион байгуулалттай бүлэглэлтэй холбогдсон тохиолдолд ял нь улам хүндэрнэ. Нидерланд нь олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, хил дамнасан хар тамхины гэмт хэрэгтэй тэмцэхэд идэвхтэй оролцдог. Энэ нь гэмт хэрэгтнүүдийг илрүүлэх, баривчлах, шүүхэд шилжүүлэх үйл явцад чухал үүрэгтэй.		тохиолдолд насаар хорих хүртэл ял оногдуулдаг. 7. Ял хүндэрдэг онцлог - Хил дамнасан болон олон улсын хар тамхины гэмт хэргийн сүлжээтэй холбоотой үйлдлийг онцгой хүнд гэмт хэрэг гэж үздэг тул ял шийтгэл илүү хүндэрдэг. - Гэмт хэргийн сүлжээг удирдсан, зохион байгуулсан, санхүүжүүлсэн зэрэг тохиолдолд нэмэлт ял оногдуулах боломжтой. 8. Хөрөнгө хураалт болон бусад нэмэлт арга хэмжээ - Гэмт хэргээс олсон хөрөнгийг хураан авах, мөнгө угаахтай тэмцэх онцгой арга хэмжээ авч хэрэгжүүлдэг.
5.	Цагдаа, прокурор, шүүх, бусад байгууллагын салбар хоорондын хамтын ажиллагаа	Цагдаа болон прокурорын хамтын ажиллагаа: - Цагдаа, прокурор нар хар тамхины гэмт хэрэгт шуурхай, үр дүнтэй мөрдөн байцаалтын ажиллагааг хамтран зохион байгуулдаг. - Цагдаа нь баримт нотолгоог цуглуулах, мөрдөн шалгах үүрэгтэй бол прокурор нь эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлэх, яллах ажиллагааг хариуцдаг. 2. Шүүхийн үүрэг: - Шүүх нь прокурорын нотлох баримтад үндэслэн гэм буруутай эсэхийг тогтоож, ял шийтгэл оноодог.	ХБНГУ-д хар тамхитай холбоотой гэмт хэрэгтэй тэмцэхэд цагдаа, прокурор, шүүх, бусад төрийн болон төрийн бус байгууллагуудын салбар хоорондын хамтын ажиллагаа нэн чухал үүрэгтэй бөгөөд энэ нь гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, ял шийтгэл оногдуулах үйл явцыг үр дүнтэй болгодог. Цагдаа, прокурор, шүүх, нийгмийн болон эрүүл мэндийн байгууллагууд, ТББ-ууд нь хар тамхитай холбоотой гэмт хэрэгтэй тэмцэхэд хамтран ажиллах, мэдээлэл солилцох, уялдаа холбоотой хяналт тавих системтэй. Энэ хамтын ажиллагаа нь гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг эрүүлжүүлэх, ял шийтгэл оногдуулах үйл явцыг үр дүнтэй болгодог.	1. Хууль сахиулах байгууллагуудын эрх мэдэл, хамтын ажиллагаа - Хар тамхитай тэмцэхэд цагдаа, прокурор, шүүх, тусгай албаныхан хоорондын харилцан уялдаа, мэдээлэл солилцоог хуулиар баталгаажуулсан. - Олон улсын хар тамхитай тэмцэх хэлэлцээр, протоколд нэгдэн орсон.

		<ul style="list-style-type: none"> - Шүүх нь ялтан болон холбогдох талуудын эрх ашгийг хамгаалах үүрэгтэй. <p>3. Олон байгууллагын уялдаа:</p> <ul style="list-style-type: none"> - Хар тамхитай тэмцэхэд холбогдох бусад байгууллагууд (жишээ нь гааль, татварын газар, нийгмийн үйлчилгээний байгууллагууд) цагдаа, прокурор, шүүхтэй мэдээлэл солилцох, хамтран ажиллах үүрэгтэй. Тухайлбал, гааль нь хил дээр хар тамхины урсгалыг илрүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг. <p>4. Хамтарсан сургалт, чадавхжуулалт</p> <ul style="list-style-type: none"> - Цагдаа, прокурор, шүүх болон бусад байгууллагуудын ажилтнууд хамтарсан сургалт, дадлага хийж, хар тамхитай тэмцэх чадвараа сайжруулдаг. <p>Тус улсад гэмт хэрэгтэн, хууль бус үйлдлийн талаарх мэдээллийг цуглуулсан, хадгалдаг нэгдсэн мэдээллийн сантай. Энэ системд цагдаа, прокурор, шүүх, гааль болон бусад холбогдох байгууллагууд нэвтрэх эрхтэй бөгөөд мэдээлэл солилцох, хамтран ажиллахад ашигладаг.¹⁷³ Мэдээллийн сан нь гэмт хэрэгтнүүдийн үйл ажиллагааг хянах, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй болгоход тусалдаг. Тус систем нь үндэсний түвшинд төдийгүй олон улсын</p>	<p>Гэмт хэрэгтний мэдээллийн нэгдсэн сан (Datenbank) байдаг бөгөөд энэ нь хууль сахиулах байгууллагуудын хооронд мэдээлэл хуваалцах, гэмт хэрэгтэнг хянах, мөрдөн байцаалтын ажлыг эрчимжүүлэх зорилготой юм. ХБНГУ-д гэмт хэрэгтний мэдээллийн нэгдсэн сан бий бөгөөд энэ нь хууль сахиулах байгууллагуудын мэдээлэл солилцох, гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал хэрэгсэл болдог. Мэдээллийг ашиглахдаа хувийн нууцлал, хүний эрхийг хамгаалах хууль журмыг чанд мөрддөг.¹⁷⁴</p> <p>Хар тамхитай холбоотой гэмт хэргийн эсрэг үр дүнтэй тэмцэхийн тулд цагдаа, прокурор, шүүхийн ажилтнууд болон нийгмийн ажилтнуудын чадавхжуулах сургалт маш чухал үүрэгтэй байдаг. Энэ сургалтууд нь мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хар тамхины гэмт хэргийн онцлогийг ойлгох, хуулийн дагуу зөв шийдвэр гаргахад чиглэгддэг.</p>	
--	--	--	---	--

¹⁷³ [European Monitoring Centre for Drugs and Drug Addiction \(EMCDDA\) – Netherlands](#)

¹⁷⁴ https://www.bka.de/EN/TheBKA/OurLegalMandate/ourmandate_node.html

		мэдээллийн сангуудтай холбогдож, хамтын ажиллагааг дэмждэг.		
6.	Гэмт хэрэгтний мэдээллийн нэгдсэн сан	<p>Тус улсад гэмт хэрэгтэн, хууль бус үйлдлийн талаарх мэдээллийг цуглуулсан, хадгалдаг нэгдсэн мэдээллийн сантай. Энэ системд цагдаа, прокурор, шүүх, гааль болон бусад холбогдох байгууллагууд нэвтрэх эрхтэй бөгөөд мэдээлэл солилцох, хамтран ажиллахад ашигладаг.¹⁷⁵ Мэдээллийн сан нь гэмт хэрэгтнүүдийн үйл ажиллагааг хянах, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй болгоход тусалдаг. Тус систем нь үндэсний түвшинд төдийгүй олон улсын мэдээллийн сангуудтай холбогдож, хамтын ажиллагааг дэмждэг</p> <p>Мэдээллийн нэгдсэн сан</p> <ul style="list-style-type: none"> - Хар тамхитай холбоотой гэмт хэрэгтнүүд болон үйлдлүүдийн талаарх мэдээллийг нэгдсэн системд бүртгэж, оролцогч байгууллагууд түүнд нэвтрэн ажилладаг. - Энэ нь хэргүүдийн уялдаа холбоог сайжруулж, урьдчилан сэргийлэхэд тусалдаг. 	<p>ХБНГУ-д гэмт хэрэгтний мэдээллийн нэгдсэн сан (Datenbank) байдаг бөгөөд энэ нь хууль сахиулах байгууллагуудын хооронд мэдээлэл хуваалцах, гэмт хэрэгтэнг хянах, мөрдөн байцаалтын ажлыг эрчимжүүлэх зорилготой юм.</p> <p>ХБНГУ-ын гэмт хэрэгтний мэдээллийн сангийн тухай</p> <ol style="list-style-type: none"> 1. Хамрах хүрээ ба бүтэц <ul style="list-style-type: none"> - Zentrales Nationales Waffenregister (ZNWR) – зэвсэгтэй холбоотой мэдээллийн сан - Kriminalpolizeiliches Informationssystem (KIS) – Цагдаагийн криминал мэдээллийн систем - Bundeszentralregister (BZR) – Төрийн төв гэмт хэргийн бүртгэл, гэмт хэрэгтний бүртгэл 2. Эрх бүхий байгууллагууд <ul style="list-style-type: none"> - Цагдаа, прокурор, шүүхийн байгууллагууд - Холбооны төв гэмт хэргийн бүртгэлийн газар (Bundesamt für Justiz) <ul style="list-style-type: none"> - Хилийн болон гаалийн байгууллагууд 3. Үйл ажиллагаа, ашиглалт <ul style="list-style-type: none"> - Гэмт хэрэгтний өмнөх гэмт хэргүүд, шийтгэл, сэжигтэй этгээдийн мэдээлэл <ul style="list-style-type: none"> - Мөрдөн байцаалтын явцад ашиглах, гэмт хэрэгтэй холбогдсон хүмүүсийг илрүүлэхэд туслах - Олон улсын мэдээллийн санд (INTERPOL, Europol) холбогдох 	<p>Тайваньд гэмт хэрэгтний мэдээллийг төвлөрүүлэн бүртгэдэг нэгдсэн мэдээллийн сантай байна. Энэ мэдээллийн сан нь цагдаа, прокурор, шүүх, хууль сахиулах болон бусад холбогдох байгууллагуудад ашиглагддаг.</p> <p>Мэдээллийн сангийн зорилго нь гэмт хэрэгтэй холбоотой мэдээллийг шуурхай солилцох, гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, ялтнуудыг хянах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжихэд оршино. Мөн хар тамхитай холбоотой гэмт хэрэгтнүүдийн мэдээллийг тусгайлан ангилж, дахин гэмт хэрэгт холбогдох эрсдэлийг бууруулахад ашигладаг.</p>

¹⁷⁵ [European Monitoring Centre for Drugs and Drug Addiction \(EMCDDA\) – Netherlands](#)

			ХБНГУ-д гэмт хэрэгтний мэдээллийн нэгдсэн сан бий бөгөөд энэ нь хууль сахиулах байгууллагуудын мэдээлэл солилцох, гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал хэрэгсэл болдог. Мэдээллийг ашиглахдаа хувийн нууцлал, хүний эрхийг хамгаалах хууль журмыг чанд мөрддөг. ¹⁷⁶	
7.	Цагдаа прокурор, шүүх, нийгмийн ажилтнын чадавхижуулах сургалт	<ol style="list-style-type: none"> Сургалтын агуулга <ul style="list-style-type: none"> Хар тамхины хууль эрх зүйн зохицуулалт, шинэчлэлтүүд; Хар тамхитай тэмцэх мөрдөн байцаалтын арга зүй; Эрүүгийн ажиллагаа болон шүүхийн шийдвэр гаргалт; Гэмт хэрэгтнүүдтэй харилцах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх арга техник; Нийгмийн ажилтны үүрэг, нөхөн сэргээх хөтөлбөрийн хэрэгжилт. Сургалтын хэлбэрүүд <ul style="list-style-type: none"> Семинар, лекц, семинарын хэлбэрээр явагддаг; Практик дадлага, кейс судалгаа; Онлайн болон биечлэн сургалт. Хамтын ажиллагаа <ul style="list-style-type: none"> Цагдаа, прокурор, шүүх, нийгмийн ажилтнуудын хамтарсан сургалт, семинар зохион байгуулдаг. Улсын болон орон нутгийн түвшинд сургалтын тогтмол хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. Чадавхыг сайжруулах зорилго 	<p>ХБНГУ-д хар тамхитай холбоотой гэмт хэрэгтэй тэмцэхэд цагдаа, прокурор, шүүх, бусад төрийн болон төрийн бус байгууллагуудын салбар хоорондын хамтын ажиллагаа нэн чухал үүрэгтэй бөгөөд энэ нь гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, ял шийтгэл оногдуулах үйл явцыг үр дүнтэй болгодог.</p> <p>Цагдаа, прокурор, шүүх, нийгмийн болон эрүүл мэндийн байгууллагууд, ТББ-ууд нь хар тамхитай холбоотой гэмт хэрэгтэй тэмцэхэд хамтран ажиллах, мэдээлэл солилцох, уялдаа холбоотой хяналт тавих системтэй. Энэ хамтын ажиллагаа нь гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг эрүүлжүүлэх, ял шийтгэл оногдуулах үйл явцыг үр дүнтэй болгодог.</p> <p>Гэмт хэрэгтний мэдээллийн нэгдсэн сан (Datenbank) байдаг бөгөөд энэ нь хууль сахиулах байгууллагуудын хооронд мэдээлэл хуваалцах, гэмт хэрэгтэнг хянах, мөрдөн байцаалтын ажлыг эрчимжүүлэх зорилготой юм. ХБНГУ-д гэмт хэрэгтний мэдээллийн нэгдсэн сан бий бөгөөд энэ нь хууль сахиулах байгууллагуудын мэдээлэл солилцох, гэмт</p>	<ol style="list-style-type: none"> Цагдаа <ul style="list-style-type: none"> Хар тамхины гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн байцаалт явуулах үүрэгтэй. Прокурор, бусад холбогдох байгууллагатай хамтран гэмт хэргийн сүлжээг задлах, нотлох баримт цуглуулах ажлыг зохион байгуулдаг. Хар тамхины гэмт хэрэг илрүүлэх, мөрдөн шалгах арга зүй, шинжээчийн мэдлэгийг сайжруулах сургалт явагддаг. Мөрдөн байцаалтын техник, сэжигтэнтэй харьцах арга барил, хууль зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтууд ордог. Прокурор <ul style="list-style-type: none"> Гэмт хэргийн хэргийг шалгаж, эрүүгийн хэрэг үүсгэх, шүүхэд шилжүүлэх үүрэгтэй. Цагдаа, шүүхтэй хамтран хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын явцыг хянан зохицуулдаг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чадавхыг сайжруулах, хар тамхитай холбоотой нарийн

		<ul style="list-style-type: none"> - Хар тамхитай холбоотой гэмт хэргийн илрүүлэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны ажиллагааг сайжруулах; - Гэмт хэрэгтнүүдийг үр дүнтэй нөхөн сэргээх, дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх; - Мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх. 	<p>хэрэгтэй тэмцэхэд чухал хэрэгсэл болдог. Мэдээллийг ашиглахдаа хувийн нууцлал, хүний эрхийг хамгаалах хууль журмыг чанд мөрддөг.</p> <p>Хар тамхитай холбоотой гэмт хэргийн эсрэг үр дүнтэй тэмцэхийн тулд цагдаа, прокурор, шүүхийн ажилтнууд болон нийгмийн ажилтнуудын чадавхжуулах сургалт маш чухал үүрэгтэй байдаг. Энэ сургалтууд нь мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хар тамхины гэмт хэргийн онцлогийг ойлгох, хуулийн дагуу зөв шийдвэр гаргахад чиглэгддэг. Цагдаа, прокурор, шүүхийн болон нийгмийн ажилтнуудын хар тамхитай холбоотой гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглэсэн чадавхижуулах сургалт нь мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, салбар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах чухал хэрэгсэл юм.</p>	<p>төвөгтэй хэргийг удирдах сургалт зохион байгуулагддаг.</p> <ul style="list-style-type: none"> - Шүүхэд нотлох баримт бүрдүүлэх, хууль зүйн зөвлөмж өгөх ур чадварыг дээшлүүлэхэд анхаардаг. <p>3. Шүүх</p> <ul style="list-style-type: none"> - Гэмт хэргийн талаарх эрүүгийн хэргийг шүүн хэлэлцэх, шийдвэр гаргах үүрэгтэй. - Эрүүгийн хариуцлагыг тогтоох, ял шийтгэл оногдуулах асуудлыг хариуцдаг. - Хар тамхины гэмт хэрэгтэй холбоотой эрүүгийн хэргийг шударгаар, хууль ёсоор шийдвэрлэх чадваржуулах сургалт явагддаг. - Эрүүгийн хууль, шинжээчийн тайлбар, ял шийтгэлийн аргачлалыг сайжруулахад чиглэсэн сургалт ордог. <p>4. Бусад байгууллага</p> <ul style="list-style-type: none"> - Эрүүл мэнд, нийгмийн ажил, хууль сахиулах бусад агентлагуудтай хамтран хар тамхины гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, сэргээн засах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. - Олон улсын байгууллагуудтай хамтран мэдээлэл солилцож, хамтарсан ажиллагааг явуулдаг.
8.	Хар тамхины хууль бус эргэлттэй тэмцэх тусгай байгууллага	(Дүрэм журам, Урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга, стратеги хөтөлбөр төлөвлөгөө) Нидерланд улсын Засгийн газар хар тамхи, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд олон байгууллагын хамтын ажиллагаанд тулгуурласан “үр нөлөөтэй түншлэл бүхий хандлага”-ыг хэрэгжүүлдэг болохыг онцолж байна.	1. Холбооны криминал агентлаг (Bundeskriminalamt, ВКА) <ul style="list-style-type: none"> - Хар тамхины гэмт хэрэгт холбогдох мөрдөн байцаалт, зохион байгуулалттай гэмт бүлэглэлтэй тэмцэх - Олон улсын харилцаа, мэдээлэл солилцоо, хамтын ажиллагаа 	Тайваньд хар тамхины хууль бус эргэлт, гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр тусгай эрх, үүрэг бүхий байгууллага байдаг. Энэ байгууллага нь ихэвчлэн Цагдаагийн Ерөнхий Газрын Хар тамхитай тэмцэх хэлтэс бөгөөд хар тамхины гэмт хэрэг илрүүлэх, мөрдөн шалгах, урьдчилан сэргийлэх үйл

		<p>Нидерланд улсад хар тамхины хууль бус эргэлт, худалдаа, үйлдвэрлэлтэй тэмцэхэд тусгай чиг үүрэг бүхий байгууллагууд үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Үндэсний Цагдаагийн Газар (National Police Service): Хар тамхины гэмт хэрэгт шуурхай мөрдөн байцаалт явуулж, томоохон бүлэглэлүүдийг илрүүлэх, устгах үүрэгтэй. - Хар тамхитай тэмцэх Тусгай Алба (Team High Impact Crime / Drug Enforcement Teams): Хар тамхины томоохон гэмт хэргийн эсрэг чиглэсэн тусгай алба, бүлэг. - Прокурорын газар, татвар, гааль, санхүүгийн хяналтын байгууллагууд: Хар тамхины наймааг санхүүжүүлэх хөрөнгө мөнгийг илрүүлэх, саармагжуулахад оролцдог. - Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд Europol, Interpol зэрэг байгууллагатай хамтран ажилладаг. - RIVM нь Эрүүл мэнд, Халамж, Спортын яамны харьяа судалгаа, бодлого дэмжлэгийн төв байгууллага бөгөөд урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулах, эрүүл мэндийн мэдээлэл, олон нийтэд чиглэсэн төсөл зохион байгуулах, нянгийн тархалт болон сэтгэц, донтолтын чиглэлийн судалгаа хийхэд чиглэсэн судалгаа явуулдаг. <p>Дээрх байгууллагууд дараах чиглэлээр хамтран ажилладаг байна. Хамтын ажиллагааны түншлэл буюу “Integrated partnership approach”</p> <p>Үүнд</p> <ul style="list-style-type: none"> - Зохион байгуулалттай хар тамхи тээвэрлэгч сүлжээг илрүүлэх; 	<ul style="list-style-type: none"> - Дотоодын болон хил дамнансан гэмт хэргийн мөрдөн шалгах гол байгууллага 2. Мужийн криминал агентлагууд (Landeskriminalamt, LKA) <ul style="list-style-type: none"> - Тухайн мужийн нутаг дэвсгэрт хар тамхитай холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн байцаах - Холбооны ВКА-тэй хамтран ажиллах 3. Хил, гааль, татварын алба <ul style="list-style-type: none"> - Хилээр хууль бус бодис зөөвөрлөхийг илрүүлэх, таслан зогсоох - Олон улсын хамтын ажиллагаа 4. Төрийн тусгай ангиуд <ul style="list-style-type: none"> - Spezialeinsatzkommandos (SEK) – онцгой ажиллагааны хэсэг, шаардлагатай тохиолдолд томоохон үйл ажиллагаа явуулах - Zollfahndungsdienst (ZFD) – гааль, татварын мөрдөгчид, хууль бус наймааг таслан зогсоох 5. Хамтын ажиллагаа <ul style="list-style-type: none"> - ВКА, LKA, гааль, татвар, хил хамгаалах байгууллагууд хооронд мэдээлэл солилцох, хамтарсан ажиллагаа явуулах - Europol, INTERPOL зэрэг олон улсын байгууллагатай хамтран ажиллах <p>ХБНГУ-д хар тамхины хууль бус эргэлтийг таслан зогсоох зориулалттай тусгай, төвлөрсөн байгууллагууд бий бөгөөд эдгээр нь холбооны болон мужийн төвшинд үйл ажиллагаа явуулдаг. Олон улсын болон дотоодын харилцан уялдаатай хамтын ажиллагааг чухалчилдаг.</p>	<p>ажиллагааг гүйцэтгэдэг. Мөн прокурор, шүүх, хууль сахиулах бусад байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, хар тамхины эсрэг бодлого, хэрэгжилтийг хангадаг. Хар тамхитай тэмцэхэд зориулсан олон улсын хамтын ажиллагааны төв болох зэрэг олон чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.</p>
--	--	---	--	---

		<ul style="list-style-type: none"> - Хохирогч болон гэмт хэрэгтнүүдийг шалгах; - Нийтийн шударга ёсыг хамгаалж, хэрэглээний төвшинг бууруулах зорилттой үйл ажиллагаа явуулдаг. <p>1992 оноос хэрэгжиж эхэлсэн “Organised Crime in the Netherlands: Threats and Plan of Action” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулалттай гэмт хэрэгт зохион байгуулалт, адаптаци, өрсөлдөөний бодлого зэрэг суурь зарчмуудыг төлөвшүүлсэн.¹⁷⁷ Административ арга хэмжээ (лиценз, тендер хяналт, байгууллага хяналт гэх мэт) болон хууль хүчний ажиглалт, мөрдөн байцаалт зэрэг нь хосолсон нэгдмэл хандлагыг илтгэнэ.¹⁷⁸</p> <p>Урьдчилан сэргийлэх хөтөлбөр: Jellinek-ийн Unity peer education нь амралтын ба үдэшлэгийн орчинд үйлчлэгчдийг peer-education аргаар сургадаг ба Нидерланд улсын хамгийн өргөн тархсан урьдчилан сэргийлэх хөтөлбөр юм. Энэ нь эрүүл мэндийн мэдлэг, аюулгүй хэрэглээний ойлголтыг залуучуудад түгээгээд зогсохгүй олон улсад сурталчилж амжилт олсон арга баримтлал юм.</p>		
6.	Хар тамхитай тэмцэх, урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр, стратеги, төлөвлөгөө, түүний агуулга	Нидерланд улс нь хар тамхины эсрэг тогтвортой үндэсний стратеги, урт хугацааны төлөвлөгөөтэй орон бөгөөд төрийн олон салбар, байгууллага хамтран хэрэгжүүлдэг. ¹⁷⁹ Тус стратеги нь хууль сахиулах, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, боловсрол зэрэг чиглэлээр холбогдох арга	ХБНГУ-ын төрөөс хар тамхитай тэмцэх, урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр, стратеги нь боловсрол, эмчилгээ, хууль эрх зүйн зохицуулалт, судалгаа гэсэн өргөн хүрээтэй, салбар хоорондын уялдаа холбоотой цогц арга хэмжээ бөгөөд үргэлж шинэчлэгдэж, сайжирсаар байна.	Тайваньд төрөөс хар тамхитай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр үндэсний хэмжээний хөтөлбөр, стратеги, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлдэг. Энэхүү хөтөлбөр нь холбогдох бүх байгууллага, түүний дотор хууль сахиулах, эрүүл мэндийн

¹⁷⁷ Partnerships in preventing organized crime in The Netherlands: Opportunities and pitfalls
<https://eucpn.org/sites/default/files/document/files/PreventingOrganizedCrimeNetherlandsEUCPNDEFINITIVE.28042022.pdf>

¹⁷⁸ Organised Crime Prevention in the Netherlands https://repub.eur.nl/pub/7385/manuscript_proefschrift_cathelijne_4_december_2005_bladwijze.pdf

		<p>хэмжээг багтаадаг. Урьдчилан сэргийлэх нь олон нийтийн боловсрол, залуучуудын дунд хар тамхины хор уршгийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, эрсдэл багатай орчин бүрдүүлэх зорилготой юм. Хэрэглээг бууруулах хүрээнд хэрэглэгчдийг илрүүлэх, сэтгэл зүйн болон эрүүл мэндийн тусламж, эмчилгээ үзүүлдэг. Хууль сахиулах хүрээнд хар тамхины хууль бус наймаа, үйлдвэрлэл, зөөвөрлөлтийг таслан зогсоох, гэмт хэргийн сүлжээг устгана. Нийгмийн дэмжлэг, нөхөн сэргээх хүрээнд гэмт хэрэгтнийг нийгэмд эргэн оруулах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд олон улсын хэмжээнд мэдээлэл солилцох, хамтарсан ажиллагаа явуулна. Мэдээлэл, судалгааны хүрээнд хар тамхины асуудлын талаар тогтмол судалгаа хийж, бодлого, арга хэмжээг сайжруулна.</p> <p>3.Хэрэгжилт, зохион байгуулалтын хувьд төрийн төв байгууллага болох Ministry of Justice and Security болон бусад холбогдох яамдууд хөтөлбөрийг удирдан зохион байгуулдаг. Оршин суугчид, орон нутгийн удирдлага, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажилладаг.</p> <p>Нидерланд улсын үндэсний фокус төв нь 1999 онд Эрүүл мэнд, Халамж, Спортын сайдын захирамжаар байгуулагдсан үндэсний мансууруулах бодисын хяналтын (National Drug Monitor) хүрээнд ажилладаг. Тус төв нь улс даяар хийгдсэн бүртгэл, судалгаа, тандалтын өгөгдлийг цуглуулж, үнэлж дүгнэж, Улсын Доод танхим (Парламент), холбогдох яамд болон бусад</p>		<p>байгууллага, боловсролын салбар, нийгмийн үйлчилгээний байгууллагуудыг оролцуулан нэгдсэн зохион байгуулалттай хэрэгждэг.</p> <p>Хөтөлбөрийн үндсэн агуулга</p> <ol style="list-style-type: none"> 1. Хар тамхины хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх <ul style="list-style-type: none"> - Олон нийтэд хар тамхины хор уршгийг таниулах, боловсрол, сургалт явуулах. - Залуучуудыг онцгойлон хамгаалах, эрсдэлтэй бүлгүүдэд чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах. 2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль сахиулах ажиллагааг сайжруулах <ul style="list-style-type: none"> - Хар тамхины хууль бус эргэлтийг таслан зогсоох, гэмт хэрэгтнүүдийг илрүүлэх, ял шийтгэл оногдуулах ажлыг эрчимжүүлэх. 3. Сэргээн засах, эмчилгээний үйлчилгээ <ul style="list-style-type: none"> - Донтох эмгэгтэй хүмүүст зориулсан эмчилгээ, сэтгэл зүйн тусламж, нийгмийн дэмжлэгийг сайжруулах. 4. Олон улсын хамтын ажиллагаа <ul style="list-style-type: none"> - Хар тамхитай тэмцэхэд олон улсын туршлага, мэдээлэл солилцох, хамтарсан ажиллагаа эрхлэх. 5. Мэдээллийн сан, судалгаа, үнэлгээ <ul style="list-style-type: none"> - Хар тамхитай холбоотой гэмт хэргийн тархалт, үр дагаврыг судлах, хөтөлбөрийн үр дүнг үнэлэх.
--	--	---	--	---

		<p>үндэсний болон олон улсын оролцогч талуудад тайлагнах үүрэгтэй.¹⁸⁰</p> <p>Үндэсний фокус төв нь Trimbos Institute-ийн Мансууруулах Бодисын Тандалт ба Бодлого Хэлтсийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд Trimbos Institute нь сэтгэл зүйн эрүүл мэнд, хамааралтай тэмцэх үйлчилгээ, нийгмийн ажил эрхэлдэг үндэсний судалгааны институт юм. Энэ институт нь Нидерланд улсын ард иргэдийн сэтгэл зүйн эрүүл мэндтэй холбоотой асуудлаар бодлого боловсруулах, улс төрчдөд мэдээлэл хүргэх үүрэгтэй. Мөн тус төв нь Аюулгүй байдал ба Хууль зүйн яамны Судалгаа, баримтжуулах төвтэй ойрхон хамтран ажилладаг онцлогтой.</p>		
7.	<p>Хар тамхины гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, түүний эсрэг арга хэмжээ</p>	<p>1. Урьдчилан сэргийлэх боловсрол, мэдээлэл нь олон нийтийн дунд хар тамхины хор уршиг, эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдээлэл өгөх, боловсролын хөтөлбөр хэрэгжүүлдэг. Сургуулиудад болон залуучуудын байгууллагад хар тамхинаас сэргийлэх сургалт зохион байгуулдаг.</p> <p>2. Нийгмийн дэмжлэг, орчин сайжруулах нь эрсдэлтэй бүлгийн хүмүүсийг дэмжих, ажил мэргэжлийн сургалт, орон сууцны нөхцөл сайжруулах зэрэг нийгмийн нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авдаг. Ядуурал, ажилгүйдэл, гэр бүл салалт зэрэг асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн дэмжлэг үзүүлдэг.</p> <p>3. Эмчилгээ, сэргээн засах хөтөлбөрүүд нь хар тамхины донтох эмчилгээ, сэтгэл зүйн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх. Донтох өвчтэй хүмүүст зориулсан эмнэлэг, төвүүдийг хөгжүүлэх.</p>	<ul style="list-style-type: none"> - Нийгмийн орчин, ажлын байрны асуудлыг шийдвэрлэх; - Сэтгэл зүйн болон эмнэлгийн тусламж үзүүлэх; - Ур чадвар олгох сургалт, боловсролын дэмжлэг үзүүлэх; - Хууль, эрх зүйн зохицуулалттай хосолсон; - Хамтын ажиллагаатай иж бүрэн системээр хэрэгждэг. <p>1. Нийгмийн нөхцөл, орчны сайжруулалт</p> <ul style="list-style-type: none"> - Орон сууц, ажлын байр олгох: <p>Гэмт хэрэгтнүүдийг орон сууц, тогтвортой ажилтай болгох замаар дахин гэмт хэрэгт орох эрсдэлийг бууруулна.</p> <ul style="list-style-type: none"> - Нийгмийн дэмжлэг үзүүлэх: <p>Гэр бүл, нийгмийн харилцааг сайжруулах, сэтгэл зүйн болон гэр бүлийн зөвлөгөө өгөх.</p>	<p>1. Урьдчилан сэргийлэх сургалт, боловсрол</p> <p>Сурагч, оюутан, залуучууд болон олон нийтэд зориулсан хар тамхины хор уршгийг ойлгуулах, сөрөг нөлөөллийг бууруулах сургалт, кампанит ажил зохион байгуулдаг.</p> <p>2. Сэтгэл зүйн болон нийгмийн дэмжлэг</p> <ul style="list-style-type: none"> - Хар тамхины хэрэглээ, донтох эрсдэлтэй хүмүүст зориулсан сэтгэл зүйн зөвлөгөө, эмчилгээ, сэргээн засах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. - Гэр бүл, орчин тойрны дэмжлэгийг сайжруулах, сөрөг нөлөөллийг багасгах үйл ажиллагаа явуулдаг.

¹⁸⁰ Dutch National focal point https://www.euda.europa.eu/about/partners/reitox/netherlands_en

		<p>4.Хууль эрх зүйн зохицуулалт нь хар тамхины хууль бус эргэлт, үйлдвэрлэл, худалдааг таслан зогсоох хууль эрх зүйн орчныг сайжруулах. Шалгуур хатууруулсан, хууль сахиулах байгууллагын чадавхыг дээшлүүлэх.</p> <p>5.Олон талт хамтын ажиллагаа нь орон нутгийн болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээлэл солилцох, хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх. Нийгмийн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд оролцдог.</p>	<p>2. Эмчилгээ, сэтгэл заслын тусламж</p> <ul style="list-style-type: none"> - Донтолтоос гарах эмчилгээ: <p>Хар тамхины донтолтоос ангижруулах эмнэлэг, сэтгэл заслын хөтөлбөрүүд.</p> <ul style="list-style-type: none"> - Сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг: <p>Гэмт хэрэгтнүүдийн сэтгэл зүйн байдал, сөрөг хандлагыг өөрчлөх эмчилгээ, зөвлөгөө.</p> <p>3. Боловсрол, ур чадварын хөгжил</p> <ul style="list-style-type: none"> - Мэргэжил сургалт, хөдөлмөр эрхлэлтийн дэмжлэг: <p>Гэмт хэрэгтнүүдийг ажилд зуучлах, ур чадварыг хөгжүүлэх сургалт.</p> <ul style="list-style-type: none"> - Урьдчилан сэргийлэх сургалт: <p>Залууст зориулсан хар тамхины хор хөнөөлийн талаарх сургалт, мэдээлэл.</p> <p>4. Хууль эрх зүйн арга хэмжээ</p> <ul style="list-style-type: none"> - Тэнсэн ял, нөхөн сэргээх хөтөлбөрүүд: <p>Хорих ялгүйгээр эмчилгээ, нийгмийн дэмжлэгт хамруулах.</p> <ul style="list-style-type: none"> - Хяналт, хязгаарлалт: <p>Давтан гэмт хэрэгтнүүдийг цагдаагийн хяналтад байлгах.</p> <p>5. Хамтын ажиллагаа</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоо: <p>Эрүүл мэнд, нийгмийн халамж, боловсрол, хууль сахиулах байгууллагууд хамтран ажиллах.</p> <ul style="list-style-type: none"> - Олон улсын хамтын ажиллагаа: <p>Хар тамхины хяналт, мэдээлэл солилцооны чиглэлээр гадаад оронтой хамтран ажиллах.</p> <p>ХБНГУ-д хар тамхины хууль бус эргэлттэй тэмцэх тусгай байгууллага байдаг бөгөөд энэ нь мансууруулах болон сэтгэл сэргээх бодисын хууль бус наймаа, үйлдвэрлэл, зөөвөрлөлтийг таслан зогсоох, илрүүлэх чиг үүрэгтэй.</p>	<p>3. Ажлын байр, боловсрол олгох хөтөлбөр</p> <p>Гэмт хэрэгтэн, өндөр эрсдэлтэй бүлэгт ажил хөдөлмөр эрхлэх, мэргэжил эзэмших боломж олгож, нийгэмд дахин оруулах замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлдэг.</p> <p>4. Хууль эрх зүйн зохицуулалт, сахилга бат</p> <p>Хар тамхитай холбоотой хууль сахиулах ажиллагааг сайжруулж, гэмт хэрэгтнүүдийг хурдан илрүүлж, хариуцлага тооцох замаар гэмт хэргийн гаралтыг бууруулдаг.</p> <p>5. Олон улсын хамтын ажиллагаа</p> <p>Хар тамхины гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын туршлага, мэдлэгийг нэвтрүүлж, хамтарсан арга хэмжээг хэрэгжүүлдэг.</p>
--	--	---	---	--

8.	<p>Эрүүгийн хуулиас өөр хуульд (Зөрчлийн хууль-Tort law) хар тамхины хэрэгт шийтгэл оногдуулж буй туршлага</p>	<p>Нидерланд улсад хар тамхины хэрэгтэй холбоотой зөрчлийн хууль (Tort law) буюу иргэний эрх зүйн хүрээнд шийтгэл оногдуулах тохиолдол ховор бөгөөд голчлон эрүүгийн хуульд үндэслэн шийтгэл оногдуулдаг. Гэхдээ хар тамхины хэрэгтэй холбоотой зарим зөрчил, журам зөрчсөн үйлдэлд (жишээ нь, жижиг хэмжээний худалдаа, хэрэглээний зөрчил) холбогдох зөрчлийн хууль, журамд заасан торгууль, арга хэмжээ ногдуулж болох тохиолдол бий. Мөн, хар тамхины хэрэглээтэй холбоотой эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний зарим асуудлыг зохицуулах тусгай хууль, дүрэм журам байдаг.</p>	<p>ХБНГУ-ын хар тамхины хэрэгтэй холбоотойгоор эрүүгийн хуулиас гадна бусад хууль, тухайлбал зөрчлийн хууль (Ordnungswidrigkeitengesetz - OWiG) хүрээнд шийтгэл оногдуулах боломжтой байдаг. Зөрчлийн хууль (Ordnungswidrigkeitengesetz - OWiG) дахь шийтгэл</p> <ul style="list-style-type: none"> - Хар тамхины зарим үйлдэл, жишээ нь бага хэмжээний хэрэглэх, зөвшөөрөлгүй хадгалах, хууль бус үйлдлийн хөнгөн хэлбэр зөрчлийн хуульд багтдаг. - Эдгээр тохиолдолд торгууль, албадлагын арга хэмжээ оногдуулдаг бөгөөд хорих ял биш. <p>Жишээ нь:</p> <ul style="list-style-type: none"> - Бага хэмжээний мансууруулах бодис хэрэглэсэн тохиолдолд торгууль ногдуулах, зарим мужид бага хэмжээний хэрэглээг зөрчлийн асуудал гэж үзэж, эрүүгийн хэрэг үүсгэхгүй байх журамтай. 	<p>Тайваньд хар тамхины гэмт хэрэгтэй холбоотой үндсэн ял шийтгэлийг эрүүгийн хуулиар зохицуулдаг. Харин Зөрчлийн тухай хууль болон бусад хөнгөн зөрчлүүдийг зохицуулсан хуульд хар тамхины хэрэглээ, жижиг хэмжээний хадгалалт зэрэг хөнгөн зөрчилд торгууль, анхааруулга зэрэг шийтгэл оногдуулах боломж байдаг. Жишээлбэл, жижиг хэмжээний хар тамхи хэрэглэсэн тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэхээс гадна, зөрчлийн журмаар торгууль ногдуулах зохицуулалт байж болно. Ийм хөнгөн шийтгэл нь голчлон урьдчилан сэргийлэх, дахин гэмт хэрэг Тайваньд хар тамхитай холбоотой бусад онцлог эрх зүйн зохицуулалт</p> <p>6. Эрүүл мэнд, сэргээн засах чиглэлийн хууль тогтоомж</p> <ul style="list-style-type: none"> - Хар тамхины хэрэглэгчид, донтох эмгэгтэй хүмүүст зориулсан сэтгэл зүйн болон эмнэлгийн эмчилгээ, сэргээн засах үйлчилгээг хуульчилсан. - Донтохоос сэргийлэх, эрүүл мэндийг хамгаалах тусгай хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг. <p>7. Хууль сахиулах байгууллагуудын эрх мэдэл, хамтын ажиллагаа</p> <ul style="list-style-type: none"> - Хар тамхитай тэмцэхэд цагдаа, прокурор, шүүх, тусгай албаныхан хоорондын харилцан уялдаа, мэдээлэл солилцоог хуулиар баталгаажуулсан. - Олон улсын хар тамхитай тэмцэх хэлэлцээр, протоколд нэгдэн орсон.
----	--	---	---	--

				<p>8. Хөрөнгө хураах, мөнгө угаахтай тэмцэх эрх зүйн зохицуулалт Хар тамхины гэмт хэрэгт ашиглагдсан хөрөнгө, эд хөрөнгийг хураах, мөнгө угаахтай тэмцэх хууль эрх зүйн зохицуулалттай.</p> <p>9. Олон улсын хамтын ажиллагаа Тайвань олон улсын хар тамхитай тэмцэх байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцох, хамтарсан мөрдөн шалгах ажиллагаанд оролцдог.</p> <p>10. Хүмүүнлэг, хүний эрхийн хэм хэмжээ Хар тамхины хэрэглэгчдийн эрхийг хамгаалах, ял шийтгэлийг хүний эрх, хүмүүнлэгийн зарчмын хүрээнд зохицуулдаг.</p>
9.	Сайн тал	<p>1. Уян хатан, бодлогын тэнцвэртэй байдал нь зөөлөн хар тамхины хэрэглээг хууль ёсны тодорхой хүрээнд зохицуулснаар гэмт хэрэг, нийгмийн асуудлыг бууруулахад хувь нэмэр оруулдаг. Хар тамхины хэрэглэгчдийг хууль бус зах зээлээс хамгаалж, эрүүл мэндийн үйлчилгээ, мэдээлэлд хялбар хүрэх боломж олгодог.</p> <p>2. Гэмт хэрэг болон гэмт хэргийн сүлжээг багасгахдаа хар тамхины томоохон гэмт хэргийн бүлэглэлүүдийн үйл ажиллагааг хууль сахиулах байгууллагаар илрүүлж, хязгаарлахад чиглэсэн системтэй арга хэмжээ авдаг.</p> <p>3. Эрсдэл бууруулах бодлого нь хэрэглэгчдийг сэтгэл зүйн болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбож, донтохоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг.</p>	<p>ХБНГУ-ын хар тамхины эсрэг хууль эрх зүйн зохицуулалт нь нарийвчилсан, олон талт, цогц бүтэцтэйгээрээ онцлог бөгөөд олон улсын жишигт нийцсэн зохицуулалттай орнуудын нэгт зүй ёсоор тооцогддог.</p> <p>Нэгдүгээрт, энэ чиглэлийн үндсэн эрх зүйн актууд болох Эрүүгийн хууль (StGB), Мансууруулах бодисын тухай хууль (BtMG), Зөрчлийн хууль (OWiG) зэрэг нь хар тамхины хэрэгтэй холбоотой үйлдэл бүрийг нарийвчлан тодорхойлж, хариуцлага хүлээлгэх нөхцөл, ял шийтгэл, сэргийлэх болон нөхөн сэргээх арга хэмжээг тусгаж өгсөн нь эрх зүйн зохицуулалтын тодорхой, ойлгомжтой байдлыг хангаж өгдөг.</p> <p>Хоёрдугаарт, урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөрүүдийг өргөн хүрээнд хэрэгжүүлдэг бөгөөд энэ нь зөвхөн хууль сахиулахын хүрээнд хязгаарлагдахгүй, боловсрол, олон нийтийн мэдээлэл, залуучуудад зориулсан сургалтын тогтолцоотой уялдан ажиллаж,</p>	<p>Тайваний хар тамхитай тэмцэх чиглэлээр эрх зүйн цогц зохицуулалтыг боловсруулан хэрэгжүүлдэг бөгөөд энэ нь олон улсын хэм хэмжээнд нийцсэн, хариуцлагатай бодлогын жишээ болж байна.</p> <p>Нэгдүгээрт, хар тамхитай холбоотой үйлдлүүдийг нарийвчлан заасан хууль, дүрэм журам тогтсон бөгөөд эрүүгийн болон зөрчлийн хэргүүдэд ялгавартай ханддаг нь эрх зүйн тодорхой байдлыг хангаж, хэрэгжилтийн үр дүнг нэмэгдүүлдэг. Энэ нь хууль зүйн системийн бүрэн бүтэн, оновчтой байдалтай шууд холбоотой.</p> <p>Хоёрдугаарт, хар тамхины хэрэглээг бууруулахад чиглэсэн боловсрол, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, мөн донтох эмгэгтэй тэмцэх эмчилгээний хөтөлбөрүүд нь хэрэглэгчийг гэмт хэрэгтэн бус, тусламж шаардлагатай</p>

		<p>4. Нийгэмд дахин нэгтгэх хөтөлбөрүүд нь Хар тамхины донтохтой тэмцэхийн зэрэгцээ гэмт хэрэгтнийг нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргэн оруулах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.</p> <p>5. Олон улсын хамтын ажиллагаа нь Европ болон дэлхийн бусад орнуудтай хамтран хар тамхины хууль бус эргэлттэй тэмцэх, мэдээлэл солилцох чиглэлээр идэвхтэй ажилладаг.</p>	<p>хэрэглээг хязгаарлах, бууруулахад чиглэгддэг. Ийм төрлийн хөтөлбөрүүд нь ялангуяа залуу үеийн дунд хэрэгцээтэй мэдээллийг түгээж, эрсдэлтэй зан үйлээс урьдчилан сэргийлэх чухал суурь болдог.</p> <p>Гуравдугаарт, мансууруулах бодист донтсон хүмүүст зориулсан эмчилгээ, нөхөн сэргээх үйлчилгээний хүртээмж сайн, төрөлжсөн төвүүд болон мэргэжлийн байгууллагууд улс даяар үйл ажиллагаа явуулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй уялдаатайгаар нийгэмд дахин нэгтгэх үйл ажиллагааг дэмждэг. Энэ нь зөвхөн эмчилгээ биш, хүнийг нийгэмд эргэн оруулах иж бүрэн тогтолцоог бүрдүүлсэн нь үр дүнтэй бодлого хэрэгжиж байгааг илтгэнэ.</p> <p>Дөрөвдүгээрт, хууль сахиулах байгууллагууд болох холбооны болон мужийн цагдаа, прокурор, шүүх, гаалийн байгууллагууд хоорондын уялдаа холбоо сайтай, мэдээлэл солилцоо, хамтарсан ажиллагаа үр дүнтэй хэрэгждэг нь хэрэг илрүүлэх, мөрдөн шалгах үйл явцыг хөнгөвчилдөг. Мөн олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах тогтолцоо нь хил дамнасан хар тамхины гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал хувь нэмэр оруулдаг.</p> <p>Тавдугаарт, хувь хүний нууц мэдээлэл болон хүний эрхийг хамгаалах чиглэлээр өндөр шаардлага тавьж, Европын Холбооны Мэдээлэл хамгааллын ерөнхий журам (DSGVO) болон хүний эрхийн хэм хэмжээ, зарчмыг мөрдөн хэрэгжүүлдэг. Гэмт хэрэгт мөрдлөг явуулах явцад тухайн хүний эрхийг зөрчихгүй байхыг хууль сахиулагчдаас шаардаж, шударга шүүх ажиллагааг хангадаг.</p>	<p>иргэн гэж үзэх нийгмийн хандлагыг дэмждэг.</p> <p>Гуравдугаарт, цагдаа, прокурор, шүүх, эрүүл мэндийн байгууллагууд болон нийгмийн халамжийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо сайтай бөгөөд энэ нь олон салбарын хамтын ажиллагаанд суурилсан, бүхэллэг хандлагыг хэрэгжүүлэх боломжийг олгодог.</p> <p>Дөрөвдүгээрт, хар тамхины гэмт хэргээс олсон хууль бус хөрөнгийг хураах, мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн эрх зүйн зохицуулалтыг нэвтрүүлсэн нь зөвхөн хэрэглэгч бус, нийлүүлэгч, зохион байгуулагч түвшинд чиглэсэн бодлогын чухал хэрэгсэл болж байна.</p> <p>Тавдугаарт, Тайваний олон улсын түвшинд хар тамхины эсрэг хамтарсан ажиллагаанд оролцож, мэдээлэл солилцох, хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр идэвхтэй байр суурьтай оролцдог.</p> <p>Зургаадугаарт, хар тамхины хэрэгт холбогдсон хүмүүсийн хүний эрх, нийгмийн хамгаалал, сэргээн засах үйлчилгээнд анхаарал хандуулдаг бөгөөд энэ нь эрүүгийн хууль сахиулахын хажуугаар нийгмийн халамжийг хослуулсан бодлогын илрэл юм.</p>
10.	Сул тал	1. Хууль бус зах зээл бүрэн тасрахгүй байх эрсдэл	Эрх зүйн зохицуулалт нь гэмт хэрэгт ял шийтгэл оногдуулахын зэрэгцээ нийгмийн	1. Ял шийтгэл хэт хатуу байж болзошгүй

		<p>Зөөлөн хар тамхины хэрэглээг зөвшөөрсөн ч, хатуу хар тамхины зах зээл болон хар тамхины худалдааны зарим хэсэг хууль бус хэвээр үлддэг.</p> <p>2. Хэрэглээг өөгшүүлэх сөрөг тал Зарим хүмүүсийн хувьд зөөлөн хар тамхины хэрэглээг зөвшөөрсөн бодлого нь хар тамхины хэрэглээг хэвийн үзэгдэл болгож, хэрэглээг нэмэгдүүлэх эрсдэлтэй.</p> <p>3. Насанд хүрээгүй болон эмзэг бүлэгт нөлөөлөх асуудал Насанд хүрээгүй хүүхдүүдэд хар тамхины хандах хязгаарлалт зарим үед хангалтгүй байж, залуучуудын дунд хэрэглээ өсөх эрсдэлтэй.</p> <p>4. Олон улсын шүүмжлэл ба хязгаарлалтууд Нидерланд улсын бодлого зарим олон улсын хамтын нийгэмлэг, улс орнуудын зүгээс харшилж, хамтын ажиллагаанд хүндрэл үүсгэх тохиолдол байдаг.</p> <p>5. Эрүүл мэндийн болон нийгмийн ачаалал Хар тамхины хэрэглээтэй холбоотой эрүүл мэндийн үйлчилгээ, сэтгэл зүйн тусламжийн хэрэгцээ өндөр хэвээр байдаг бөгөөд нийгмийн дэмжлэг шаардлагатай.</p>	<p>сэргээн засах, эмчилгээний арга хэмжээг хослуулсан, салбар хоорондын хамтын ажиллагаанд тулгуурласан системтэйгээр хэрэгжиж буй нь бодлогын уялдаа, үр нөлөөг илүү нэмэгдүүлдэг. Гэсэн хэдий ч энэхүү цогц системийн хүрээнд тодорхой сул талууд байсаар байгаа бөгөөд зарим нь зохицуулалт, хэрэгжилтийн шатанд хүндрэл дагуулж байна.</p> <p>Нэгдүгээрт, хууль эрх зүйн олон баримт бичиг зэрэгцэн үйлчилдэг тул зарим тохиолдолд мэдээлэл ойлгоход төвөгтэй, иргэд төдийгүй мэргэжилтнүүдийн хувьд ч ойлгомжгүй байдал үүсгэх нь бий.</p> <p>Хоёрдугаарт, бага хэмжээний хэрэглээтэй холбоотой зохицуулалт нь улс орон даяар нэг ижил жишигтэй биш байдаг. Зарим мужид бага хэмжээний каннабисыг хэрэглэсэн тохиолдлыг зөрчил гэж үзэх бол, бусад мужид эрүүгийн хэрэг гэж хүлээн авч болох тул хэрэглэгчийн хувьд ойлгомжгүй, хууль сахиулах байгууллагын хувьд тогтмол бус байдал үүсэх эрсдэлтэй.</p> <p>Гуравдугаарт, донтолын эсрэг эмчилгээ, нийгмийн дэмжлэгийн үйлчилгээний хүртээмжийг авч үзвэл, бүх муж, хотод ижил түвшинд хүрч ажилладаггүй. Зарим бүс нутагт нөхөн сэргээх төв, мэргэжлийн үйлчилгээний байгууллага дутагдалтай, хүний нөөцийн хомсдолтой байгаа нь нийгмийн халамжийн тогтолцооны тэгш хүртээмжид нөлөөлж байна.</p>	<p>Зарим тохиолдолд хар тамхины хэрэгт оногдуулах хорих ял, торгууль хэт хатуу байх нь хүний эрх, нөхөн сэргээх арга хэмжээнд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.</p> <p>2. Давтан гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ хангалтгүй байж болох Сэргээн засах, дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх хөтөлбөрүүд бүрэн хүртээмжтэй биш, зарим бүлэгт хүрэхгүй байх магадлалтай.</p> <p>3. Нийгмийн ялгаварлан гадуурхалт Хар тамхины хэрэглэгчид, ялангуяа донтохтой холбоотой хүмүүсийг нийгмээс тусгаарлах, ялгаварлан гадуурхах хандлага хэвээр байж болзошгүй.</p> <p>4. Хууль сахиулах байгууллагын хэтэрхий төвлөрсөн хяналт Цагдаа, прокурорын хүчээр гэмт хэргийг илрүүлэхэд төвлөрч, сэргээн засах үйлчилгээгээр хангах тал дээр сул тал гарч болзошгүй.</p> <p>5. Олон улсын хүлээн зөвшөөрөл ба хамтын ажиллагааны хязгаарлалт Тайваний олон улсын зарим байгууллагад албан ёсоор хүлээн зөвшөөрөгдөөгүй тул хамтын ажиллагаа зарим талаар хязгаарлагдмал байдаг.</p>
--	--	--	---	---

